



БАЯНХОНГОР
АЙМГИЙН
ЗДТГ

Баянхонгор аймгийн Иргэдийн
төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10
дугаар сарын 20-ны өдрийн 11/49 дугаар
тогтоолын хавсралт.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОТЬ 4: ОЙН САН, ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭ, ТХГН, АЯЛАЛ-РЕКРЕАЦ, УСНЫ
САНГИЙН ГАЗАР ТӨЛӨВЛӨЛТ

ТӨСЛИЙН ДУГААР: БХАОНӨГ/202112028

ЗАХИАЛАГЧ: БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТАНИЛЦСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,

ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ХИШИГБААТАР/

ХЯНАСАН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА /Д.АЛТАНГЭРЭЛ/



ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЗӨВЛӨГӨӨ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ЛАНРЕС” ХХК

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРАЛ	<u>И.Мягмаржав</u>	/И.МЯГМАРЖАВ Ph.D/
ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР	<u>П.Мягмарцэрэн</u>	/П.МЯГМАРЦЭРЭН Ph.D/
ХӨРС СУДЛААЧ	<u>Д.Ариунцэцэг</u>	/Д.АРИУНЦЭЦЭГ Ph.D/
МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР	<u>Т.Шинэбаяр</u>	/Т.ШИНЭБАЯР/
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАГЧ	<u>Ж.Алтангадас</u>	/Ж.АЛТАНГАДАС/
КАДАСТРЫН ИНЖЕНЕР	<u>П.Баярцэрэн</u>	/П.БАЯРЦЭРЭН/
БЭЛЧЭЭР СУДЛААЧ	<u>Л.Ганхуяг</u>	/Л.ГАНХУЯГ/

УЛААНБААТАР ХОТ
2022 ОНЫ 11 САР



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 1149

Номгон

Аймгийн Газар зохион байгуулалтын
ерөнхий төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөний бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Баянхонгор аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3.Ерөнхий төлөвлөгөөг үндэслэн сум тус бүр Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар боловсруулж, батлуулан ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0121212

ГАРЧИГ

НЭГ. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	11
1.1 Тариалангийн газрын агро-экологийн бүсчлэл	12
1.2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	14
1.2.1 Суурь нөхцөлийн үнэлгээ	14
1.2.2 Хүчин зүйлийн үнэлгээ	17
1.3 Тариалангийн газрын ашиглалтын одоогийн байдал.....	20
1.4 Усалгаатай газар тариалан	23
1.4 Газар тариалангийн хэрэгцээт байдлын үнэлгээ	27
1.4.1 Газар тариалангийн бүтээгдэхүүний одоогийн хэрэгцээ, хангамж	27
1.4.2 Газар тариалангийн бүтээгдэхүүний ирээдүйн хэрэгцээ, хангамж	29
1.5 Тариалангийн газрын төлөвлөлт	34
1.6 Жимс, жимсгэнэ тариалах газрын төлөвлөлт	41
1.6.1 Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ	41
1.6.2 Жимс, жимсгэний газрын хэрэгцээт байдлын үнэлгээ	47
1.6.3 Жимс, жимсгэний газрын төлөвлөлт	51
1.7 Тариалангийн талбайн ойн зурвас байгуулах төлөвлөлт	53
1.8 Тариалангийн талбайн хөрс сайжруулах арга хэмжээ, зөвлөмж	57
ХОЁР. ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	70
2.1 Зам, шугам сүлжээний газрын ашиглалтын байдал.....	71
2.2 Авто замын газрын төлөвлөлт	72
2.3 Төмөр замын сүлжээний төлөвлөлт	81
2.4 Агаарын тээврийн төлөвлөлт	84
2.5 Шилэн кабель	87
2.6 Эрчим хүч дамжуулах шугамын газрын төлөвлөлт	88
ГУРАВ. БАЙГАЛИЙН АЯЛАЛ-РЕКРЕАЦИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	90
3.1. Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	91
3.1.1 Тохиромжтой байдлын үнэлгээний аргачлал.....	91
3.1.2. Суурь нөхцөлийн үнэлгээ	91
3.1.3. Хүчин зүйлийн үнэлгээ.....	94
3.2 Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал	98
3.2.1 Монгол улсын аялал жуулчлалын салбарын одоогийн байдал	98
3.2.2 Баянхонгор аймгийн аялал жуулчлал	103
3.4 Аялал жуулчлал-рекреацийн төлөвлөлт	121
3.4.1 Аялал жуулчлалын чиглэлүүд.....	121
3.4.2 Газар хөдлөлтийн ул мөртэй танилцах аялалын маршрут	123
3.4.3 Түүх соёлын ул мөртэй танилцах аялалын маршрут.....	125

3.4.4 Хүн үүслийн ул мөртэй танилцах аяллын маршрут	127
3.4.5 Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялалын маршрут.....	129
3.4.6 Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялалын маршрут.....	131
3.4.7 Говийн 6 гайхамшигт амьтадтай танилцах аялалын маршрут	133
3.4.8 Тусгай сонирхолын (Ан агнуур) аялал жуулчлалын төлөвлөлт	134
3.5 Аялал жуулчлалын бүс нутгийн төлөвлөлт.....	138
ДӨРӨВ. ОЙН САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	142
4.1. Ойн сангийн газрын нөхцөл, нөөцийн суурь судалгаа.....	143
4.1.1 Оршил.....	143
4.1.2 Ойн сан ба түүний төлөв байдал ¹	143
4.1.3 Ойн сан бүхий газар ¹	146
4.1.4 Ойн нөөц ¹	151
4.1.5 Баянхонгор аймгийн ойн төлөв байдал, ойн менежментийн үйл ажиллагаанд хийсэн SWOT дүн шинжилгээ ¹	158
4.2. ОЙН САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	160
4.2.1 Ой хамгааллын арга хэмжээ ¹	160
4.2.2 Ойн аж ахуйн арга хэмжээ ¹	162
4.2.3 Ойн сангийн газрыг ашиглуулах төлөвлөгөө ¹	175
ТАВ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ	176
5.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт	177
5.2 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт	182
5.2.1 Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт	182
5.2.2 Сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт.....	187
ЗУРГАА. УСНЫ САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	200
6.1 Усны сангийн газрын нөөц	201
6.2 Усны менежментэд баримтлах үндсэн зарчим	204
6.3 ХАА-н усан хангамжийн төлөвлөлт	206
6.3.1 ХАА-н усан хангамжийн хамгаалалтын бүсүүд.....	206
6.3.2 Рашааны хамгаалалтын бүсийн төлөвлөлт	207
6.3.3 Нуурыг элсний нүүлтээс хамгаалах, усны ундаргыг нэмэгдүүлэх төлөвлөлт ..	208
6.3.4 Ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах төлөвлөлт	209
6.3.5 Газрын доорх усны ордын нөөц, тэжээгдлийн муж дахь төлөвлөлт	219
6.3.6 Усны урсац бүрэлдэх эх газрын төлөвлөлт.....	220
6.4 Хот, суурины усан хангамжийн төлөвлөлт	223
6.4.1 Хот, суурины усан хангамжийн хэрэгцээт байдлын үнэлгээ	223
6.4.2 Хот, суурины усан хангамжийн хамгаалалтын бүсийн төлөвлөлт.....	227
Ашигласан ном, хэвлэл	231
ХАВСРАЛТ	233

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1.Бүсүүдийн тариалангийн талбайн агро-цаг уурын үзүүлэлт	12
Хүснэгт-2.Тариалангийн газрын байршил тогтоох шалгуур	14
Хүснэгт-3.Тариалангийн газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь	17
Хүснэгт-4.Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ	20
Хүснэгт-5.ГНС-ийн шинэчилсэн тооллого, бүртгэгдсэн болон ГКМС-нд эрх нь баталгаажсан тариалангийн талбай, га /2020-2021/	21
Хүснэгт-6.Тариалсан нийт талбай болон хурааж авсан ургацын хэмжээ (2010-2020)....	22
Хүснэгт-7.Хурааж авсан ургацын хэмжээ	23
Хүснэгт-8.Баянхонгор аймагт ашиглагдаж байсан услалтын системийн судалгаа	24
Хүснэгт-9.Улсын төсвийн хөрөнгөөр зураг, төсөв нь хийгдсэн услалтын системүүд....	26
Хүснэгт-10. Газар тариалангийн бүтээгдэхүүний хангамж /Аймаг нэгдсэн/.....	27
Хүснэгт-11. Төлөвлөлтийн жилүүд дэх хүн амын өсөлтийн тооцоолол	29
Хүснэгт-12. Нэг хүний жилийн дундаж хүнсний хэрэгцээ (г/хүн)	31
Хүснэгт-13. Газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэгцээ	31
Хүснэгт-14. Хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай талбайн хэмжээ, га	34
Хүснэгт-15. Тариалангийн газрын төлөвлөлт	39
Хүснэгт-16. Жимс, жимсгэнэ тариалах газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл.....	41
Хүснэгт-17. Жимс, жимсгэнэ тариалах газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь	44
Хүснэгт-18. Жимс, жимсгэний газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ.....	47
Хүснэгт-19. Төлөвлөлтийн жилүүд дэх хүн амын өсөлтийн тооцоолол	49
Хүснэгт-20. Нэг хүний жилийн дундаж хүнсний хэрэгцээ (г/хүн)	49
Хүснэгт-21. Жимс, жимсний бүтээгдэхүүний хэрэгцээ	50
Хүснэгт-22. Жимс, жимсгэний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардлагатай тариалангийн газрын тооцоо	51
Хүснэгт-23. Жимс, жимсгэний талбайн төлөвлөлт	52
Хүснэгт-24. Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас.....	54
Хүснэгт-25. Хөрсний элэгдэлд нэрвэгдэх эрсдэл	58
Хүснэгт-26. Карбонат бүхий хар шороот хөрсний	59
Хүснэгт-27. Хөрсний 0-30 см-ийн гүн дэх ургамлын үлдэгдэл /жилийн дундаж/	67
Хүснэгт-28. Зам шугам сүлжээний газрын өөрчлөлт, мян.га	71
Хүснэгт-29. Одоо байгаа авто замууд	72
Хүснэгт-30. Замын сүлжээний байгуулах газар ашиглалтын суурь нөхцөл, тавигдах шаардлага.....	76
Хүснэгт-31. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт баригдах авто замын төлөвлөлт	78
Хүснэгт-32. Баянхонгор аймгийн сумдад шинээр барих гүүрнүүд	81
Хүснэгт-33. Төмөр замын сүлжээний төлөвлөлт	82
Хүснэгт-34. Шилэн кабелийн сүлжээ эзэмшигчид.....	87
Хүснэгт-35. Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ.....	88

Хүснэгт-36.	Төлөвлөсөн цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ	89
Хүснэгт-37.	Амралт зугаалгын газрын байршил тогтоох шалгуур.....	91
Хүснэгт-38.	Байгалийн аялал-рекреацийн газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь.....	94
Хүснэгт-39.	Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ.....	97
Хүснэгт-40.	Улсын хилээр орсон гадаад зорчигчид, бүс нутаг, улсаар.....	101
Хүснэгт-41.	Баянхонгор аймгийн түүх соёлын дурсгалт газрын судалгаа	105
Хүснэгт-42.	Аялалын чиглэл, уртын хэмжээ.....	121
Хүснэгт-43.	Баянхонгор аймгийн ан агнуурын бүс нутгийн төлөвлөлт.....	136
Хүснэгт-44.	Баянхонгор аймгийн аялал жуулчлалын газрын төлөвлөлт	140
Хүснэгт-45.	Ойн сан бүхий газрын бүсийн төрөл.....	145
Хүснэгт-46.	Ойн сан бүхий газрын талбай (ОТМТ, 2022).	146
Хүснэгт-47.	Ойн сан бүхий газрын талбай, га /сумаар/ (ОТМТ, 2022).....	150
Хүснэгт-48.	Ойн нөөцийн дүнгийн хүснэгт /нөөц - мян.м ³ /	151
Хүснэгт-49.	Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлт /модны төрлөөр/ (ОТМТ, 2022).	152
Хүснэгт-50.	Шилмүүст, навчит ойн насны бүлгийн хүснэгт (ОТМТ, 2022).....	152
Хүснэгт-51.	Заган ойн хэв шинжийн ангилал (ОТМТ, 2022).	153
Хүснэгт-52.	Ойн сан бүхий газрын талбай, га /сумаар/	154
Хүснэгт-53.	Шилмүүст-навчит ой бүхий газрын төлөв байдал, га /сумаар/	156
Хүснэгт-54.	Заган ой бүхий газрын төлөв байдал, га /сумаар/	157
Хүснэгт-55.	SWOT дүн шинжилгээ (ОТМТ, 2022).....	158
Хүснэгт-56.	Ой хамгаалах төлөвлөгөөний зардал /2022-2026 он/ (ОТМТ, 2022).....	161
Хүснэгт-57.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх төслийн санал	163
Хүснэгт-58.	Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөний нийт зардал (ОТМТ, 2022) /2022-2026 он/.....	165
Хүснэгт-59.	Шилмүүст, навчит ойн арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжих сумд/га/.....	165
Хүснэгт-60.	Заган ойн арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжих сумд /га/.....	166
Хүснэгт-61.	Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө /2022-2026/	170
Хүснэгт-62.	Арчилгааны огтлолтын хэлбэр, хийх хугацаа.....	172
Хүснэгт-63.	Арчилгааны огтлолтын төлөвлөгөө	173
Хүснэгт-64.	Ойн эрүүл ахуйн огтлолтын төлөвлөгөө	174
Хүснэгт-65.	Бэлтгэх модны хэмжээ.....	174
Хүснэгт-66.	Иргэдийн нөхөрлөлийн ашиглалтанд буй ойн судалгаа	175
Хүснэгт-67.	Улсын тусгай хамгаалалттай газар	177
Хүснэгт-68.	Төлөвлөлөөр улсын тусгай хамгаалалтанд авах санал /Полигон/.....	179
Хүснэгт-69.	Улсын тусгай хэрэгцээнд шинээр авах газар нутаг (цэгэн).....	180
Хүснэгт-70.	Аймгийн тусгай хамгаалалттай газар /тогтоолоор/	182

Хүснэгт-71.	Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчилийн судалгаа	183
Хүснэгт-72.	Орон нутгийн тусгай хамгаалалтаас хасах, хил заагт өөрчлөт оруулах /төлөвлөлтөөр/	184
Хүснэгт-73.	Орон нутгийн тусгай хамгаалалтанд шинээр авах /төлөвлөлтөөр/.....	185
Хүснэгт-74.	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг тогтоолоор (Полигон).....	187
Хүснэгт-75.	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг тогтоолоор (цэгэн) ..	189
Хүснэгт-76.	Сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчилийн судалгаа	193
Хүснэгт-77.	Сумын тусгай хэрэгцээнээс хасах, хил заагт өөрчлөт оруулах /төлөвлөлтөөр/	195
Хүснэгт-78.	Орон нутгийн тусгай хэрэгцээнд шинээр авах /төлөвлөлтөөр/.....	196
Хүснэгт-79.	Сумын тусгай хэрэгцээнд шинээр авах (цэгэн)	197
Хүснэгт-80.	2020 оны Газрын нэгдмэл санд усны сан бүхий газрын эзлэх талбай...	201
Хүснэгт-81.	Баянхонгор аймгийн гадаргын усны тооллого	202
Хүснэгт-82.	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс.....	205
Хүснэгт-83.	Усны сан бүхий газрын төлөвлөлтийн бүсүүд.....	206
Хүснэгт-84.	Рашааны хамгаалалтын бүсийн төлөвлөлт.....	207
Хүснэгт-85.	Нуурыг элсний нүүлтээс хамгаалах, усны ундаргыг нэмэгдүүлэх ойн зурвас.....	208
Хүснэгт-86.	Хөв, цөөрөм байгуулах газрын байршил тогтоох шалгуур	209
Хүснэгт-87.	Хөв цөөрөм байгуулах хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь	212
Хүснэгт-88.	Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ	215
Хүснэгт-89.	Хөв цөөрөм байгуулах газрын төлөвлөлт	216
Хүснэгт-90.	Газрын доорх усны ордын нөөц, тэжээгдлийн муж	219
Хүснэгт-91.	Усны урсац бүрэлдэх эх газар	220
Хүснэгт-92.	Баянхонгор аймгийн хэмжээний ундны усны ирээдүйн хэрэглээ	224
Хүснэгт-93.	Баянхонгор сумын ундны усны нөөцийн эрсдэлийн үнэлгээ.....	225
Хүснэгт-94.	Баянхонгор сумын усан хангамжийн хэрэгцээ	226
Хүснэгт-95.	Хот суурины усан хангамжийн хамгаалалтын бүс.....	227
Хүснэгт-96.	Хот суурины усан хангамжийн хамгаалалтын бүсийн менежмент, төлөвлөлтийн бүсүүд.....	229

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг-1.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл.....	15
Зураг-2.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн нэгдсэн үнэлгээ.....	16
Зураг-3.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээ.....	18
Зураг-4.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ.....	19
Зураг-5.	Тариалангийн газрын төлөвлөлт.....	38
Зураг-6.	Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл.....	42
Зураг-7.	Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн нэгдсэн үнэлгээ.....	43
Зураг-8.	Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын.....	45
Зураг-9.	Жимс, жимсгэний газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ.....	46
Зураг-10.	Монгол орны жимсний таримлын бүсчилэл /Б.Нинж/.....	48
Зураг-11.	Ойн зурвас байгуулсан байдал.....	54
Зураг-12.	Тариалангийн талбайг хамгаалах ойн зурвасын төлөвлөлт.....	56
Зураг-13.	Хөрсний элэгдэл эвдрэлд эмзэг байдал.....	58
Зураг-14.	Царгас.....	62
Зураг-15.	Холимон тариалан.....	63
Зураг-16.	Хаялбарын дагуу тариалсан байдал.....	63
Зураг-17.	Амрааж олон ургамал тариалсан талбай.....	64
Зураг-18.	Одоо байгаа авто замууд.....	75
Зураг-19.	Авто замын төлөвлөлт.....	79
Зураг-20.	Баянхонгор аймгийн гүүрний төлөвлөлт.....	80
Зураг-21.	Төмөр замын бүтээн байгуулалтын төслүүд.....	82
Зураг-22.	Төмөр замын төлөвлөлт.....	83
Зураг-23.	Одоо байгаа Баянхонгор хотын нисэх онгоц хөөрөх, буух зурвас.....	84
Зураг-24.	Баян-Овоо, Баянлиг суманд төлөвлөсөн нисэх онгоц хөөрөх, буух зурвас ...	85
Зураг-25.	Төлөвлөсөн нисэх онгоцны хөөрөх, буух зурвас.....	86
Зураг-26.	Шилэн кабель.....	87
Зураг-27.	Шугам сүлжээний газрын төлөвлөлт.....	89
Зураг-28.	Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлыг хязгаарлагч хүчин зүйлүүд.....	92
Зураг-29.	Амралт зугаалгын газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл.....	93
Зураг-30.	Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн үнэлгээ.....	95
Зураг-31.	Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ.....	96
Зураг-32.	Монголын аялал жуулчлалын сонирхлын бүс.....	98
Зураг-33.	Жуулчдын тоо дүнд эзлэх хувиар, улсаар, 2020 он.....	101

Зураг-34.	Манай улсын аялал жуулчлалын голлох бүс нутаг	102
Зураг-35.	Баянхонгор аймгийн аялал жуулчлалын нөөц газрын судалгаа	104
Зураг-36.	Баянхонгор аймгийн аялал жуулчлалын зураг	122
Зураг-37.	Газар хөдлөлтийн ул мөртэй таницах аялал жуулчлалын зураг	124
Зураг-38.	Түүх соёлын ул мөртэй танилцах аялал жуулчлалын зураг	126
Зураг-39.	Хүн үүслийн ул мөртэй танилцах аялал жуулчлалын зураг	129
Зураг-40.	Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялал жуулчлалын зураг	130
Зураг-41.	Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялал жуулчлалын зураг	132
Зураг-42.	Говийн ховор ан амьтадтай танилцах аялал жуулчлалын зураг	134
Зураг-43.	Ан агнуурын бүс нутгийн төлөвлөлт	135
Зураг-44.	Аялал жуулчлалын газрын төлөвлөлт	139
Зураг-45.	Баянхонгор аймгийн ойн тархалт ГНС-ийн ангилалаар	144
Зураг-46.	Баянхонгор аймгийн ойн тархалт /ойн төрлөөр/	147
Зураг-47.	Баянхонгор аймгийн навчит, шилмүүст ойн тархалт, төлөв байдлын зураг	154
Зураг-48.	Баянхонгор аймгийн заган ойн тархалт, төлөв байдал	155
Зураг-49.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний урьдчилсан төлөвлөгөө	162
Зураг-50.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний урьдчилсан төсөв	163
Зураг-51.	Заган ой бүхий газрын төлөвлөлт	167
Зураг-52.	Шилмүүст, навчит ой бүхий газрын төлөвлөлт	168
Зураг-53.	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	178
Зураг-54.	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт	181
Зураг-55.	Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт	186
Зураг-56.	Сумын тусгай хэрэгцээний газар нутгийн төлөвлөлт	199
Зураг-57.	Усны сүлжээ	203
Зураг-58.	Рашааны хамгаалалын бүс тогтоосон байдал	208
Зураг-59.	Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл	210
Зураг-60.	Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн нэгдсэн үнэлгээ	211
Зураг-61.	Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн үнэлгээ	213
Зураг-62.	Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ	214
Зураг-63.	Хөв цөөрөм байгуулах төлөвлөлт	218
Зураг-64.	Усны сан бүхий газрын төлөвлөлт	222
Зураг-65.	Усан хангамжийн хамгаалалтын менежментийн бүсүүд	228

СХЕМ ЖАГСААЛТ

Схем-1.	Газар хөдлөлтийн ул мөртэй таницах аялал жуулчлалын нөөц	123
Схем-2.	Түүх соёлын ул мөртэй танилцах аялал жуулчлалын нөөц	125
Схем-3.	Хүн үүслийн ул мөртэй танилцах аялал жуулчлалын нөөц.....	127
Схем-4.	Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялал жуулчлалын нөөц.....	129
Схем-5.	Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялал жуулчлалын нөөц.....	131
Схем-6.	Говийн 6 гайхамшигт амьтадтай танилцах аялал жуулчлалын нөөц.....	133
Схем-7.	Заган ойн талбайн төрөл ¹	148
Схем-8.	Ой хамгааллын арга хэмжээ ¹	160

НЭГ. ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Тариалангийн газрын агро-экологийн бүсчлэл

Баянхонгор нутгийн хойд хэсгээр Хангайн нурууны уулархаг муж ноёлж байхад өмнөд хэсэг нь Говийн их муж, Алтайн өмнөх говийн мужид хамрагдана. Тариалангийн газрууд нь бага хэмжээний нутаг дэвсгэрийг хамрах учир тэгшивтэр гадаргад байрладаг.

Аймгийн цаг уурын онцлогыг авч үзвэл халуун хуурай зунтай мужид багтдаг. Энэ нь хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл, жилийн хур тунадасны хэмжээ бага, агаарын хуурайшилт ихтэй, богино хуурай өвөл болдог зэргээр тайлбарлагдана.

Хүснэгт-1. Бүсүүдийн тариалангийн талбайн агро-цаг уурын үзүүлэлт

д/д	Бүсийн дугаар	Хамрагдах сумдын нэр	Нийт ашиглагдах талбай /га/	Ашиглаж байгаа талбай /га/	Агаарын чийгшил	Ургамал ургах хоногийн тоо	Жилд унах хур тундас мм
1	2	3	4	5	6	7	8
1	1-р бүс	Жаргалант	812	119.3	40-68% буюу чийглэгдүү	112-153	250 мм
2		Заг	231	59			
3		Галуут	140.2	87.8			
4		Эрдэнэцогт	73.3	25.52			
5		Өлзийт	565	246			
6		Баян-овоо	89.5	72.62			
7		Баянхонгор	103.21	84.67			
ДҮН			2014.21	635.91			
8	2-р бүс	Бөмбөгөр	220.7	82	35-63 % буюу хуурайдуу	136-162	100-150 мм
9		Бууцагаан	152	125.54			
10		Баацагаан	908	38.96			
11		Баянцагаан	170.7	73.2			
ДҮН			1451.4	319.7			
12	3-р бүс	Жинст	7.5	7.5	33-57% буюу хуурай	182-218	50-100 мм
13		Богд	13.6	13.6			
14		Баянлиг	194	16.7			
15		Баянговь	97.4	17.19			
16		Шинэжинст	29	19			
17		Баянөндөр	5	5			
ДҮН			339	78.99			
18	4-р бүс	Хүрээмарал	9.7	6.5	45-70 буюу чийглэгдүү	109-152	160-210 мм
19		Баянбулаг	4.9				
20		Гурванбулаг	6.3	0.1			
ДҮН			20.9	6.6			
НИЙТ ДҮН			3825.51	1041.2			

Эх үүсвэр: Тариалангийн талбайн нэгдсэн тооллого хийх ажлын хэсэг

Тус аймгийн тариалангийн газрын бүсчлэлийг талбайн төлөв байдал, хөрсний төрөл, механик бүрэлдэхүүн, талбайн өндөржилт ба налуужилт, чулуужилт, элэгдэл эвдрэл, агрохимийн шинж чанар, уур амьсгалын онцлог, усны хүрэлцээ хангамж, зам харгуй, шугам сүлжээ дайрсан эсэх зэрэг унаган болон ашиглалтын явцад гарсан өөрчлөлтүүд зэргийг үндэслэн 4 бүс болгон хуваана. Үүнд:

1-Р БҮС: Тус бүсэд хамрагдах Заг, Жаргалант, Галуут, Эрдэнэцогт, Өлзийт, Баян-овоо, Баянхонгор зэрэг сумдын тариалангийн талбай нь Байдраг, Түйн голын сав газраар болон нутгийн жижиг гол горхи булаг шандын хөлөөр ус бараадан байрлах учир харьцангуй усан хангамж сайтай, бага оврын услалтын систем түшиглэсэн байдаг. Байдраг, Түйн голын хөндийд аллювийн хурдас дээр тогтсон аллювийн нугын хөрсний хэв шинж дангаараа ноёлох бөгөөд заримдаа аллювийн нугын сулавтар хөгжилтэй хөрс, голын хайрган хөрстэй бүрдэл үүсгэн тархана. Эдгээр хөрсүүд нь бүгд голын хөндийг дагасан нэгэн төрлийн гадаргад ихэвчлэн бүрдэл болон тархдаг, хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 20-40 см, ялзмаг агууламж 1.2-1.6%, ерөнхий азот 0.06-0.08 % байх ба үе давхарга доошлох тутам энэ хэмжээ буурдаг бөгөөд хөдөлгөөнт фосфор, калийн агууламжаар ядуувтар, ердийн цайвар хүрэн хөрстэй ойролцоо байна.

2-Р БҮС: Бөмбөгөр, Бууцагаан, Баацагаан, Баянцагаан зэрэг хангайгаас говьруу шилжих завсрын бүс нутагт дунд зэргийн зузаан, хөнгөн шавранцар цайвар хүрэн хөрс тархана. Уг хөрсний хүрэн хөрснөөс ялгагдах нэг онцлог гэвэл ялзмагт үе нимгэн, ялзмагийн агууламж болон бусад шим тэжээлийн бодисын агууламжаар бага байдаг явдал юм. Тухайлбал, ялзмагт үеийн зузаан дунджаар 22 см, хэлбэлзэл нь 20-30 см, ялзмаг агууламж дээд үе давхаргадаа 1,0-2,5%, ерөнхий азот 0,10% байх ба үе давхарга доошлох тутам энэ хэмжээ эрс буурна. Хөдөлгөөнт фосфор, калийн агууламжаар хангалтгүй, хүрэн хөрснөөс бага, 100 гр хөрсөндөө 1.4-2.0 мг фосфор, 4.8-5.3 мг кали агуулна.

3-Р БҮС: Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баянөндөр зэрэг урд талын сумд нь цөлөрхөг хээрийн болон говь цөлийн бүсэд багтах учир хөрс үүсэх үйл явц нь газарзүйн болон цаг уурын өвөрмөц онцлогтой уялдан ялзмагт үе нимгэн, үржил шимээр ядуувтар механик бүрэлдэхүүний хувьд голдуу хөнгөн элсэнцэр, хөнгөн шавранцар байна. Уг хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 22 см бөгөөд 21-24 см-т хэлбэлзэнэ, ялзмаг агууламж 0,86-1,1%, ерөнхий азот 0,02-0,09%, Хөдөлгөөнт фосфор, калийн агууламжаар хангалтгүй, ядуувтар, 100 г хөрсөндөө 1.4 мг фосфор, 10.0 мг кали агуулна. Энэ хэмжээ нь ХАА-н таримлын бүрэн дүүрэн ургац авахад шаардлагыг хангаж чадахгүй байна.

4-Р БҮС: Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг зэрэг сумдууд хангайн нурууны төв хэсэгт д.т.дээш 2000-3000 метрийн өндөрт орших өндөр уулт, ойт хээрийн бүсэд хамаарагдана. Хөрс нь ялзмагт үеийн зузаан дунджаар 20-30 см, ялзмаг агууламж 1,2-1,6%, ерөнхий азот 1.2-1.6%, байх ба үе давхарга доошлох тутам энэ хэмжээ нь буурна. Тус сумдын тариалангийн газрын хөрс нь үржил шим, шинж чанарын хувьд ерөнхийдөө ядуувтар учир ХАА-н таримал тариалахад хөрс сайжруулалт хийж, тухайн таримлын онцлогт тохируулан эрдэс болон шим бордоог зайлшгүй хэрэглэх шаардлагатай юм. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд ихэвчлэн хөнгөн элсэнцэр бүтэцтэй байгаа нь хөрс салхийг тэсвэрлэх чадвар муутай гэсэн үг.

1.2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Олон хүчин зүйлийн шинжилгээний арга нь ГЗМС-н технологи дээр суурилдаг (Baban and Wan-Yusof, 2003). Судалгаа нь дараахь хоёр үе шаттай: Мэдээллийг бэлтгэх ба олон хүчин зүйлийн шинжилгээ хийх гэсэн хоёр үе шаттай: Эхний үе шатанд төлөвлөлтийн хамгийн энгийн шаардлагыг хангах суурь нөхцөлийг тогтооно. Хоёрдугаар шатанд олон хүчин зүйлийн дүн шинжилгээг АНР (АНР Аналитик шатлан эрэмбэлэх математик). програм хангамжийг ашиглан жинлэсэн дунджаар тогтооно. Суурь нөхцөлийн болон хүчин зүйлийн судалгааг Ландсат 8, Google earth хиймэл дагуулын мэдээ, GDEM 30 метрийн өндрийн тоон загварын зургуудыг ашиглаж сургалттай болон сургалтгүй ангиллын аргаар газрын бүрхэвчийн ангиллыг тогтоосон.

1.2.1 Суурь нөхцөлийн үнэлгээ

Constrain буюу суурь нөхцөлийн зураг гаргахад тариалангийн талбай, нуур, хот суурины тэг гортиг, малчдын улирлын байршлын ашиглалтын хил, зааг гэх мэт нөхцөлүүдийг харгалзан Constraint буюу суурь нөхцөлийн зургийг гаргасан. Ингэхдээ сонгон авсан үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн зураг үүсгэж, зургуудыг давхцуулж хадлан авах тохиромжтой газрыг сонгох дүн шинжилгээг Erdas Imagine програм дээр хийсэн (Хүснэгт- 2).

Хүснэгт-2. Тариалангийн газрын байршил тогтоох шалгуур


Шалгуур үзүүлэлт, өгөгдлүүд		Ач холбогдол
Хөдөө аж, ахуйн зориулалттай газар		
1	Суурьшлын бүсэд байх ёсгүй	Аюулгүй байдал
2	Ойн бүсээс хол байх	Байгаль орчин/Нөөц
3	Газрын налуу хэвгий 12 градусаас бага байх	Аюулгүй байдал/ Байгаль орчин
4	Хөрсний чийгшил ихтэй газраас хол байх	Аюулгүй байдал/ Байгаль орчин
5	Үржил шимгүй газар сонгохгүй байх	Байгаль орчин/Эдийн засаг
6	Голтой ойр боловч хамгаалалтын бүсэд биш байх	Эдийн засаг/ Аюулгүй байдал/ Байгаль орчин
7	Хөрсний чанар, ургамлын гарц сайтай газарт байх (NDVI)	Эдийн засаг
8	Дархан цаазтай болон Тусгай хамгаалалттай газарт байршаагүй байх	Байгаль орчин/Нөөц
9	Байгалийн сэргээгдэх эрчим хүч ашиглах бололцоотой газарт байх (aspect)	Эдийн засаг/Байгаль орчин

Суурь нөхцөлийн зургийг дээрхи хүчин зүйлийг харгалзан Boolean зургийн аргаар хийдэг. Булеан зураг дээр өгөгдлийн утга нь 0 болон 1 гэсэн хоёр утгын нөхцөлтэй. 0 нөхцөл нь боломжгүй буюу зөвшөөрөхгүй нөхцөл, 1 гэсэн нөхцөлт утга нь зөвшөөрөх буюу боломжит утгыг илэрхийлнэ байна (Зураг-1).



Зураг-1. Тариалангийн газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл

Дээрх зургийг Boolean зургийн нөхцөлт утгын аргыг ашиглан зурагласан бөгөөд 0 утгатай гарч байгаа газруудыг тохиромжгүй гэж үзнэ. Зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн. Дээрх суурь нөхцөлийн зургуудыг нэгтгэж нэгдсэн үнэлгээний зургийг гаргасан (Зураг-2).



Зураг-2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн нэгдсэн үнэлгээ

Дээрх зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн.

1.2.2 Хүчин зүйлийн үнэлгээ


Тохиромжтой байдлын үнэлгээнд олон хүчин зүйл ашиглаж байгаа (factor) үед энэ аргыг хэрэглэнэ. Олон хүчин зүйлүүдийг хооронд нь харьцуулахад нэг нь нөгөөгөөсөө илүү ач холбогдолтой ба эзлэх жингийн хувьд өндөр жин дарна. Шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэхдээ АНР (analytical hierarchy process) буюу шатлан захирах дүн шинжилгээний аргыг ашигласан (Saaty 1977). Энэ арга нь шалгуур үзүүлэлтийн эрэмбэлэлтийн матрицаар жингийн утгыг тодорхойлдог.

Сонгон авсан хүчин зүйлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэлтийн матрицыг ашиглан жингийн утгыг тодорхойлохын тулд судалгаанд ашиглагдаж буй хүчин зүйлийг хадлангийн талбайн тохиромжтой байдалд нөлөөлөх ач холбогдлоор эрэмбэлсэн (Хүснэгт-3).

Хүснэгт-3. Тариалангийн газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь

№	Хүчин зүйл	Эрэмбэ	Харьцангуй жин
1	Хөрсний төрөл	1	0.2901
2	Ялзмаг	2	0.2099
3	Ялзмагт үеийн зузаан	3	0.1516
4	Механик бүрэлдэхүүн	4	0.1095
5	Хур тунадас	5	0.0788
6	Өндөршил	6	0.0563
7	Голын нягтшил	7	0.0400
8	Налуу	8	0.0284
9	Чулуу	9	0.0203
10	Зүг зовхис	10	0.0151
CR=0.0615			


Дээрх эрэмбэлэлтээс хамгийн ач холбогдолтой нь газрын гадаргын налуу болон хөрсний тогтвортой байдал, хамгийн ач холбогдол багатай нь хөрсний гүний усний түвшин гэж тооцоод хүчин зүйлүүдийг эрэмбэлсэн. Эрэмбэлэлтийн матрицаар тооцон гаргасан жингийн утга хэр зэрэг үнэнд нийцэж байгаа consistency ratio буюу нийцлийн харьцааны индексээр тооцож үзэхэд 0.0615 байгаа нь хүчин зүйлийн хоорондын харьцаа зохицол сайтай болох нь батлагдаж байна.



Зураг-3. Тариалангийн газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээ

Дээрх хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний зургийг радиометрийн заслын тусламжтайгаар бүх зургийг 0-255 хооронд нь утга авахуулж засвар хийж зурагласан бөгөөд өндөр утга авах тусам маш тохиромжтой, бага утга авах тусам нэн тохиромжгүй газар нутаг юм.

Тариалангийн газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн болон хүчин зүйлүүдийн нэгдсэн зургийг гаргасан (Зураг-4.).



Зураг-4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зургийг тохиромжтой байдлаар нь тохиромжтой, дунд зэрэг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромжгүй, суурь нөхцөл гэж ангилан авч үзлээ (Хүснэгт-4).

Хүснэгт-4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

№	Тохиромжтой байдлын ангилал	Талбай, га	Эзлэх, хувь
1	Нэн тохиромжтой		
2	Тохиромжтой		
3	Дунд зэрэг тохиромжтой	375902	3.25
4	Хязгаарлагдмал тохиромжтой	1977545	17.12
5	Тохиромжгүй	5043513	43.66
6	Газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл	4155536	35.97
Нийт		11552495	100.00

Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний үр дүнгээс одоо ашиглагдаж байгаа газар ашиглалтын суурь нөхцөлүүдийг хасаж тооцоо хийхэд аймгийн нийт нутаг дэвсгэрийн 3.25 хувь буюу 375902 га нь дунд зэрэг тохиромжтой, 17.12 хувь буюу 1977545 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 43.66 хувь буюу 5043513 га нь тохиромжгүй, 35.97 хувь буюу 4155536 га нь газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл гэж тус тус гарч байна.

1.3 Тариалангийн газрын ашиглалтын одоогийн байдал

Тус аймаг нь монгол орны физик газар зүйн мужлалаар Говь-Алтайн нурууны баруун хэсэгт далайн түвшинээс дээш 696-3945 метрийн өндөрт орших бөгөөд хангай говь хосолсон өргөн уудам нутаг дэвсгэртэй.

2019-2020 оны хооронд хийгдсэн газрын нэгдмэл сангийн шинэчилсэн тооллогын үр дүнгээр 9300 орчим га тариалангийн талбай бүртгэгдсэнээс хөрсний үржил шим, усны хүрэлцээ хангамжаас шалтгаалан 2450 га талбайг ашиглах боломжтой гэсэн судалгаатай байна. Гэвч сүүлийн 5 жилийн дүнгээр 550-900 орчим га талбайг ашиглан тариалалт хийж байна. Аймгийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин 10 хүрэхгүй хувьтай байгаа бөгөөд тариалан эрхлэгчдийн 87 хувь нь талбайгаа энгийн аргаар 13 хувь нь инженерийн хийцтэй усалалтын системээс усалдаг. 2017 оны байдлаар хаврын тариалалтаар нийт 907.8 га талбайд (төмс 205 га, хүнсний ногоо 111 га, тэжээлийн ургамал 293 га гэх мэт) тариалалт хийсэн нь өмнөх оны дүнгээс 16 хувиар өссөн байна. Төмсний хэрэгцээний 55%, хүнсний ногооны хэрэгцээний 20%-ийг аймагтаа тарьж ургуулсан бүтээгдэхүүнээр хангаж байна.

Хангайн тариалангийн бүсийн Бөмбөгөр, Жаргалант, Галуут сумдад тэжээлийн ургамал тариалах үйл ажиллагааг бодлогоор дэмжиж бага оврын тэжээлийн үйлдвэр байгуулах болон аймгийн төв болон ойр орших сумдуудад өвөл, зуны цогцолбор хүлэмжийн аж ахуйг байгуулж хөгжүүлэх шаардлагатай гэж сум орон нутгийн удирдлагаас санал дэвшүүлсэн.

Стандартын шаардлага хангасан 300-1000 хүртэл тн багтаамжтай хөргүүр, агааржуулагчтай зoorь агуулах барьж ашиглалтад оруулах нт зүйтэй юм. “Хүнсний ногоо”, “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд тариалах талбайг 1500 – 2000 га-д хүргэх, Талын толгой зэрэг услалтын системүүдийг хүчин чадалыг бүрэн ашиглах, таримлын нэр төрөл, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, борлуулалтын нэгдсэн сүлжээ байгуулж, өрсөлдөх чадварыг бий болгох замаар тариалах талбай, хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, хангамжийг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 17 сумын 71 иргэн аж ахуйн нэгжийн эзэмшилд нийт 8718 м² талбай бүхий 94 ширхэг хүлэмж ашиглагдаж 8 нэр төрлийн нарийн ногоог тариалан зах зээлд борлуулсан байна. Мөн 2020 онд төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 38 м²-ийн 4 улирлын загвар хүлэмжийг барьж ашиглалтад оруулан 3 удаагийн танилцуулга сургалтыг зохион байгуулжээ. Газар тариалангийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй 11 сумын 1457 тн-ийн багтаамжтай 53 ширхэг энгийн нүхэн зoorь одоогоор ашиглагдаж байна. Энэ онд GIZ төслийн 15 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10-20 тн багтаамж бүхий халаалттай зoorийг “Номгоны андууд” ХХК шинээр барьж өөрсдийн хэрэгцээнд ашиглаж эхлээд байгаа. Стандартын шаардлага хангасан зoorь агуулах дутагдалтай байгаагаас тариаланч ногоочид намар ургац хураалтын цагаар төмс хүнсний ногоог хямд үнээр бөөндөж борлуулахын зэрэгцээ хавар тариалах үрээ нөөцөлж үлдээдгүй зэрэг бэрхшээлүүд тулгарсаар байна.

Аймгийн хэмжээнд Хангай, Тал хээр, Говийн бүсэд нийт 2020-2021 онд явагдсан газрын нэгдмэл сангийн тооллого бүртгэлийн судалгааны ажлын хүрээнд 9300 орчим га тариалангийн талбайг бүртгэж зурагласан байна.

Хүснэгт-5. ГНС-ийн шинэчилсэн тооллого, бүртгэгдсэн болон ГКМС-нд эрх нь баталгаажсан тариалангийн талбай, га /2020-2021/

№	Таримлын төрөл	ГНС-ийн шинэчилсэн тооллого, бүртгэгдсэн талбай, га	ГКМС-нд эрх нь баталгаажсан талбай	
			Га	Нэгж талбар
1	Үр тариа	157.81	79.2	8
2	Төмс, хүнсний ногоо	865.42	322.95	217
3	Жимс, жимсгэнэ	298.8	303.1	27
4	Тэжээлийн ургамал	414.78	194.9	13
5	Атаршсан талбай	7566	-	-
Нийт		9302.81	900.15	265

Дээрх хүснэгтээс харахад газар тариалангийн зориулалтаар ашиглах боломжтой 9302 га талбайгаас 900.15 га талбайг давхардсан тоогоор 265 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмших, ашиглах зориулалтаар олгож эрхийг нь баталгаажуулсан байна. Хөдөө аж ахуйн салбарын стратегийн ач холбогдол бүхий хүнсний гол бүтээгдэхүүнүүдийн нэг нь газар тариалангийн салбараас авч буй үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ юм.

Ийм учраас 2020 оны байдлаар Баянхонгор аймгийн хэмжээнд тариалсан талбайн хэмжээ болон хурааж авсан ургацын хэмжээг доорх хүснэгтээр харууллаа (Хүснэгт-6).

Хүснэгт-6. Тариалсан нийт талбай болон хурааж авсан ургацын хэмжээ (2010-2020)

Сум	Тариалсан талбай, га					Хураасан ургац, тн				
	2010	2017	2018	2019	2020	2010	2017	2018	2019	2020
Баянхонгор	533	752	543	589	561	4008	2368	3320	3357	3210
Баянхонгор	193	159	129	107	96.5	1709	571	1269	857	792
Баацагаан	4.8	8.5	2	2	2.1	28.8	81.7	1.1	3.4	4.4
Баянбулаг	3	3.5			0.5	9.9	15			2.4
Баянговь	10.9	24.6	30.3	34.3	22.2	84	13.3	66.1	98.3	103
Баянлиг	38.2	18	24.5	25.7	32	150	93.2	131	152	192
Баян-Овоо	37	78	78.8	86.1	92.2	211	296	527	592	672
Баян-Өндөр	4.5	2.5	0.5	0.2	0.3	14.9	10.1	1	2.2	0.8
Баянцагаан	9.9	66.3	60.4	58.4	52.6	69.1	87	110	104	72.2
Богд	9.2	0.5	0	0.1	0.6	62.4	2.1	0.1	0.1	9.5
Бөмбөгөр	42.2	13.6	6.2	49	28.3	259	50.7	18.4	148	120
Бууцагаан	44.4	106	0	0	19.4	448	46.5	18.1		79.3
Галуут	4.2	32.6	13.1	12.5	12	8.1	19.8	2.7	66.2	38.8
Гурванбулаг	5.7	1				4.3	1.6			
Жаргалант	4	16.1	5.6	23.2	42.1	41	34.8	20	121	153
Жинст	7.5	6.3	13.3	15.2	16.7	19.2	36.6	30.3	37.8	13.4
Заг	1.9	18.7	5.7	4.7	7.3	4.8	21.7	8.7	22	24.4
Өлзийт	49.3	103	90	85.7	81.1	328	702	797	567	535
Хүрээмарал	4.3	37	34.2	33	0.8	21.4	18.3	15.2	78.3	1.8
Шинэжинст	12.1	11.5	2.3	3.9	6.8	137	13.5	27.4	37.4	46.3
Эрдэнэцогт	47	45.5	47.4	48.3	47.4	399	253	278	470	350

Эх сурвалж: 2020 оны статистикийн эмхэтгэл

Дээрх хүснэгтээс харахад 2010 онд 533 га талбайгаас 4008 тн ургац хурааж авч байсан байна. Гэтэл 2017-2020 оны хооронд талбайн хэмжээ нэмэгдэж 543-752 га талбайд тариалалт хийсэн байна. Харин хурааж авсан ургацын хэмжээ 2368-3357 тн болж буурсан байна.

1.4 Усалгаатай газар тариалан

Баянхонгор аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 онд гаргасан судалгаагаар 681 га талбайд 24 ААН, хоршоо, 344 иргэн тариалалт хийж, тариалалтын төлөвлөгөөг 97,2 хувиар биелүүлсэн хэдий ч усны хүрэлцээгүйгээс 21.9 га талбайн ургац алдаж 659.1 га талбайгаас 3466 тн ургац хураасан байна (Хүснэгт-7).

Хүснэгт-7. Хурааж авсан ургацын хэмжээ

№	Таримлын төрөл	Тариалсан талбай /га/	Хурааж авсан Ургац /тн/
1	Төмс	180.1	1663.6
2	Хүнсний ногоо	123.9	798.8
3	Тэжээлийн ургамал	327	896.3
4	Үр тариа	3	7.6
5	Жимс, жимсгэнэ	25.1	99.8
Нийт		659.1	3466.1

Усалтын систем бүхий сумдаас усалтын системийн нарийвчилсан судалгааг авч нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлсэн. Нийт 9 усалтын системийн 3 нь Хоршоо аж ахуйн нэгжийн эзэмшилд, 1 нь ЗДТГазрын эзэмшилд 5 нь иргэдийн эзэмшилд ашиглагдаж байгаа бөгөөд Одоогийн байдлаар 318 га талбай буюу нийт хүчин чадлын 42,9 хувийг ашиглагдаж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 6,9 хувиар буюу 51,1 га-аар нэмэгдсэн. Өлзийт сумын Бумбатын 96 га-гийн усалтын системийн зураг төслийн ажил бүрэн хийгдэж дууссан бөгөөд Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1928264846 төгрөг. Нийт хөрөнгө оруулалтыг 1-р ээлж, 2-р ээлжид хийгдэх ажлын төрлөөр ялгаж төсвийн тооцоо хийгдсэн. Үүнд : 1-р ээлжийн хөрөнгө оруулалт 936487251 төгрөг, 2-р ээлжийн хөрөнгө оруулалт 991777595 төгрөг тус тус төлөвлөгдсөн тул барьж байгуулахад шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэх санал хүсэлтийг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Энэ онд усалтын системүүдийг бүрэн паспортжуулан ашиглалт хамгаалалтыг сайжруулах тариалалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилт тавин сумдын МЭҮТасгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж 5 \ Цагдуултай, Талын толгой, Цагаан гол, Эхийн гол, Хунзат\ усалтын системийг ХХААХҮЯамнаас ирүүлсэн загвараар паспортжуулан ажиллалаа.

Засгийн газрын Худалдан авах үйл ажиллагааны газраас Баянговь сумын “Цагаан гол”-ын усалтын системийн тендерийг 2014 оны 3 сарын 7-нд зарлаж “Шимт газар” ХХК 287,2 сая төгрөгийн ажил гүйцэтгэн хүлээлгэн өгсөн хэдий ч бүрэн ашиглах боломжгүй эвдэрч гэмтсэн байна.

Хүснэгт-8. Баянхонгор аймагт ашиглагдаж байсан услалтын системийн судалгаа

№	Услалтын системийн нэр, эзэмшигч	Байршил, сум, баг, координат	Одоо тариалж байгаа талбайн хэмжээ, га	Төслийн хүчин чадал, га	Засвар шинэчлэлт хийсэн тухай	Тайлбар	Хөрөнгийн хэмжээ сая/төг
1	Хоолт\”Цахир дэл” хоршоо, н.Амаа\	Баян-Овоо	42	52	2007 онд засварлагдсан	Жимс, хүнсний ногоо тариалдаг, тэжээлийн ургамал нэмж тариалах боломжтой	
2	Борбалгас \ЗДТГ, Зоригт\	Өлзийт	14	92	2008 онд засварлагдсан	ус хүрэлцэхгүй суваг бөглөрсөн	
3	Шаргалжуут\”И х Богд, Г.Батцэнгэл\	Өлзийт	12	58	2009 онд засварлагдсан	Гол татарсаны улмаас усны хүрэлцээ муудсан	
4	Бумбат ЗДТГ	Өлзийт	55	96	Гар усалгаанд шилжсэн 2018 онд засварлах зураг төсөв хийгдсэн	Услалтын систем баригдаснаар гадаргын усны алдагдал буурч талбайг бүрэн ашиглах боломжтой	1928,3
5	Лигийн гол , ЗДТГ	Баянлиг	30	60	2013 онд шинэчлэл, засвар хийгдсэн усны хүрэлцээ нөөц муутай	3 бороожуулагч байсан 1-ийг баянговьд шилжүүлсэн 1 -ийг нь ахмадын цэцэрлэгт мод усалгаанд ашиглаж байгаа	240,9
6	Цагаан гол/ Хургалж/ ЗДТГ	Баянговь	42,5	60	2014 онд 287.549.0 төгрөгийн ажил хийгдсэн өмнөх үндсэн хөрөнгө 680,86 сая төг.	услалтын систем ашиглалтгүй болсон тул голоос сувгаар татаж гар усалгаанд шилжсэн	938,41
7	Эхийн гол, ЗДТГ	Шинэжинст	10,5	20	2009,2013 онд засварлагдсан	Усан сангаасаа усалгаа хийж байгаа	388.5

8	Цагдуулт,ЗДТГ	Баянцагаан	45	60	2013 онд 60 га-д шинэчлэл, засвар хийгдсэн	Тэжээлийн ургамал, төмс хүнсний ногоог нэмж тариалах боломжтой	343.96
9	Хөх эрэг, одоогоор эзэмшилгүй	Баацагаан	0	52	Ашиглалтгүй	Услалтын систем ашиглах боломжгүй	153.9
10	Өлзийт гол, ЗДТГ	Бууцагаан	40	76	2013 онд шинэчлэл, засвар хийгдсэн	Усны хүрэлцээ муутайгаас шалтгааланбүрэн ашиглах боломжгүй байна.	217.8
11	Баян , ЗДТГ	Бууцагаан	15	28	2013 онд шинэчлэл, засвар хийгдсэн		65.4
12	Талын толгой, ЗДТГ	Галуут	15	142	2013 онд 60 га-д шинэчлэл, засвар хийгдсэн	Бороожуулагч ажиллуулахад зардал өндөр гардаг түлш зарцуулалт ихтэй тул сувгийн усалгаагаар бага талбай ашиглаж байгаа	57484.9
13	Хэрсэн, Гэрэлт мөнх ундарга	Баацагаан	15	20	Гүн өрмийн худаг ашиглаж усалгаа хийдэг	2019 оноос эхэлж ашиглаж байна.	
14	Зүүн гол, эзэмшилгүй	Богд	0	0	ашиглалтгүй	Эвдэрч тоногдсон.	
15	Хунзат ЗДТГ	Бөмбөгөр	15	80	Газар эзэмшил болон хашаа хамгаалалтын шалтгаанаар тариалалт бага хийгддэг.	Толгойн барилгын ус тогтоох төв хаалт ажиллагаагүй учир усаа тогтоон барьж чадахгүй байгаа	126.98

Дээрх хүснэгтээс харахад 11 сумын 15 услалтын системийн хүчин чадал нь 896 га талбайг услах бүрэн хүчин чадалтай бөгөөд эвдрэл гэмтлийн улмаас 324 га талбайг усалгаатай газар тариалангийн зориулалтаар ашиглаж байна. Эдгэр услалтын системүүдийн ашиглалтын байдлын нь авч үзвэл бүрэн ашиглалтгүй болсон 2, гар ажиллагаанд шилсэн 6, эвдрэл гэмтэлтэй бүрэн ашиглах боломжгүй 4, бүрэн ашиглах боломжтой 3 услалтын систем байна. Иймээс услалтын системийн хүчин чадлыг бүрэн ашиглахын тулд эвдэрч гэмтсэн услалтын системүүдийг засварлаж ашиглалтанд оруулах шаардлагатай.

Хүснэгт-9. Улсын төсвийн хөрөнгөөр зураг, төсөв нь хийгдсэн услалтын системүүд

Сумын нэр	Ашиглалтанд оруулах услалтын систем	Зураг төсөв хийсэн он	Хөрөнгө оруулалт (сая төг)	Талбайн хэмжээ(га)	Өмчлөгч
Заг	Сайхан тохой	2014	147.92	60	сумын ЗДТГ
Баацагаан	Хөх Эрэг	2013	153.98	52	
Бөмбөгөр	Хотын булан	2013	107.94		
	Бор толгой	2014	101.32		
Өлзийт	Бумбат	2018	1.93	96	
Бүгд			2439.45		

Дээрх эвдэрч гэмтсэн услалтын системүүдийг улсын төсвийн хөрөнгөөр зураг, төсөв нь хийгдсэн боловч засвар шинэчлэлт хийгдээгүй өдий хүрсэн байна.

1.4 Газар тариалангийн хэрэгцээт байдлын үнэлгээ

Хүн амын хүнсний хэрэгцээг тогтоохдоо жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээнд үндэслэн тооцох шаардлагатай байдаг. Газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжийг тодорхойлохдоо одоогийн болон төлөвлөлтийн хугацаан дах үе шатуудаар тооцож гаргасан.

1.4.1 Газар тариалангийн бүтээгдэхүүний одоогийн хэрэгцээ, хангамж

Хүн амын хүнсний хэрэгцээг тогтоохдоо ургацын нийт хэмжээнд өрхийн хураасан ургац, аж ахуйн нэгж байгууллагын хураасан нийт дүнгээр тооцно.

Тариалангийн газраас авч буй нийт ургацын хэмжээ буюу нийлүүлэлт нь хүн амын хүнсний эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгааг тодорхойлох шаардлагатай (Хүснэгт-10).

Хүснэгт-10. Газар тариалангийн бүтээгдэхүүний хангамж /Аймаг нэгдсэн/

Сумд	Хүн ам	Үр тариа				Төмс			
		Хүнсний хэрэгцээнд шаардлагатай хэмжээ, тн	Тариалсан талбай, га	Хурааж авсан ургац, цн	Хангамж хувь	Хүнсний хэрэгцээнд шаардлагатай хэмжээ, тн	Тариалсан талбай, га	Хурааж авсан ургац, цн	Хангамж хувь
Аймаг нэгдсэн	89329	12064	4.3	7.1	0.15	3913	208.1	1818.7	46.48
Баянхонгор	31948	4315	0.5	6	0.85	1399	61.6	602.1	43.0
Баацагаан	3295	445				144	1.2	2.8	1.9
Баянбулаг	1799	243				79	0.1	0.1	0.1
Баянговь	3055	413				134	8	58	43.3
Баянлиг	3881	524	3.5	0.5	0.375	170	7.5	79.3	46.7
Баян-Овоо	2610	352				114	28	364	318.4
Баян-Өндөр	2632	355				115	0.3	0.7	0.6
Баянцагаан	3566	482				156	8.5	14	9.0
Богд	3130	423				137			0.0
Бөмбөгөр	3361	454	0.3	0.6	0.514	147	6	66	44.8
Бууцагаан	3694	499				162	8.5	32	19.8
Галуут	4166	563				182	5.8	15.1	8.3
Гурванбулаг	2321	313				102			
Жаргалант	2931	396				128	5.2	17.1	13.3
Жинст	2261	305				99	3.5	6.2	6.3
Заг	2124	287				93	5	17.8	19.1

Өлзийт	3868	522				169	42	381.3	225.1
Хүрээмарал	1757	237				77	0.8	1.8	2.3
Шинэжинст	2520	340				110	2	5.1	4.6
Эрдэнэцогт	4410	596				193	14.2	155.3	80.4

Үргэлжлэл

Сумд	Хүн ам	Хүнсний ногоо			
		Хүнсний хэрэгцээнд шаардлагатай хэмжээ, тн	Тариалсан талбай, га	Хурааж авсан ургац, цн	Хангамж хувь
Аймаг нэгдсэн	89329	7825	110.1	742.9	9.49
Баянхонгор	31948	2799	28.3	152.5	5.4
Баацагаан	3295	144	0.4	1.6	0.6
Баянбулаг	1799	79	0.4	2.3	1.5
Баянговь	3055	134	4.2	24.8	9.3
Баянлиг	3881	170	6	64.2	18.9
Баян-Овоо	2610	114	14.2	108.4	47.4
Баян-Өндөр	2632	115		0.1	
Баянцагаан	3566	156	3.1	14.2	4.5
Богд	3130	137	0.6	9.5	3.5
Бөмбөгөр	3361	147	2	15.9	5.4
Бууцагаан	3694	162	7.9	29.3	9.1
Галуут	4166	182	3.2	7.7	2.1
Гурванбулаг	2321	102			
Жаргалант	2931	128	0.6	1.3	0.5
Жинст	2261	99	3.2	5.2	2.6
Заг	2124	93	2.3	6.6	3.5
Өлзийт	3868	169	15.6	118.4	34.9
Хүрээмарал	1757	77			
Шинэжинст	2520	110	4.8	41.2	18.7
Эрдэнэцогт	4410	193	13.3	139.7	36.2

Дээрх хүснэгтээс харахад тус аймаг нь газар тариалангийн үйлдвэрлэл харьцангуй сул хөгжсөн бөгөөд 2020 оны байдлаар аймгийн нийт хүн амын хүнсний ногооны хэрэгцээг төмсний 46 хувь, хүнсний ногооны 9.49 хувь, үр тарианы 0.15 хувийг тус тус хангаж байна.

1.4.2 Газар тариалангийн бүтээгдэхүүний ирээдүйн хэрэгцээ, хангамж

Хүн амын хүнсний хэрэгцээг тооцохдоо Монгол улсын эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” тушаалаар батлагдсан нормыг баримтласан бөгөөд уг тушаалын 4-р хавсралт болох “Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г баримтлав.

Баянхонгор аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарын стратегийн ач холбогдол бүхий хүнсний гол бүтээгдэхүүнүүдийн нэг газар тариалангийн салбараас авч буй үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хэрэгцээг төлөвлөлтийн хугацаан дах хүн амын өсөлттэй уялдуулан хэрэгцээг тооцоолж гаргасан.

Хүн амын өсөлт, бүтцийг тооцохдоо Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 12-р сарын 15-ны 1/149 тоот тушаалын хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалын дагуу тооцсон болно. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2022-2037 оныг дуустал хэрэгжихээр төлөвлөсөн учир хүн амын өсөлт, бүтцийг тооцохдоо 15 жилийн хугацаагаар тооцсон (Хүснэгт-11).

Хүснэгт-11. Төлөвлөлтийн жилүүд дэх хүн амын өсөлтийн тооцоолол

Сумд	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
Аймаг нэгдсэн	89329	90139	90957	91782	92614	93454	94302	95157	96020	96891
Баянхонгор	31948	32238	32530	32825	33123	33423	33727	34032	34341	34653
Баацагаан	3295	3325	3355	3385	3416	3447	3478	3510	3542	3574
Баянбулаг	1799	1815	1832	1848	1865	1882	1899	1916	1934	1951
Баянговь	3055	3083	3111	3139	3167	3196	3225	3254	3284	3314
Баянлиг	3881	3916	3952	3988	4024	4060	4097	4134	4172	4210
Баян-Овоо	2610	2634	2658	2682	2706	2731	2755	2780	2806	2831
Баян-Өндөр	2632	2656	2680	2704	2729	2754	2779	2804	2829	2855
Баянцагаан	3566	3598	3631	3664	3697	3731	3765	3799	3833	3868
Богд	3130	3158	3187	3216	3245	3275	3304	3334	3364	3395
Бөмбөгөр	3361	3391	3422	3453	3485	3516	3548	3580	3613	3646
Бууцагаан	3694	3728	3761	3795	3830	3865	3900	3935	3971	4007
Галуут	4166	4204	4242	4280	4319	4358	4398	4438	4478	4519
Гурванбулаг	2321	2342	2363	2385	2406	2428	2450	2472	2495	2517
Жаргалант	2931	2958	2984	3011	3039	3066	3094	3122	3151	3179
Жинст	2261	2282	2302	2323	2344	2365	2387	2409	2430	2452
Заг	2124	2143	2163	2182	2202	2222	2242	2263	2283	2304
Өлзийт	3868	3903	3938	3974	4010	4047	4083	4120	4158	4195
Хүрээмарал	1757	1773	1789	1805	1822	1838	1855	1872	1889	1906
Шинэжинст	2520	2543	2566	2589	2613	2636	2660	2684	2709	2733
Эрдэнэцогт	4410	4450	4490	4531	4572	4614	4656	4698	4740	4783

Үргэлжлэл

Сумд	2030	2031	2032	2033	2034	2035	2036	2037
Аймаг нэгдсэн	97770	98657	99552	100454	101366	102285	103213	104149
Баянхонгор	34967	35284	35604	35927	36253	36582	36913	37248
Баацагаан	3606	3639	3672	3705	3739	3773	3807	3842
Баянбулаг	1969	1987	2005	2023	2041	2060	2079	2097
Баянговь	3344	3374	3405	3435	3467	3498	3530	3562
Баянлиг	4248	4286	4325	4364	4404	4444	4484	4525
Баян-Овоо	2857	2883	2909	2935	2962	2989	3016	3043
Баян-Өндөр	2881	2907	2933	2960	2987	3014	3041	3069
Баянцагаан	3903	3938	3974	4010	4046	4083	4120	4158
Богд	3426	3457	3488	3520	3552	3584	3616	3649
Бөмбөгөр	3679	3712	3746	3780	3814	3848	3883	3919
Бууцагаан	4043	4080	4117	4154	4192	4230	4268	4307
Галуут	4560	4601	4643	4685	4727	4770	4813	4857
Гурванбулаг	2540	2563	2587	2610	2634	2658	2682	2706
Жаргалант	3208	3237	3266	3296	3326	3356	3387	3417
Жинст	2475	2497	2520	2543	2566	2589	2612	2636
Заг	2325	2346	2367	2389	2410	2432	2454	2476
Өлзийт	4233	4272	4311	4350	4389	4429	4469	4510
Хүрээмарал	1923	1940	1958	1976	1994	2012	2030	2048
Шинэжинст	2758	2783	2808	2834	2860	2885	2912	2938
Эрдэнэцогт	4827	4870	4915	4959	5004	5050	5095	5142

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд байдлаар 89329 хүн ам тоологдсон бөгөөд төлөвлөлтийн 15 жилийн хугацаанд 104149 хүн ам болж 14820 хүн амаар өсөх тооцоо гарч байна.

Хүн амын хүнсний хэрэгцээг тооцох нь АГЗБЕТ нь үзэл баримтлалд тусгасан хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний хангамж хүртээмжийг сайжруулах, аюулгүй нөөц бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай газрыг төлөвлөхөд гол үндэслэл болно.

Дээрх хүн амын өсөлтийн тооцоололдоо тулгуурлан хүн амд шаардагдах хүнсний хэрэгцээг тооцоолохдоо Эрүүл мэндийн сайдын 2017 оны а/74 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан нэг хүнд шаардагдах жилийн дундаж хүнсний хэрэглээний нормыг баримталсан.

Хүснэгт-12. Нэг хүний жилийн дундаж хүнсний хэрэгцээ (г/хүн)

Эрүүл мэндийн сайдын 2017 оны а/74 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Хоногт хэрэглэх хэмжээ (г)	Үндсэн шимт бодисууд (г)						Нүүрс ус	Илчлэг (ккал)
		Уураг			Тос				
		Нийт	үүнээс		Нийт	үүнээс			
амьтны	ургамлын		амьтны	ургамлын					
Малын мах	120	19	19		12	12			180
Загас	30	5	5		4	4			60
Шувууны мах	40	8	8		3	3			63
Сүү (үнээний сүү, 3.2% тос)	160	5	5		5	5		8	95
Цагаан идээ (тараг)	180	5	5		6	6		7	102
Гурил	100	13		13	1		1	74	357
Гурилан бүтээгдэхүүн	180	14		14	2		2	125	575
Төрөл бүрийн будаа	50	4		4	0		0	31	140
Төмс	120	2		2	0		0	24	108
Хүнсний ногоо	260	3		3	0		0	18	85
Буурцагт ургамал	40	8		8	1		1	20	119
Жимс, жимсгэнэ	200	1		1	0		0	20	82
Өндөг	20	3	3	0	2		2	0	32
Ургамлын тос	23				23		23		207
Цөцгийн тос, 72% тослог	10				7	7			66
Сахар, чихрийн зүйл	33							33	128
БҮГД	1563	90	45	45	67	37	30	360	2400
Үндсэн шимт бодисын илчлэг		360			600			1440	
Үндсэн шимт бодисын илчлэгийн эзлэх хувь		15%			25%			60%	

Тайлбар: Илчлэгийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг харьцангуй эрүүл монгол хүний хүнсний бүтээгдэхүүний хоногийн дундаж хэрэглээн дээр үндэслэн тогтоов.

Дээрх стандартаар батлагдсан нэг хүнд шаардагдах жилийн дундаж хүнсний хэрэглээний нормыг баримтлан Баянхонгор аймгийн хэмжээнд газар тариалангийн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг тооцоолж гаргасан (Хүснэгт..13.).

Хүснэгт-13. Газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэгцээ

Сумд	Хүн ам	Хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай хэмжээ /тн/											
		Үр тариа			Төмс	Хүнсний ногоо					Нарийн ногоо /Хүлэмж/		
		Буудай	Арвай	Буурцагт ургамал		Байцаа	Лууван	Манжин	Сонгино	Сармис	Улаан лооль	Өргөст хэмх	Чинжүү
2020 он													
Аймаг нэгдсэн	89329	9129	1630	1304	3913	3261	2608	978	652	326	326	489	163
Баянхонгор	31948	3265	583	466	1399	1166	933	350	233	117	117	175	58
Баацагаан	3295	337	60	48	144	120	96	36	24	12	12	18	6
Баянбулаг	1799	184	33	26	79	66	53	20	13	7	7	10	3

Баянхонгор аймгийн зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө. Боть 4

Баянговь	3055	312	56	45	134	112	89	33	22	11	11	17	6
Баянлиг	3881	397	71	57	170	142	113	42	28	14	14	21	7
Баян-Овоо	2610	267	48	38	114	95	76	29	19	10	10	14	5
Баян-Өндөр	2632	269	48	38	115	96	77	29	19	10	10	14	5
Баянцагаан	3566	364	65	52	156	130	104	39	26	13	13	20	7
Богд	3130	320	57	46	137	114	91	34	23	11	11	17	6
Бөмбөгөр	3361	343	61	49	147	123	98	37	25	12	12	18	6
Бууцагаан	3694	378	67	54	162	135	108	40	27	13	13	20	7
Галуут	4166	426	76	61	182	152	122	46	30	15	15	23	8
Гурванбулаг	2321	237	42	34	102	85	68	25	17	8	8	13	4
Жаргалант	2931	300	53	43	128	107	86	32	21	11	11	16	5
Жинст	2261	231	41	33	99	83	66	25	17	8	8	12	4
Заг	2124	217	39	31	93	78	62	23	16	8	8	12	4
Өлзийт	3868	395	71	56	169	141	113	42	28	14	14	21	7
Хүрээмарал	1757	180	32	26	77	64	51	19	13	6	6	10	3
Шинэжинст	2520	258	46	37	110	92	74	28	18	9	9	14	5
Эрдэнэцогт	4410	451	80	64	193	161	129	48	32	16	16	24	8
2027 он													
Аймаг нэгдсэн	95157	9725	1737	1389	4168	3473	2779	1042	695	347	347	521	174
Баянхонгор	34032	3478	621	497	1491	1242	994	373	248	124	124	186	62
Баацагаан	3510	359	64	51	154	128	102	38	26	13	13	19	6
Баянбулаг	1916	196	35	28	84	70	56	21	14	7	7	10	3
Баянговь	3254	333	59	48	143	119	95	36	24	12	12	18	6
Баянлиг	4134	423	75	60	181	151	121	45	30	15	15	23	8
Баян-Овоо	2780	284	51	41	122	101	81	30	20	10	10	15	5
Баян-Өндөр	2804	287	51	41	123	102	82	31	20	10	10	15	5
Баянцагаан	3799	388	69	55	166	139	111	42	28	14	14	21	7
Богд	3334	341	61	49	146	122	97	37	24	12	12	18	6
Бөмбөгөр	3580	366	65	52	157	131	105	39	26	13	13	20	7
Бууцагаан	3935	402	72	57	172	144	115	43	29	14	14	22	7
Галуут	4438	454	81	65	194	162	130	49	32	16	16	24	8
Гурванбулаг	2472	253	45	36	108	90	72	27	18	9	9	14	5
Жаргалант	3122	319	57	46	137	114	91	34	23	11	11	17	6
Жинст	2409	246	44	35	105	88	70	26	18	9	9	13	4
Заг	2263	231	41	33	99	83	66	25	17	8	8	12	4
Өлзийт	4120	421	75	60	180	150	120	45	30	15	15	23	8
Хүрээмарал	1872	191	34	27	82	68	55	20	14	7	7	10	3
Шинэжинст	2684	274	49	39	118	98	78	29	20	10	10	15	5
Эрдэнэцогт	4698	480	86	69	206	171	137	51	34	17	17	26	9
2032 он													
Аймаг нэгдсэн	99552	10174	1817	1453	4360	3634	2907	1090	727	363	363	545	182
Баянхонгор	35604	3639	650	520	1559	1300	1040	390	260	130	130	195	65
Баацагаан	3672	375	67	54	161	134	107	40	27	13	13	20	7
Баянбулаг	2005	205	37	29	88	73	59	22	15	7	7	11	4
Баянговь	3405	348	62	50	149	124	99	37	25	12	12	19	6
Баянлиг	4325	442	79	63	189	158	126	47	32	16	16	24	8

Баян-Овоо	2909	297	53	42	127	106	85	32	21	11	11	16	5
Баян-Өндөр	2933	300	54	43	128	107	86	32	21	11	11	16	5
Баянцагаан	3974	406	73	58	174	145	116	44	29	15	15	22	7
Богд	3488	356	64	51	153	127	102	38	25	13	13	19	6
Бөмбөгөр	3746	383	68	55	164	137	109	41	27	14	14	21	7
Бууцагаан	4117	421	75	60	180	150	120	45	30	15	15	23	8
Галуут	4643	474	85	68	203	169	136	51	34	17	17	25	8
Гурванбулаг	2587	264	47	38	113	94	76	28	19	9	9	14	5
Жаргалант	3266	334	60	48	143	119	95	36	24	12	12	18	6
Жинст	2520	258	46	37	110	92	74	28	18	9	9	14	5
Заг	2367	242	43	35	104	86	69	26	17	9	9	13	4
Өлзийт	4311	441	79	63	189	157	126	47	31	16	16	24	8
Хүрээмарал	1958	200	36	29	86	71	57	21	14	7	7	11	4
Шинэжинст	2808	287	51	41	123	103	82	31	21	10	10	15	5
Эрдэнэцогт	4915	502	90	72	215	179	144	54	36	18	18	27	9
2037 он													
Аймаг нэгдсэн	104149	10644	1901	1521	4562	3801	3041	1140	760	380	380	570	190
Баянхонгор	37248	3807	680	544	1631	1360	1088	408	272	136	136	204	68
Баацагаан	3842	393	70	56	168	140	112	42	28	14	14	21	7
Баянбулаг	2097	214	38	31	92	77	61	23	15	8	8	11	4
Баянговь	3562	364	65	52	156	130	104	39	26	13	13	20	7
Баянлиг	4525	462	83	66	198	165	132	50	33	17	17	25	8
Баян-Овоо	3043	311	56	44	133	111	89	33	22	11	11	17	6
Баян-Өндөр	3069	314	56	45	134	112	90	34	22	11	11	17	6
Баянцагаан	4158	425	76	61	182	152	121	46	30	15	15	23	8
Богд	3649	373	67	53	160	133	107	40	27	13	13	20	7
Бөмбөгөр	3919	400	72	57	172	143	114	43	29	14	14	21	7
Бууцагаан	4307	440	79	63	189	157	126	47	31	16	16	24	8
Галуут	4857	496	89	71	213	177	142	53	35	18	18	27	9
Гурванбулаг	2706	277	49	40	119	99	79	30	20	10	10	15	5
Жаргалант	3417	349	62	50	150	125	100	37	25	12	12	19	6
Жинст	2636	269	48	38	115	96	77	29	19	10	10	14	5
Заг	2476	253	45	36	108	90	72	27	18	9	9	14	5
Өлзийт	4510	461	82	66	198	165	132	49	33	16	16	25	8
Хүрээмарал	2048	209	37	30	90	75	60	22	15	7	7	11	4
Шинэжинст	2938	300	54	43	129	107	86	32	21	11	11	16	5
Эрдэнэцогт	5142	525	94	75	225	188	150	56	38	19	19	28	9

Тус аймаг нь 2020 оны байдлаар аймгийн нийт хүн амын хүнсний ногооны хэрэгцээг төмсний 46 хувь, хүнсний ногооны 9.46 хувь, үр тарианы 0.15 хувийг тус тус хангаж байна. Эндээс үзэхэд тус аймагт газар тариалангийн үйлдвэрлэл харьцангуй сул хөгжсөн бөгөөд төлөвлөлтийн үе шатны жилүүдэд хүн ам өсөхийн хэрээр газар тариалангийн хэрэгцээт бүтээгдэхүүн нэмэгдэж байна.

1.5 Тариалангийн газрын төлөвлөлт

Төлөвлөлтийн хугацаан дах хүн амын өсөлт, бүтцийг тооцохдоо Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 12-р сарын 15-ны 1/149 тоот тушаалын хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалын дагуу тооцсон болно. Энэхүү хүн амын өсөлтийн тооцоололд тулгуурлан хүн амд шаардагдах хүнсний хэрэгцээг төлөвлөлтийн үе шатуудаар тооцоолж гаргасан. Цаашид төлөвлөлтийн үе шатуудад нэмэгдүүлэх шаардлагатай бүтээгдэхүүний хэмжээг тооцоолоход төмс, хүнсний ногоо, үр тариа үйлдвэрлэлээр хүн амын хэрэгцээг хангахад шаардагдах газрын хэмжээг гаргав (Хүснэгт-14).

Хүснэгт-14. Хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай талбайн хэмжээ, га

Сумд	Хүн амын тоо	Хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай талбайн хэмжээ, га-аар											
		Үр тариа			Төмс	Хүнсний ногоо					Нарийн ногоо /Хүлэмж/		
		Буудай	Арвай	Буурцагт ургамал	Төмс	Байцаа	Лууван	Манжин	Сонгино	Сармис	Улаан лооль	Өргөст хэмх	Чинжүү
Га-ийн ургацын дундаж хэмжээ /цн/га/		12.2	21.2	11.1	87	76.3	77.1	106	112	62.3	12.2	21.3	11.1
Аймаг нэгдсэн	89329	7483	769	1175	450	427	338	92	58	52	267	230	147
Баянхонгор	31948	2676	275	420	161	153	121	33	21	19	96	82	53
Баацагаан	3295	276	28	43	17	16	12	3	2	2	10	8	5
Баянбулаг	1799	151	15	24	9	9	7	2	1	1	5	5	3
Баянговь	3055	256	26	40	15	15	12	3	2	2	9	8	5
Баянлиг	3881	325	33	51	20	19	15	4	3	2	12	10	6
Баян-Овоо	2610	219	22	34	13	12	10	3	2	2	8	7	4
Баян-Өндөр	2632	220	23	35	13	13	10	3	2	2	8	7	4
Баянцагаан	3566	299	31	47	18	17	14	4	2	2	11	9	6
Богд	3130	262	27	41	16	15	12	3	2	2	9	8	5
Бөмбөгөр	3361	282	29	44	17	16	13	3	2	2	10	9	6
Бууцагаан	3694	309	32	49	19	18	14	4	2	2	11	9	6
Галуут	4166	349	36	55	21	20	16	4	3	2	12	11	7
Гурванбулаг	2321	194	20	31	12	11	9	2	2	1	7	6	4
Жаргалант	2931	246	25	39	15	14	11	3	2	2	9	8	5
Жинст	2261	189	19	30	11	11	9	2	1	1	7	6	4
Заг	2124	178	18	28	11	10	8	2	1	1	6	5	3
Өлзийт	3868	324	33	51	19	19	15	4	3	2	12	10	6

Баянхонгор аймгийн зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө. Боть 4

Хүрээмарал	1757	147	15	23	9	8	7	2	1	1	5	5	3
Шинэжинст	2520	211	22	33	13	12	10	3	2	1	8	6	4
Эрдэнэцогт	4410	369	38	58	22	21	17	5	3	3	13	11	7
2027 он													
Аймаг нэгдсэн	95157	7974	818	1253	479	456	362	98	62	55	284	244	156
Баянхонгор	34032	2851	293	448	171	163	129	35	22	20	102	87	56
Баацагаан	3510	294	30	46	18	17	13	4	2	2	11	9	6
Баянбулаг	1916	161	16	25	10	9	7	2	1	1	6	5	3
Баянговь	3254	273	28	43	16	16	12	3	2	2	10	8	5
Баянлиг	4134	346	36	54	21	20	16	4	3	2	12	11	7
Баян-Овоо	2780	233	24	37	14	13	11	3	2	2	8	7	5
Баян-Өндөр	2804	235	24	37	14	13	11	3	2	2	8	7	5
Баянцагаан	3799	318	33	50	19	18	14	4	2	2	11	10	6
Богд	3334	279	29	44	17	16	13	3	2	2	10	9	5
Бөмбөгөр	3580	300	31	47	18	17	14	4	2	2	11	9	6
Бууцагаан	3935	330	34	52	20	19	15	4	3	2	12	10	6
Галуут	4438	372	38	58	22	21	17	5	3	3	13	11	7
Гурванбулаг	2472	207	21	33	12	12	9	3	2	1	7	6	4
Жаргалант	3122	262	27	41	16	15	12	3	2	2	9	8	5
Жинст	2409	202	21	32	12	12	9	2	2	1	7	6	4
Заг	2263	190	19	30	11	11	9	2	1	1	7	6	4
Өлзийт	4120	345	35	54	21	20	16	4	3	2	12	11	7
Хүрээмарал	1872	157	16	25	9	9	7	2	1	1	6	5	3
Шинэжинст	2684	225	23	35	14	13	10	3	2	2	8	7	4
Эрдэнэцогт	4698	394	40	62	24	22	18	5	3	3	14	12	8
2032 он													
Аймаг нэгдсэн	99552	8339	857	1309	501	476	377	103	65	58	298	256	164
Баянхонгор	35604	2983	306	468	179	170	135	37	23	21	107	92	59
Баацагаан	3672	308	32	48	18	18	14	4	2	2	11	9	6
Баянбулаг	2005	168	17	26	10	10	8	2	1	1	6	5	3
Баянговь	3405	285	29	45	17	16	13	4	2	2	10	9	6
Баянлиг	4325	362	37	57	22	21	16	4	3	3	13	11	7
Баян-Овоо	2909	244	25	38	15	14	11	3	2	2	9	7	5
Баян-Өндөр	2933	246	25	39	15	14	11	3	2	2	9	8	5
Баянцагаан	3974	333	34	52	20	19	15	4	3	2	12	10	7
Богд	3488	292	30	46	18	17	13	4	2	2	10	9	6


Баянхонгор аймгийн зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө. Боть 4

Бөмбөгөр	3746	314	32	49	19	18	14	4	2	2	11	10	6
Бууцагаан	4117	345	35	54	21	20	16	4	3	2	12	11	7
Галуут	4643	389	40	61	23	22	18	5	3	3	14	12	8
Гурванбулаг	2587	217	22	34	13	12	10	3	2	2	8	7	4
Жаргалант	3266	274	28	43	16	16	12	3	2	2	10	8	5
Жинст	2520	211	22	33	13	12	10	3	2	1	8	6	4
Заг	2367	198	20	31	12	11	9	2	2	1	7	6	4
Өлзийт	4311	361	37	57	22	21	16	4	3	3	13	11	7
Хүрээмарал	1958	164	17	26	10	9	7	2	1	1	6	5	3
Шинэжинст	2808	235	24	37	14	13	11	3	2	2	8	7	5
Эрдэнэцогт	4915	412	42	65	25	24	19	5	3	3	15	13	8
2037 он													
Аймаг нэгдсэн	104149	8725	897	1370	524	498	394	107	68	61	312	268	171
Баянхонгор	37248	3120	321	490	188	178	141	38	24	22	111	96	61
Баацагаан	3842	322	33	51	19	18	15	4	2	2	11	10	6
Баянбулаг	2097	176	18	28	11	10	8	2	1	1	6	5	3
Баянговь	3562	298	31	47	18	17	13	4	2	2	11	9	6
Баянлиг	4525	379	39	60	23	22	17	5	3	3	14	12	7
Баян-Овоо	3043	255	26	40	15	15	12	3	2	2	9	8	5
Баян-Өндөр	3069	257	26	40	15	15	12	3	2	2	9	8	5
Баянцагаан	4158	348	36	55	21	20	16	4	3	2	12	11	7
Богд	3649	306	31	48	18	17	14	4	2	2	11	9	6
Бөмбөгөр	3919	328	34	52	20	19	15	4	3	2	12	10	6
Бууцагаан	4307	361	37	57	22	21	16	4	3	3	13	11	7
Галуут	4857	407	42	64	24	23	18	5	3	3	15	12	8
Гурванбулаг	2706	227	23	36	14	13	10	3	2	2	8	7	4
Жаргалант	3417	286	29	45	17	16	13	4	2	2	10	9	6
Жинст	2636	221	23	35	13	13	10	3	2	2	8	7	4
Заг	2476	207	21	33	12	12	9	3	2	1	7	6	4
Өлзийт	4510	378	39	59	23	22	17	5	3	3	13	12	7
Хүрээмарал	2048	172	18	27	10	10	8	2	1	1	6	5	3
Шинэжинст	2938	246	25	39	15	14	11	3	2	2	9	8	5
Эрдэнэцогт	5142	431	44	68	26	25	19	5	3	3	15	13	8

Дээрх хүснэгтээр аймгийн хүн амыг газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүнээр хангахад хэдэн га талбай шаардлагатай байгааг төлөвлөлтийн үе шатуудаар тооцож гаргасан. Үе шатуудаар доор харууллаа.

- 2020 оны байдлаар аймгийн хүн амыг газар тариалангийн гаралтай голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох төмсөөр хангахад 450 га, байцаагааар хангахад 427 га, луувангаар хангахад 338 га, манжингаар хангахад 92 га, сонгиноор хангахад 58 га, сармисаар хагахад 52 га, хүлэмжийн ногоо болох улаан лоолоор хангахад 267 га, өргөст хэмхээр хангахад 230 га, чинжүүгээр хангахад 147 га талбай тус тус шаардлагатай байна.
- 2027 онд аймгийн хүн амыг өсөлттэй уялдуулан газар тариалангийн гаралтай голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох төмсөөр хангахад 479 га, байцаагааар хангахад 456 га, луувангаар хангахад 362 га, манжингаар хангахад 98 га, сонгиноор хангахад 62 га, сармисаар хагахад 55 га, хүлэмжийн ногоо болох улаан лоолоор хангахад 284 га, өргөст хэмхээр хангахад 244 га, чинжүүгээр хангахад 156 га талбай тус тус шаардлагатай байна.
- 2032 онд аймгийн хүн амыг хүн өсөлттэй уялдуулан газар тариалангийн гаралтай голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох төмсөөр хангахад 501 га, байцаагааар хангахад 476 га, луувангаар хангахад 377 га, манжингаар хангахад 103 га, сонгиноор хангахад 65 га, сармисаар хагахад 58 га, хүлэмжийн ногоо болох улаан лоолоор хангахад 298 га, өргөст хэмхээр хангахад 256 га, чинжүүгээр хангахад 164 га талбай тус тус шаардлагатай байна.
- 2037 онд аймгийн хүн амыг хүн өсөлттэй уялдуулан газар тариалангийн гаралтай голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох төмсөөр хангахад 524 га, байцаагааар хангахад 498 га, луувангаар хангахад 394 га, манжингаар хангахад 107 га, сонгиноор хангахад 68 га, сармисаар хагахад 61 га, хүлэмжийн ногоо болох улаан лоолоор хангахад 312 га, өргөст хэмхээр хангахад 268 га, чинжүүгээр хангахад 171 га талбай тус тус шаардлагатай байна.

Энэхүү тооцооллыг хийхэд гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээт талбайг тооцсон бөгөөд бусад бүтээгдэхүүнийг ээлжлэн тариалалтын явцад үйлдвэрлэл явуулах боломжтой гэж үзсэн болно (Зураг-5, Хүснэгт-15).



Зураг-5. Тариалангийн газрын төлөвлөлт

Хүснэгт-15. Тариалангийн газрын төлөвлөлт

Сумд	Ашиглалт	Төлөвлөлт	Төлөвлөлтөөр		
			Газар тариалан бүс	Төмс хүнсний ногоо	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ
Баянхонгор	136.78				
Баацагаан	54.57	757.38		23.25	
Баянбулаг	4.88	9.81			
Баянговь	157.14	139.40	139.4		
Баянлиг	97.16	0.00			
Баян-Овоо	73.86	85.42			85.42
Баян-Өндөр	0.76	5.46		5.46	
Баянцагаан	102.84	19.15	4.53	4.57	
Богд	11.48	3037.18		926.97	
Бөмбөгөр	118.3	6702.25	462.20	147.16	0.82
Бууцагаан	166.36	65.44	45.63	6.10	1.60
Галуут	229.03	436.45			
Гурванбулаг		163.82	27.38	136.44	
Жаргалант		2108.83		6.17	
Жинст	11.38	3.91		3.91	
Заг	212.1	70.11			
Өлзийт	243.71	197.91	169.2	24.71	
Хүрээмарал		39.08	9.0	30.08	
Шинэжинст	8.51	120.54	117.77	2.77	
Эрдэнэцогт	43.32	44.19			
Нийт	1672.2	14006.3	975.1	1317.6	87.8

Үргэлжлэл

Сумд	Төлөвлөлтөөр				
	Төмс, хүнсний ногоо, тэжээл ургамал	Нарийн ногоо	Жимс, жимсгэнэ	Үр тариа	Атаршсан талбай
Баянхонгор					
Баацагаан	734.13		44.9		
Баянбулаг	9.81				
Баянговь					
Баянлиг					
Баян-Овоо					
Баян-Өндөр					
Баянцагаан	10.05		2.03		
Богд	2110.21				

Бөмбөгөр	5992.13			99.94	
Бууцагаан	12.11				
Галуут	436.45				
Гурванбулаг					
Жаргалант	126.05				1976.6
Жинст					
Заг	70.11				
Өлзийт		4.00	2.0		
Хүрээмарал					
Шинэжинст			254.38		
Эрдэнэцогт	44.19		58.63		
Нийт	9545.25	4.0	362.0	99.9	1976.6

Дээрх хүснэгтээс харахад тус аймгийн хэмжээнд 1672.2 га талбай газар тариалангийн зориулалтаар ашиглагдаж байна. Үүнээс газрын кадастрын мэдээллийн санд 900.15 га талбай бүртгэлтэй байна. 2037 он хүртэл 14006 га талбайг газар тариалангийн зориулалтаар төлөвлөж өгсөн. Үүнээс Газар тариалангийн бүс 957.1 га, төмс хүнсний ногооны зориулалтаар 1317.6 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэни зориулалтаар 87.8 га, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 9545.25 га, нарийн ногооны зориулалтаар 4 га, жимс, жимсгэний зориулалтаар 362 га, үр тарианы зориулалтаар 100 га талбайг тус тус төлөвлөсөн байна. Мөн 1976.6 га атаршсан талбайг төлөвлөлтөнд тусгагдаагүй байна.

1.6 Жимс, жимсгэнэ тариалах газрын төлөвлөлт

1.6.1 Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Олон хүчин зүйлийн шинжилгээний арга нь ГЗМС-н технологи дээр суурилдаг (Baban and Wan-Yusof, 2003). Судалгаа нь дараахь хоёр үе шаттай: Мэдээллийг бэлтгэх ба олон хүчин зүйлийн шинжилгээ хийх гэсэн хоёр үе шаттай: Эхний үе шатанд төлөвлөлтийн хамгийн энгийн шаардлагыг хангах суурь нөхцөлийг тогтооно. Хоёрдугаар шатанд олон хүчин зүйлийн дүн шинжилгээг АНР (АНР Аналитик шатлан эрэмбэлэх математик). програм хангамжийг ашиглан жинлэсэн дунджаар тогтооно. Суурь нөхцөлийн болон хүчин зүйлийн судалгааг Ландсат 8, Google earth хиймэл дагуулын мэдээ, GDEM 30 метрийн өндрийн тоон загварын зургуудыг ашиглаж сургалттай болон сургалтгүй ангиллын аргаар газрын бүрхэвчийн ангиллыг тогтоосон.

Суурь нөхцөлийн үнэлгээ

Constrain буюу суурь нөхцөлийн зураг гаргахад усан сан, гол, нуур, ой, салхины дээд хурд, жилийн зочир хүйтрэлт, хөрсний төрөл, ширхэгийн бүрэлдэхүүн, гадаргын налуу гэх мэт нөхцөлүүдийг харгалзан Constraint буюу суурь нөхцөлийн зургийг гаргасан. Ингэхдээ сонгон авсан үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн зураг үүсгэж, зургуудыг давхцуулж хадлан авах тохиромжтой газрыг сонгох дүн шинжилгээг Erdas Imagine програм дээр хийсэн (Хүснэгт- 16).

Хүснэгт-16. Жимс, жимсгэнэ тариалах газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл


Шалгуур үзүүлэлт, өгөгдлүүд		Ач холбогдол
Жимс, жимсгэнэ тариалах зориулалттай газар		
1	Усан сан бүхий газартай давхацахгүй байх	Усаар бүрхэгдсэн
2	Ойн сан бүхий газартай давхацахгүй байх	Ойгоор бүрхэгдсэн
3	Газрын налуу хэвгий 25 градусаас бага байх	Аюулгүй байдал/ Байгаль орчин
4	Хөрсний чийгшил ихтэй газраас хол байх	Аюулгүй байдал/ Байгаль орчин
5	Салхигүй нөмөр,энгэр эвэр газар сонгох	Байгаль орчин/Эдийн засаг

Суурь нөхцөлийн зургийг дээрхи хүчин зүйлийг харгалзан Boolean зургийн аргаар хийдэг. Булеан зураг дээр өгөгдлийн утга нь 0 болон 1 гэсэн хоёр утгын нөхцөлтэй. 0 нөхцөл нь боломжгүй буюу зөвшөөрөхгүй нөхцөл, 1 гэсэн нөхцөлт утга нь зөвшөөрөх буюу боломжит утгыг илэрхийлнэ байна (Зураг-6).



Зураг-6. Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл

Дээрх зургийг Boolean зургийн нөхцөлт утгын аргыг ашиглан зурагласан бөгөөд 0 утгатай гарч байгаа газруудыг тохиромжгүй гэж үзнэ. Зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн. Дээрх суурь нөхцөлийн зургуудыг нэгтгэж нэгдсэн үнэлгээний зургийг гаргасан (Зураг-7).



Зураг-7. Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн нэгдсэн үнэлгээ

Дээрх зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн.

Хүчин зүйлийн үнэлгээ


Тохиромжтой байдлын үнэлгээнд олон хүчин зүйл ашиглаж байгаа (factor) үед энэ аргыг хэрэглэнэ. Олон хүчин зүйлүүдийг хооронд нь харьцуулахад нэг нь нөгөөгөөсөө илүү ач холбогдолтой ба эзлэх жингийн хувьд өндөр жин дарна. Шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэхдээ АНР (analytical hierarchy process) буюу шатлан захирах дүн шинжилгээний аргыг ашигласан (Saaty 1977). Энэ арга нь шалгуур үзүүлэлтийн эрэмбэлэлтийн матрицаар жингийн утгыг тодорхойлдог.

Сонгон авсан хүчин зүйлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэлтийн матрицыг ашиглан жингийн утгыг тодорхойлохын тулд судалгаанд ашиглагдаж буй хүчин зүйлийг хадлангийн талбайн тохиромжтой байдалд нөлөөлөх ач холбогдлоор эрэмбэлсэн (Хүснэгт-17).

Хүснэгт-17. Жимс, жимсгэнэ тариалах газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь

№	Хүчин зүйл	Эрэмбэ	Харьцангуй жин
1	Жилийн дундаж салхины хурд	1	0.2901
2	Гүний усны нөөц	2	0.2099
3	Гадаргын налуу	3	0.1516
4	Жилийн хасах температур нийлбэр	4	0.1095
5	Салхины дээд хурд	5	0.0788
6	Хөрс	6	0.0563
7	Ширхэгийн бүрэлдэхүүн	7	0.0400
8	Урвалын орчин	8	0.0284
9	Дулаан хангамж	9	0.0203
10	Жилийн нийлбэр хур тунадас	10	0.0151
CR=0.0615			


Дээрх эрэмбэлэлтээс хамгийн ач холбогдолтой нь газрын гадаргын налуу болон хөрсний тогтвортой байдал, хамгийн ач холбогдол багатай нь хөрсний гүний усний түвшин гэж тооцоод хүчин зүйлүүдийг эрэмбэлсэн. Эрэмбэлэлтийн матрицаар тоохон гаргасан жингийн утга хэр зэрэг үнэнд нийцэж байгаа consistency ratio буюу нийцлийн харьцааны индексээр тооцож үзэхэд 0.0615 байгаа нь хүчин зүйлийн хоорондын харьцаа зохицол сайтай болох нь батлагдаж байна.



Зураг-8. Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээ

Дээрх хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний зургийг радиометрийн заслын тусламжтайгаар бүх зургийг 0-255 хооронд нь утга авахуулж засвар хийж зурагласан бөгөөд өндөр утга авах тусам маш тохиромжтой, бага утга авах тусам нэн тохиромжгүй газар нутаг юм.

Жимс, жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн болон хүчин зүйлүүдийн нэгдсэн зургийг гаргасан (Зураг-9).



Зураг-9. Жимс, жимсгэний газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

Тариалангийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зургийг тохиромжтой байдлаар нь тохиромжтой, дунд зэрэг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромжгүй, суурь нөхцөл гэж ангилан авч үзлээ (Хүснэгт-18).

Хүснэгт-18. Жимс, жимсгэний газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

№	Тохиромжтой байдлын ангилал	Талбай, га	Эзлэх, хувь
1	Нэн тохиромжтой	681138	5.90
2	Тохиромжтой	1610968	13.94
3	Дунд зэрэг тохиромжтой	3184970	27.57
4	Хязгаарлагдмал тохиромжтой	5127580	44.39
5	Тохиромжгүй	947840	8.20
Нийт		11552495	100.00

Жимс, жимсгэний газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний үр дүнгээс одоо ашиглагдаж байгаа газар ашиглалтын суурь нөхцөлүүдийг хасаж тооцоо хийхэд аймгийн нийт нутаг дэвсгэрийн 5.9 хувь буюу 681138 га нь нэн тохиромжтой, 13.94 хувь буюу 1610968 га нь тохиромжтой, 27.57 хувь буюу 3184970 га нь дунд зэрэг тохиромжтой, 44.39 хувь буюу 5127580 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 8.2 хувь буюу 947840 га нь тохиромжгүй гэсэн ангилалд тус тус хамрагдаж байна.

1.6.2 Жимс, жимсгэний газрын хэрэгцээт байдлын үнэлгээ

Жимс, жимсгэнэ нь үр, жимсэндээ олон төрлийн амин дэм, биологийн идэвхт бодис агуулдаг тул хүн амын эрүүл мэнд, хүнс, гоо сайхны нэн чухал тарималд тооцогддог. Жимс, жимсгэнийн үйлдвэрлэл нь олон жилийн уйгагүй хөдөлмөр, хөрөнгө санхүүжилт, туршлага, ур чадвар шаарддаг бөгөөд төр засгаас тууштай, урт хугацааны тогтвортой дэмжлэг үзүүлж байж үр дүнд хүрдэг онцлогтой. Манай орны хувьд өргөн уудам нутаг дэвсгэртэй, байгаль, эрс тэс уур амьсгалын бүсүүдэд байгалийн 60 гаруй төрлийн жимс, жимсгэнэ ургадаг бөгөөд эрдэмтэн, судлаачид, олон төрлийн жимс, жимсгэнийг тариалж нутагшуулах, үржүүлэх агротехнологийг боловсруулан шинэ сорт гаргах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологийг хөгжүүлсээр байна.

Жимс, жимсгэнийн өртгийн сүлжээг хөгжүүлэх, түүний байршил, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан бүс нутгийн нөөц, байгаль цаг уурын онцлог, дэд бүтэц, ложистик, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймээс Монгол орны байгаль цаг уур, газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн онцлогийг харгалзан жимсний таримлыг дараах байдлаар бүсчилэн зурагласан байна (Зураг-10.).



Зураг-10. Монгол орны жимсний таримлын бүсчилэл /Б.Нинж/

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан судалгаагаар 2020 оны байдлаар манай улсын хөдөө аж ахуйн салбарын стратегийн ач холбогдол бүхий хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний дотоодын хэрэгцээг авч үзвэл 115.2 мянган тонн төмс, 249.6 мянган тонн хүнсний ногоо, 38.4 мянган тонн буурцагт ургамал, 192.0 мянган тонн жимс, жимсгэнэ хэрэгцээтэй байна.

Жимс, жимсгэний бүтээгдэхүүний хэрэгцээ

Жимс, жимсгэнэ нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, сахар, эрдсийн элемент болон биологийн идэвхт бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн төдийгүй бут сөөг нь ойн зурвас, ногоон байгууламж байгуулах замаар хөрс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, элсний нүүдлийг зогсооход хамгаалалт болдог олон талын ашиг тустай. Манай улсын нэг хүн 1990 онд 12 кг жимс, жимсгэнэ хэрэглэж байсан бол 2007 онд 8.4 кг болж буурсны зэрэгцээ чанарын баталгаагүй импортын жимс хэрэглэж байна. Сүүлийн жилүүдэд жимс, жимсгэний хэрэгцээ огцом өсч, байгалийн жимсийг олон хэлбэрээр ашиглаж байгаа ч, нөөцийг нь арвижуулах асуудал хоцорч байна. 2009 оны байдлаар улсын хэмжээнд 1200 га талбайд жимс, жимсгэнэ тариалж байгаагийн 80

гаруй хувийг чацаргана эзэлж байна. Чацаргана нь найрлагадаа С, В1,В2, В9, А, К, F, В, Р бүлгийн амин дэм, тос, биологийн идэвхт бодис агуулан хүнсний болон гоо сайхан,

эмийн олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үнэт түүхий эд тул түүний эрэлт хэрэгцээ дотоодод ч, дэлхийн зах зээл дээр ч жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Төлөвлөлтийн үе шатуудад /2020, 2027, 2032, 2037 онууд/ өсөн нэмэгдэх хүн амыг тооцоолон шаардагдах бүтээгдэхүүний хэрэгцээг дор үзүүлэв (Хүснэгт-19).

Хүснэгт-19. Төлөвлөлтийн жилүүд дэх хүн амын өсөлтийн тооцоолол

Ангилал	2020 он	2027 он	2032 он	2037 он
Баянхонгор	89329	95157	99552	104149

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд байдлаар 89329 хүн ам тоологдсон бөгөөд төлөвлөлтийн 15 жилийн хугацаанд 104149 хүн ам болж 14820 хүн амаар өсөх тооцоо гарч байна.

Дээрх хүн амын өсөлтийн тооцоололдоо тулгуурлан хүн амд шаардагдах хүнсний хэрэгцээг тооцоолохдоо Эрүүл мэндийн сайдын 2017 оны а/74 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан нэг хүнд шаардагдах жилийн дундаж хүнсний хэрэглээний нормыг баримталсан.

Хүснэгт-20. Нэг хүний жилийн дундаж хүнсний хэрэгцээ (г/хүн)

Эрүүл мэндийн сайдын 2017 оны а/74 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Хоногт хэрэглэх хэмжээ (г)	Үндсэн шимт бодисууд (г)						Илчлэг (ккал)	
		Уураг			Тос				Нүүрс ус
		Нийт	Үүнээс		Нийт	Үүнээс			
амьтны	ургамлын		амьтны	ургамлын					
Төрөл бүрийн будаа	50	4		4	0		0	31	140
Жимс, жимсгэнэ	200	1		1	0		0	20	82
БҮГД	1563	90	45	45	67	37	30	360	2400
Үндсэн шимт бодисын илчлэг		360			600			1440	
Үндсэн шимт бодисын илчлэгийн эзлэх хувь		15%			25%			60%	

Тайлбар: Илчлэгийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг харьцангуй эрүүл монгол хүний хүнсний бүтээгдэхүүний хоногийн дундаж хэрэглээн дээр үндэслэн тогтоов.

Дээрх стандартаар батлагдсан нэг хүнд шаардагдах жилийн дундаж хүнсний хэрэглээний нормыг баримтлан Баянхонгор аймгийн хэмжээнд жимс, жимсгэний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг тооцоолж гаргасан (Хүснэгт-21).

Хүснэгт-21. Жимс, жимсний бүтээгдэхүүний хэрэгцээ

Сумд	Хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай хэмжээ /тн/											
	2020			2027			2032			2037		
	Чацаргана	Үхрийн нүд	Бусад	Чацаргана	Үхрийн нүд	Бусад	Чацаргана	Үхрийн нүд	Бусад	Чацаргана	Үхрийн нүд	Бусад
Баянхонгор	700	466	1166	745	497	1242	780	520	1300	816	544	1360
Баацагаан	72	48	120	77	51	128	80	54	134	84	56	140
Баянбулаг	39	26	66	42	28	70	44	29	73	46	31	77
Баянговь	67	45	112	71	48	119	75	50	124	78	52	130
Баянлиг	85	57	142	91	60	151	95	63	158	99	66	165
Баян-Овоо	57	38	95	61	41	101	64	42	106	67	44	111
Баян-Өндөр	58	38	96	61	41	102	64	43	107	67	45	112
Баянцагаан	78	52	130	83	55	139	87	58	145	91	61	152
Богд	69	46	114	73	49	122	76	51	127	80	53	133
Бөмбөгөр	74	49	123	78	52	131	82	55	137	86	57	143
Бууцагаан	81	54	135	86	57	144	90	60	150	94	63	157
Галуут	91	61	152	97	65	162	102	68	169	106	71	177
Гурванбулаг	51	34	85	54	36	90	57	38	94	59	40	99
Жаргалант	64	43	107	68	46	114	72	48	119	75	50	125
Жинст	50	33	83	53	35	88	55	37	92	58	38	96
Заг	47	31	78	50	33	83	52	35	86	54	36	90
Өлзийт	85	56	141	90	60	150	94	63	157	99	66	165
Хүрээмарал	38	26	64	41	27	68	43	29	71	45	30	75
Шинэжинст	55	37	92	59	39	98	62	41	103	64	43	107
Эрдэнэцогт	97	64	161	103	69	171	108	72	179	113	75	188
Нийт	1956	1304	3261	2084	1389	3473	2180	1453	3634	2281	1521	3801

Дээрх хүснэгтэд төлөвлөлтийн үе шатууд дах жимс, жимсгэний хэрэгцээг тооцож харуулсан бөгөөд **2020** оны байдлаар чацаргана 1956 тн, үхрийн нүд 1304 тн, бусад төрлийн жимс, жимсгэнэ 3261 тн, **2027** онд чацаргана 2084 тн, үхрийн нүд 1389 тн, бусад төрлийн жимс, жимсгэнэ 3473 тн, **2032** онд чацаргана 2180 тн, үхрийн нүд 1453 тн, бусад төрлийн жимс, жимсгэнэ 3634 тн, **2037** онд чацаргана 2281 тн, үхрийн нүд 1521 тн, бусад төрлийн жимс, жимсгэнэ 3801 тн болж өсөн нэмэгдэх тооцоо гарч байна.

1.6.3 Жимс, жимсгэний газрын төлөвлөлт

Монгол улс хүн амын хүнсний хэрэгцээг газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүн болох төмсөөр 100 хувь, хүнсний ногоогоор 51-55 хувь, нарийн ногоогоор 5-10 хувь, жимс, жимсгэнээр 5-7 хувиар хангаж байна. Өнөөдрийн байдлаар газар тариалангийн салбар дотроос эрүүл мэндийн чухал бүтээгдэхүүн болох жимс, жимсгэний хангамж маш хомс байгаа.

Жимс, жимсгэнэ, түүний дотроос чацаргана тариалах хөдөлгөөнийг дэмжих, түүнийг хүмүүсийн амьдрал ахуйгаа дээшлүүлэх, ажлын байр бий болгохын зэрэгцээ боловсруулах үйлдвэр байгуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотооддоо хэрэглэх, гадаад зах зээлд нийлүүлэх тодорхой бодлоготой ажиллах зайлшгүй шаардлага гарч байна. Сүүлийн 40-өөд жилийн туршлагаас үзэхэд чацарганыг манай орны аль ч бүсэд тариалах бололцоотой байна.

Жимс, жимсгэнэ нь хүний биед зайлшгүй хэрэгцээт амин дэм, сахар, эрдсийн элемент болон биологийн идэвхт бодисоор баялаг хүнсний чухал бүтээгдэхүүн төдийгүй бут сөөгөн ойн зурвас, ногоон байгууламж байгуулах замаар хөрс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, элсний нүүдлийг зогсооход хамгаалалт болдог олон талын ашиг тустай.

Цаашид төлөвлөлтийн үе шатуудад жимс, жимсгэнээр тус аймгийн хүн амын хүсний хэрэгцээг хангахад шаардагдах газрын хэмжээг гаргав (Хүснэгт-22).

Хүснэгт-22. **Жимс, жимсгэний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардлагатай тариалангийн газрын тооцоо**

Сумд	Хүн амын хүнсний хэрэгцээнд шаардлагатай талбайн хэмжээ /тн/											
	2020			2027			2032			2037		
	Чацаргана	Үхрийн нүд	Бусад	Чацаргана	Үхрийн нүд	Бусад	Чацаргана	Үхрийн нүд	Бусад	Чацаргана	Үхрийн нүд	Бусад
Га-ийн дундаж ургац /цн/га/	40	33	20	40	33	20	40	33	20	40	33	20
Баянхонгор	175	141	583	186	151	621	195	158	650	204	165	680
Баацагаан	18	15	60	19	16	64	20	16	67	21	17	70
Баянбулаг	10	8	33	10	8	35	11	9	37	11	9	38
Баянговь	17	14	56	18	14	59	19	15	62	20	16	65
Баянлиг	21	17	71	23	18	75	24	19	79	25	20	83
Баян-Овоо	14	12	48	15	12	51	16	13	53	17	13	56
Баян-Өндөр	14	12	48	15	12	51	16	13	54	17	14	56
Баянцагаан	20	16	65	21	17	69	22	18	73	23	18	76
Богд	17	14	57	18	15	61	19	15	64	20	16	67
Бөмбөгөр	18	15	61	20	16	65	21	17	68	21	17	72

Бууцагаан	20	16	67	22	17	72	23	18	75	24	19	79
Галуут	23	18	76	24	20	81	25	21	85	27	21	89
Гурванбулаг	13	10	42	14	11	45	14	11	47	15	12	49
Жаргалант	16	13	53	17	14	57	18	14	60	19	15	62
Жинст	12	10	41	13	11	44	14	11	46	14	12	48
Заг	12	9	39	12	10	41	13	10	43	14	11	45
Өлзийт	21	17	71	23	18	75	24	19	79	25	20	82
Хүрээмарал	10	8	32	10	8	34	11	9	36	11	9	37
Шинэжинст	14	11	46	15	12	49	15	12	51	16	13	54
Эрдэнэцогт	24	20	80	26	21	86	27	22	90	28	23	94
Нийт	489	395	1630	521	421	1737	545	440	1817	570	461	1901

Дээрх хүснэгтэд төлөвлөлтийн үе шатуудад хүн амыг жимс, жимсгэний хэрэгцээт бүтээгдэхүүнээр хангахад **2020** оны байдлаар чацаргана 489 га, үхрийн нүд 395 га, бусад төрлийн жимс, жимсгэнэ 1630 га, **2027** онд чацаргана 521 га, үхрийн нүд 421 га, бусад төрлийн жимс, жимсгэнэ 1737 га, **2032** онд чацаргана 545 га, үхрийн нүд 440 га, бусад төрлийн жимс, жимсгэнэ 1817 га, **2037** онд чацаргана 570 га, үхрийн нүд 461 га, бусад төрлийн жимс, жимсгэнэ тариалахад 1901 га талбай шаардлагатай гэж гарч байна.

Жимс, жимсгэний талбайн төлөвлөлтийг хийж гүйцэтгэхдээ Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн газар, аймгийн болон орон нутгийн удирдлага, малчид, мэргэжилтэнгүүдийн саналыг харгалзан үзэж төлөвлөв.

Хүснэгт-23. Жимс, жимсгэний талбайн төлөвлөлт

Сумд	Ашиглалт	Төлөвлөлт	Төлөвлөлт үе шат		
			2027	2032	2037
Баянхонгор	37.24				
Баацагаан	2.0	44.9	22.46	13.47	8.98
Баянговь	0.25	-	-	-	-
Баянлиг	10.0	-	-	-	-
Баян-Овоо	-	85.42	42.71	0.00	17.08
Баян-Өндөр	-	-	-	-	-
Баянцагаан	0.52	2.03	1.02	0.61	0.41
Богд	0.24	-	-	-	-
Бөмбөгөр	-	0.82	0.82	-	-
Бууцагаан	39.78	1.6	1.60	-	-
Жаргалант	1.15	-	-	-	-
Заг	206	-	-	-	-
Өлзийт	13.0	2.0	2.00		
Шинэжинст	2.51	254.38	127.19	76.31	50.88
Эрдэнэцогт	0.12	58.63	29.32	17.59	11.73
Нийт	312.8	449.8	227.1	107.99	89.07

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймаг нь одоогийн байдлаар 312.8 га талбайг жимс, жимсгэний зориулалтаар олгосон байна.

Төлөвлөлтийн хугацаанд жимс, жимсгэний зориулалтаар нийт 449.8 га талбайг төлөвлөсөн байна. Төлөвлөлтийн хугацаанд дахь үе шатуудаар нь авч үзвэл 2027 он гэхэд 227.1 га талбайд, 2032 он гэхэд 107.99 га талбайд, 2037 он гэхэд 89.07 га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн болно.

1.7 Тариалангийн талбайн ойн зурвас байгуулах төлөвлөлт

Ойн зурвас салхины хүчийг сааруулж хөрс салхиар эвдрэхээс хамгаалах, хөрсний чийг хатаах салхины үйлчилгээг бууруулах, хөрсний усны түвшинг дээшлүүлдгээрээ чухал ач холбогдолтой. Энэ нь хуурай гандуу бүс нутгийн агро-ойжуулалт хөгжүүлэх хамгийн гол арга болно. Өөрөөр хэлбэл тариалан талбайд найдвартай усны эх үүсвэрийг түшиглэн ойн зурвас байгуулах ажлыг хийснээр найдвартай ургац авах нөхцөл бүрдэнэ.

Ойн зурвасны салхинаас хөрс хамгаалах чадвар нь зурвасны өндөр, өргөнөөс хамаарахын дээр салхины хурд, чиглэлээс шалтгаална. Ойн зурвас салхины хурдыг өөрийнхөө өндрийн хэмжээнээс салхины эсрэг чиглэлд 5 дахин, салхины уруу чиглэлд 30 дахин зайд багасгаж чаддаг байна. Ойн зурвасыг ноёлох салхины хөндлөн байгуулна.

Ойн зурвасыг бүтцийн хувьд салхи нэвт салхилдаггүй буюу битүү, нэвт салхилдаг, салхи сийгдэг гэж хуваана.

Мод, сөөг навчилсан байх үед салхи нэвтрэхээргүй шигүү тарьсан, өөрөөр хэлбэл хар мод, хус, нарс, хайлаас зэрэг өндөр моднуудын хамт бутлаг намхан моднуудыг чөлөөнд нь тарьсан ойн зурвасыг нэвт салхилдаггүй зурвас гэнэ.

Нэвт салхилдаг бүтэцтэй зурвас гэж бут сөөг тариагүй, зай завсраар нь салхи салхилдаг зурвасыг хэлнэ. Ийм зурвас газрын гадаргууд модны өндөрөөс 3-5 дахин хол зайд салхины хурдыг сааруулна. Нэвт салхилдаг бүтэцтэй зурвасанд элс, шороо хуримтлагдах нь бага, харин цас жигд хунгарлана.

Салхи сийгдэг зурвас гэж өндөр моднуудын хамт бут, сөөг таригдсан боловч салхины чигийг өөрчлөхөөргүйгээр зай завсартайгаар зохиогдсон зурвасыг хэлнэ.

Аймгийн хэмжээгээр нийт 255.8 км урт тариалангийн талбайн ойн зурвас байгуулахаар төлөвлөлөө.

Хавар болон намрын улиралд шороон шуурганы давтагдал сумдын тариалангийн талбайд ноёлох салхины чигт хөндлөн алсын хамгаалалт хийх зорилгоор нэн түрүүнд тариалангийн талбайн ойн зурвасыг байгуулах нь зүйтэй (Жишээ зураг-11.).



Зураг-11. Ойн зурвас байгуулсан байдал

Хүснэгт-24. Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас

Сумд	Төлөвлөлт		Төлөвлөлт үе шат					
	Хамгаалалтын зурвас		2027		2032		2037	
	Урт /км/	Талбай /га/	Урт /км/	Талбай /га/	Урт /км/	Талбай /га/	Урт /км/	Талбай /га/
Баянхонгор	3.1	36.6	1.9	21.4	0.8	9.1	0.5	6.1
Баацагаан	11.6	117.8	5.8	70.7	3.5	35.3	2.3	23.6
Баянбулаг	2.8	30.3	1.4	18.2	0.8	9.1	0.6	6.1
Баянговь	11.6	118.7	7.4	75.5	2.5	26.0	1.7	17.3
Баянлиг	4.8	49.2	2.4	29.5	1.4	14.8	1.0	9.8
Баян-Овоо	15.1	152.8	7.5	91.7	4.5	45.9	3.0	30.6
Баян-Өндөр	2.0	20.5	1.0	12.3	0.6	6.1	0.4	4.1
Баянцагаан	4.0	41.2	2.0	24.7	1.2	12.4	0.8	8.2
Богд	38.9	391.7	19.5	235.0	11.7	117.5	7.8	78.3
Бөмбөгөр	28.6	287.7	14.3	172.6	8.6	86.3	5.7	57.5
Бууцагаан	6.2	109.9	3.1	65.9	1.9	33.0	1.2	22.0
Галуут	15.5	158.8	4.9	50.9	6.3	64.8	4.2	43.2
Гурванбулаг	4.5	46.5	2.3	27.9	1.4	14.0	0.9	9.3
Жаргалант	49.0	496.0	24.5	297.6	14.7	148.8	9.8	99.2
Жинст	0.5	5.6	0.3	3.4	0.2	1.7	0.1	1.1
Заг	3.2	32.7	2.2	21.8	1.1	10.9	-	-
Өлзийт	17.3	159.3	5.9	61.0	6.8	58.9	4.6	39.3
Шинэжинст	6.8	69.2	3.4	41.5	2.0	20.7	1.4	13.8
Эрдэнэцогт	12.0	124.5	2.5	25.3	70.0	715.2	45.9	469.5
Бүгд	225.55	2448.8	112.2	1346.9	70.0	715.2	45.9	469.5

Төлөвлөлтийн хугацаанд 225.55 км урттай ойн зурвасыг 2448 га талбайд тариалахаар төлөвлөсөн болно.

Ойн зурвасны өргөн, эгнээний тоо нь тухайн нутгийн салхины хүч, хөрсний механик бүтэц, зурвасанд тариалж буй модны төрлөөс хамаарна. Ойн зурвас нь тариалангийн талбайн хөрсийг эвдрэлээс хамгаалах, элсний нүүдлийг зогсооход чухал хэрэгсэл юм. Энэхүү ойн нэвт салхилдаг зурвасыг 3-5 эгнээгээр, эгнээ хооронд 3 м, мөр хооронд 0.7 м зайтайгаар хайлаасыг тарих нь тохиромжтой. Мөн цайвар хүрэн хөрсөнд нарсыг хамгийн сайн нөхцөлд, хужир марзгүй, нугын хүрэн хөрсөнд тариалах нь тохиромжтой харин хайлаасыг 50-60 см гүн хагалсан хөрсөнд зурвасны эгнээ хооронд 3 м, мөр хооронд 0.7 м-ээр тарих нь зүйтэй .

Ойн зурвас нь газрын гадаргуу ба таримал ургамлаас уурших ууршилтыг задгай газрынхаас дунджаар 30 хувь орчим бууруулдаг.

Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах хэлбэрүүд:


- Талбай хамгаалах ойн зурвас: Хуурай халуун салхинаас тариалангийн талбайг хамгаалах, хөдөө аж ахуйн таримал ургамал ургах нөхцөлийг сайжруулах зорилгоор тариалангийн талбай, услалтын системд ойн зурвас байгуулна.
- Ус тохируулах ойн зурвасыг энгэр хажуу налуу газруудад газрын налуугийн хөндлөн чиглэлд байгуулдаг. Энэ зурвасын үндсэн зориулалт нь цас борооны усны урсах хөдөлгөөнийг сааруулж хөрсөнд аль болох ихээр шингээж хөрсийг угаан урсаж эрэг ганга гарч эвдрэхээс хамгаалах явдал юм.
- Ганга, гуу жалгыг хамгаалах ойн зурвасыг нэгэнт бий болсон ганга жалгыг ихэсгэхгүй байж бэхжүүлэх зорилгоор эрэг гангын налуу хажуу ёроолд хөндлөн чиглэлтэй ойн зурвас байгуулна.

Тариалангийн талбай хамгаалах ойн зурвас байгуулахад тухайн районы хөрс, цаг уур, ургах орчин, сонгон авч байгаа мод сөөгийн биологийн онцлогийг сайтар уялдуулах хэрэгтэй.

Ойн зурваст тарьж ашиглах мод сөөгийг өндрийнх нь болон биологийн нь онцлогоор 3 ангилна. Үүнд:

1. Голлох үүлдрийн мод: зурваст таригдах модны хамгийн өндөр бөгөөд ихэнхийг нь эзлэх модыг хэлнэ. Манай орны ойт хээрийн бүсэд энэ зориулалтаар шинэс, нарс, хус, улиас, хээрийн бүсэд шинэс, хус, улиас, говийн бүсэд хайлаас, улиас, тоорой зэрэг модыг ашиглаж болно.
2. Дагалдах үүлдрийн мод: голлох модны завсар зайгаар сүүдэрт нь ургаж хажуугаас нь сүүдэрлэн хөөж даган ургаж хөрсийг байнга сүүдэрлэн хог ургамал ургахаас хамгаалж байна. Дагалдах үүлдэрээр манай орны нөхцөлд хайлаас, улиангар, заг, тоорой зэрэг модыг тариалж болох юм.
3. Бут сөөг: зурвасын доорх хөрсийг сүүдэрлэн хог ургамал ургахаас хамгаалахын хамт гадна талаар суулгаж голлох ба дагалдах модыг хамгаалан салхи нэвтрүүлдэггүй зурвасын доод ярусын хаалт болгон тарьдаг.

Манай орны нөхцөлд ойт хээрийн бүсэд шар хуайс, чацаргана өмхий ховол, үхрийн нүд, нохойн хошуу, хээрийн бүсэд шар хуайс, харгана тошлой сухай, говийн бүсэд харгана, тошлой, хармаг, шаваг, ортууз зэргийг ашиглаж болно. Гэхдээ тухайн талбайн хөрсний нөхцөлийг харгалзах хэрэгтэй. Хэрвээ элсэрхэг ялгаа бүхий хөрстэй орчинд бол улиас, шавранцар ялгаа бүхий хөрсөнд хар мод, хус мэтийн модыг сонгоно.



Зураг-12. Тариалангийн талбайг хамгаалах ойн зурвасын төлөвлөлт

1.8 Тариалангийн талбайн хөрс сайжруулах арга хэмжээ, зөвлөмж

Тариалангийн хөрсний элэгдэл эвдрэл гэдэг нь байгалийн болон хүний сөрөг үйл ажиллагааны улмаас хөрсний өнгөн хэсгийн үржил шимт давхарга салхи болон усны нөлөөгөөр хөрс үржил шимээр ядуурч доройтох үзэгдэл юм. Гадаргын урсац нь хэвгий болон халцгай газрын хөрсийг урсган зөөдөг бол салхи нь хамгаалалтгүй (гадаргуу дээрээ ургамлан бүрхэвчгүй) газрын сул хэсгүүдийг хийсгэдэг.

Дэлхийн хуурай газрын 30 орчим хувийг ХАА-н үйлдвэрлэлд эдлэн газар болгон ашиглаж байгаа ба үүний 11% буюу 1,5 тэрбум га газрыг тариаланд ашиглаж байгаагаас 1,100 сая га талбай буюу доройтсон нийт газар нутгийн 56% нь усны нөлөөгөөр, 28% нь салхиар элэгдээд байна.

Манай орны тариалангийн талбайн хөрс элэгдэж эвдрэх шалтгаан:

- Хөрс нь тогтоцын хувьд элэгдэл эвдрэлд орох эмзэг бүтэцтэй. Үүнд: угаас ялзмаг багатай, амархан бутарч бүтцээ алддаг, нийт тариалангийн талбайн 84% нь хөнгөн шавранцар, юмуу элсэн механик бүрэлдэхүүнтэй
- Салхины хүч ихтэй, 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр салхины хурд ихэсдэг, энэ үе нь хуурайшилт ихтэй, хөрс ургамлан бүрхэвчгүй байх хаврын тариалалтын үетэй давхацдаг
- Салхины хүчийг сааруулах байгалийн саад байдаггүй
- Зонхилох талбайнууд дов толгод дамнасан байрлалтай, хэвгий
- Богино эргэлттэй ээлжлэн тариалах систем мөрддөг, үндсэн таримал нь улаан буудай
- Ургамлан бүрхэвчгүй цулгуй уринш бэлтгэдэг
- Тариалангийн талбайд ургац хураасны дараа, өвөл мал бэлчээрлүүлдэг
- Бордоо маш бага хэрэглэдэг
- Уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж хуурайшилт ихсэж байгаа зэрэг болно.

Манай тариалангийн талбайнууд элэгдэж эвдрэн цул элс болох аюул тулгараад байна. Салхины нөлөөгөөр элс хийсч зөөгдөх үйл явц тасралтгүй үргэлжилсээр байгаа бөгөөд ялангуяа хүний зохисгүй үйл ажиллагааны уршгаар элсний нүүдэл сүүлийн жилүүдэд улам идэвхжсээр байна. 1941 оноос хойш 40 гаруй жилийн хугацаанд шинээр элсжсэн газар 3,3 мянга гаруй км² талбайг хамарсан (Т.Баасан 2003) байна.

Ямар хөрс элэгдэл, эвдрэлд нэрвэгдэмтгий вэ?

Хөрсний элэгдэл гэдэг нь хүний үйл ажиллагаагаар өдөөгдөн хурдасгагдсан байгалийн үйл явц юм. Хүний буруутай үйл ажиллагааны нөлөөллөөр (байгалийн нөөцийн хэрэглээ) урьдчилан таамаглаж болохуйц эсвэл урьдчилан тооцох боломжгүй үр дагавар гардаг.

Хөрс элэгдэл эвдрэлд нэрвэгдэж байгаа нь тухайн талбайн хөрсний элэгдэл эвдрэлд эмзэг байдал, уур амьсгал, салхины хүчний нөлөөллийн үр дүн юм.


Хөрсний элэгдэл эвдрэлд эмзэг байдал нь хөрсний төрөл, органик бодисын агууламжаас хамаарна. Эрдэс болон органик бодисын агууламж ихтэй хөрсний элэгдэл эвдрэлд эмзэг байдлыг дараах бүдүүвчээр үзүүлэв.

Хөрсний шавар, тоосон фракцын эзлэх хэмжээ мөн органик бодисын агууламж бага байх тусмаа элэгдэл эвдрэлд эмзэг байна. Хөрсний органик бодисын агууламж хэдийчинээ өндөр байх тусам элэгдэл эвдрэлд өртөх эрсдэл төдийчинээ багасна.

Манай орны хөрс нь тогтоцын хувьд элэгдэл эвдрэлд орох эмзэг бүтэцтэй. Үүнд: угаас ялзмаг багатай, амархан бутарч бүтцээ алддаг, нийт тариалангийн талбайн 84% нь хөнгөн шавранцар, юмуу элсэн механик бүрэлдэхүүнтэй тул элэгдэл эвдрэлд эмзэгт тооцогддог. Хөрсийг ургамлан нөмрөггүй байлгах явдал нь хөрсний элэгдэл эвдрэлд эмзэг байдлыг хоёр дахин нэмэгдүүлдэг. Хэрэв талбайд гадаргуу ургамлан нөмрөгтэй байвал талбайн гадаргуу дээр салхи шууд цохихгүй, гадаргууд дээр ирэх салхины хурд, хүч нь саарч ирдэг.

Нөгөө талаас нарны тусгал хөрсөн дээр шууд тусаж хөрсний чийгийн ууршилтыг нэмэгдүүлснээр хөрс хуурайшиж элэгдэлд нэрвэгдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Ер нь бол хөрс жилийн бүхий л улиралд олон наст таримал тариалсан ургамлан нөмрөгтэй л байвал элэгдэлд нэрвэгдэх эрсдэл хамгийн бага байна. Үр тариа, тосны ургамал, эрдэнэ шиш, манжин, төмс, үхэр сүүл ба бусад тусгай зориулалтын юмуу өргөн мөрт таримлуудыг тариалахад тухайн талбайн хөрс элэгдэлд нэрвэгдэх эрсдэл их байна.



Зураг-13. Хөрсний элэгдэл эвдрэлд эмзэг байдал

Хүснэгт-25. Хөрсний элэгдэлд нэрвэгдэх эрсдэл

Хөрсний механик бүрэлдэхүүн	>7°-аас дээш эгц налуу	3°-7°-ийн налуу	2°-3°-ийн налуу	2°-аас бага налуу
Элс	Маш их	Их	Дунд	Бага
Шавар ихтэй элс	Маш их	Их	Дунд	Бага
Элс ихтэй шавранцар	Маш их	Их	Дунд	Бага
Элсэрхэг тоос ихтэй шавранцар	Маш их	Их	Дунд	Бага
Тоос ихтэй шавранцар	Маш их	Их	Дунд	Бага
Тоосорхог шавранцар	Их	Дунд	Бага	Маш бага
Бусад эрдэс хөрс	Бага	Бага	Маш бага	Маш бага

Тариалангийн талбайг хөрсний эвдрэлээс хамгаалах зөвлөмж

Манай орны тариалангийн талбай, томоохон уулс, голын хөндий, тэгш тал газраар байршсан байдаг бөгөөд хөрс хөнгөн механик бүтэцтэй болохоор салхины эвдрэлд хялбархан орох аюултай.

Тариалангийн бүс нутгаар 3-р сарын 20-дын үеэс салхилж эхлээд 5-р сүүлчийн 10 хоногт намддаг салхи тариалангийн талбай гадаргуудаа ургамлын бурхэвчгүй цаг хугацаатай тохирч байдаг нь манай орон хөрс хамгаалах системээр тариалангийн үйлдвэрлэл явуулахаас өөр аргагүй болгож байгаа юм. Хаварт олонтой тохиолддог шороон шуурга гадаргуудаа сүрлэн хучлагагүй талбайн хөрсийг хийсгэж элс, хайрга болгон улс оронд асар их хохирол учруулж болно.

Салхины эвдрэлд амархан орох хөрсний хэсгүүд бол 0.1-0.5 мм голч бүхий жижиг хэсгүүд юм. Харин 1 мм-ээс том голч бүхий хэсгүүд салхины эвдрэлд төдийлөн автагддаггүй. Их хүчтэй салхинд ч хөрсний гадаргуу дээр бага зэрэг гулсдаг. Энэ шинжээр нь 1 м.м-ээс дээш голчтой хэсгүүдийг хөрс хамгаалагч гэж нэрлэх бөгөөд 1 мм-ээс бага голчтой хэсгүүдийг салхинд хийсэх аюултай хэсэг гэдэг, Салхинд хийсэмтгий хэсгүүдийг 0.1-0.5 мм хөдөлгөөнд оруулж эхлэх салхины хүчийг босго гэж нэрлэдэг. Хөрсний бүтэц гадаргуугын байдлаас шалтгаалан босго нь харилцан адилгүй байдаг.

Эрдэмтдийн судалгаагаар элсэнцэр хөрс 3.0-4.5 м/сск хөнгөн шавранцар хөрс 5.0 орчим м/сск, хүнд шавранцар хөрс 5.5-7.0 м/сек хүчтэй салхинд хийсч эхлэх ажээ. Өөрөөр хэлбэл хөрс хийсгэж эхлэх салхины хүч /босго/ нь хөрс шавранцар болох тутам дээшилдэг байна. Хөрсний янз бүрийн хэмжээтэй хэсгүүдийн үүрэг салхины эвдрэлээс хамгаалахад харилцан адилгүй болохыг илрүүлжээ. Өөрөөр хэлбэл хөрсний янз бүрийн хэмжээтэй хэсгүүдийн хийсч эхлэх салхины хурдыг тогтоосон байдаг.

Хүснэгт-26. Карбонат бүхий хар шороот хөрсний

Хөрсний хэсгийн голч, /мм/	Салхины хурд, м/сек	Хөрсний хэсгийн чийг, %	Хөрсний хэсгийн голч, /мм/	Салхины хурд, м/сек	Хөрсний хэсгийн чийг, %,
0.25	3.8	6.1	1-2	11.2	6.5
0.25-0.5	5.3	7.4	2-3	13.1	7.0
0.5-1.0	6.8	7.6	3-5	17.6	6.8

1 мм-ээс бага голчтой хэсгүүд 3.8-6.8 м/сек-ийн салхинд хийсч эхэлж байхад 1 мм-ээс том голчтой хэсгүүд 11.2-17.6 м/сек-ийн хүчтэй салхинд л өнхөрч эхэлсэн байна. Хөрсний гадаргуу дээр ийм их хүчтэй салхи тохиолдох нь маш ховор тул 1 мм-ээс том хэсгээр гадаргуу нь хучигдсан хөрс салхины эвдрэлд барагтай бол орохгүй. Хөрсний хэсгүүдийн дотор 1 мм-ээс том голчтой хэсгүүд 50%-ийг эзэлж байвал салхинд хийсч эхэлдэг тул хөрсний эвдрэлд орох аюултайд тооцдог. Хөрсний өнгөн хэсэгт 0-5 см үед 1 мм-ээс том голчтой хэсэг 45%-иас бага агуулагдаж байвал салхинд тэсвэргүй хөрс, 45-60% байвал дунд зэргийн тэсвэртэй, 60%-иас дээш бол тэсвэртэй хөрсөнд тооцож болохыг тогтоожээ.

Уринш ба ногоон бордоот уринш

Уринш

Уринш нь ээлжлэн тариалах системийн нэг хэсэг бөгөөд хөрсний үржил шимийн бууралтыг багасгах, таримлын ургацыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Чийг дутагдалтай манай орны нөхцөлд хөрсөнд чийг хуримтлуулах, хог ургамалтай тэмцэх зорилгоор уринш бэлтгэж байна.

Уриншийг цулгуй уринш, тарималт уринш, тусгай зориулалттай уринш хэмээн ангилна. Тусгай зориулалттай уриншийг дотор нь ногоон бордоот уринш, хөшигт уринш гэж ангилна.

Талбайг зуны турш байнга боловсруулан өнжөөгөөд дараах жил нь зусах таримал тариалбал цулгуй уринш гэнэ. Европын орнууд шиг чийглэг зөөлөн уур амьсгалтай нутагт бол уриншийн талбайг зуны турш байнга боловсруулан өнжөөгөөд намар өвөлжих таримал тариалдаг.

Цулгуй уринш нь хөрсний нөөц үржил шимийг шавхан дайчлах арга болохоос биш түүнийг нэмэгдүүлдэггүй. Харин ч эсрэгээр нөөц үржил шимийг нэлээд шуурхай барагдуулах, хөрсийг олон сараар ургамлан бүрхэвч, нөмрөггүй байлгасны улмаас хөрс хийсч алдагдах, салхины элэгдэлд нэрвэгдүүлэх эрсдэлд хүргэдэг.

Г.Гунгаанямын судалгаагаар (1996) хөрсний салхины элэгдлийн улмаас цулгуй уриншаас 1 га талбайгаас жилд 47,7 тн шороо хийсдэг нь тогтоогджээ. Нэг га талбай тутмаас хийсч үгүй болох шорооны хэмжээ нь хөрсний хэв шинж, хөрсний эвдрэлийн зэрэглэлээс хамаарч өөр өөр байдаг байна. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй сул эвдэрсэн хөрснөөс жилд дунджаар 25,4тн/га, дунд зэрэг эвдэрсэн хөрснөөс 133,4 тн/га, хүчтэй эвдэрсэн хөрснөөс 213,6тн/га нарийн ширхэгт үржил шимт хөрс, шороо хийсдэг (Н.Нямсамбуу 2004) байна. Иймээс тарималт уринш, тусгай зориулалттай уринш түүний дотор ногоон бордоот уринш бэлтгэж хөрсний нөөц үржил шимийг дээшлүүлэх үр дүнтэй аргыг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ногоон бордоот уринш

Хөрсний физик бүтэц, үржил шимийг дээшлүүлэх зорилгоор ногоон бордуур ургамал, тэдгээр ургамлын иш, навчисыг талбайн хөрсөнд булж өгөх үйл ажиллагааг ногоон бордоо хэрэглэх гэнэ. Энэхүү үйл ажиллагаа нь хучлага хэрэглэх болон нөмрөг таримал тариалахаас ялгаатай ойлголт юм. Учир нь сүүлийн нэрлэсэн хоёр аргыг хөрсийг салхи усны элэгдлээс хамгаалах зорилгоор ашигладаг.

Ногоон бордоо хэрэглэхийн зорилго нь хөрсөнд органик бодис нэмж өгөх, хөрсийг хамгийн ихээр дутагддаг шим тэжээлийн бодис азот (N)-оор баяжуулах явдал юм.

Ногоон бордооны үндсэн хоёр төрөл бий:

1. **In-situ ногоон бордоо:** Хэрэв ногоон бордооны таримал нь үндсэн болон завсрын таримлын зориулалтаар тухайн талбайд тариалагдаж булагдсан бол In-situ- ногоон бордоо гэнэ.

Тэдгээр таримал нь:

- Үндсэн таримал,
 - Мөр хооронд таригдсан таримал,
 - Бүс нутгийн хөрс, уур амьсгалын нөхцлөөс хамаарч цулгуй уриншид тариалсан таримал.
2. Ногоон мөчир, навчисаар бордох: талбайн ойр орчимд ургаж буй мод, бутыг тайрч танах, арчилгаа тордолт хийх явцад гарсан мөчир, навчисаар тухайн талбайг бордох үйл ажиллагаа юм.

Ногоон бордооны үзүүлэлтүүд, чанар: Богино хугацаанд их хэмжээний ногоон массын ургац бүрдүүлж чаддаг байх. Ялангуяа өсөлт хөгжилтийн эхэн үедээ түргэн ургалттай, хог ургамлыг дарангуйлж чаддаг байх.

- Шүүслэг навчтай хэсгийн масс нь модлог хэсгээс илүү их байвал задрах хугацаа нь урт байдаг.
- Агаараас азотыг шингээж хөрсөнд оруулдаг тул буурцагт ургамал байх нь илүү тохиромжтой.
- Хүчирхэг, голлосон үндэсний системтэй байвал хөрсний доод үе давхаргаас шим тэжээлийн бодисыг шингээж хөрсний өнгөн үе давхарга руу шилжүүлж, хөрсний бүтцийг сайжруулдаг.
- Үржил шимээр ядуу хөрсөнд ч ургах боломжтой байх.

Ногоон бордоо хийх хугацаа, арга: Ногоон бордуур таримлыг цэцэглэлтийн өмнөх буюу эсвэл цэцэглэлтийн шатанд хөрсөнд булж өгдөг. Ихэнх ногоон бордуур таримлууд тариалснаас хойш 6-8 долоо хоногийн дараа ногоон массыг хамгийн их хэмжээгээр бүрдүүлдэг ба ногоон масс нь шүүслэг шинэ байдаг.

Ногоон бордоонд ашиглаж байгаа ургамлыг ногоон бордуур таримал гэнэ. Ногоон бордоонд зориулж вандуухай, хошоон, рапс, гиш, вандуй, сэвэг зарам, гандэгээ, ягаан хөцөнгө, царгас, хошоонгор зэрэг таримлыг тариалдаг. Рапс зэрэг буурцагт биш таримлыг азотын бордоогоор бордож ногоон масс их өгдөг учир сайн бордоо болдог байна. Зарим ногоон бордуур таримлыг хадаж малын тэжээлд ашиглаад хэнзийг нь хөрсөнд булж бордоо болгох боломжтой. Үүнээс гадна ногоон бордоог эрдэс ба багсармал бордоотой хамтруулан хэрэглэж болно. Үржил шим багатай, хөнгөн хөрс бүхий талбайд уриншид ногоон бордуур таримал тариалахад үр нөлөө сайтай байдаг. Ногоон бордоо хэрэглэсэн талбайд хог ургамал багатай байдаг нь ургацыг нэмэгдүүлэх бас нэг нөхцөл бүрдүүлдэг.



Зураг-14. Царгас

Шүдлэг хошооны Сэлэнгэ-1 сортын таримал хувилбарыг, МААЭШХ-д Д.Алимаа, Ц.Ариунболд, Ч.Мөнхбат нар, нутгийн дээжүүдээс шалгаруулан бөөний сонголтын аргаар гарган авч, 2014 онд Улсын сорт сорилтын зөвлөлд бүртгүүлсэн Шүдлэг хошоон нь хоёр наст, хөгжлийн хэмээр хоёрдмол хөгжилтэй, өөрөөр хэлбэл өвөлжих ба зусах найлзуур үүсгэдэг, буурцагт ургамал. Шүдлэг хошоон, цагаан хошооныг тариалангийн талбайд ногоон бордуур, нөмрөг таримал байдлаар тариалж хөрсний бүтэц, үржил шимийг сайжруулдаг.

Ногоон бордооны давуу талууд:

3. Хөрсний органик бодисыг нэмэгдүүлж хөрсний бичил организмын үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
4. Хөрсний бүтэц, ус барих чадварыг нэмэгдүүлж, урсалтыг багасган борооны усаар эвдрэх явдлыг бууруулдаг
5. Ногоон бордуур таримал хөрсний доод үе давхаргаас шим тэжээлийн бодисыг сорон авч булагдсан дээд үе давхаргадаа оруулж өгдөг
6. Ногоон бордуур таримал буурцагт ургамал байвал агаараас азотыг шингээж хөрсөнд оруулдаг, ингэснээр сэлгээний дараагийн тарималд ашиглагдана. Ихэнхдээ азотын 2/3 нь агаараас үлдсэн хувь нь хөрснөөс авч ашиглагддаг.
7. Мөн P_2O_5 , Ca, Mg, Fe зэрэг шим тэжээлийн бодисын агууламжийг нэмэгдүүлдэг.
8. Фосфатын бордоог ногоон бордуур буурцагт ургамалд хэрэглэхэд ургац нэмэгдэх, ризо бактерийн тоог огцом нэмэгдүүлж сэлгээний дараагийн тарималд ашиглагдах фосфорын хэмжээг нэмэгдүүлдэг.

Ногоон бордооны сул талууд:

- Хур тунадаснаас хамааралтай нутагт ногоон бордуур таримлын өсөлт хөгжилт, задралд чийг дутагдах тал байдаг тул дараагийн сэлгээний таримлын соёололт, өсөлт хөгжилтөнд нөлөөлөх тал байдаг.
- Ногоон бордуур таримал ургах болон задралын хугацаа нийтдээ 75-80 өдөр үргэлжилнэ.

- Өвчин хортон ихээр гарах тохиолдолд ногоон бордуур таримлын талбайд тархаахгүйн тулд арга хэмжээ авах шаардлагатай болдог.

Мөн ногоон бордоот уринш хийхэд ч малаас хамгаалахад түвэгтэй, хашаа барьдаг ч энэ нь зардал, хөдөлмөр их шаарддаг, мал хашааг эвдэлж сүйтгэх зэргээр тариаланчдад хүндрэл их учруулдаг.

Гэвч тариаланчид энэхүү тулгарах хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг олохыг хичээж, орон нутаг болон өөрийн аж ахуй, компаний хүрээнд чармайн ажиллах хэрэгтэй.

Холимог тариалан

Холимог тариалан гэж нэг талбайд хоёр болон түүнээс дээш таримлыг тариалахыг хэлнэ. Холимог тариалан тариалахад талбайг нарийн зурвасуудад хуваан өөр өөр таримлуудыг тариалдаг. Энэ нь орчин үеийн машин техникийн ажиллагааг хялбарчлах ба таримлууд өсөлт хөгжилтөө харилцан дэмжих үзэгдэл – синергизмийг бий болгодог.



Зураг-15. Холимон тариалан

Хаялбар (контур шугам)-ын дагуу зурваслан тариалах нь

Үүнийг манай судлаачид хэжлүүр тариалан хэмээн монголчилсон ч байдаг. Налуугийн буурах чиглэлд хаялбарын дагуу зурваслан тариалснаар борооны усны хүчийг сааруулж, хөрсний урсалтыг бууруулдаг. Голдуу бага зэргийн налуу талбайд хийнэ. Зурвасыг хэт өргөн хийвэл хөрс борооны усны нөлөөгөөр урсах магадлал их байх тул зурвасыг аль болох нарийн хийх нь зохистой байдаг.



Зураг-16. Хаялбарын дагуу тариалсан байдал

Талбайг амрааж, олон наст ургамал тариалах нь

Европын ХАА-н бодлогын дагуу 1992-2008 оны хооронд газар тариалангийн компани, аж ахуйн нэгжүүд заавал хэсэг талбайг амрааж (ашиглахгүйгээр) үлдээх ёстой гэж заасан байв. Энэ нь үйлдвэрлэлийн хэмжээг бууруулах, компани, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэр дэх биологийн олон талт байдлыг хангах зорилготой юм. Амраах талбайд сэлгээний ээлжинд (жил бүр юмуу, 2 жил тутамд өөр өөр газарт), сэлгээний ээлжинд биш (5-20 хүртэлх жил нэг талбайд) уриншлах таримал тариалах юмуу эсвэл байгалийн жамаар сэргээх зорилгоор үлдээдэг. Уриншийн талбайгаас ялгаатай тал нь үр суулгахаас өөрөөр талбайг хагалж, сэндэчилэх зэрэг боловсруулалт хийгдэхгүй.

Амрааж үлдээсэн талбайг зөвхөн хадах эсвэл пестицид шүршинэ. Амрааж үлдээсэн зарим талбайд зэрлэг цэцэг, зүлэгийг зурваслан тариалж байсан. Энэхүү менежмент нь “хольж тариалсан зэрлэг цэцэгсийн зурвас”, “тариалангийн талбай, бэлчээрийн талбайн захаар үет ургамлын тусгаарлах зурвас” гэсэн хувилбарыг ч багтаадаг.

Англи улсын фермерүүд нийт талбайн 25 орчим хувийг гурав хүртэлх жилээр амрааж, шувууд болон бусад байгалийн зэрлэг амьтдад амьдрах орчин бүрдүүлж өгдөг. Фермерүүд амрааж үлдээсэн талбайг шаардлагатай бол буцаан ашиглалтанд оруулна. Европын холбооны хуулиар амрааж орхисон га талбай тутамд татаас өгдөг. Харин авах татаасын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд зэрлэг амьтдын амьдрах орчин, орон байр болдог талбайн захын мод бут, ургамлан хашлагыг зайлуулахыг хориглодог.

Амраах талбайг арчилгааны арга ажиллагаа нь байгаль орчны байгууллагын үзлэг, хяналт дор явагдах ба арга ажиллагааг өөрчлөх тохиодолд байгаль орчны байгууллагатай зөвлөлдөнө. Тухайн үеийн дүрэм журмаар амрааж үлдээсэн талбайд сонгомол үйлчилгээтэй гербицид цацсан бол 4 дүгээр сарын 15-наас 6 дугаар сарын 1-ний хооронд хадахыг хориглодог. Мөн амрааж үлдээсэн талбайд 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө боловсруулалт хийхийг хориглодог. Эдгээр практикт мөрдөх журмууд нь шувууд үүрээ засах зэрэг байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөг бий болгодог.



Зураг-17. Амрааж олон ургамал тариалсан талбай

Зурваслан тариалалт хийх

Зурваслан тариалах аргыг АНУ, Канад, Казахстаны хөрсний эвдрэл гардаг нутгуудад өргөн хэрэглэдэг. Эрдэмтэн П.С.Захаровын судалгаагаар олон наст өвсний 25 метрийн зурвас 80 метр хүртэл өргөн талбайн зурвасыг салхинаас хамгаалж чаддагийг Казахстан улсын үр тарианы эрдэм шинжилгээний аж ахуйн нөхцөлд тогтоожээ. Кустанайн ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнд явуулсан судалгаагаар зурваслан тариалах аргыг хэрэглэснээр хөрсний эвдрэлийг зогсоож үр тарианы ургацыг 3.9 цн-ээр нэмэгдүүлж байсныг мэдээлжээ. Бушмелева Т.И./1980/ ОХУ-ын Алтайн хязгаарын Хакассын ХАА-н туршлага станцад явуулсан судалгаагаар хөрс нь эвдрэлд дунд зэрэг орсон талбайд уриншийн зурвасны өргөн 50 хүртэл метр эвдрэлд хүчтэй орсон талбайд 25-30 метр хүртэл багасгах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрчээ. Манай улсад хийсэн судалгаагаар зурвасны өргөн 50-100 метр байж болно гэж үздэг.

Хөнгөн механик хөрстэй, салхины хүч ихтэй, хөрсний гадаргууд гуурс, ургамлын үлдэгдэл бага байдаг нутгуудад хөрс хамгаалах ээлжлэн тариалах систем хэрэглэдэг. Үүний дотор зурваслан тариалах буюу нэг, олон наст таримал ургамлын тариалангийн хоорондуур уриншийг түүнтэй салаавчлан нарийн зурвасаар байршуулдаг.

Тариалангийн талбайг зурваслах зарчим нь:

1. Тариалангийн төв бүс нутагт салхи 3-р сарын 20-оос 5-р сарын 25-ыг хүртэл хүчтэй салхи ихэвчлэн баруун, баруун хойт зүгээс ажиглагддаг тул зурвасыг хүчтэй салхитай үеийн голлох салхины чигийн хөндлөн байршуулах нь зүйтэй.
2. Элсэнцэр хөрстэй талбайд зурвасны өргөн бага 30 м хүртэл, шавранцар хөрсөнд тапбайн байршил бусад хүчин зүйлээс хамааран 50-100 м байхаар зурвасны өргөнийг зөв тогтоох.
3. Хөрсний бүтэц, салхины хүчээс гадна талбайн байршлыг нэг бүрчлэн бодолцож тэнд салхи аль зүгээс салхилдаг, салхиныхаас гадна усны эвдрэл гарах эсэхийг нарийвчлан авч үзэхийн гадна үрлүүр, сийрүүлүүр- комбайны хадуурын өргөнийг тооцоолон илүү явалт гаргахгүйгээр тооцоолж зурвасын өргөнийг тогтооно.

Хөрс ядуурах

Хөдөө аж ахуйн таримал ургамлын ургац буурдаг шалтгааны нэг нь таримлыг ээлжлэн тариалахгүйгээр дагнан тариалснаас хөрс ядуурдаг байна. Хөрс ядуурах гэдэг ойлголтод хөрсний үржил шим ихээр буурч өвчин, хортон дэлгэрч, тухайн тарималд хортой нөлөө үзүүлдэг бодис хөрсөнд буй болохыг хэлдэг. Хөрс ядуурах үйл явцад өөрөөр хэлбэл нэг таримал ургамлыг дахин давтан тариалахад ургац нь буурахад ургамал үндэснээсээ хөрсөнд ангижруулж байгаа ургамлын янз бүрийн хаягдал чухал үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл ургамлын үлдэгдлээс буюу ургамлын үлдэгдлийн ялзарсан хэсгээс хортой бодис ялгардаг байна. Таримал олон ургамлын гуурсны үлдэгдэл буудай, сорго, эрдэнэшишийн үрийн ургалтыг зогсоодог буюу нялх соёоны ургалтыг саатуулдаг уусамтгай бодис агуулагддагийг тогтоосон байна.

Ялангуяа соргогийн үлдэгдэлд буудайн анхдагч үндэсний 75 хувийг үхүүлдэг их хортой бодис илэрсэн байна.

Нэг төрлийн ургамлыг олон жил дагнан нэг талбайд тариалан ургамлын үндэс тархах хөрсний гүнд бичил организмын тоо цөөрснөөс хөрсний биологийн идэвхитэй үйл ажиллагаа буурдаг байна.

Сангас исгэж бордоо хийх: Хөрсний үржил шим ядууран таримлын ургац хэвийн хэмжээнд хүрэхгүй үед химийн бордоо хэрэглэж, зориудаар ургацыг нэмэгдүүлэх арга хэмжээ авдаг. Энэ нь экологийн цэвэр, эрүүл мэндэд тустай хүнсний бүтээгдэхүүн авахад сөрөг нөлөө үзүүлнэ. Харин бид таримал ургамалд ашиглагдах тэжээлийн бодисын агууламж ихтэй, байгалийн цэвэр бордоо “шувууны сангас”-ыг ашиглан уламжлалт аргаар бордоо хийх бага оврын үйлдвэрийг Баянчандмань суман дахь шувууны фермерийг түшиглэн байгуулахаар төлөвлөгөөнд тусгаж байна.

Шувууны сангас ургамалд ашиглагддаг тэжээлийн бодис агуулсан шим бордоо юм. Сангас нь азот, фосфор, калийн агууламжаар их байдаг. Төмөр болон модон торх бэлтгээд 50 литр усанд 5-6 кг сангас хийнэ. 7 хоног торхныхоо амыг даавуу, нийлэг уугаар сайтар таглан исгэнэ.

Мөн иссэний дараа торхонд 50 литр ус нэмж 100 литр шингэн бордоо бэлтгэнэ. Ийнхүү бэлтгэсэн шингэн бордоог үр тариа болон төмс, хүнсний ногооны талбайд таримлын ургалтын хугацаанд 6,7,8-р сард нэмэлт бордоо болгон хэрэглэнэ. Шувууны сангас таримлын ургацыг 25-30 хувь нэмэгдүүлдэг.

Усалгаатай тариалалтын үед усалгааны хамт исгэсэн сангасыг хольж усална. Талбайн хэмжээнээс хамаарч нормыг тогтооно. Хүнсний ногооны талбайн хэмжээ ихэвчлэн 6-10м² байдаг учир 10 литр иссэн сангасаар бордоно.

Тариалангийн талбайг ээлжлэн тариалах систем

ХАА-н таримал ургамлыг ээлжлэн тариалахгүйгээр нэг талбайд дагнан тариалбал өвчин, хортон их дэлгэрдэг, ургац нь үлэмж буурдаг. Ээлжлэн тариалахын гол зорилго нь таримал ургамлын шаардлагыг цаг уур, хөрсний шинж чанаруудтай нийцүүлэх явдал юм.

Тариалж байгаа таримал ургамлын биологийн шаардлагыг хөрсний нөхцөлүүдтэй уялдуулан үзвэл тэдгээрийн хооронд шим тэжээлийн бодис, чийгийн горим, бусад хүчин зүйлүүдийн ялгаа гардаг. Эдгээр ялгааг хамгийн бага байдалд хүргэх арга ээлжлэн тариалах болон агротехникийн бусад арга хэмжээ, тухайлбал сорт, таримлыг сонгох, бордоо хэрэглэх, чийг хуримтлуулах хамгаалах гэх мэт юм.

ХАА-н таримал ургамлыг ургуулах агротехникийн арга хэмжээг нарийвчлан төлөвлөх асуудал зөвхөн ямар таримлуудыг тухайн талбайд яаж ээлжлэн тариалахаас хамаардаг. Тариалахаар төлөвлөж буй сорт, таримал ургамлын онцлогт хөрсний хүчин зүйлүүдийг харгалзан тогтоож болно. Энэ утгаар ээлжлэн тариалалт нь агротехникийн үндэс болдог. Үүнд үндэслэн ургамлын онцлогийг хөрсний шинж чанартай уялдуулах агротехникийн арга хэмжээнүүд боловсрогдон төлөвлөгддөг. Урьдавчаар олон наст ургамал байсан хөрс нь тухайн хөрсний байгалийн шинж чанараас ч илүү нөлөө дараачийн тарималд үзүүлдэг.

Харин нэг наст ургамал урьдавч нь байсан талбайд тийм ч их хүчтэй нөлөөлөл үзүүлэхгүй ч зарим тохиолдолд агротехникийн арга хэмжээгээр зохицуулагдахааргүй тохиолдол байдаг.

Ээлжлэн тариалах систем нь ХАА-н таримал ургамлын ургацанд эерэгээр нөлөөлдөг болохыг дараах гурван үндэслэлээр тайлбарлаж болно.

- 1) Ургамал тэжээлээ авахад химийн нөлөөний шалтгаан
- 2) Хөрсний гол шинж чанар өөрчлөгдсөнөөс ургамал ургахад нөлөөлөх шалтгаан
- 3) Биологийн шалгаанууд, тухайлбал өвчин хортон, хог ургамал тархсан байдаг, бичил биетний идэвхижилт, г.м.
- 4) Ээлжлэн тариалалтын эдийн засгийн үр ашиг

Хөрсний шим тэжээлийн агууламжид ээлжлэн тариалалтын нөлөө:

Ээлжлэн тариалах таримлууд дотор өргөн мөрт таримлын эзлэх хувийн жин нэмэгдэх хирээр хөрсөнд үлдэх ургамлын үлдэгдэл багасдаг байна.

Хүснэгт-27. **Хөрсний 0-30 см-ийн гүн дэх ургамлын үлдэгдэл /жилийн дундаж/**

ЭТС-д эзлэх талбай, %			Ургамлын үлдэгдлийн тоо	
Өргөн мөрт таримал тарьсан	Үр тариа тарьсан	Олон наст өвс тарьсан	ц/га	%
37.5	50	12.5	39.7	100
66.7	33.3	-	29.6	74
75.0	25.0	-	25.6	64

Талбайн гадаргуугийн га тутамд үлдээсэн ургамлын үлдэгдэл ээлжлэн тариалалтын бүтцэд өргөн мөрт таримал 37.5% байхад 39.7 цн, 75% болгож өсгөхөд 25.6 цн болж буурсан байна.

Ургамал хоол тэжээлийнхээ бодисыг хөрснөөс авах хэмжээ, ургамлын үндэснээс ялгаруулах бодис нь бичил биетнүүдийн үйл ажиллагаанаас хамаарна. Бичил биетнүүдийн үйл ажиллагаа ургамалд ашиглагдах эрдэс бодис, азотын хэмжээнд ихээр нөлөөлнө. Азотын эргэлтэд оролцдог бичил биетнүүд гол төлөв хагалгааны гүнд байрших бөгөөд тариалангийн төв бүсэд 5-р сараас эхлэн үйл ажиллагаагаа эрчимжүүлж, тоогоо олшруулсаар 8-р сар дуустал хамгийн өндөрт хүрээд цаашид буурдаг. Ээлжлэн тариалахгүйгээр, байнга ашигласан талбайд азотын эргэлтэд оролцдог нянгийн тоо 30-35%-иар бага байдаг. Харин ээлжлэн тариалалт хийж хөрс сайн боловсруулан бордоо хэрэглэхэд нянгийн тоо 40-70%-иар нэмэгддэг байна. Иймээс ээлжлэн тариалах, хөрс боловсруулах, бордох үйл ажиллагааг хөрсөнд ялзмаг, азот, ургамалд ашиглагдах шим тэжээлийн бодис хуримтлуулахад чиглүүлэх, бичил биетний үйл ажиллагааг идэвхижүүлэх, тэдгээрийн тоо, хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлөх нь чухал. Нөгөө талаар зарим таримал ургамалд ашиглагдахааргүй хэлбэрт байгаа шим тэжээлийн бодисыг ашиглагдах хэлбэрт оруулдаг байна. Сагаг, шошлой, хошуу будаа зэрэг ургамлууд хөрсөн дэх фосфороор өөрийгөө хангаад зогсохгүй, хөрсөнд үлдээдэг байна.

Буурцагт ургамлууд хөрсөнд азотыг үлдээж ургамлын хоол тэжээлд чухал нөлөө үзүүлдэг. Царгас тариад гурвад жил болсон талбайн га тутамд дунджаар 300 кг азот хуримтлагдаж, 150 кг нь үлддэг, хошоонгорыг тариалаад 2 жил болсон талбайд 150 кг азот хуримтлагдаж хөрсөнд 75-100 кг нь үлддэг. Буурцагт үр тариа хөрсөнд 50-60 кг азот ургалтынхаа хугацаанд хуримтлуулдаг боловч хөрсөндөө бараг үлдээдэггүй. Гэхдээ хөрсний азотыг өөртөө зарцуулдаггүй.

Буурцагт ургамлыг нэг га талбайд хэдэн жил дараалан тариалахад булцуу үүсгэх бичил биетний хөгжилд муу нөлөөлдөг учраас буурцагт ургамлыг өөр ургамалтай сэлгэж тариалан хуримтлуулсан азот дараачийнхаа таримал ургамлын ургацад үзүүлэх таатай нөлөө нь зөвхөн чийгийн хангамж сайтай нөхцөлд сайн илэрдэг.

Газар тариалангийн үйлдвэрлэлд ялангуяа ирээдүйд тариалж буй таримлынхаа эрдэс бодис, азотын хэмжээг үндэслэн шим эрдэс бордооны зохих нөөцтэй байвал таримлыг бордох бордооны системийг боловсруулан хэрэглэж болно.

Хөрсний чийг, ээлжлэн тариалалт: Хөрсний шим, тэжээлийн бодисын зэрэгцээгээр ургамлын амьдралд хөрсний чийг чухал хүчин зүйл болдог. Хөрсний чийг нь түүний хоол, тэжээл, дулаан, агааржуулалтын горим, биологийн үйл явцад дам нөлөө үзүүлдэг. Хэрэв хур тунадас орохгүй, ургамлыг услахгүй бол ургамлын хөгжилт түүний бүх амьдрал хөрсөнд байгаа бүтээгдэхүүнт чийгнээс шууд хамаарна. Бүтээгдэхүүнт чийг нь хөрсөнд байгаа нийт ус, хөрсний хамгийн бага чийгийн багаамж, түүний гундах чийгийн хэмжээнээс шалтгаална.

ХАА-н таримал ургамлыг тариалах, хөрс боловсруулах аргууд хөрсний ус нэвтрүүлэх чадварт нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл хур тунадасны болон усалгааны усыг нэгж хугацаанд шингээх чадварт хөрсний бүтэц, хөрс боловсруулах арга, тариалсан таримлууд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг.

Хөрсний бүтэц сайжирч, нягтралт нь багасах тутам ус нэвтрүүлэх чадвар дээшилнэ. Бүтэц муутай, нягтарсан хөрс ус, чийгийг муу шингээдэг. Манай оронд тариалж буй зусах үр тарианы ургалтын эхний үе шатанд буюу зуны эхний хагаст чийг дутагдагаас ургац нь их хэмжээгээр буурдаг.

Үр тариа, хүнсний ногоо, техникийн болон тэжээлийн ургамлуудын ус хэрэглэх хэмжээг ургамал ургалтын үе шат, хөрсний чийг, унах тунадасны хуваарилалттай уялдуулан ямар сортууд чийгийн хангамж сайн байхыг тогтоож болно. Царгас, чихрийн манжин, наранцэцэг мэтийн үндэс нь хөрсний гүнд тархдаг /3-3.5 метрт/ таримлууд хөрсийг гүнээс нь чийггүй болгодог бөгөөд эдгээр таримлын хэрэглэсэн чийгийг услахгүй бол 4-5 жилийн дараа бүрэн нөхнө.

Саглагар, шигүү үндэстэй ургамлууд хөрсний чийгийг сайн ашигладаг. Тийм үндэстэй ургамалд үет олон наст ургамлууд орно. Харин сонгино, хэмх, цоохор маальз зэрэг ургамлуудын үндэс нь хөрсний бага гүнд тархдаг тул тэдгээрийг тариалахад сайн услах хэрэгтэй болдог. Төмсний үндэсний систем муу хөгжсөн байдаг тул ялангуяа, ургалтынхаа эхний үе шатуудад хөрсний 0-30 см-ийн гүнд чийг хангалттай байхыг шаарддаг.

Үндэсний хөгжил муутай буюу хөрсний бага гүнд тархдаг үндэстэй таримал тариалсан талбайд бүтээгдэхүүнт чийг их үлддэг тул дараа нь хүчирхэг үндэстэй таримал тариалж болно.

Хог ургамал, өвчин, хортонтой тэмцэхэд ээлжлэн тариалалтын үүрэг:

Ихэнхи хог ургамал нь өөрийн амьдралын явцад тодорхой таримал ургамлын өсөлт хөгжилтөнд өөрийнхөө өсөлт хөгжилтийг тохируулсан байдаг. Тухайлбал, зусах үр тарианы талбайд нэг хэсэг хог ургамлууд тархаж зохицсон байдаг бол өргөн мөрт таримлынхад өөр хэсэг хог ургамал, олон наст өвснийхөд гуравдахь хэсэг хог ургамлууд зохицон ургана.

Таримал ургамлыг хог ургамлын өсөлттэй өрсөлдөх чадвараар нь гурав хуваадаг байна. Үүнд:

- 1) Өрсөлдөх чадвар сайтай ургамлууд /өвөлжих үр тариа, олон наст өвс, г.м./
- 2) Дунд зэрэг өрсөлдөх чадвартай /арвай, овъёс, наранцэцэг, эрдэнэшиш, г.м./
- 3) Өрсөлдөх чадвар муу таримлууд /зусах буудай, бог будаа, төмс, чихрийн манжин,г.м

Ийнхүү гурван хэсэгт хуваасан нь биологийн үүднээс өрсөлдөх чадварыг нь үзсэнээс гадна тэдгээрийг ургуулахад хэрэглэж буй агротехникээс хамааруулсан байдаг. Нэг таримлыг эсвэл биологийн шинжээр ижил төрлийн таримлыг жил дараалан тариалахад хог ургамал мэдэгдэхүйц ихэсдэг нь эдгээр хог ургамал биологийнхоо хувьд боловсрох хугацаа, өсөлт хөгжилтийн үе шатаараа таримал ургамлаас арай эрт байдаг.

Таримлыг бордох эсвэл услахад хог ургамлын төрөл, зүйл өөрчлөгдөж хөрснөөс шим тэжээлийн бодис, бордоог сайн ашигладаг хог ургамлууд зонхилдог. Тухайлбал азотын бордоогоор бордоход лууль, зэрлэг бог будаа, хээрийн сармаг илүү ургадаг бол фосфорын бордоогоор бордоход хөдөөгийн шаралзгана, калийн бордоогоор бордоход хөдөөгийн бираага, зангуу, хөдөөгийн шаралзгана илүү ургадаг байна.

Тариалангийн талбайг услахад хог ургамлын төрөл өөрчлөгдөж ус, чийгэнд дуртай, түр зуурын их чийгийг тэсвэрлэдэг хог ургамлуудын /урвуу гагадай, ногоон хоног будаа, чөдөр сэдэргэнэ, хамхуул/ тоо ихэснэ. Мөн урьдавчаасаа хамаарч талбайд тархах хог ургамал харилцан өөр байдаг бөгөөд төмс тариалж байсан талбайд чихрийн манжингийн дараа тариалсан үр тарианы талбай хог ургамалгүй шахам байхад үр тарианы дараа дахин үр тариа тариалсан талбайнх үлэмж ихэсдэг байна.

ХОЁР. ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

2.1 Зам, шугам сүлжээний газрын ашиглалтын байдал

Тус аймгийн зам, шугам сүлжээний газар нь 2020 оны байдлаар аймгийн нийт нутаг дэвсгэрийн 0.1 хувь буюу 7.9 мян.га талбай эзэлж байна. Үүнээс авто замын газар нь 4.6 мян.га буюу 58.23 хувь, агаарын тээврийн газар нь 0.1 мян.га буюу 1.27 хувь, шугам сүлжээний газар нь 3.2 мян.га буюу 40.51 хувийг тус тус эзэлж байна.

ГНС-ийн шинэчилсэн тооллого, бүртгэлийн ажлыг 2020-2021 оны хооронд газрын мэргэжлийн байгууллага “АТТП” ХХК нь төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах гэсэн судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгааны ажлыг өндөр нарийвчлалын сансрын зураг, хот, тосгон бусад суурин газрын газар ашиглалт болон өөрчлөлтийг дроны зураглал, хээрийн хэмжилт судалгааны ажилд тулгаарлан хийж гүйцэтгэсэн байна

Тус аймгийн зам, шугам сүлжээний газрын газар ашиглалтын дэд ангилалд 2017-2020 оны хооронд хэрхэн өөрчлөлт гарсаныг доорх хүснэгтээр харууллаа (<http://www.1212.mn/>).

Хүснэгт-28. Зам шугам сүлжээний газрын өөрчлөлт, мян.га

Зам шугам сүлжээний газрын газар ашиглалтын ангилал	2017		2018		2019		2020		Өөрчлөлт Мян.га (+,-)
	Мян.га	Хувь	Мян.га	Хувь	Мян.га	Хувь	Мян.га	Хувь	
Зам, шугам сүлжээний газар	8.07	100	8.07	100	8.07	100	7.9	100	-0.17
Авто замын газар	4.74	58.74	4.74	58.74	4.74	58.74	4.6	58.23	-0.14
Агаарын тээврийн газар	0.06	0.74	0.06	0.74	0.06	0.74	0.1	1.27	-0.68
Шугам сүлжээний газар	3.26	40.40	3.26	40.40	3.26	40.40	3.2	40.51	-0.06

Эх үүсвэр: <http://www.1212.mn/>

Дээрх хүснэгтээс харахад тус аймгийн зам шугам сүлжээний газар нь 2017 онд 8.07 мян.га байсан бол 2020 оны жилийн эцэст 7.9 мян.га гэж газрын нэгдмэл сангийн тайланд тусгагдсан байна. Энэ нь ойролцоогоор 4 жилийн хугацаанд (-0.17 мян.га)-аар буурсан байна. Үүнээс: агаарын тээврийн газар нь 2017 онд 0.06 мян.га байсан бол 2020 оны жилийн эцэст 0.74 мян.га болж (-0.68 мян.га)-аар нэмэгдсэн, шугам сүлжээний газар нь 2017 онд 3.26 мян.га байсан бол 2020 оны жилийн эцэсийн байдлаар 3.2 мян.га болж (-0.06 мян.га)-аар буурч тус тус өөрчлөлт орсон байна.

2.2 Авто замын газрын төлөвлөлт

Авто замын газар нь 2017 онд 4.74 мян.га байсан бол 2020 оны жилийн эцэсийн байдлаар 4.6 мян.га болж (-0.14 мян.га)-аар буурч өөрчлөлт орсон байна. Энэхүү өөрчлөлт нь голлон хэмжил, бүртгэлийн нарийвчлан сайжирснаас үүдэлтэй балансын зөрүү юм.


Хүснэгт-29. Одоо байгаа авто замууд

Д/д	Авто замын сүлжээгээр холбогдох замнал. /холбогдох хот,суурин, ордууд, хатуу хучилттай замын нэр/	Замын хучилтын төрөл	Хэмжээ /км/
1	Арвайхээр-Баянхонгор	Хатуу хучилттай авто зам	57.51
2	Баян-Овоо сум	Хатуу хучилттай авто зам	0.5
3	Баян-Овоо сум	Хатуу хучилттай авто зам	0.2
4	Баянхонгор сум	Хатуу хучилттай авто зам	12.38
5	Баянхонгор-Алтай	Хатуу хучилттай авто зам	223.75
6	Баацагаан-Баян-Овоо	Ердийн зам	130.48
7	Баацагаан-Жинст	Ердийн зам	65.52
8	Баянбулаг	Ердийн зам	34.12
9	Баянбулаг	Ердийн зам	54.41
10	Баянбулаг-Гурванбулаг	Ердийн зам	59.59
11	Баянбулаг-Гурванбулаг-Заг	Ердийн зам	87.56
12	Баянбулаг-Хүрээмарал	Ердийн зам	42.45
13	Баянбулаг-Хүрээмарал	Ердийн зам	49.79
14	Баянговь	Ердийн зам	16.34
15	Баянговь сум	Ердийн зам	44.62
16	Баянговь сум	Ердийн зам	92.96
17	Баянговь-Жинст	Ердийн зам	164.33
18	Баянлиг	Ердийн зам	9.18
19	Баянлиг	Ердийн зам	74.55
20	Баянлиг сум	Ердийн зам	106.05
21	Баянлиг сум	Ердийн зам	31.52
22	Баянлиг-Баянговь	Ердийн зам	43.45
23	Баянлиг-Богд	Ердийн зам	75.87
24	Баян-Овоо	Ердийн зам	58.94
25	Баян-Овоо-Эрдэнэцогт	Ердийн зам	36.84
26	Баян-Өндөр-Баянцагаан-Баацагаан	Ердийн зам	147.72
27	Баян-Өндөр-Шинэжинст сум	Ердийн зам	126.41
28	Баянхонгор-Жинст	Ердийн зам	91.68

29	Баянхонгор-Эрдэнэцогт	Ердийн зам	27.33
30	Баянцагаан сум	Ердийн зам	48.59
31	Баянцагаан-Баацагаан	Ердийн зам	82.11
32	Баянцагаан-Баянговь	Ердийн зам	54.03
33	Баянцагаан-Баян-Өндөр	Ердийн зам	37.26
34	Баянцагаан-Баянхонгор	Ердийн зам	185.03
35	Баянцагаан-Бөмбөгөр	Ердийн зам	164.58
36	Баянцагаан-Шинэжинст	Ердийн зам	60.28
37	Богд	Ердийн зам	66.71
38	Богд сум	Ердийн зам	27.47
39	Богд сум	Ердийн зам	27.47
40	Богд сум	Ердийн зам	78.46
41	Богд-Жинст	Ердийн зам	27.92
42	Бөмбөгөр	Ердийн зам	26.06
43	Бууцагаан	Ердийн зам	36
44	Бууцагаан сум	Ердийн зам	9.4
45	Бууцагаан-Баацагаан	Ердийн зам	81.93
46	Бууцагаан-Заг	Ердийн зам	87.12
47	Галуут-Баян-овоо-Баянхонгор	Ердийн зам	79.06
48	Галуут-Бөмбөгөр	Ердийн зам	72.05
49	Гурванбулаг	Ердийн зам	82.02
50	Гурванбулаг	Ердийн зам	87.7
51	Гурванбулаг-Заг	Ердийн зам	63.95
52	Жаргалант	Ердийн зам	161.78
53	Жаргалант сум	Ердийн зам	42.3
54	Жаргалант-Галуут	Ердийн зам	78.64
55	Жаргалант-Заг	Ердийн зам	26.69
56	Жинст сум	Ердийн зам	101.01
57	Заг-Галуут-Жаргалант	Ердийн зам	125.29
58	Заг-Хүрээмарал	Ердийн зам	94.71
59	Заг-Хүрээмарал-Бууцагаан	Ердийн зам	112.74
60	Өлзийт	Ердийн зам	4
61	Өлзийт сум	Ердийн зам	53.99
62	Хүрээмарал	Ердийн зам	54.14
63	Хүрээмарал сум	Ердийн зам	53.41
64	Хүрээмарал-Бууцагаан	Ердийн зам	60.66
65	Хүрээмарал-Бууцагаан	Ердийн зам	42.54

66	Хүрээмарал-Бууцагаан- Бөмбөгөр-Баянхонгор	Ердийн зам	232.98
67	Шинэжинст	Ердийн зам	122.4
68	Шинэжинст	Ердийн зам	70.83
69	Шинэжинст	Ердийн зам	67.7
70	Шинэжинст сум	Ердийн зам	88.38
71	Шинэжинст-Баацагаан	Ердийн зам	124.61
72	Шинэжинст-Баянговь сум	Ердийн зам	66.67
73	Эрдэнэцогт	Ердийн зам	65.53
74	Эрдэнэцогт-Өлзийт-Баянхонгор	Ердийн зам	87.78

Замын сүлжээний инженерийн шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газар нутгийг төлөвлөхөд газар ашиглалтын салбар хоорондын уялдааг хангах, ой, усны сан бүхий газар, тариалангийн газар, манхан элс, намаг, мөнх цас, нуур, байнгын урсгалтай гол горхи, байгаль, түүх, соёл, археологийн дурсгалт газраас аль болохоор хол байршуулахаас гадна, өвөлжөө хаваржаа, хадлангийн талбай зэрэг бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газартай давхцуулахгүй байх, нөхөн олговор олгох, газрыг дүйцүүлэн хамгаалах, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх зэрэг газар зохион байгуулалтын ажилтай нягт уялдуулан төлөвлөхөд тавигдах шаардлагуудыг газар ашиглалтын суурь нөхцөл гэж үзнэ (Хүснэгт 30).



Зураг-18. Одоо байгаа авто замууд

Хүснэгт-30. Замын сүлжээний байгуулах газар ашиглалтын суурь нөхцөл, тавигдах шаардлага

№	Шаардлага тавигдах хүчин зүйл	Замын сүлжээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөлт, төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага
1	Ойн сан бүхий газар	Ойн сан бүхий газрыг дайран өнгөрөх замын трассыг төсөвлөхдөө аль болох мод багатай хэсгийг сонгож, мод тайрахаас зайлсхийх, зайлшгүй тохиолдолд ойн сангийн газрын дүйцүүлэн хамгаалалтыг хийх
2	Усны сан бүхий газар	Гол, мөрөн, нуур, тойром, рашаан, булаг, шандаас хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүйгээр тооцно.
3	Элс	Элс бүхий газраас аль болох зайлсхийх
4	Мөнх цэвдэг	Мөнх цэвдэг болон газар доорх мөсжилтэй газар дээгүүр өнгөрөх замын зураг төсөлд дараах зүйлийг тусгах явдлыг анхаарвал зохино. Үүнд: -Хүлэр бүрхэвч бүхий газраар дайруулахгүй байх, -Замын инженерийн шугаман байгууламжийн техникийн шийдэлд саад болохгүй тохиолдолд аль болох мөнх цэвдгийг дайруулахгүй байх, -Аль болох сэтэрхий хийхээс зайлсхийх, сэтэрхийг зайлшгүй шаардлагын улмаас баривал налуулгийн гажилт нуранги үүсэх, мөстөх, ул шорооны үндсэн суурь усанд автахаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байх
5	Зэрлэг амьтан, гэрийн мал, тэжээвэр амьтан	- Замын сүлжээ нь үндэсний болон тухайн бүсийн нутаг дэвсгэрийн нийтлэг эрх ашиг, ашиг сонирхолтой нийцсэн байх - Малчдын улирлаар бэлчээр ашиглах нүүдлийн зам, гарц гаргах, зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөн, нүүдэллэх зам, бусад онцлогийг тооцон тэдгээрийн хэвийн амьдрах нөхцөлийг хангах стандартын шаардлага хангасан төмөр болон авто замыг хөндлөн гарах төрөл бүрийн бусад гарц /чиглүүлэгч хаалт бүхий/ заавал барих шаардлагатай. -Шинээр барих төмөр замыг малын бэлчээр, үржил шимт хөрстэй хадлан бэлчээрийн газрыг аль болох тойрч гарах -Тариаланд тохиромжтой болон тариалангийн газраар дайруулахгүй байх. -Зайлшгүй шаардлага, газарзүйн нөхцөл, орон зайн хувьд өөр хувилбар сонгох боломжгүйгээс бусад

		тохиолдолд ТХГН-ийн хязгаарлалтын бүсээс бусад бүсийг дайрч өнгөрөхгүй байх. -Газар ашиглалт, нөхөн олговрын асуудлыг шийдэх, байгаль, экологийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс авто болон төмөр зам барихаар газар сонгохдоо орон нутгийн удирдлага, газрын харилцаа, байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөн байх. -Газрын сервитутын эрхийг хангасан байх
6	Хот, тосгон, бусад суурины газар	-Хот суурины газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулах, хот, суурины дундуур дайрч гарахгүй, тодорхой зайд тойрч гарахаар төлөвлөх -Нөөц нь тогтоогдсон орд бүхий талбай дээгүүр дайрахгүй бай
7	Байгаль, түүх соёл, археологийн дурсгалт газар	Аль болох хол зайтай байх (хамгаалалтын бүсийг 500 метрээр татах)
8	Нөхөн олговор	Газрын эрх бүхий болон эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдэд нөхөн олговор олгох
9	Газрыг дүйцүүлэн хамгаалах	Зам барьж байгуулахад газрын төлөв байдлыг өөрчилж, унаган төрхийг эвддэг тул хууль журам, стандарт, зааврын дагуу зураг төсөвт газрыг дүйцүүлэн хамгаалах зардлыг тусгаж хэрэгжүүлэх

Эх сурвалж: Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд авто замын газрын төлөвлөгөөг дараах хоёр үе шаттайгаар төлөвлөсөн байна. Үүнд:

✓ 1-р үе шат 2017-2020: Нэн тэргүүн ээлжинд хэвтээ тэнхлэгийн замын сүлжээг барьж дуусгаж аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар нийслэлтэй холбох, ХАА-н бүтээгдэхүүний экспортын ойрын ирээдүй, зах зээлийн боломж, улс бүс нутгийн чанартай

рашаан сувилал, аялал жуулчлалын зам тээврийн нөхцөлийг эн тэргүүнд сайжруулах хэрэгцээ, шаардлагыг харгалзан олон улсын болон улсын чанартай мөн тусгай зориулалтын замуудыг барихаар төлөвлөжээ.

✓ 2-р үе шат 2020-2024 он: Эдийн засгийн бүс, бүс хоорондын босоо тэнхлэгийн замыг барих ажлыг эрчимжүүлэх, бүс доторх болон бүс хооронд аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар холбож, бүсүүдийн дотоод болон бүс хоорондын нийгэм, эдийн засгийн харилцааны таатай орчинг бүрдүүлэх, олон улс хоорондын зам тээврийн сүлжээтэй нэгдэж холбогдох, хил залгаа орнуудын бүс нутаг, мужуудтай

хамтын ажиллагаа, зах зээлийн харилцаанд оролцох хилийн боомтуудыг ойролцоох аймаг, сумын төвүүд, хэвтээ босоо тэнхлэгийн замуудтай холбохоор төлөвлөсөн байна.

Улсын ГЗБЕТ-нд олон улсын чанартай хилийн боомтуудыг холбохоор төлөвлөсөн авто замууд, тусгай зориулалтын аялал жуулчлалын зориулалттай авто замууд, орон нутгийн чанартай дараах чиглэлийн автозамуудыг барихаар төлөвлөсөн (Хүснэгт 31).

Хүснэгт-31. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт баригдах авто замын төлөвлөлт


Авто замын чиглэл	Авто замын сүлжээгээр холбогдох замнал./холбогдох хот, суурин, ордууд, хатуу хучилттай замын нэр/	Замын ангилал, зориулалт	Хэрэгжих хугацаа	Урт /км/
Олон улсын чанартай авто зам (Улсын ГЗБЕТ-нд 2-р үе шатанд хэрэгжих авто замууд)				
Баянхонгор-гурван тэс-шивээхүрэн	Баянлиг-Богд-Жинст-Баянхонгор	Хатуу хучилттай авто зам	2024-2037	283.92
Арвайхээр-гурван тэс - Шивээхүрэн	Арвайхээр-Гурвантэс-Баянлиг-Шивээхүрэн	Хатуу хучилттай авто зам	2024-2037	67.3
Тусгай зориулалтын аялал жуулчлалын зам				
Бууцагаан-Баянбулаг-Отгон-Улиастай	Бууцагаан-Хүрээмарал-Баянбулаг-Отгон-Улиастай	Хатуу хучилттай авто зам	2026-2037	135
Баянхонгор-Шаргалжуут	Эрдэнэцогт-Өлзийт-Шаргалжуут	Хатуу хучилттай авто зам	2022-2037	50.65
Орон нутгийн чанартай авто зам				
Баянхонгор - Эрдэнэцогт	Баянхонгор - Эрдэнэцогт	Хатуу хучилттай авто зам	2026-2037	26.38
Баянхонгор - Гурванбулаг	Баянхонгор- Баян-Овоо- Галуут-Жаргалант - Заг - Гурванбулаг	Хатуу хучилттай авто зам	2026-2037	241.8



Зураг-19. Авто замын төлөвлөлт

Авто замын гүүр:

Баянхонгор аймгийн Заг суманд 2022-2026 онд 2 гүүр, Эрдэнэцогт суманд 2 гүүр, Жинст суманд 1 гүүр, Богд суманд 1 гүүр, 2026-2031 онд шинээр барихаар төлөвлөлтөнд орууллаа.



Зураг-20. Баянхонгор аймгийн гүүрний төлөвлөлт


Хүснэгт-32. Баянхонгор аймгийн сумдад шинээр барих гүүрнүүд

Сумын нэр	№	Байршил	Солбилцол		Төлөвлөлт хугацаа
			Уртраг	Өргөрөг	
Заг сум	1	Загийн гол	99° 10' 14.74"	46° 56' 40.565"	2022-2037
	2		99° 17' 47.73"	46° 51' 19.686"	2022-2037
Эрдэнэцогт сум	3	Өртөмт	100° 56' 57.519"	46° 33' 16.904"	2022-2037
	4	Түйн гол Бригадын ар	100° 54' 40.298"	46° 36' 15.258"	2022-2037
Жинст сум	5	Хавцгай ам	100° 41' 21.272"	45° 36' 59.914"	2022-2037
Богд сум	6		100° 46' 49.020"	45° 11' 33.405"	2022-2037

2.3 Төмөр замын сүлжээний төлөвлөлт

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шинээр байгуулах, шинэчлэн зохион байгуулах “Шинэ төмөр зам”-ын бүтээн байгуулалт нь үндсэн 3 үе шаттай, 3 үндсэн чиглэлийг хамарч хийгдэх хөгжлийн олон чиглэлийн төсөл, хөтөлбөр боловсруулагдаж ирсэн. “Төмөр замын шугамын чиг тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 232 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой уурхайгаас Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг хүртэлх төмөр замын шугамын чигийг баталж, 2019 оны 6 дугаар сараас барилгын ажлыг эхлүүлсэн. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь Тавантолгой өртөөнөөс эхлэн Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрийг дайран хилийн Гашуунсухайт боомтод хүргэхээр төлөвлөсөн байна. Эдгээр төмөр замын төлөвлөлтүүдийг багцалж 1-р үе шат гэж анхлан 2015 онд нэрлэж байсан. Мөн түүнчлэн 2-р үе шатны бүтээн байгуулалтаар Сайншанд-Баруун-Урт, Баруун-Урт-Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын нийт 846 км урт уг төмөр замын төсөвт өртөг тухайн үеийн ханшаар (2019) 1.1 тэрбум ам.доллар бөгөөд ОХУ-Монгол-БНХАУ-ыг холбох зүүн бүсийн босоо тэнхлэгийн төсөл юм.

3-р үе шатанд Нарийн сухайт-Шинэжинст-Алтай-Арц суурь гэсэн чиглэл алс ирээдүйд БНХАУ-Монгол Улс-ОХУ-г босоо тэнхлэгээр холбосон баруун бүсэд баригдах алс ирээдүйн төсөл мөн дэвшүүлэгдсэн. Энэ төслийн Баянхонгор аймагт хамаарах баруун бүсийн босоо тэнхлэгийн трасс Нарийн сухайтаас эхлэн Шинэжинст сум хүрэх эхний зангилааг доор төлөвлөлтийн зурагт тусгав. Анхлан 2014-2015 оны үе дэх төсөөлөөр Шинэжинст хүртэл нарийн цагирагийн төмөр зам байх бөгөөд дугуй солих өртөө байгуулж цааш Алтай- Арц суурь хүртэл өргөн цагирагийн төмөр зам байхаар төсөл гаргасан байдаг.



Зураг-21. Төмөр замын бүтээн байгуулалтын төслүүд


Эх үүсвэр: Монголын төмөр зам

Дээрх 3 үе шаттай бүтээн байгуулалтаар шинэ төмөр замуудыг барьснаар жилд 30 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг тээвэрлэн экспортлох боломжтой болж, төмөр замын ашиглалтын үед 1300 орчим байнгын ажлын байрыг бий болгож, нүүрсний экспортыг дэмжиж, БНХАУ, ОХУ-ын нутаг дэвсгэр, түүний далайн боомт болон гуравдагч орны зах зээл рүү тээвэрлэлт хийх боломж бүрдэх юм.

Хүснэгт-33. Төмөр замын сүлжээний төлөвлөлт

Төмөр замын чиглэл	Хэрэгжих хугацаа	Төмөр замын урт, км
Өмнөговь аймгийн Нарийн сухайтын нүүрсний орд уурхайгаас (Гурвантэс сумын нутаг дэвсгэр) Баянхонгор аймгийн Шинэжинст сумын төвөөр дайран Алтай хот хүрэх	2030-2037	270
Шинэжинст- Алтай хот	2030-2037	360
Алтай- Арц суурь	2030-2037	600
Алтай- Хөшөөт-Бургастай	-	287


Өмнөговь аймгийн Нарийн сухайтын нүүрсний уурхайгаас эхлэн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дэвсгэрийг дайран хойд ОХУ-ын хил дээрх Арц суурь боомт хүртэлх төмөр замын төлөвлөсөн нийт урт нь 1497 км юм.



Зураг-22. Төмөр замын төлөвлөлт



2.4 Агаарын тээврийн төлөвлөлт

Одоогийн байдлаар Баянхонгор аймгийн төвд байрлах 128.26 га нисэх буух зурвас, 273.25 га талбайг агаарын тээврийн хамгаалалтын зурвасын зориулалтаар ашиглаж байна.




Зураг-23. Одоо байгаа Баянхонгор хотын нисэх онгоц хөөрөх, буух зурвас

Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд 263.52 га, Баянлиг суманд 6.41 га газрыг нисэх онгоц хөөрөх, буух зурвас аэродромын зориулалтаар орон нутгийн саналд үндэслэн байгуулахаар төлөвлөсөн.

	Сумын нэр	№	Солбилцол			
			X	Y		
	Баян-Овоо	1	100° 26'	46° 19'	57.302''	0.602''
		2	100° 26'	46° 18'	31.877''	53.494''
		3	100° 26'	46° 18'	8.168''	45.735''
		4	100° 25'	46° 20'	8.747''	1 .85 ''
		5	100° 24'	46° 20'	49.543''	40.99 ''
		6	100° 25'	46° 20'	13.263''	48.761''
		7	100° 25'	46° 20'	32.465''	20.621''
8		100° 26'	46° 19'	17.523''	14.551''	
9		100° 26'	46° 19'	43.318''	22.073''	
	Сумын нэр	№	Солбилцол			
			X	Y		
	Баянлиг	1	100° 51'	44° 33'	12.6 5''	16.148''
		2	100° 51'	44° 33'	14.525''	15.078''
		3	100° 51'	44° 33'	14.408''	12 506''
		4	100° 50'	44° 33'	49.906''	4.337''
5		100° 50'	44° 33'	48.997''	7.385''	


Зураг-24. Баян-Овоо, Баянлиг суманд төлөвлөсөн нисэх онгоц хөөрөх, буух зурвас



Зураг-25. Төлөвлөсөн нисэх онгоцны хөөрөх, буух зурвас

2.5 Шилэн кабель

2003 оноос хойш холбоо мэдээллийн систем шилэн кабелийн сүлжээнд шилжсэнээр Монголын төмөр замын 1400 км, Мобикомын 450 орчим км шилэн кабель тус тус ажиллаж байсан бол 2008 оноос Хятадын Засгийн газрын 50 сая долларын хөнгөлөлттэй зээлээр бүх аймгийн төвүүд болон 150 сум, суурин газар холбогдсоноор нийт шилэн кабелийн урт давхардсан байдлаар 28600 км болжээ. Өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдсон сум, суурин газруудыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр ангилан Зураг-26-р үзүүлээ.



Зураг-26. Шилэн кабель

Хүснэгт-34. Шилэн кабелийн сүлжээ эзэмшигчид


№	Сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	Сумдын тоо
1	МХС	17
2	“Мобиком” ХХК	1
3	“Скайнэтворкс” ХХК	3

2.6 Эрчим хүч дамжуулах шугамын газрын төлөвлөлт

Баянхонгор аймгийн эрчим хүчний систем нь аймгийн төв болон ойролцоох Өлзийт, Эрдэнэцогт сумдыг 6 кВ-ын 77,7 км, Шаргалжуут рашаан сувилал тосгон, Заг, Гурванбулаг, Жаргалант сумдыг 10 кВ-ын 150,5 км, Баян-Овоо, Галуут, Баацагаан, Хүрээмарал, Баянбулаг сумдыг 15 кВ-ын 339 км, Бөмбөгөр, Бууцагаан сумдыг 35 кВ-ын 295,5 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээж байна. Нийт 862,7 км цахилгаан дамжуулах агаарын шугама, 155 дэд станц трансформатораар дамжуулан 1012 ААНБ, 11100 ахуйн хэрэглэгчид нийт 12112 хэрэглэгчидэд цахилгаан түгээж байна.

Хүснэгт-35. Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ

№	Цахилгаан дамжуулах агаарын шугамын чиглэл	Шугам сүлжээний хүчин чадал	Урт, км
1	Баянхонгор сум	0.4 кв-ийн шугам	0.37
2	Өлзийт сум	6 кв-ийн шугам	1.5
3	Бөмбөгөр сум	6 кв-ийн шугам	4.5
4	Гурванбулаг-Заг сум	10 кв-ийн шугам	58.14
5	Заг-Жаргалант сум	10 кв-ийн шугам	23.83
6	Баянхонгор сум	10 кв-ийн шугам	4.8
7	Баянхонгор-Эрдэнэцогт сум	10 кв-ийн шугам	75.96
8	Жинст-Богд-Баруунбаян Улаан	15 кв-ийн шугам	52.54
9	Бөмбөгөр-Баянцагаан	15 кв-ийн шугам	72.79
10	Галуут-Баянхонгор	15 кв-ийн шугам	51.88
11	Баянхонгор-Өлзийт	15 кв-ийн шугам	16.11
12	Хүрээмарал-Баянбулаг	15 кв-ийн шугам	47.28
13	Баянговь-Баянлиг	15 кв-ийн шугам	39.6
14	Баянцагаан-Баян-Өндөр-Шинэжинст	15 кв-ийн шугам	90.88
15	Хүрээмарал-Бууцагаан	15 кв-ийн шугам	39.93
16	Баян-Овоо-Баянхонгор	15 кв-ийн шугам	89.99
17	Шинэжинст сум	15 кв-ийн шугам	3.2
18	Баянлиг-Баруунбаян Улаан	35 кв-ийн шугам	76.1
19	Жаргалант-Бөмбөгөр	35 кв-ийн шугам	108.68
20	Шинэжинст-Баянлиг сум	35 кв-ийн шугам	126.18
21	Бөмбөгөр-Баянхонгор сум	35 кв-ийн шугам	95.86
22	Бууцагаан-Бөмбөгөр сум	35 кв-ийн шугам	71.28
23	Баянхонгор-Өлзийт-Нарийнтээл	110 кв-ийн шугам	62.96



Зураг-27. Шугам сүлжээний газрын төлөвлөлт

Баянхонгор аймгийн Баянцагаан суманд сумын төвөөс Гичгэнэ баг хүртэл 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 15.94 км, Дэлгэрэх баг хүртэл 35.85 км, Цэцэн баг хүртэл 26.94 км шугам сүлжээ орон нутгийн саналд үндэслэн байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт-36. Төлөвлөсөн цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээ

Холбогдох чиглэл	Шугам сүлжээ	Урт, км	Хэрэгжих хугацаа
Баянцагаан сум-Гичгэнэ баг	6 кВ-ийн шугам	15.94	2022-2037
Баянцагаан сум-Дэлгэрэх баг	6 кВ-ийн шугам	35.85	2022-2037
Баянцагаан сум-Цэцэн баг	6 кВ-ийн шугам	26.94	2022-2037

ГУРАВ. БАЙГАЛИЙН АЯЛАЛ-РЕКРЕАЦИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

3.1. Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

3.1.1 Тохиромжтой байдлын үнэлгээний аргачлал

Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхдээ ГХГЗЗГ-ын даргын 2015 оны 200 тоот тушаалын 5-р хавсралтаар батлагдсан арга зүйг баримталж хийх ёстой боловч энэхүү арга зүйг зайлшгүй боловсронгуй болгох шаардлагатай байна. Тохиромжтой байдлын үнэлгээг газрын гадарга, уур амьсгал, рашаан гадаргын ус, био нөөц, байгаль түүх, соёл гэх мэт олон хүчин зүйл, тэдгээрийн жинлэсэн дундаж хамаарлаар тооцох ёстой боловч аялал жуулчилалын гол нөөц болох ландшафт гоо зүй, байгаль түүх, соёлын дурсгалт зүйлийг тусгахдаа агуй, галт уул, хүрхрээ байвал орон нутгийн газар нутгийг бүхэлд нь аялал жуулчилалд тохиромжтой гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл нөлөөлөл болон үйлчилгээний хүрээг тодорхой тусгаж өгөөгүй байна.

Учир нь гадаад болон дотоодын жуулчид нь тухайн орон нутагт ганц нэг эсвэл хэт их алслагдсан, байгаль, түүх, соёлын дурсгалт, ландшафтын гоо зүй (Улсын тусгай хамгаалалттай газар, дэлхийн өв газар, бохирдлын түвшин)-г үзэх гэж бус тодорхой маршрутын дагуу аялах сонирхолтой байдаг. Энэхүү тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан аялал-жуулчилал-рекреацийн бүсийг тогтоох, төлөвлөх зорилгоор хийгддэг. Гэсэн хэдий ч тус сумын хэмжээнд аялал-жуулчилалын маршрут маршрут төлөвлөх нөөц боломж байхгүй байна. Ийм учираас амралт зугаалгын бүсийн тохиромжтой байдлын үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Олон хүчин зүйлийн шинжилгээний арга нь ГЗМС-н технологи дээр суурилдаг (Baban and Wan-Yusof, 2003). Судалгаа нь дараахь хоёр үе шаттай: Мэдээллийг бэлтгэх ба олон хүчин зүйлийн шинжилгээ хийх гэсэн хоёр үе шаттай: Эхний үе шатанд тохиромжтой байдлын хамгийн энгийн шаардлагыг хангах суурь нөхцлийг тогтооно. Хоёрдугаар шатанд олон хүчин зүйлийн дүн шинжилгээг АНР (АНР Аналитик шатлан эрэмбэлэх математик). программыг хангамжыг ашиглан жигнэсэн дундажаар тогтооно.

3.1.2. Суурь нөхцөлийн үнэлгээ

Constrain буюу суурь нөхцөлийн зураг гаргахад тариалангийн талбай, одоо байгаа хот суурин газар, дэд бүтэц, улсын тусгай хамгаалалттай газар, уул уурхайн талбай, гол, нуур, булаг, худаг, уст цэг гэх мэт нөхцөлүүдийг харгалзан Constraint буюу суурь нөхцөлийн зургийг гаргасан. Ингэхдээ сонгон авсан үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн зураг үүсгэж, зургуудыг давхцуулж аялал жуулчилалд тохиромжтой газрыг сонгох дүн шинжилгээг Erdas Imagine програм дээр хийсэн (Хүснэгт-37).

Хүснэгт-37. Амралт зугаалгын газрын байршил тогтоох шалгуур

Ашиглалтын төрөл	Балл	Авах арга хэмжээ
Тариалангийн талбай	0	Одоо байгаа тариалангийн талбай дээр байж болохгүй
Одоо байгаа хот суурин газар	0	Одоо байгаа суурьшлын бүсэд байж болохгүй
Дэд бүтэц	0	Дэд бүтэцтэй ойр боловч шороон болон авто замтай давхцахгүй байх

Улсын тусгай хамгаалалттай газар	0	Онцгой болон онгон бүсэд байж болохгүй
Уул уурхайн талбай	0	Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайд байж болохгүй
Гол мөрөн	0	Голтой ойр боловч хамгаалалтын бүсэд биш байх
Булаг, худаг, уст цэг	0	Булаг, худаг, уст цэгтэй ойр байх боловч хамгаалалтын бүсэд биш байх


Эх сурвалж: Амралт зугаалгын газрын тохиромжтой байдлын үнэлгээ. ГХГЗЗГ. 2015.

Суурь нөхцлийн зургийг дээрхи хүчин зүйлийн харгалзан Boolean зургийн аргаар хийдэг. Булеан зураг дээр өгөгдлийн утга нь 0 болон 1 гэсэн хоёр утгын нөхцөлтэй. 0 нөхцөл нь боломжгүй буюу зөвшөөрөхгүй нөхцөл, 1 гэсэн нөхцөлт утга нь зөвшөөрөх буюу боломжит утгыг илэрхийлнэ (Зураг.28.).



Зураг-28. Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлыг хязгаарлагч хүчин зүйлүүд

Дээрх зургийг Boolean зургийн нөхцөлт утгын аргыг ашиглан зурагласан бөгөөд 0 утгатай гарч байгаа газруудыг тохиромжгүй гэж үзнэ. Зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн. Дээрх суурь нөхцлийн зургуудыг нэгтгэж нэгдсэн үнэлгээний зургийг гаргасан (Зураг -29.).



Зураг-29. Амралт зугаалгын газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл

Дээрх зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн.


3.1.3. Хүчин зүйлийн үнэлгээ

Тохиромжтой байдлын үнэлгээнд олон хүчин зүйл ашиглаж байгаа (factor) үед энэ аргыг хэрэглэнэ. Олон хүчин зүйлүүдийг хооронд нь харьцуулахад нэг нь нөгөөгөөсөө илүү ач холбогдолтой ба эзлэх жингийн хувьд өндөр жин дарна. Шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэхдээ АНР (analytical hierarchy process) буюу шатлан захирах дүн шинжилгээний аргыг ашигласан (Saaty 1977). Энэ арга нь шалгуур үзүүлэлтийн эрэмбэлэлтийн матрицаар жингийн утгыг тодорхойлдог. Сонгон авсан хүчин зүйлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэлтийн матрицыг ашиглан жингийн утгыг тодорхойлохын тулд судалгаанд ашиглагдаж буй хүчин зүйлийг байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдалд нөлөөлөх ач холбогдлоор эрэмбэлсэн (Хүснэгт-38.).

Хүснэгт-38. **Байгалийн аялал-рекреацийн газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь**

№	Хүчин зүйл	Эрэмбэ	Харьцангуй жин
1	Гол	1	0.3269
2	Ойн бонитет	2	0.2274
3	Газрын гадарга	3	0.1568
4	Нар гийгүүлэлт	4	0.1076
5	Дэд бүтэц	5	0.0734
6	Жилд нар гийгүүлэх хугацаа	6	0.0498
7	Гадаргын хэрчигдэлийн шигүү	7	0.0340
8	Агаарын дунаж температур	8	0.0241
CR=0.0428			


Дээрх эрэмбэлэлтээс хамгийн ач холбогдолтой нь газрын гадаргын налуу болон хөрсний тогтвортой байдал, хамгийн ач холбогдол багатай нь хөрсний гүний усний түвшин гэж тооцоод хүчин зүйлүүдийг эрэмбэлсэн. Эрэмбэлэлтийн матрицаар тооцон гаргасан жингийн утга хэр зэрэг үнэнд нийцэж байгаа consistency ratio буюу нийцлийн харьцааны индексээр тооцож үзэхэд 0.0428 байгаа нь хүчин зүйлийн хоорондын харьцаа зохицол сайтай болох нь батлагдаж байна.



Зураг-30. Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн үнэлгээ

Дээрхи хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний зургийг радиометрийн заслийн тусламжтайгаар бүх зургийг 0-255 хооронд утга авхуулж засвар хийж зурагласан бөгөөд өндөр утга авах тусам маш тохиромжтой, бага утга авах тусам аялал жуулчлалын зориулалтаар ашиглахад нэн тохиромжгүй газар нутаг юм.

Амралт зугаалгын газрын тохиромжтой байдлын суурь нөхцлийн болон хүчин зүйлүүдийн нэгдсэн зургийг гаргасан (Зураг ..).



Зураг-31. Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зургийг тохиромжтой байдлаар нь нэн тохиромжтой, тохиромжтой, дунд зэрэг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл гэж ангилан авч үзлээ (Хүснэгт-39.).

Хүснэгт-39. Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

№	Тохиромжтой байдлын ангилал	Талбай, га	Эзлэх, хувь
1	Тохиромжтой	200804	1.7
2	Дунд зэрэг тохиромжтой	520968	4.5
3	Хязгаарлагдмал тохиромжтой	1388078	12.0
4	Тохиромжгүй	9132154	79.0
5	Газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл	310490	2.7
Нийт		11552495	100

Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний үр дүнгээс одоо ашиглагдаж байгаа газар ашиглалтын суурь нөхцлүүдийг хасаж тооцоо хийхэд тус сумын нийт нутаг дэвсгэрийн 1.7 хувь буюу 200804 га нь тохиромжтой, 4.5 хувь буюу 520968га нь дунд зэрэг тохиромжтой, 12 хувь буюу 1388078 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 79 хувь буюу 9132154 га нь тохиромжгүй, 2.7 хувь буюу 310490 га нь газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл тус тус гарч байна.

3.2 Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал

3.2.1 Монгол улсын аялал жуулчлалын салбарын одоогийн байдал

Дэлхийн улс орнууд даяарчлагдахын хэрээр түүнийг даган аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж байна. Манай улс мөн адил энэ хөгжлийг даган аялал жуулчлалын салбар тэр дотроо дотоодын болон гадаадын аялал жуулчлал улам хөгжсөөр байгаа билээ.



Зураг-32. Монголын аялал жуулчлалын сонирхлын бүс

Монгол улс нь дэлхийн аялал жуулчлалын бүсчлэлийн дагуу зүүн хойд Азид багтдаг бөгөөд энэ бүсэд БНХАУ, Монгол, БНСУ, Япон, ОХУ-ын зүүн хэсгийн муж, автономит улсууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Үүнтэй холбоотой эдгээр бүс нутгийн улсын иргэд манай улсад ихэвчлэн ирж байна.

Манай улсын аялал жуулчлалын салбарын хөгжил нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр илүү хурдацтай болж ирсэн. Гадаад болон дотоодын судлаачид Монгол улс нь олон улсын тавцанд өрсөлдөхүйц үйлдвэрлэлийн таван салбарыг хөгжүүлэх боломжтой гэж үзсэн байдаг. Эдгээр таван салбарын нэг нь аялал жуулчлал юм.

“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутаг аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэж тусгасан.

Аялал жуулчлалын салбар нь үл шавхагдах нөөцүүдийг ашиглан үлэмж хэмжээний орлого олох боломжтой. Тиймээс манай улс “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-доо эдийн засгийн үндсэн тулгуур, орлогын томоохон эх сурвалж нь аялал жуулчлал байх болно гэж заажээ.

“Монгол Улсын аялал жуулчлалын тухай” хуулийн 3.1.3-т аялал жуулчлалын бүс нутаг гэж Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх,

соёлын нөөц бүхий газар нутаг байна гэж заасан байдаг. Энэ дагуу Монгол улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үндсэн зургаан бүсийг төлөвлөсөн байна. Үүнд:

- Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэн бүхий Хөвсгөлийн бүс
- Түүх соёлын үнэт дурсгалууд бүхий Орхон голын бүс
- Эх газрын өвөрмөц, онгон байгаль, палеонтологийн олдвор, ховор ан амьтан бүхий Говийн бүс
- Чингис хааны түүхтэй холбоотой дурсгалт газрууд бүхий Хэнтийн бүс
- Олон ястны зан заншил, соёлын онцлог бүхий өндөр уулын бүсийн экосистемт Алтайн бүс
- Улаанбаатар хот орчмын бүс зэрэг болно.


Эдгээр бүсүүдэд тулгуурлан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол улсад аялал жуулчлал хөгжих суурь болох ёстой гэж үздэг. Мөн аймаг бүр энэ баримтлалд тохируулан аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрүүд боловсруулан ажиллаж байгаа аж.

Монгол Улсын хилээр 2020 онд 1.3 сая зорчигч орсны 66.9 мянга нь гадаадын зорчигчид байна. Энэ нь өмнөх оноос 89.5 хувь буюу 570.0 мянгаар буурчээ.

Өмнөх онуудад байнга өсөлттэй явж ирсэн бөгөөд 2019-2020 оны хооронд Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор энэ онд огцом бууралттай жил байлаа. Тэдний 87.8 хувь нь 30 хүртэл хоног, 1.7 хувь нь 30-аас 90 хүртэл хоног, 10.5 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна.

Гадаадын зорчигчдын 53.7 хувь нь Европ, 41.5 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг, 2.8 хувь нь Америк, 2.0 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

График-1. Монгол Улсын хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчид, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2016-2020 он




Эх сурвалж 1212.mn

Сүүлийн 5 жилийн байдлаар хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчдыг авч үзэхэд Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгаас ирж байгаа зорчигчид илүү их хувийг

эзэлж байсан бол өмнөх оныхтой харьцуулахад 19.7 пунктээр буурсан ба харин Европ тивээс ирсэн зорчигчид өмнөх оныхоос 21.1 пунктээр өссөн байна.

Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 11 жилийн байдлаар авч үзвэл 2010-2012 оны хооронд жуулчдын тоо нэмэгдэж байсан бол 2013-2015 оны хооронд буурах хандлагатай байсан байна. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирж байсан бөгөөд 2016 онтой харьцуулахад 38.0 хувь буюу 153.1 мянгаар, 2017 онтой харьцуулахад 19.0 хувь буюу 88.0 мянгаар, 2018 онтой харьцуулахад 5.3 хувь буюу 28.0 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол 2020 оны байдлаар нийт жуулчдын тоо 58.9 мянга болж 2019 онтой харьцуулахад 89.4 хувь буюу 498.4 мянгаар буурсан бөгөөд энэ нь цар тахал дэгдсэнтэй холбоотой.


График-2. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчид, жуулчид, сүүлийн 11 жилийн байдлаар, мян.хүн



Эх сурвалж 1212.тп

Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг аяллын зорилгоор ангилан харвал, 87.9 хувь буюу 58.9 мянга нь аялал жуулчлалын зорилгоор, үлдсэн 12.1 хувь буюу 8.1 мянга нь ажиллах, суралцах, байнга оршин суух гэсэн урт хугацааны зорилгоор иржээ.


График-3. Жуулчдын тоо, улирал, сүүлийн 5 жилийн байдлаар, мян. Хүн



Эх сурвалж 1212.тп

Монгол Улсад ирсэн нийт жуулчид 2016-2019 оны дунджаар 68.6 хувь нь II, III дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирдэг нь дээрх зургаас

харагдаж байна. Өвлийн улиралд ирэх жуулчдын тоо бага байгаа нь манай орны цаг уурын байдал хатуу ширүүн болон өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй зэргээс шалтгаалсан байх магадлалтай.



Зураг-33. Жуулчдын тоо дүнд эзлэх хувиар, улсаар, 2020 он

Хүснэгт-40. Улсын хилээр орсон гадаад зорчигчид, бүс нутаг, улсаар

	2017	2018	2019	2020
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг	301,642	324,013	336,991	24,419
БНХАУ	201,912	216,379	208,449	17,340
БНСУ	76,637	86,013	103,379	5,515
Казахстан	23,093	21,621	25,163	1,564
Европ	131,284	154,326	170,153	33,959
ОХУ	110,353	133,402	146,783	30,980
Беларусь	10,777	11,015	12,654	2,338
ХБНГУ	10,154	9,909	10,716	641
Америк	22,612	24,139	25,349	1,770
АНУ	17,663	18,866	19,948	1,416
Канад	4,204	4,481	4,501	320
Бразил	745	792	900	34
Өмнөд Ази	2,567	3,225	3,546	268
БНЭУ	2,082	2,572	2,793	236
Иран	230	349	416	19
Балба	255	304	337	13
Ойрх Дорнод	3,401	4,146	4,023	604
Турк	2,262	2,779	1,999	573
Израил	911	945	1,158	20
Катар	228	422	866	11
Африк	1,068	1,379	1,931	321
Өмнөд Африк	928	1,218	1,764	299
Гана	54	55	72	10
Кени	50	67	58	9
Харьяалалгүй	36	39	37	3

Нийт	462,574	511,228	541,993	61,341
------	---------	---------	---------	--------

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 2020 онд 64.7 (96.7%) мянга нь насанд хүрсэн хүн, 2.2 (3.3%) мянга нь хүүхэд, 50.9 (76.1%) мянга нь эрэгтэйчүүд, 16.0 (23.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 53.8 хувь нь Европ, 41.5 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг, 2.8 хувь нь Америк, 1.9 хувийг Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 46.3 хувийг ОХУ-ын иргэд, 25.9 хувийг БНХАУ-ын иргэд, 8.2 хувийг БНСУ-ын иргэд, 3.5 хувийг Беларусь, 2.3 хувийг Казахстан, 2.1 хувийг АНУ-ын иргэд, 11.6 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.



Зураг-34. Манай улсын аялал жуулчлалын голлох бүс нутаг

Гадаадын жуулчдын хамгийн их очдог нутаг нь Өвөрхангай болон Өмнөговь аймгууд, түүний дараагаар нийт жуулчдын 20.0 хувь нь очдог буюу Хөвсгөл болон Архангай аймгууд оржээ.

Архангай аймагт зочлогчдын хувьд Тэрхийн цагаан нуур орчмын байгалийн үзэсгэлэнг сонирхдог бол, Улаанбаатар хотын орчимд буюу Тэрэлжийн бүсэд Монголд зочилсон жуулчдын 20.0 орчим хувь очдог.

Мөн Баян-Өлгий аймгийн хувьд Монголын аялал жуулчлалын чухал бүсүүдийн нэг бөгөөд ангийн отгууд байрладаг, адал явдалт аялал хийхэд тохиромжтой бүс нутаг юм. Хэнтий аймагт Чингис хаан, Монголын эзэнт гүрний түүхийг сонирхогч жуулчид илүү их зочлох хандлагатай байдаг бол, Дорнод аймгийн хувьд дорнод Монголын тал хээрийн экосистемийг сонирхсон жуулчид түлхүү аялдаг. Бусад аймгуудын хувьд гадаадын жуулчдыг хүлээн авах нь бага, жуулчдын сонирхлыг татах маркетингийн үйл ажиллагаа харьцангуй сул байна.

3.2.2 Баянхонгор аймгийн аялал жуулчлал

Баянхонгор аймаг нь байгалийн олон бүс бүслүүр буюу хангай, тал хээр, говь, цөлийн үзэсгэлэнт байгалийг хамран оршдог. Тус аймагт ирсэн хэн бүхэн энэ нутаг дахь хүн төрөлхтний анхны соёлоос эхлээд эртний хүмүүс амьдарч байсныг нотолсон Цагаан агуй, өөр гариг ертөнцийн оюун ухаантнуудын бүтээл байж болох Цагаан булагийн хадны дүрс зургууд, эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн түүх, соёлын дурсгал болох Бичигтийн хөндийн хадны сүг зургууд, байгаль өвөрмөц сонин тогтоцтой, анагаах эдгээх чадвараараа хосгүй 96 хэмийн халуун Шаргалжуутын халуун рашаан, эртний хаад ноёдын хуралдан чуулж байсан Заг-Байдрагийн Хүрэнбэлчир, одоогоос 200 сая жилийн тэртээ амьдарч байсан аварга биет динозаврын чулуужсан яс бүхий Бүгийн цав, Ногоон цавууд, энэ дэлхий дээр анх монгол нутагт шатар үүссэнийг гэрчлэх Шатар чулууны хөшөө цогцолбор, дэлхий дээр зөвхөн манай аймгийн нутагт цөөн тооны байдаг говийн баавгай хэмээх Мазаалай зэрэг гайхамшгуудыг үзэх боломжтой.




График-4. Баянхонгор аймгийн 2018-2019 онд ирсэн жуулчдын тоо

Цар тахлаас өмнө Баянхонгор аймгийн жуулчны тоог 2018 болон 2019 онуудтай нь харьцуулахад гадаадын жуулчдын тоо 2%-иар өссөн, дотоодын жуулчдын тоо 67%-иар өссөн байна.





График-5. Баянхонгор аймгийн 2019-2020 онд ирсэн жуулчдын тоо

Гэвч цар тахлын үеийн Баянхонгор аймагт ирсэн нийт жуулчдын тоог өмнөх онтой харьцуулахад гадаадын жуулчдын тоо 100%-иар буурсан, дотоодын жуулчдын тоо 42.7%-иар буурсан үзүүлэлттэй байна. Жуулчдын тоо буурсан шалтгаан нь дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахлын улмаас улсын хил хаагдсан, улс дотор хөл хорио тогтоосноос нийт жуулчдын тоо буурсан байна.



Зураг-35. Баянхонгор аймгийн аялал жуулчлалын нөөц газрын судалгаа

Судалгаагаар Монголд аялаж буй жуулчдын 70 орчим хувь нь үзэсгэлэнт байгалийг, 50 орчим хувь нь нүүдлийн соёл, уламжлалт ахуйг, 25 орчим хувь нь Чингис хааны түүх, 15 орчим хувь нь адал явдалт аялалыг сонирхдог гэж гарсан байна. Энэ судалгааны үр дүнгээс үндэслээд аймгийн нутаг дэвсгэрт байгалийн дурсгал, түүх соёлын дурсгал бүхий аялал жуулчлалын нөөцийг судалгааг нэгтгэн бүртгэв.

Хүснэгт-41. Баянхонгор аймгийн түүх соёлын дурсгалт газрын судалгаа

Дд	Сумын нэр	Барилга, архитектурын дурсгал	Булш оршуулгын дурсгал	Палеонтологийн дурсгалт газар	Тахил тайлгын байгууламж	Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар	Хадны зураг, бичгийн дурсгал	Хөшөө дурсгал	Чулуун зэвсгийн дурсгалт газар	Нийт дурсгалт газар
1	Баянхонгор	18	3		5		3	5		34
2	Баацагаан	6	2		8		2	4		22
3	Баянбулаг	6	3		8		2	8		27
4	Баянговь	2	4		5		2	4		17
5	Баянлиг	2	1		2		4		6	15
6	Баян-овоо	6	31		5		6	4	1	53
7	Баян-Өндөр	4	8		6	2	2	3	6	31
8	Баянцагаан	8	5		5		4	4		26
9	Богд	4	3	2	6		2	6		23
10	Бууцагаан	8	17		6		10	5		46
11	Бөмбөгөр	6	22		15		6	7		56
12	Галуут	8	12		15		5	5		45
13	Гурванбулаг	12	8		8			14		42
14	Жаргалант	2	14		10		7	10		43
15	Жинст		4		6	2	6	10		28
16	Заг	10	13		11		4	8		46
17	Өлзийт	12	19		21		2	18		72
18	Хүрээмарал	8	15		17		18	7		65
19	Шинэжинст		11	2	4		10			27
20	Эрдэнэцогт	16	38		11		14	13		92
	Аймгийн нийт	138	233	4	174	4	109	135	13	810

Аялал жуулчлалын байгалийн нөөц:

Шаргалжуутын халуун рашаан



Шаргалжуутын халуун рашаан нь далайн түвшнээс дээш 1492 метр өндөрт Шаргалжуут голын дэргэд байрладаг. Энэ гайхамшигт рашаан нь 108 төрлийн өвчнийг анагаах чадвартай, 108 төрлийн халуун, хүйтэн рашаануудаас бүрддэг. Эдгээрийн хамгийн халуун нь нэмэх 96 хэмийн халуун байдаг.

Шаргалжуутын халуун рашаан нь байгалийн өвөрмөц сонин тогтоц, анагаах эмчлэх чадвараараа дэлхийд хосгүй рашааны нэгэнд тооцдог. Шаргалжуутын рашаан бүр нь хүний бие эрхтнүүдийн байгалиас урлан бүтээсэн хэлбэр дүрс бүхий хад, чулуунаас ундрэн гардаг. Тухайлбар, хоолойн өвчнийг анагаах рашаан гэхэд хүний хоолойн хэлбэр дүрстэй хадаас, шүдний рашаан гэхэд шүдний хэлбэр дүрс бүхий хаднаас оргилон гарч байдаг нь байгалийн сонин хачин гайхамшигийн нэг юм.

Говийн үзэсгэлэнт байгаль-Их богд уул



Баянхонгор аймгийн говийн үзэсгэлэнт байгаль нь аймгийн төвөөсөө 150км-т орших их говийн элсэн манхан, заган шугуйд шургалан тогтсон Бөөнцагаан болон Орог нуур, Монголын хоолойгоос эхлэн эх орны баруун хязгаар буюу Монгол улсын торгон хил хүртэл сунаан тогтсон өргөн уудам нутгийг хамарна. Баянхонгорын говь нутаг нь энэ

дэлхийн анхны хүн амьдарч байсан буурал түүхийн гэрч болохын зэрэгцээ аварга биет үлэг гүрвэлийн чулуужсан яс, түүний амьдарч байсан ул мөр болон дун хясаа зэрэг цэнгэг усны амьтдын чулуужсан яс, далайн ёроол байсныг илтгэх шавар хэрмэн цавууд нь Баянхонгорын говь нутаг нь 200-100 сая жилийн тэртээ гадагшаа урсгалгүй цэнгэг усны ай сав байсныг илтгэдэг. Баянхонгор аймгийн БНХАУ-тай хиллэдэг улсын хилээс 100 орчим км өргөн газрыг хамрах Говийн их дархан газрын ЮНЕСКО-ийн шим мандлын нөөц газрын сүлжээнд “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл” гэдэг зэрэглэлээр 1996 онд дэлхийн өв гэж “Дэлхийн хүн ам ба шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд бүртгэж авсан. Говь-Алтай нурууны ноён оргилуудын нэг, мөнх цаст их богд уул нь

далайн түвшинээс дээш 3957 метр өргөгдсөн Монголын их говьд орших атлаа хангайн байгалийг санагдуулам номин ногоон хөвл ургамал, өнгө алаглах цэцэгсийн хүрээлэн, хүрхрэн шуугих хүрхрээ, өндөр уулын түргэн урсгалт гол горхи, газар хөдлөлтөөс тогтсон байгалийн өвөрмөц сонин тогтоц, нуур, дэлхийд ховордож дархлагдсан аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтад, Вансэмбэрүү, алтан гагнуур, лидэр зэрэг эмийн ургамлуудтай.



Цагаан агуй

Монгол улс, тэр тусмаа Баянхонгор аймаг нь хүн үүссэн өлгий нутаг болохыг гадаадын олон орны эрдэмтэд нотолсоор ирсэн. Тухайлбал, 1989 онд Баянхонгор аймгийн "Уран хайрхан"

гэдэг газраас олдсон архелогийн олдвор нь одоогоос 500 000 жилийн өмнө манай дэлхий дээр анх хүн үүссэнийг нотлох үнэ цэнэтэй олдвор байсан бол 1996 онд Америк, Орос, Монголын эрдэмтдийн хамтарсан экспедицийн олсон олдвор нь дэлхий дээр одоогоос 750 000 жилийн тэртээ хүн амьдарч байсныг нотолжээ. Энэ олдвор нь одоогоор энэ дэлхий дээр олдоод байгаа олдворуудаас хамгийн эртнийх нь. Иймээс Баянхонгор аймаг нь хүн төрөлхтний өвөг дээдсийн өлгий нутаг юм.

Бичигт хад




Баянлиг сумын нутаг Баянгийн нурууны Их Бичигтийн аманд эдүгээгээс 3000 жилийн тэртээд эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болох сүг зургууд бүхий байгалийн галерэй бий.

Энд сонирхол татсан нэгэн зураг бол анжисанд үхэр

хөллөөд газар хагалж буй хүнийг дүрсэлсэн зураг юм. Энэ зургийг МЭӨ-III мянган жилийн өмнөх үеийн бүтээл гэж үздэг. Үүнээс үзэхэд энэ нутагт оршин суугчид 3000 жилийн өмнө малын хүчийг тэргэнд хөллөн ашиглаж газар тариалан эрхэлж байсны нотолгоо юм. Иймээс энэ зураг нь Дэлхий дээр хамгийн анх түрүүн тэрэг бүтээсэн ард түмний нэг нь Монгол гэдгийг харуулж байгаа илэрхийлэл гэж нэгэн судлаач хэлсэн байдаг. Бичигт хад нь хадны сүг зургуудын агуулга, хэмжээ дүрслэлээрээ ази тивдээ хамгийн томд тооцогдох дурсгалт газар юм.

Цагаан булаг



Цагаан булаг” -ын хадны дүрс зургууд нь хүүхдийн сэдвээс бүрдсэн зургуудын цогцолбор дурсгал мөн. Энд хүүхэд гулгасаар байгаад хадыг хонхойлгон мөлгөр гадаргуутай болгосон боловуу гэмээр гулсуур хад, 3-4 настай хүүхэд хадыг хонхойлгон /хэв гарган/ гишгээд явсан гутлын мөр, хадан дээр хэв гарган бүтээсэн хэвтэж байгаа хүүхдийн дүрс зэрэг олон зургууд байдаг. Уг хүүхдийн зургийн онцлог нь гарын дунд хуруунууд нь бусад хуруунуудаасаа хоёр

дахин урт бөгөөд үзүүр дээрээ том товгортой, толгой дээрээ цагираг хэлбэрийн антен боловуу гэмээр дүрстэй, чих нь урт нарийн, хөл нь майг бөгөөд богинохон, ахар сүүл нь урт дүрс байдаг. Түүх соёлын хосгүй нандин энэ дурсгалыг судалж байгаа зарим эрдэмтэд эдгээр дурсгалыг өөр гариг ертөнцийн оюун ухаантны бүтээл байж болох юм гэж үзсэн нь бий.

Бүгийн цав



Бүгийн цавийн хоолойд зочлох үед өөр гариг ертөнцөд хөл тавьсан мэт сэтгэгдэл төрж, одоогоос 150 гаруй сая жилийн тэртээх амьдрал төсөөлөгддөг. Тэнд ертөнцийн гайхамшиг хэмээгдэх 50-иас 80 тонн жинтэй, 20 шахам метр урт, 3-4 метр өндөр аварга гүрвэлүүдийн чулуужиж хоцорсон яс, дун хясаа зэрэг цэнгэг

усны амьтадын чулуужиж хоцорсон яс, дун хясаа зэрэг цэнгэг усны амьтадын чулуужсан яс, далайн ёроол байсныг илтгэх шавар хэрмэн цавуудыг үзсэнээр монголын говь нутаг нь 2 сая жилийн тэртээ гадагшаа урсгалгүй цэнгэг усны ай сав газар байсныг мэдэх болно.

Шатар чулуун хөшөө цогцолбор



Эрдэнэцогт сумын нутагт байдаг "Шатар чулуу"-ны хөшөө дурсгал нь манай эриний өмнөх 3000 жилийн тэртээх эртний хүмүүсийн оюуны соёлын гайхамшигт өв юм. Шатар чулууны тухай түүхийн нэн сонин домог байдаг. Энэ нь Монгол овогтны нэгэн том шатарчин хааныг нас барахад энэ газар оршуулж түүний дурсгалыг мөнхлөн Шатар чулууны хөшөө дурсгалыг босгосон гэж ам дамжин ярьж иржээ. Энэ домгийг нотлох сүг зураг сийлбэр бүхий дөрвөлжин хашлагатай оршуулга, Монгол шатрын дүрс хэлбэрүүд болох янз бүрийн амьтны чулуун сийлбэрүүд байдаг. МЭ 450-550 жилийн үед Хүннү нар шатар тоглодог байсныг Английн эрдэмтэн Г.Мэрэй Шатрын товч түүх номондоо тэмдэглэснээс үзвэл, Монгол овогтноос анх шатар үүсч хөгжсөн гэсэн дүгнэлт хийж болох магадлалтай.

Тамчийн хавцал



Баянхонгор аймгийн төвөөс 90 км, Эрдэнэцогт сумаас 62 км зайд эртний их хагарал галт уулын хүрмэн чулууг уулын голын ус зүссэнээс үүссэн маш сүрлэг гүн хавцал оршдог.

Мөн Гиван, Халиут гэсэн хоёрхон агуулга замаар ердийн хөсгөөр нэвтэрхээс өөр гарцгүй, хүрмэн чулуу, хад асга болсон, хажуу хана дагаж хар мод ургаж, хавцлын дундуур боргилон хөөсрөн урсах голын усны сав дагуу бургас, улиас, сонгино, хад, тошлой, нохойн хошуу, алтан гагнуур, биелэг өвс зэрэг эмийн өвс ургамал ургадаг.

Заг Байдрагийн хүрэн бэлчир



Монголын нууц товчоонд "Тэндээс Чингэс хаан Ван хан хоёрыг буцаж явахад Найманы Хадгалдагч Хөгсэү Сабраг "Заг-Байдрагийн бэлчирт" цэрэг засаж тулалдахаар зэхэж байсан ажгуу. Чингэс хаан Ван хан хоёр хатгалдъя хэмээн цэрэг засаж хүрч (ирээд) орой боллоо маргааш хадгалдъя хэмээн зэрэгцэн хонов.

Тэгээд Ван хан буйран дээрээ гал түлж орхиод шөнө Хар сүүл (голын нэр) өөд хөтлөн явжээ” гэж бичсэн байдаг. Хожим түүхийн энэ дурсгалт газарт Манжийн Энх-Амгалан хааны 25 дугаар оны /1686 он/ улаан бар жилийн намар Халх долоон хошууны хаад, ноёд, төрийн зүтгэлтнүүд цугларч Улсын Их Хуралдайг хуралдуулан Монгол улсын хувь заяатай холбоотой амин чухал асуудлуудыг хэлэлцэж байсан түүхтэй.

Хүрэнбэлчир нь Баянхонгор аймгийн төвөөс 170 км, Заг сумаас 15 км зайтай. Монголын эртний түүх, утга зохиолын гайхамшигт дурсгал болох “Монголын нууц товчоо”-нд Их эзэн Чингис хааны цэрэг дайлаад мордохдоо “Хүрэн бэлчирт буудаллаж байсан тухай өгүүлсэн нь байдаг.

16-р зууны үед Халхын өндөр Гэгээн Занабазар, Өөлдийн Галдан хутагт нарын санаачилга удирдлагын дор Дөчин дөрөвний ноёдын их чуулган мөн энэ л нутагт болж, Монгол түмний хувь заяаны асуудлыг тунгаан болгоож байсан.

Галуутын хавцал



Баянхонгор аймгийн төвөөс 75 км, галуут сумын төвөөс баруун тийш 20 км-т оршдог аймгийн байгалийн үзсэглэнт газруудын нэг юм. Олгой нуураас Галуут гол тийшээ урсан гарахдаа 2 км орчим урт энэ хавцлыг үүсгэжээ. Хавцал нь 100-150 орчим метр гүнзгий эгц цавчим бөгөөд өргөн нь дунджаар 10 метр орчим өргөн юм.

Энэ хавцалын эгч хажуугийн хад чулуунд үүссэн ялимгүй тавцангууд дээр хаврын цагт усны шувууд өндөглөдөг. Усны шувуудын өндгийг хавцлын дээрээс өнгийн харахад ширээн дээр цагаан будаа цацсан мэт цайран харагдах нь үнэхээр сонин. Гэрэл зураг сонирхогчдын болон шувууны аялалд гойд нийцнэ.

Бөөн цагаан нуур



Баянхонгор аймаг дахь Нууруудын хөндийн хамгийн том, давст нуур юм. Бөөн цагаан нуурт 99 гол, горхи нийлж мөрөн болоход ганцхан гол тутсан гэдэг Бадрагийн гол цутгадаг.

Нуурын өргөн нь 11км, урт нь 24 км. Энэ нуурыг алсаас харахад цагаан өнгөтэй харагддаг учраас Бөөн цагаан нуур хэмээн нэрлэсэн түүхтэй. Бөөн цагаан нууранд 96 зүйлийн шувууд хуран цугладаг, дэлхийд гайхагдсан ховорхон нуур юм. Монгол улсад урсдаг нийт нууруудын хамгийн том талбайтай нууруудын эхний аравт ордог.

Биндэрьяа хөх нуур



Энэ нуур нь загас элбэгтэй, хангай нутгийн үзэсгэлэнт байгальд оршдог цэнгэг нуур. Биндэрьяа Хөх нуурт өвлийн загасчлалын улсын тэмцээн зохион байгуулагддаг уламжлалтай, загас сонирхогчдын сонирхлыг татдаг үзэсгэлэнт нуур юм. Баянхонгор аймгийн төвөөс 233 км, Жаргалант сумын төвөөс баруун хойд зүгт 70 км-т оршдог аймгийн үзэсгэлэнт газруудын нэг.

Энэ нуур нь аймагтаа цэвэр усны нөөцөөрөө 2-т ордог загастай, эргэн тойрондоо ойгоор хүрээлэгдсэн нуурын сав дагуу бургас, улиас, буриагуул, торлог эмжиж, арц бамбай зэрэг үнэртэн, сонгино, хад тошлой, нохойн хошуу, алтан гагнуур, биелэг өвс зэрэг эмийн өвс ургамал ургадаг.

Мазаалай говийн баавгай



Дэлхий дээр 20 гаруйхан тоотой үлдсэн говийн баавгай хэмээх Мазаалай нь зөвхөн Баянхонгорын говийн бүс нутаг л байдаг.

Тэрчлэн Баянхонгор аймагт дэлхийн Улаан номонд орсон хулан, хавтгай, ирвэс, Монгол улсын улаан номонд орсон эрэн хүрэн, цоохондой, хар сүүлт зээр, аргаль, янгир, жороо тоодог зэрэг ховор ховордсон амьтад элбэг байдаг.

Гурван мандалын хадны зураг



Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт сумын төвөөс зүүн хойш 40 гаруй км-т орших баруун хойноос зүүн урагш цувран тогтсон оройг нь тэгш тайрсан мэт сонин тогтвортой гурван уулыг Гурван мандал хэмээнэ.

Энд хадны зураг, эртний Түрэгийн рупи бичээс тэргүүтэй сонирхолтой дурсгал тун ихтэй. Ялангуяа уулын оройн тэгш толигор хаднуудаар олон үеийн хүний бүтээл, хадны сүг зураг, тамга тэмдгийн зүйл арвин ажээ.

Холбоолж нуур



Баянхонгор хотоос зүүн өмнө зүгт 100 км зайд орших Холбоолжийн ягаан давс хэмээн алдарсан Холбоолж нуур нь хүнсний давсны томоохон орд газрын нэг бөгөөд эрт дээр үеэс хүмүүс давсанд орж, шавар эмчилгээ хийдэг ард эмчилгээний томоохон түшиц газрын нэг юм. Мөн давст нуурын зэрэгцээ орших нуурт төрөл бүрийн усны шувууд, тэдний дотроос хайр дурлалын бэлгэдэл хэмээн нэрлэдэг хун шувууд ихээр цуглардаг учир нутгийн иргэд энэ нуурыг Хунт нуур хэмээн нэрлэдэг юм.

Дөш уул



Эрдэнэцогт сумын нутагт Дөш толгой хэмээх унтарсан галт уул бий. Энэхүү галт уул нь шовгор дүрсээ хадгалан үлдсэн байдаг. Түүний хайлмал бодис Эрдэнэцогт сумын төв хүртэл. 20-оод км урссан байдаг. Дөш уул нь 25 га талбайтай, 30-40 м гүн уурхай байдаг. Энэхүү уурхай нь 60 жил ашиглах байгалийн нөөцтэй юм. Энэхүү Дөш уулын хүрмэн чулуугаар блок хийхэд чанар, шахалт, даацын хувьд маш сайн байдаг. Иймд барилгын материалын томоохон орд юм.

Орог нуур



Баянхонгор аймаг дахь нууруудын хөндий дахь хоёр дахь том нуурын урт 30 км, өргөн баруун зүүн хоёр талдаа 8-9 км, харин хамгийн нарийн газраа 1,2 км байна. Их говийн чимэг болсон Орог нуурын эргэн тойронд их говийн элсэн манхнууд, говь нутгийн чимэг болсон заган шугуйд, дэлхийд ховордсон хоёр бөхт тэмээн сүрэг бэлчиж, нүүдлийн соёл иргэншлийн томоохон төлөөлөгч болсон төв халхын малчин ардууд ажиллаж амьдарч байдаг нь гадаадын аялагчдын сонирхлыг ирэхгүй татдаг билээ.

Орог нуурын хаяанаас дэлхийн хамгийн эртний хүн амьдарч байсан буурь сууц олдож байсны зэрэгцээ түүх соёлын нандин өв болох олон зуун хиргэс үүр, булш бунханууд нуурын зүүн хаяагаар ярайн байдаг.

Ширээгийн бичигт хад



Монгол улснаа Нисэх хэмээн алдаршсан улсын арслан Пагамын Аюушийн төрсөн газар /Өвөлжөө/. Энэхүү өвөлжөөний ар хэсгийн хад нь эртний хүмүүсийн ахуй амьдралыг харуулсан 150 гаруй хадны сүг зураг, монгол улсын газрын зураг хэлбэртэй хад зэрэг байгаль, түүхийн дурсгалт газар юм.

Пунцаг овоо



Энэхүү овоо нь далайн түвшнээс дээш 3000 орчим метрийн өндөрт байрладаг Монгол улсын томоохон овооны нэг юм. Энэхүү овооны эргэн тойронд нь буган чулуун хөшөө, эртний хиргэсүүр бүхий дурсгалуудтай.

Домогт үгүүлснээр: Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Их Богдын зүүн жигүүр, Жаран Богдын шилд нэгэн унтарсан галт уул байдаг бөгөөд энэ нь өөрийн гэсэн домогтой.

Эрт цагт энэ ууланд нэгэн гоо үзэсгэлэнт бүсгүй эцэг эхийнхээ хамт амьдардаг байж. Гэвч бүсгүй өөрийнхөө гоо үзэсгэлэнд эрдээд нутгийнхаа залуусыг огт тоодоггүй байжээ. Гэтэл алс нутгийн аянчин Пунцаг тайж хэмээх сайхан залуу тус нутгаар дайран өнгөрөхдөө бүсгүйд хайр сэтгэлтэй болсон байна. Пунцаг тайж нөхдөөсөө хоцрон Их Богд ууланд саатаж үлдээд үзэсгэлэнт бүсгүйтэй ханилан суухаар болжээ. Гэвч нутгийн залуус гоо бүсгүйг харь хошууны хүнтэй ханилсанд дургүйцэж атаархаж хорсохдоо нөхрийг нь хороочихож. Тэгэхдээ Пунцагийг тайж хүн байсан болохоор нэгэн галт уулын өрх амсарт хул мориных нь хамтаар бунхлан оршуулсан гэдэг. Түүнээс хойш тэр галт уулыг “Пунцаг овоо” гэж нэрлэх болжээ.

Халиутын рашаан



Заг сумаас 20 км, Заг, Байдрагийн голын уулзварт орших “Халиут”-ын рашаан нь нүд, хамар, зүрх, ходоодны өвчнийг анагаах чадвартай. Рашааны дэргэд жижиг амралтын газартай.

Тус рашааныг түшиглэн 4 өрөө бүхий 16 хүний амралтын байртай. Халиутын рашаан нь 1958 онд ШУА-ын Химийн хүрээлэн МҮЭ-ийн төв зөвлөлийн шинжилгээгээр батламжлагдсан рашаан юм. Уг рашааныг дотор эрхтэн болох /элэг, цөс, бөөр, ходоод/, эмэгтэйчүүд, толгой, нүд, хоолой зэрэг эрхтэнүүдийн өвчинг илаашруулах зорилгоор уудаг.

Галуутын Бурхант хад



Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт байдаг Бурхант хад гэдэг газарт эгц том хаднуудад сийлсэн Бурханы олон зургууд байдаг. Эдгээр бурханы зургуудыг 1890 оны орчим бүтээсэн гэж үздэг.

“Өхэг” – рашаан



Өхэгийн рашаан нь Баянхонгор аймгийн Галуут сумын 1-р багийн гутагт Хангайн нуруунд Улаанбаатар хотоос 740 км, Баянхонгор аймгаас 110 км, Галуут сумын төвөөс 27 км зайд байрладаг. Тус газар нь хангайн үзэсгэлэнд байгальд байрладаг, эргэн тойрондоо бүхий л төрлийн ховор эмийн ургамал, байгалийн өвөрмөц тогтоц бүхий дурсгалт газруудтай.

Уг рашаан нь галт уулийн тагтийг хөрч царцах явцад бий болж газрын гүнээс хөрсний гадаргуу дээр гарч ирэх хүртэл төрөл бүрийн чулуулгын ан цав жижиг нүх сүвээр дээшлэн олон төрлийн эрдэслэг бодис агуулсан анагаах хосгүй чанартай 20 гаруй төрлийн халуун хүйтэн рашаантай.

Рашааны найрлагад кали, натри, сульфат, гидрокарбинат, хүхэр, устөрөгч, кальци, магни зэрэг 10 гаруй химийн элементүүдтэй. Рашааныг ходоод, элэг, цөс, уушиг, зүрхний өвчинд хүртдэг. Мөн нүд, бүх төрлийн харшил, үе мөчний өвчин, арьсны харшилд бигнэж тавьдаг улаан, шар, ногоон замагтай.

Домогт үгүүлснээр: Эрт дээр үед нэг анчин ан хийж яваад нэгэн гөрөөсийг цээжээр нь буудаж шархдуулжээ. Шархадсан гөрөөс цусаа савируулж явсаар Тунсаг хайрханы ар хормойгоос урсан гарсан олон булгийн нэгнээс уугаад шархаа эдгээчихээд яваад өгчээ. Үүнийг харсан анчин тэр халуун булгууд анагаах чадалтай рашаан юм байна гэдгийг мэдсэн ажээ.

Өргөөтийн хүйтэн рашаан



Өргөөтийн рашаан нь Баянхонгор аймгаас 75 км, Галуут сумаас 35 км-т, Өргөөтийн голын зүүн эрэг дээр эргэн тойрон уулсаар хүрээлэгдэн оршино. Өргөөтийн рашаан нь Монгол улсын хамгийн хүйтэн рашаануудын нэг бөгөөд хоолой, нүд, үе мөчний өвчинд нэн сайн. Зуны дэлгэр цагт амрагчдын ачаалал их байдаг.

Тус рашаан нь 6 ханатай гэрийн буурийн чинээ элстэй тойром мэт дугуйрсан цэв хүйтэн харзыг хол ойроос ирсэн олон зуун хүмүүс өглөө, өдөр, орой, бүр зарим нь харанхуй болсон үдшээр ч ээлжлэн хөл нүцгэлэн туучихыг харах болно. Тийнхүү туучих нь хоолойн ангинд гойд сайн хэмээхийн зэрэгцээ мөн үе мөчний өвчин эмгэгт сайн хэмээнэ. Анх удаа туулж буй хүн дуу шуутайхан арай хийн ганц нэг тойрно. Тэгсээр дараа дараагийн удаад урьдын туршлагжсан хүмүүсийн адил илүү тэсвэр тэвчээртэй болж сэтгэл зүйн талаар өөрийгөө ялсаар, басхүү эд эсээ цэв хүйтэн усаар цочроож, өөрийн нүднээ үл үзэгдэгч дархлааны армийн далд дайчдаа вакцинжуулж байгаа мэт өлчиржүүлдэг ажээ. Зун нь энэ рашааныг сайн туулаад, намар нь урагшаа 20 хүрэхгүй км-ийн зайд орших Баян-Овооны Үүдийн давсанд орсон байхад өвлийн хүйтэн, хаврын хавсрагт ханиад томуунд дарлуулахгүй чамбай сайн өлчирждөг байна.

Үүдийн нуур



Галуут сумын төвөөс 28 км, сүмбэр 2-р багийн нутагт оршдог. Өргөөтийн харзыг туулсаны дараа энэхүү нуурыг туулсанаар хоолойн өвчин эдгэрдэг. Үүнээс гадна үе мөчинд сайн эмчилгээний шавар гардаг.

Амарбуянт хийд



Баян-Өндөр сумын нутагт байдаг Амарбуянтийн хийдийг Манжийн хааны тэнгэр тэтгэсний 15 дугаар оны модон морин жил (1750 он) Агваансодном гэдэг лам анх үүсгэж байгуулснаас хойш 1000 гаруй шавь ном хурдаг, баруун хязгаарын томоохон хийдийн нэг болсон түүхтэй.

Шарын шашны тэргүүн XIII Далай лам Түвдэнжамц 1904 оны модон луу жил Амарбуянтийн хийдэд морилох үед, Алтан тээлийн уулнаас 10 орчим км газар цагаан эсгий дэвсэж, хоёр талаар нь өнгийн чулуугаар хаан бугуйвч, хатан сүйх, угалз хээ өрж, хийдийн урд талын дэнжийг сүйх тэрэг чөлөөтэй багтахаар сэтгэлж зам засч хүндтэтгэл үзүүлж байсны ул мөр одоо ч тодхон үлдсэн байдаг. 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн үед тус хийдийг нураасан ч, дуганууд хана болон суурь, лам нарын өргөө гэрийн туурь, хашаа зэрэг нь үлдэж, 1990-ээд оноос уг суурин дээр хуучин байсан дуган, хийдүүдийг сэргээн босгож одоо хурал ном нь хэвийн хэмжээнд хурдаг, говь нутгаар аялагчдын зорьж очдог газрын нэг болсон аж.

Баянхонгор аймагт зохион байгуулдаг арга хэмжээнүүд Биндэрьяа хөх нуурын цом загасчлалын тэмцээнд



Баянхонгор аймгийн Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба болон Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас жил бүрийн 2 дугаар сард зохион байгуулдаг.

Тус арга хэмжээнд Хамгийн том загас барьсан загасчин шалгаруулах, хамгийн их загас барьсан баг шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулдаг.

Ламын гэгээний улаан тэмээг тэмдэглэх баяр



Баянхонгор аймгийн Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба болон Баянлиг сумын Засаг даргын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, засаг даргын Тамгын газраас Ламын гэгээний улаан тэмээг тэмдэглэх баярыг жил бүрийн 10 дугаар сард Баянлиг суманд зохион байгуулдаг.

Баярын хүрээнд тэмээ тэмдэглэх ёсон, тууль хайлах, ингэ хөөслөх, тэмээ туйлуулах тэмцээн, сайхан тэмээтэй хос шалгаруулах тэмцээн, урлагын тоглолт, тэмээний гаралтай сүү сүүн бүтээгдэхүүн, гар урлал бэлэг дурсгалын худалдаа зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг.

Сарлагийн наадам



Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба болон Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газраас сарлагын наадамыг жил бүрийн 7 дугаар сард зохион байгуулдаг.

Баярын хүрээнд сарлагын сайхан хос шалгаруулах тэмцээн, ердийн хөсгийн цуваа, уран бугуйлч шалгаруулах тэмцээн, сарлаг үхрийн уралдаан, сайхан бух шалгаруулах тэмцээн, эмнэг сарлаг булгиулах тэмцээн, сарлагын гаралтай сүү сүүн бүтээгдэхүүн, гар урлал бэлэг дурсгалын худалдаа зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг.

“Түйн голын жавар” өвлийн наадам



Баянхонгор аймгийн Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба болон Биеийн тамир спортын газраас Түйн голын жавар үргээх өвлийн наадамыг жил бүрийн 1 дүгээр сард зохион байгуулдаг.

Наадамын хүрээнд мөсөн шагайн тэмцээн, шагай шүүрэх, няслах тэмцээн, хээрийн цайны амт шалгаруулах тэмцээн, үндэсний хувцастай сайхан хос шалгаруулах тэмцээн, тэшүүрийн уралдаан, өвлийн үндэсний хувцасны худалгаа зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг.

Шинийн арван тавны буян хураах өдөр



Баянхонгор аймгийн Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба болон Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газраас Пандэ чойнхорлин хийдтэй хамтран жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 15-ны өдөр зохион байгуулдаг.

Наадамн хүрээнд Мандал өргөх ёслол, ганчэн ламын 9-р дүр Гачэн Чогбрүл Ринбочэд мөргөж тусгайлан адис авах, Хачин ламын хийдтэй танилцах, Жанлав Цогцол ном хурах, Цагаан шүхэрт, цэнд айлдах, нутгийн сан тавих, шатар чулуун хөшөө цогцолбортой танилцах арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг.

Заг-Байдрагийн хүрэн бэлчир монгол туургатны харвуул их наадам



Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба болон Монголын үндэсний сурын холбоотой хамтран Заг, Жаргалант сумдын нутаг “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-нд ХҮРЭН БЭЛЧИР хэмээн тэмдэглэгдсэн түүхэн газрыг олон нийгэд таниулан сурталчилах,

цаашид аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх ард иргэдийн ажлын байр, ашиг орлого нэмэгдүүлэх, Монгол Үндэстний Эрийн гурван наадмын нэгэн төрөл, Үндэсний өв соёлын бахархал сурын харвааг Монголын үндэстэн, ястны уламжлагдаж ирсэн төрлөөр сэргээн хөгжүүлэхэд тэмцээний зорилгоор 2 жилд 1 удаа 7 дугаар сарын 19, 20, 21-нд зохион байгуулдаг. Наадамн хүрээнд Холч харваа, Бөмбөлөг намнах харваа, Зэвт харваа, Үндэсний сурын харваа, Гар урлал, бэлэг дурсгалын үзэсгэлэнт худалдаа зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг.

3.4 Аялал жуулчлал-рекреацийн төлөвлөлт

3.4.1 Аялал жуулчлалын чиглэлүүд

Баянхонгор аймаг нь байгалийн олон янзын бүс бүслүүр буюу хангай, тал хээр, говийн үзэсгэлэнт байгалийг хамран оршиж байгаа нь аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг хөгжүүлэх давуу талыг бий болгосон. Иймээс Монгол оронд байгалийн аялал хийхээр ирсэн жуулчид зөвхөн Баянхонгор аймгаар аялахад л Монголын байгалийн гурван өөр бүс, нүүдэлчдийн амьдралын 3 өөр хэв шинж, соёл, өвөрмөц онцлогийг үзэж сонирхох ховорхон боломжийг олно. Тухайлбал, энэ дэлхий дээрх хамгийн анх хүн амьдарч байсныг нотолсон “Цагаан агуй”, өөр гараг ертөнцийн оюун ухаантнуудын бүтээл байх магадлалтай “Цагаан булаг”-ын хадны дүрс зургууд, эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болох “Бичигтийн хөндий”-н хадны сүг зургууд бүхий байгалийн галерей, байгалийн өвөрмөц сонин тогтоцтой анагаах эдгээх чадвараараа хосгүй, 96 хэмийн халуун “Шаргалжуут”-ын рашаан, одоогоос 100-200 сая жилийн тэртээ амьдарч байсан аварга биет динозаврын чулуужсан яс бүхий “Бүгийн цав”, энэ дэлхий дээр анх монгол нутагт шатар үүссэнийг гэрчлэх “Шатар чулуу”-ны хөшөө дурсгал, дэлхий дээр ердөө 20 гаруй тоогоор үлдээд байгаа говийн баавгай хэмээх “Мазаалай” гэх мэт гайхамшгуудыг нэрлэж болох юм.


Аймгийн хэмжээнд дараахь чиглэлээр аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Улсын хэмжээний аялал жуулчлалын төлөвлөлттэй уялдуулан аймгийн хэмжээнд нийт 1953 км урт дараах чиглэлээр аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөж байна (Хүснэгт-42).

Хүснэгт-42. Аялалын чиглэл, уртын хэмжээ

Дд	Аялалын маршрут	Км
1	Газар хөдлөлтийн ул мөртэй таницах аялалын маршрут	435
2	Түүх соёлын ул мөртэй танилцах аялалын маршрут	638
3	Хүн үүслийн ул мөртэй танилцах аялалын маршрут	623
4	Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялалын маршрут	286
5	Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялалын маршрут	1107
6	Говийн ховор ан, амьтадтай танилцах аялалын маршрут /УБ, БХ, ӨМ, ГА/	1953
Нийт		5042

Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх “Хангай, тал хээр, говийн үзэсгэлэнт байгаль хосолсон гурван бүсийн нутаг, нүүдэлчдийн амьдралын гурван өөр хэв шинж, соёл, өвөрмөц онцлог, хүн үүссэн өлгий нутаг, түүх соёлын дурсгалт газрууд, дэлхийд ховордож дархлагдсан амьтан, ургамал, халуун рашаан” зэрэг хаана ч давтагдашгүй бүтээгдэхүүнүүдээ түшиглэн хөгжүүлэхээр тодорхойлов.



Зураг-36. Баянхонгор аймгийн аялал жуулчлалын зураг

3.4.2 Газар хөдлөлтийн ул мөртэй танилцах аялалын маршрут

Баянхонгор аймгийн нийт нутаг дэвсгэр газар хөдлөлтийн шаталбараар бараг бүхэлдээ 7-аас дээш баллын шаталбарт хамрагдагддаг. Газар хөдлөлтийн улмаас үүссэн байгалийн өвөрмөц тогтоц бүхий аялалын нөөцтэй юм. (Схем-1).




Схем-1. Газар хөдлөлтийн ул мөртэй таницах аялал жуулчлалын нөөц

Дээрх газар хөдлөлтийн ул мөртэй таницах аялал жуулчилал хөгжих боломжит нөөцүүдийг координатжуулж аялалын маршрут болон үйлчилгээний төрлийг гаргаж харууллаа (Зураг-37).


3.4.3 Түүх соёлын ул мөртэй танилцах аяллын маршрут

Баянхонгор аймгийн дотоод аялал жуулчдад зориулсан хангайн чиглэлд түүх соёлын ул мөртэй танилцах аяллын сонирхолтой нөөцтэй юм. (Схем-2).



Схем-2. Түүх соёлын ул мөртэй танилцах аялал жуулчлалын нөөц

Дээрх түүх соёлын ул мөртэй танилцах аялал жуулчилал хөгжих боломжит нөөцүүдийг координатжуулж аялалын маршрут болон үйлчилгээний төрлийг гаргаж харууллаа (Зураг-38).



Зураг-38. Түүх соёлын ул мөртэй танилцах аялал жуулчлалын зураг

3.4.4 Хүн үүслийн ул мөртэй танилцах аяллын маршрут

Баянхонгорын говь нутаг нь дэлхийд анх хүн амьдарч байсныг нотолсон археологийн олдвор, аварга биет үлэг гүрвэл болон эртний далайн амьтан ургамлын чулуужсан яс олдсон, одоогоос 200-100 сая жилийн өмнө гадагшаа урсгалгүй далайн ай сав байсныг нотолсон хэрмэн цавууд гээд дэлхийн түүхийн олон чухал үйл явцын ул мөрийг хадгалан үлдсэн байгалийн асар том галерей юм (Схем-3.).


Энэ газрын давуу тал нь гадаадын жуулчдын тэр тусмаа Японы жуулчдын сонирхлыг гойд татдаг нүд алдам цэлгэр хоолойд байрлах учир энэ цогцолбор дээр онгоц буух бүрэн бололцоотой.

Мөн БНХАУ-ын Сэхээ боомтоос Баянхонгороор дайрч ОХУ-тай холбогдох босоо тэнхлэгийн авто зам Баянлиг сумаар дайран өнгөрөх учир эдийн засгийн хувьд ихээхэн үр өгөөжтэй бүс нутаг байх болно.



Схем-3. Хүн үүслийн ул мөртэй танилцах аялал жуулчлалын нөөц

Хүн үүслийн ул мөртэй танилцах аялал жуулчилал хөгжих боломжит нөөцүүдийг координатжуулж аялалын маршрут болон үйлчилгээний төрлийг гаргаж харууллаа (Зураг-39).



Зураг-39. Хүн үүслийн ул мөртэй танилцах аялал жуулчлалын зураг

3.4.5 Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялалын маршрут

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт далайн түвшнээс дээш 1492 метрт Улаанбаатар хотоос 670 орчим километр зайтай оршдог.

Шаргалжуутын гол руу түрж орсон Хатад хэмээх толгойн энгэрт байх боржин чулуунууд дундаас оргилон урсах 108 рашаан бий. Тэдгээр рашаанууд нь манай орны 50 гаруй халуун рашааны дотроос хамгийн халуун, хамгийн их нөөц ундаргатай нь юм. Ихэнхи ундарга нь 60-93 хэмийн халуун, хүхэрлэг, шаварлаг байдаг учраас эмчилгээнд ч хэрэглэдэг.


Шаргалжуут хэмээх нэрний учир нь Манжийн дарлалын үед элч нар Ховд, Улиастай ороод буцах замдаа “Их гол” хэмээх голыг гаталдаг байжээ. Нэгэн удаа Манжийн яаралтай мэдээ авч явсан элчийг ирэхэд “Их гол”-ын ус улаанаараа эргэлдэн хөөсөрч байжээ. Үүнээс үүдэн манжууд уг голыг “Шаргалжуутын гол” хэмээн нэрийдсэн байна. Нутгийнхан голынхоо нэрийг муухайгаар дуудуулахгүйн тулд “Шаргалжуут” хэмээн зөөллөжээ.

Энэхүү рашаан нь хэдэн зууны тэртээгээс анагаан эдгээх чадвараараа гайхагдаж, өвчиндөө шаналсан олон ардыг “тэнхрүүлэн тэтгэсэн буянт ус” билээ. Рашааны тогтоц нь, алгаа дэлгээд бүх эрхтэн, махбодь, эд эсээ дэлгэн хэвтэж байгаа хүний хэлбэртэй. Баянхонгор аймаг Шаргалжуутын рашаанаараа нэн алдартай. Тус рашаанд дотоод, гадаадын олон жуулчин, мөн өвчнөө анагаах, амарч сувилуулах хүсэлдээ хөтлөгдсөн олны хөл тасардаггүй жуулчлалын нөөцтэй юм. (Схем-4.).



Схем-4. Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялал жуулчлалын нөөц

Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялал жуулчилал хөгжих боломжит нөөцүүдийг координатжуулж аялалын маршрут болон үйлчилгээний төрлийг гаргаж харууллаа (Зураг-40.).



Зураг-40. Шаргалжуутын бүс нутагтай танилцах аялал жуулчлалын зураг


3.4.6 Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялалын маршрут

Монголын говийг нууцлаг, ер бусын гэж гадныхан хэлдэг. Энэ аялалын маршрут нь говийн байгалийн үзэсгэлэнт газрууд болох ногоон цав, хаан тоорой мод, эхийн гол, сэгс цагаан богд, хөөтийн агуй, хатан суудлын хавцал, шар хулс, амарбуянт хийд зэрэг үзэсгэлэнт бөгөөд түүхийн дурсгалт газрууд руу хөтөлнө. (Схем-5).



Схем-5. Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялал жуулчлалын нөөц

Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялал жуулчилал хөгжих боломжит нөөцүүдийг координатжуулж аялалын маршрут болон үйлчилгээний төрлийг гаргаж харууллаа (Зураг-41).



Зураг-41. Говийн үзэсгэлэнт газартай танилцах аялал жуулчлалын зураг

3.4.7 Говийн 6 гайхамшигт амьтадтай танилцах аялалын маршрут

Эхийн голын Баянбүрд нь Монголын говь нутагт байдаг Баянбүрдүүдээс хамгийн алдартай нь бөгөөд далайн түвшнээс 750 м өргөгдсөн Баянхонгор аймгийн хамгийн нам дор газар юм.


Эхийн голийн усыг ашиглан томоохон хэмжээний хиймэл нуур бүхий усалтын системийг байгуулж алим, шийгуа, амтат гуа, помидор зэргийг тарьж дотоодын хэрэгцээнд нийлүүлж байсан уламжлалтай.

Эхийн голын Баянбүрд нь Заг, Тоорой, Хайлаас, Сухай зэргээс бүрдсэн ойтой, Эхийн голын цэвэр тунгалаг гол, говь нутгийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газар нутаг бүхий говийн хангайгаас гадна говийн 6 гайхамшиг хэмээн нэрлэгддэг, улаан номд орж дархлагдсан Мазаалай хэмээх говийн баавгай, Хавтгай, Хулан, Аргаль, Янгир, Хар сүүлт зээр зэрэг ховор ан амьтдын нутаг юм. (Схем-6.).



Схем-6. Говийн 6 гайхамшигт амьтадтай танилцах аялал жуулчлалын нөөц

Говийн ховор ан, амьтадтай танилцах аялал жуулчилал хөгжих боломжит нөөцүүдийг координатжуулж аялалын маршрут болон үйлчилгээний төрлийг гаргаж харууллаа (Зураг-42).




Зураг-42. Говийн ховор ан амьтадтай танилцах аялал жуулчлалын зураг

3.4.8 Тусгай сонирхолын (Ан агнуур) аялал жуулчлалын төлөвлөлт

Хурдацтай хөгжиж буй өнөө үед эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах, нөөц баялаг түүний дотор агнуурын санг хамгаалах, тоо толгойг өсгөн үржүүлэх, зүй зохистой ашиглахтай холбоотой цогц арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлсний үр дүнд тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрэлдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн батлагдсан “Амьтны тухай” хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан журмуудад агнуурын нөөцийг хамгаалах, зүй зохистой, тогтвортой ашиглалтыг дэмжих зорилгоор газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах буюу “агнуурын бүс нутаг”-ийг бий болгох улмаар тэдгээрийн хамгаалалтыг бэхжүүлэх, менежментийг нь сайжруулах эрх зүйн орчин тусгагдсан байдаг. Амьтны тухай хуулийн 4.1.11 дэхь заалтад тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичиг нь “ан агнуурын менежментийн төлөвлөгөө” байна гэж тусгажээ.



Зураг-43. Ан агнуурын бүс нутгийн төлөвлөлт

Экологийн тэнцвэрт байдал алдагдаж буй сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр байгалийн нөөцийн хамтын, тогтвортой менежментийн талаарх үзэл баримтлал, тухайлбал байгаль хамгаалах ажилд орон нутгийн иргэдийн оролцоог хангах, тэдгээрийн нөөц бололцоонд тулгуурлан биологийн төрөл зүйлийг хамгаалах, зүй зохистой ашиглах асуудал хурцаар тавигдаж байна.

Хүснэгт-43. Баянхонгор аймгийн ан агнуурын бүс нутгийн төлөвлөлт

ДД	СУМЫН НЭР	ТӨЛӨВЛӨЛТ	НЭР	ТӨРӨЛ	ТАЛБАЙ, ГА
АН АГНУУРЫН БАТЛАГДСАН БҮС					
1	Баацагаан	Ан агнуурын батлагдсан бүс	Улаан аргалант	Аргал, Янгир	11062.5
2	Баянбулаг	Ан агнуурын батлагдсан бүс	Баянцагаан	Янгир	23462.6
3	Баянцагаан	Ан агнуурын батлагдсан бүс	Баянцагаан	Аргал-Янгир	10636.1
4	Богд	Ан агнуурын батлагдсан бүс	Хөх хадны хүүш	Аргал, Янгир	26710.0
5	Бөмбөгөр	Ан агнуурын батлагдсан бүс	Цагаан сайр	Янгир	21470.5
6	Бууцагаан	Ан агнуурын батлагдсан бүс	Богд аав уул	Янгир	37629.2
7	Галуут	Ан агнуурын батлагдсан бүс	Булгийн нуруу	Аргал, Янгир	29734.0
8	Галуут	Ан агнуурын батлагдсан бүс	Гэртийн нуруу	Буга	11726.2
9	Жаргалант	Ан агнуурын батлагдсан бүс	Далай хайрхан	Янгир	16973.7
10	Жинст	Ан агнуурын батлагдсан бүс	Жинст хайрхан	Аргал	20789.0
11	Жинст	Ан агнуурын батлагдсан бүс	Хавцгайт	Аргал, Янгир	3685.1
12	Өлзийт	Ан агнуурын батлагдсан бүс	Баян бийр	Аргал, Буга, тарвага	20392.8
13	Өлзийт	Ан агнуурын батлагдсан бүс	Баян хангай хишиг	Аргал, Янгир	25308.2
		Нийт			259580.0
АН АГНУУРЫН НӨӨЦ БҮС НУТАГ					
1	Баянлиг	Аргал хонины тархац бүс нутаг		Аргал	9526.7
2	Баян-Өндөр	Аргал хонины тархац бүс нутаг		Аргал	92593.3
3	Баян-Өндөр	Аргал хонины тархац бүс нутаг	Говийн А	Аргал	30570.5
4	Баян-Өндөр	Аргал хонины тархац бүс нутаг	Говийн А	Аргал	21992.1
5	Шинэжинст	Аргал хонины тархац бүс нутаг	Говийн А	Аргал	29300.8
6	Баянлиг	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	18674.2
7	Баянлиг	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	18471.6
8	Баянлиг	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	28918.9

9	Баянлиг, Баянговь	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	28914.1
10	Баянцагаан	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	15877.0
11	Баянцагаан	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	24215.3
12	Жинст, Богд, Баянговь	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	133329.8
13	Хүрээмарал	Янгир ямааны тархац бүс нутаг	Чандмань марал	Янгир	30690.6
14	Шинэжинст	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	9787.3
15	Шинэжинст, Баянговь	Янгир ямааны тархац бүс нутаг		Янгир	42051.7
Нийт					534913.8
ТӨЛӨВЛӨЖ БУЙ АН АГНУУРЫН БҮС					
1	Жаргалант	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Янгир	12683.8
2	Заг, Жаргалант, Галуут, Бөмбөгөр	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Янгир	77419.4
3	Шинэжинст	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Янгир	54132.9
4	Баацагаан	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Аргал, Янгир	329.8
5	Баянговь	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Янгир	39033.9
6	Баянговь	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Янгир	31662.7
7	Баянговь	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Аргал, Янгир, Ирвэс	5532.1
8	Баян-Өндөр	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Янгир, хар сүүлт	133960.9
9	Эрдэнэцогт	Төлөвлөж буй ан агнуурын бүс		Буга, согоо	4777.0
Нийт					359532.4
Аймаг нийт					1154026.1

Агнуурын бүс нутгийг сонгохдоо бүс нутгийн бэлчээрийн нөхцөл, усан хангамж, байгалийн нөлөө, амьдрах орчин, хүний нөлөө, агнуурын нөөц зэрэг хүчин зүйлийг харгалзан төлөвлөлөө.

Хэнтий аймгийн нутагт агнуурын бүс нутгийг сонгохдоо айл малын байршил, тоо толгой, ил задгай усны байршил гэх мэт зэрлэг хөхтөн амьтны элдэв хэлбэрт нөлөөлж болзошгүй нийгэм эдийн засгийн холбогдолтой мэдээлэлд анализ хийснээс гадна амьдрах орчны загварчлалаар тодруулан гаргасан тухайн амьтдын тархац, байршлын цөм нутаг, тоо толгой, нөөцийн үнэлгээ зэрэг мэдээллийг ашиглав.

Сүүлийн жилүүдэд тус аймгийн малын тоо толгойн бодит өсөлтөөс шалтгаалан ховор болоод агнуурын амьтдын байршил нутагт бэлчээр талхлагдах үзэгдэл газар авч байна.


Баянхонгор аймгийг хэмжээнд ан агнуурын батлагдсан 13 бүс, ан агнуурын 15 нөөц бүс нутаг байдаг. Аргал, тарвага, янгир, хар сүүлт, буга согоо ан амьтдын нөөцтэй ан агнуурын 9 бүс нутаг шинээр төлөвлөлөлөө.

3.5 Аялал жуулчлалын бүс нутгийн төлөвлөлт

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд /2020-2025/ Эдийн засгийн тэргүүлэх чиглэлд Орон нутгийн түүхэн дурсгалт, үзсэглэнт газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр тусгасан.

Орчин үед аялал жуулчлал нь нийгэм, эдийн засгийн өндөр өсөлттэй салбаруудын нэг болж, зугаа цэнгэл, чөлөөт цагаа өнгөрөөх арга төдий бус орон нутгийн хөгжилд эерэг нөлөөлөх хүчин зүйл болгон хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Ялангуяа тогтвортой аялал жуулчлал нь орон нутгийн ард иргэд, бизнес эрхлэгчдээс замаар тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах хамгийн боломжит нөөц юм. Энэ нь орон нутгийн иргэдийн ажиллаж, амьдрах орчныг сайжруулж, мэргэжилгүй болон хагас мэргэшсэн ажиллах хүчийг чадавхжуулж, улмаар орон нутгийн соёл, байгаль, нийгэмд үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллийг эерэг болгох боломжтой.



Зураг-44. Аялал жуулчлалын газрын төлөвлөлт

Баянхонгор аймгийн хэмжээнд аялал жуулчлалын зориулалтаар 63 байршилд төлөвлөсөн. Үүнээс Амралт сувилалын бүс 23, Аялал жуулчлалын бүс 39, Тусгай зориулалтын аялал жуулчлалын бүс 1 тус тус төлөвлөсөн.

Хүснэгт-44. Баянхонгор аймгийн аялал жуулчлалын газрын төлөвлөлт

№	Сумын нэр	Бүс	Байршил	Газрын нэр	Талбай, га
1	Баацагаан	Аялал жуулчлалын бүс	2	Бөөн цагаан, Бөөн цагаан нуур	1248.7
2	Баянбулаг	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	1	Бөөн цагаан нуур	46.7
3	Баянговь	Аялал жуулчлалын бүс	2	Нарангийн булаг, Байшинт	3.9
4	Баянговь	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	3	Их арцангын ам, Хөмсгийн рашаан /Ичээт/, Ишигний эвэр хайрхан	70.4
5	Баянговь	Амралт сувилалын бүс	1	Байшинт	22.9
6	Баянлиг	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	2	Цагаан агуй, Бичигт хад	677.5
7	Баянлиг	Аялал жуулчлалын бүс	1		1.0
8	Баян-Овоо	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	2	Хөх бүрд, Асгамба	277.9
9	Баян-Овоо	Аялал жуулчлалын бүс	1	Хөх бүрд	7.3
10	Баян-Өндөр	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	1	Амарбуянт хийд	0.4
11	Баянхонгор	Аялал жуулчлалын бүс	1	Баянхонгор	2.1
12	Баянцагаан	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	2	Өлийн эх, Зуслан ирмэг	782.4
13	Баянцагаан	Тусгай зориулалтын аялал жуулчлалын бүс	1	Аргалант	9395.9
14	Богд	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	2	Сэвсүүлийн дөрөлж, Орог нуур захын цагаан элс	1898.8
15	Бөмбөгөр	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	1	Элээтийн хясаа	29.9
16	Бууцагаан	Төлөвлөж буй амралт, сувилалын бүс	3	Овоот түрүү, Нимгэн шовх Уул Гандирс хүрээлэн	219.2
17	Галуут	Төлөвлөж буй амралт сувилалын бүс	8	Өргөөтийн харз, Үхэгийн рашаан, Хойд үүдийн давсан нуур, Хойд	1177.8

				тээлийн рашаан, Хойд өргөөтийн рашаан, Хуримт, Бөөрөг, Тээлийн рашаан, Нарийн цохиотын рашаан	
18	Галуут	Амралт, сувилалын бүс	2	5-р бригад, Өргөөтийн харз	109.2
19	Гурванбулаг	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	1	Хөх нуур	2775
20	Жаргалант	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	2	Биндэрьяа хөх нуур, Даравгуай нуруу	252.3
21	Жинст	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	3	Хавцгай ам, Таван элс, Улиатын ам	531.3
22	Жинст	Төлөвлөж буй амралт, сувилал, аялал жуулчлалын бүс	1	Холбоолж нуур	502.7
23	Заг	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	2	Хүрэн бэлчир, Халиут	290.9
24	Өлзийт	Амралт сувилалын бүс	3	Бага шаргалжуут, 3-бригад	6.6
25	Өлзийт	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	5	Бага шаргалжуут, Агуйт, Гялгарын хавцгай, Уушгийн хад, Бийрийн нуур, буагн чулуун хөшөө	5474.0
26	Хүрээмарал	Төлөвлөж буй аялал жуулчлалын бүс	1	4-р Бригад	1482.6
27	Хүрээмарал	Амралт сувилалын бүс	1	Холбоо нуур	2693.4
28	Шинэжинст	Төлөвлөж буй аялал жуулчлалын отоглох бүс	1	Цагаан хаалга	0.5
29	Эрдэнэцогт	Төлөвлөж буй амралт сувилалын бүс	4	Эрхэт хавцал, Дөрөлж, Шатар чулуу, Хүүхдийн зуслан	159.6
30	Эрдэнэцогт	Амралт сувилалын бүс	1	Шаргалжуут	44.6
Нийт			61		30185

ДӨРӨВ. ОЙН САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

4.1. Ойн сангийн газрын нөхцөл, нөөцийн суурь судалгаа

4.1.1 Оршил


“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Ойн тухай хууль”, “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөр, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” зорилтот бүс нутгийн “Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 2021-2027 он”, “Баянхонгор аймгийн 2021 хөгжлийн төлөвлөгөө” зэрэг төр засаг, орон нутгаас дэвшүүлэн ажиллаж буй хөтөлбөр, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчимд үндэслэсэн Баянхонгор аймгийн “Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө”-г “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслийн захиалгаар ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэнд 2021 онд боловсруулсан байна. Энэ ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөтэй Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг уялдуулах арга хэмжээг хийж гүйцэтгэлээ. Мөн дараах материалуудыг судлаж төлөвлөгөөний суурь материал болгон ашиглав.

- Баянхонгор аймгийн “Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө”-ний материал 2022 он
- Баянхонгор аймгийн Ой зохион байгуулалтын материал, 2015 он
- Баянхонгор аймгийн заган ой бүхий сумдын (Баян-өндөр, Баацагаан, Шинэжинст) ойн менежментийн төлөвлөгөө 2021-2024 он
- Баянхонгор аймгийн заган ой бүхий сумдын (Баян-өндөр, Баацагаан, Шинэжинст) нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 2020 он

4.1.2 Ойн сан ба түүний төлөв байдал¹

“Ойн тухай” хуульд ² зааснаар “Ой бүхий газар, таримал ой, бут сөөг, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн цоорхой, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын талбай нь ойн сан бүхий газар”-т хамаарна. Ойгоор бүрхэгдсэн газар, өмнө ой байснаа гадны нөлөөнд өртөж ойгоор бүрхэгдээгүй болсон газар болон цаашид ой тэлэн ургах боломжтой ойн орчныг бүхэлд нь ойн сан бүхий газарт хамруулна. Ойн сан бүхий газрыг хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдлыг харгалзан хамгаалалтын ба ашиглалтын бүс гэж ангилна. Хамгаалалтын бүсэд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газар нутаг, хот суурин газрын эргэн тойрны ногоон бүс, гол мөрний эхийн болон голын дагуух хориотой зурвасын ой, 100 га хүртэлх төгөл ой, 30 хэмээс дээш хэмийн налуу газрын ойг хамруулна.

¹ “Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө” (ОТМТ, 2022)-нөөс авч ашиглав



Зураг-45. Баянхонгор аймгийн ойн тархалт ГНС-ийн ангилалаар

Баянхонгор аймгийн нутагт тархан ургасан ойн сан бүхий газар нь Хангайн нурууны БЦГ, Их Богд уулын БЦГ, Говийн их ДЦГ-ын А хэсэг, Говь Гурван Сайхан уулын БЦГ зэрэг Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон Баянбүрд, 30 хэмээс дээш налуу газрын ой, ногоон бүс, хориотой зурвас зэрэг Хамгаалалтын бүсэд бүхэлдээ хамрагдаж байна (ОТМТ, 2022).




График-6. Ойн бүсийн төрөл¹

Ойн сан бүхий талбайн 70%-нь Улсын ТХГН-т, 28%-нь заг, баян бүрд бүхий талбай, 2 орчим хувь нь суурин газрын ногоон бүс, голын эхийн болон эрэг дагуух хориотой бүс болон 30 хэмээс дээш налуу газрын ойн бүсэд тус тус хамрагдаж байна (ОТМТ, 2022).

Ойн тухай хуульд зааснаар³ Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хүснэгт-45. Ойн сан бүхий газрын бүсийн төрөл

Д.д	Ойн бүсийн төрөл	Ойн сан бүхий газрын талбай (га)	Эзлэх хувь
1	Хангайн нурууны БЦГ	17296	2,1%
2	Ногоон бүсийн ой	2847	0,3%
3	Хориотой зурвасын ой	9	0,1%
4	30 хэмээс дээш налуу газрын ой	13283	1,6%
Шилмүүст, навчит ойн дүн		33435	4,1%
5	Говийн Их ДЦГ	409010	49,8%
6	Говь Гурван Сайхан БЦГ	148029	18,0%
7	Заган ой Баянбүрд	230207	28,1%
Заган ойн дүн		787246	95,9%
Нийт дүн		820681	100%


4.1.3 Ойн сан бүхий газар¹

Баянхонгор аймаг нь Хангайн нурууны салбар уулсын урд захын өндөрлөг болон Говь Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийг хамран говь хангайн бүсийг дамнан оршдог онцлог газар нутаг юм. Нутгийн хамгийн өндөр цэг нь Говь Алтайн нурууны оргил 3957 м өргөгдсөн Их Богд уул бөгөөд хамгийн нам цэг нь Алтайн өвөр говьд 750 м өндөр юм. Зээрэнгийн хөндий, Номингийн говь зэрэг Алтайн өврийн их говиудтай. Байгаль цаг уурын онцлог нөхцөлд тархсан хангайн бүсийн навчит, шилмүүст мод болон говь, хээрийн бүсийн заган ой тархан ургадгаараа Монголын ой бүхий бусад нутгаас нилээд өвөрмөц бүс нутаг юм (ОТМТ, 2022). Баянхонгор аймгийн ойн сан бүхий газрын нийт талбай 820 681 га байгаагаас 4% буюу 33 435 га талбай нь Хангайн бүсийн шилмүүст, навчит ой бол 96%-нь буюу 787 246 га Говийн бүсийн заган ой юм. Аймгийн газар нутгийн 7,1 хувийг ойн сан бүхий газар эзэлнэ (Баянхонгор аймгийн ой зохион байгуулалтын тайлан 2015). Баянхонгор аймгийн нутагт тархан ургасан байгалийн ой, заг болон бут сөөг бүхий талбайг (542,4 мян.га) аймгийн газар нутагтай (11600,0 мян.га) харьцуулахад ойрхог чанар 4,7% байна (ОТМТ, 2022).

Хүснэгт-46. Ойн сан бүхий газрын талбай (ОТМТ, 2022).

Ойн сангийн талбайн төрлийн ангилал			Ойн сангийн талбайн хэмжээ, га		
			Шилмүүст, навчит ой	Заган ой	Нийт талбай
Ойн талбай	Ойгоор бүрхэгдсэн талбай	Байгалийн ой (заг)	29 667	509 586	539 253
		Сөөг, торлог	65	3 121	3 186
	Ойгоор бүрхэгдсэн талбайн дүн		29 732	512 707	542 439
	Ойгоор бүрхэгдээгүй талбай	Тармаг ой (заг)	2 443	274 401	276 844
		Шатсан ойн талбай	327	8	335
		Ойжих талбай (загжих)	844	128	972
	Ойгоор бүрхэгдээгүй талбайн дүн		3 614	274 537	278 151
Ойн талбайн дүн			33 346	787 244	820 590
Ойн бус талбай	Мод үржүүлгийн газар			2	2
	Цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр		89		89
	Ойн бус талбайн дүн		89	2	2
Ойн сангийн нийт талбай			33 435	787 246	820 681

Баянхонгор аймгийн нутагт тархан ургасан Хангайн бүсийн шилмүүст, навчит ойн сан бүхий газрын 88,7%-нь байгалийн ой, 0,2% сөөг, торлог, 7,3% тармаг ой байна (ОТМТ, 2022).



Зураг-46. Баянхонгор аймгийн ойн тархалт /ойн төрлөөр/

Ойн сангийн талбайгаас 327 га буюу 1% орчим га талбай түймэрт өртсөн бол цаашид ой тэлэн ургах боломжтой талбай 2,5% байна (ОТМТ, 2022).





График-7. Ойн сангийн газрын төрлийн ангилал¹

Заган ойн хувьд 65,7%-нь байгалийн заган ой, 0,4%-нь сөөг торлог, 34%-нь тармаг заг бүхий талбай байна. Заган ойн сан бүхий газар нутагт 335 га талбайд хатсан заг, 972 га талбайд заг тэлэн ургах боломжтой газар нутаг хамрагдаж байна (ОТМТ, 2022).



Схем-7. Заган ойн талбайн төрөл¹

Баянхонгор аймгийн нутагт 33435 га талбай бүхий шилмүүст, навчит ой Баян-Овоо, Галуут, Жаргалант, Өлзийт, Эрдэнэцогт зэрэг 5 сумдын нутгийг хамран тархан ургана. Ойн тархалтыг сумаар авч үзвэл Эрдэнэцогт сумын нутагт 45,7%, Галуут суманд 38,5%, Жаргалант суманд 12 орчим хувь нь хамаарна. Өлзийт, Баян-овоо сумын нутагт ойн багахан хэсэг буюу 1-2% байна (ОТМТ, 2022).




График-8. Шилмүүст, навчит ойн талбай (сумаар)¹

Баянхонгор аймгийн заган ойн талбай нь 7 сумын нутагт тархан ургасан байна. Заган ойн талбайн 48%-нь Баян-өндөр, 30%-нь Шинэжинст, 19%-нь Баянлиг сумын нутагт зонхилон тархах ба Баянговь, Богд, Баацагаан, Жинст сумдад багахан хэмжээтэй байна (ОТМТ, 2022).




График-9. Заган ойн талбай (сумаар)¹

Хүснэгт-47. **Ойн сан бүхий газрын талбай, га /сумаар/ (ОТМТ, 2022).**

Д.д	Ой бүхий сумдын нэр	Ойн сан бүхий газрын төрөл			Ойн сангийн талбай, га
		Ойгоор бүрхэгдсэн	Ойгоор бүрхэгдээгүй	Ойн бус талбай	
Шилмүүст, навчит ой бүхий сумдууд					
1	Баян-Овоо	343	-	3	346
2	Галуут	11859	917	83	12859
3	Жаргалант	3612	360	-	3972
4	Өлзийт	880	92	-	972
5	Эрдэнэцогт	13038	2245	3	15286
Ойн дүн		29732	3614	89	33435
Заг бүхий сумдууд					
6	Баянговь	1519	-	-	1519
7	Баянлиг	127737	21972	-	149709
8	Баян-Өндөр	206867	174264	-	381131
9	Богд	11476	479	2	11957
10	Баацагаан	2117	376	-	2493
11	Жинст	458	688	-	1146
12	Шинэжинст	162533	76758	-	239291
Заган ойн дүн		512707	274537	2	787246
Ойн сангийн нийт дүн		542439	278151	91	820681

Ойн сангийн модны төрөл¹

Шилмүүст, навчит ойн нөөцийг бүрдүүлэгч зонхилох модны төрөл нь шинэс бөгөөд улиас, улиангар багахан хэмжээгээр дагалдан тархах бол говийн бүсэд ургах гол мод нь заг юм. Тоорой, бургас, сухай болон бусад сөөг, торлог ойн нөөцөд багахан хувийг эзлэн ургана (ОТМТ, 2022).




График-10. Шилмүүст, навчит ойн нөөц, модны төрлөөр (ОТМТ, 2022).

Тус аймгийн нутагт тархан ургасан ойн голлох төрөл нь шинэс бөгөөд улиангар, улиас мод 1 хүрэхгүй хувийг эзэлнэ (ОТМТ, 2022).




График-11. Заган ойн нөөцөд модны төрлийн эзлэх хувь¹

4.1.4 Ойн нөөц¹

Ой дахь ургаа модны ишний эзлэхүүнийг ойн нөөц гэсэн үзүүлэлтээр илэрхийлнэ. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглахад ойн нөөц нь чухал үзүүлэлт болдог. Баянхонгор аймгийн хувьд хангайн бүсийн шилмүүст, навчит ойн нөөц 2287,1 мянган шоометр, говийн бүсийн заган ойн нөөц нь 325,0 мянган байна. Ойн санд байгалийн ойн ургаа нөөцөөс гадна тармаг болон бүлэг модны нөөц, хатсан, унасан модны нөөц байна Шилмүүст, навчит ойн ургаа нөөцийн 96,7%-нь байгалийн ойн нөөц, 3,3%-нь тармаг болон бүлэг модны нөөц эзэлж байна. Ойд 17,6 мян.м³ хатсан, унасан нөөцтэй байна. Заган ойн хувьд ойн ургаа нөөцийн 8,1%-нь тармаг ойн нөөц байгаагас гадна хатаж хуурайссан загийн нөөц 69,2 мян.м³ гэж судалгаагаар тогтоосон байна Ойн нөөцийн 26% нь налуугийн 3-р бүлэг буюу 26-35 хэмийн налууд, 74% нь 35 хэмээс дээш налууд тархан ургасан байна. (ОТМТ, 2022).

Хүснэгт-48. Ойн нөөцийн дүнгийн хүснэгт /нөөц - мян.м³/

Байгалийн ойн нөөц	Тармаг модны нөөц	Бүлэг модны нөөц	Ургаа ойн бүх нөөц	Хатсан модны нөөц	Унанг и модны нөөц	Налуугийн бүлэг			
						1	2	3	4
						0-15 хэм	16-25 хэм	26-35 хэм	36< хэм
Шилмүүст, навчит ойн нөөц									
2213,6	58,9	14,6	2287,2	11,4	3,0	0,7	2,0	577,2	1633,7
Заган ойн нөөц									
298,6	26,3	-	325,0	69,2	-	-	-	-	-

Баянхонгор аймгийн ой нь модны төрөл, модны нас, өтгөрөл, нөөц болон бусад үзүүлэлтээрээ харилцан адилгүй байхаас гадна аж ахуйн ач холбогдлоороо ялгаатай байна.

Хүснэгт-49. Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлт /модны төрлөөр/ (ОТМТ, 2022).

Модны Төрөл	Талбай мян.га	Нөөц мян.м ³	Бүх дундаж өсөлт, мян.м ³	Дундаж нас	Бонитет	Дундаж өтгөрөл	1га-н нөөц м ³	1га-н өсөлт м ³
Хангайн бүсийн Шилмүүст, навчит ой								
Шинэс	29534	2211,8	18,4	121	5,0	0,47	78	0,64
Улиангар	29	0,6	0,01	6	5,0	0,45	21	0,26
Бургас	104	1,2	0,1	35	5,0	0,27	11	0,3
Дүн	29667	2213,6	18,5	-	5,0	0,47	75	0,62
Говийн бүсийн Заг бүхий ой								
Улиас	94	2,9	0,2	61	5,0	0,34	31	0,51
Заг	509,0	285,4	11,9	24	3,0	0,35	0,56	0,02
Тоорой	0,5	10,3	-	-	-	-	20	-
Дүн	509,6	298,6	12,4	-	3,0	0,35	0,58	0,02

Баянхонгор аймагт зонхилон тархсан шинэсэн ойн дундаж нас нь 121 жил бөгөөд 1 га-н өсөлт нь 0,64 м³, 1 га-н нөөц нь 78 м³ байна. Модны жилийн өсөлт болон 1 га-н нөөц, дундаж нас зэрэг таксацын үзүүлэлтийг харгалзан ойн арга хэмжээг төлөвлөнө. Тус бүс нутагт зонхилон тархсан шинэсэн ойн дундаж өтгөрөл 0,47 байгаа нь ой сийрэгжих хандлагатай байгааг харуулж байна (ОТМТ, 2022).

Хүснэгт-50. Шилмүүст, навчит ойн насны бүлгийн хүснэгт (ОТМТ, 2022).

Модны төрөл	Насны бүлэг								ДҮН	
	Залуу ой		Дунд насны ой		Болц гүйцэж буй ой		Болц гүйцсэн ой		талбай, га	нөөц, мян.м ³
	талбай, га	нөөц, мян.м ³	талбай, га	нөөц, мян.м ³	талбай, га	нөөц, мян.м ³	талбай, га	нөөц, мян.м ³		
Шинэс	690	31,7	9171	535,9	2222	152,4	17451	1491,7	29534	2211,8
Улиангар	28	0,6	1	0,04					29	0,6
Бургас			104	1,2					104	1,2
Дүн	718	32,3	9276	537,1	2222	152,4	17451	1491,7	29667	2213,6

¹ “Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө” (ОТМТ, 2022)-нөөс авч ашиглав





График-12. Шилмүүст ойн насны бүлгийн тархалт (ОТМТ, 2022).

Тус нутгийн шилмүүст, навчит ойн хувьд насны бүлгийн тархалт харилцан адилгүй жигд бус байна. Ойн нөөцийн 67,4%-нь болц гүйцсэн хөгшин ой байгаа бол залуу ойн нөөц маш бага хувьтай байгаа нь графикаас харагдаж байна. Ойн хэв шинжийн ангиллаар Баянхонгор аймгийн шилмүүст, навчит ой бүхий бүс нутаг нь Ургамалжилтын мужлалаар ойт хээрийн мужид багтах ба Хангайн их мужийн Зүүн хойд Хангайн хошууны тайгажуу шинэсэн ойд хамаарна. Ойн хэв шинжийн ангилалаар Алаг өвст Шинэсэн ойн хэв шинж зонхилон тархана (ОТМТ, 2022).

Хүснэгт-51. Заган ойн хэв шинжийн ангилал (ОТМТ, 2022).

Ойн хэв шинж	Модны төрөл (га талбай)			Нийт дүн	Эзлэх хувь
	Заг	Тоорой	Улиас		
Элсний заг	19081		58	19139	4
Сайр садаргын заг	390960	514	22	391496	77
Шал тойрмын заг	45555		14	45569	9
Чулуут цөлийн заг	53382			53382	10
Дүн	508978	514	94	509586	100


¹ “Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө” (ОТМТ, 2022)-нөөс авч ашиглав



Зураг-47. Баянхонгор аймгийн навчит, шилмүүст ойн тархалт, төлөв байдлын зураг

Хүснэгт-52. Ойн сан бүхий газрын талбай, га /сумаар/

Дд	Ойн сан бүхий сумдын нэр	Ойн сангийн талбай, га
Шилмүүст, навчит ой бүхий сумдууд		
1	Баян-Овоо	346
2	Галуут	12859
3	Жаргалант	3972
4	Өлзийт	972
5	Эрдэнэцогт	15286
Шилмүүст ойн талбайн дүн		33435
Заган ой бүхий сумдууд		
1	Баянговь	1519
2	Баянлиг	149709
3	Баян өндөр	381131
4	Богд	11957
5	Баацагаан	2493
6	Жинст	1146
7	Шинэжинст	239291
Заган ойн дүн		787246
Аймгийн хэмжээнд ойн сангийн талбайн дүн		820681



Зураг-48. Баянхонгор аймгийн заган ойн тархалт, төлөв байдал

4.1.3 Ойн сангийн өөрчлөлт¹

Баянхонгор аймгийн ойн сан бүхий газарт хийсэн ой зохион байгуулалтын судалгааны материалд ойн өөрчлөлтийг тооцож гаргасан байна. Шилмүүст ойн сангийн газрын төрлийн өөрчлөлтийн хүснэгтээс харахад ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай 7987 га талбайгаар, ойгоор бүрхэгдээгүй талбай 1802 га талбайгаар тус тус нэмэгдэж ойн талбай нийт дүнгээрээ 9746 га талбайгаар нэмэгдсэн байна (2006-2015 оны ойн зохион байгуулалтын мэдээ).

Баянхонгор аймгийн хэмжээнд хийсэн 2015 оны ой зохион байгуулалтын материалд үзүүлснээр байгалийн ойн талбай 7922 га, сөөг, торлог 65 га талбайгаар нэмэгдсэн бол ойгоор бүрхэгдээгүй талбайн мод бэлтгэсэн талбай 21 га, ойжих талбай 285 га талбайгаар багасаж тармаг мод 1821 га, шатсан талбай 327 га талбайгаар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан байна (2006-2015 оны ойн зохион байгуулалтын мэдээ).

Хүснэгт-53. Шилмүүст-навчит ой бүхий газрын төлөв байдал, га /сумаар/

№	Сум	Шинэс	Бургас	Улиангар	Торлог	Цагаан энгэр	Ойжих талбай	Шатсан ой
1	Баян-Овоо сум	342.15				3.28		
2	Галуут сум	12872.32	64.94	22.12	64.71	83.25	86.16	
3	Жаргалант сум	3295.40	199.56					
4	Өлзийт сум	986.14		0.82				
5	Эрдэнэцогт сум	14218.10	14.14			3.08	756.77	346.04
	Нийт талбай	31714.10	278.64	22.94	64.71	89.61	842.93	346.04

Өмнөх ой зохион байгуулалтын судалгаагаар багахан хэмжээтэй төгөл ой, зураа мод орхигдсоноос шалтгаалан сүүлийн ой зохион байгуулалтын тооцоонд байгалийн ой, сөөг торлог зэрэг ойгоор бүрхэгдсэн талбай нэмэгдэж гарсан байна. Харин түймэрт өртсөн болон тармаг ойн талбайн хэмжээ нэмэгдэж байгаа нь ойгоор бүрхэгдсэн талбайгаас ойгоор бүрхэгдээгүй талбай руу шилжих хандлагатай байгааг харуулж байна (2006-2015 оны ойн зохион байгуулалтын мэдээ).

Тармаг ойн талбай нэмэгдэж байгаа шалтгаан нь ойгоос ахуйн зориулалтаар мод бэлтгэхдээ ойг хэт сийрэгжүүлэх, ойгоос хууль бусаар мод бэлтгэж байгаагаас гадна ойн байгалийн сэргэн ургалт хангалтгүй явагдаж ой тэлж ургах боломж хомс байна. Өмнөх ой зохион байгуулалтаас хойш ойжих талбайн хэмжээ 285 га-гаар багассан байгаа нь ойн орчин алдагдаж ой сэргэн ургах боломжит талбай хумигдаж хээрших хандлагатай байгааг илтгэж байна. Заган ойн хувьд өмнөх судалгаанд хамрагдаагүй талбайг нарийвчлан оруулж тооцсон тул нийт талбайн хэмжээ нэмэгдэж гарсан байна. Заган ойн талбайн төрлөөр нь авч үзвэл тармаг заг бүхий талбай 84,0 мянган га-гаар нэмэгдсэн байгаа нь заг бүхий талбай хэт сийрэгжих хандлагатай болохыг харуулж байна (ОТМТ, 2022).

Хүснэгт-54. Заган ой бүхий газрын төлөв байдал, га /сумаар/

Сум	Заган ой	Тоорой	Сөөг	Бургас	Загжих талбай	Буйлс	Мод үржүүлгийн газар
Баацагаан сум	2404.71						
Баянлиг сум	145437.57	747.55	1496.74		2.92		
Баян-Өндөр сум	382511.71						
Богд сум	10996.1754				36.86	923.64	1.71
Жинст сум	1061.69			24.37	84.79		
Шинэжинст сум	243020.36	74.56	289.91				
Бүгд	785432.22	822.12	1786.65	24.37	124.57	923.64	1.71

¹ “Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө” (ОТМТ, 2022)-нөөс авч ашиглав

4.1.5 Баянхонгор аймгийн ойн төлөв байдал, ойн менежментийн үйл ажиллагаанд хийсэн SWOT дүн шинжилгээ¹

Баянхонгор аймгийн ойн төлөв байдал, ойн менежментэд тулгарч буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, ойн менежментийг сайжруулахын тулд цаашид авах арга хэмжээ, шийдэл, стратегийг тодорхойлоход SWOT, “TOWS MATRIX” дүн шинжилгээний аргыг ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэн хэрэглэсэн байна (Хүснэгт 55).

Хүснэгт-55. SWOT дүн шинжилгээ (ОТМТ, 2022).

Давуу тал	Сул тал
<p>Өндөр өргөгдсөн уулархаг нутаг болон нам дор хангай говь хосолсон байгалийн бүс бүслүүрийн өвөрмөц тогтоцтой, олон хэв шинж бүхий ландшафт, өргөн удам нутаг дэвсгэртэй /биологийн олон янз байдал/</p> <p>Байгалийн үзэсгэлэнт газар, дэлхийд данстай нэн ховор, ховордсон ан амьтан, ургамлын амьдрах орчин болдог тархац нутагтай /биологийн төрөл зүйл/</p>	<p>Нутаг дэвсгэрийн өмнөд хэсгээрээ хур тунадас маш бага (жилд 50-100мм) хуурайшилт ихтэй, гангийн нөлөө их, хүчтэй салхи, шороон шуургын давтамж нэмэгдсэн</p> <p>Бэлчээрийн ургамлын тархалт сийрэг, гарц, ургац бага, бэлчээрийн даац хэтэрсэн, зохицуулах механизм тодорхой бус, бэлчээрийн нөөц чадавх бага</p>
<p>Аймгийн ойн сан бүхий газар нь Хангайн нурууны БЦГ, Их Богд уулын БЦГ, Говийн их ДЦГ-ын А хэсэг, Говь Гурван Сайхан уулын БЦГ зэрэг Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон Баянбүрд, 30 хэмээс дээш налуу газрын ой, ногоон бүс, хориотой зурвас зэрэг Хамгаалалтын бүсэд бүхэлдээ хамрагдаж байна.</p>	<p>Ойг зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах, үр түүх, тарьц, суулгац ургуулах ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай</p> <p>Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын тарьц суулгац бэлтгэх Мод үржүүлгийн газар бага, тарьц суулгацийн нөөц байхгүй</p>
<p>Биологийн олон янз байдлыг тэтгэх, экологийн чухал ач холбогдол бүхий томоохон баян бүрд, нуур цөөрөмтэй</p> <p>Ургамал ургах дулааны нийлбэр температур их</p> <p>Тусгай хамгаалалттай газар, биологийн чухал ач холбогдол бүхий газар нутгийг орон нутгийн мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор хийх боломжтой</p>	<p>Булаг шандтай ойр сибирь хармаг болон заган ой малын бэлчээрлэлтэнд байнга өртөж, эрс доройтсон ба эдгээр газруудад малчдын өвөлжөө, хаваржаа, намаржаа байрших ба тус газарт малчид жилийн 4 улиралд сэлгээгүйгээр малаа бэлчээдэг</p> <p>Малчдын амжиргааны ганц эх үүсвэр болсон ямааны тоо толгойн өсөлт нь бэлчээр, ой, сөөг ургамал доройтох, цөлжилт нэмэгдэх үндсэн хүчин зүйл болж байна</p>
<p>Шилмүүст навчит ой болон заган ойн зохион байгуулалт хуулийн дагуу 10 жил тутам хийгддэг</p> <p>Ойн сан бүхий газар нутаг төдийгүй бусад ургамалжилтад түймрийн аюул бага байдаг</p> <p>Хур тунадас бага хэдий ч ургамал</p>	

<p>ургалтын хугацаа урт Мод, сөөг тарьж ургуулах, ойн сангаа хамгаалах сонирхолтой</p>	
<p style="text-align: center;">Боломж</p>	<p style="text-align: center;">Эрсдэл, аюул</p>
<p>Байгалийн бүс бүслүүр, ландшафтын хэвшинжийн олон янз байдалд нийцсэн тогтвортой ногоон хөгжлийн хандлагыг төлөвшүүлэх, байгаль хамгаалах уламжлалыг сэргээн хөгжүүлэх. Байгалийн үзэсгэлэнт газар, дэлхийд данстай нэн ховор, ховордсон ан амьтан, ургамлын нөөцийн зүй зохистой менежментийг нэвтрүүлэх, аялал жуулчлал зэрэг аж ахуйн салбарыг хөгжүүлэх. МҮГ, хүлэмжийн аж ахуй эрхлэх, түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх. Ногоон байгууламж, доройтсон ойн ойжуулалт, салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, булаг шандын эхийг хамгаалах, мод тарих, иргэдийг хашаа, өвөлжөө, хаваржаандаа мод тарихад уриалах зэрэг амьдрах орчноо сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх Нар, салхины сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах. ENSURE төслөөс Тусгай хамгаалалттай газар, биологийн чухал ач холбогдол бүхий газар нутгийн байгаль орчин, газар, ус, цаг уур, мэргэжлийн хяналт зэрэг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хийж байгаа</p>	<p>Уур амьсгалын дулаарал, хүчтэй салхи, шороон шуурга, үер, ган зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ихэсэж байгаа ба цаашид ч улам нэмэгдэж болзошгүй</p> <p>Биологи, экологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутгийг хамгаалалтад авахгүй бол үнэ цэнэтэй, нэн ховор, ховор амьтан ургамал устах</p> <p>Бэлчээр ашиглах, хамгаалах гэрээ байгуулах, даац хэтрэлтийг зохицуулах норм, эдийн засгийн механизм нэвтрүүлж, малын тоо толгойг бэлчээрийн тохируулахгүй бол цөлжилтөд нэрвэгдэх эрсдэл үүсээд байна.</p> <p>Тармаг заг болон заган ойд малаа бэлчээх нь заган ойн доройтлыг улам бүр нэмэгдүүлж, цөлжилтөд нэрвэгдэх.</p> <p>Газар, заган ой, усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхгүйгээр байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн эрсдэл үүсэх үндсэн нөхцөл бүрдэнэ.</p> <p>Байгаль хамгааллын арга хэмжээг иргэд нөхөрлөлд түшиглэсэн иргэдийн зүй ёсны эрхийг баталгаажуулах замаар эзэнтэй болгохгүйгээр дан ганц төрийн байгууллагын хяналтын хүчин чадал буурсаар байгалийн нөөц устаж үгүй болох эрсдэлтэй</p> <p>Усны эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийг тогтоож төлөвлөхгүй бол усны нөөц хомсдох, бохирдох эрсдэлтэй</p> <p>Ус ашиглалтын нэгдсэн бодлого байхгүй</p>

4.2. ОЙН САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Баянхонгор аймгийн ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ гэж үзсэн байна (ОТМТ, 2022). Үүнд:

- Аймгийн ойн санд 450 га талбайд ойжуулалтын ажил, 171 га талбайд байгалийн сэргэн ургалтанд туслах ажил, 2485 га талбайд цэвэрлэгээний ажил, 1520 га талбайд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд үр түүх байнгын болон түр талбай тусгаарлах 105 га талбай, 10,0 сая тарьц суулгац ургуулах ажил зэрэг үйл ажиллагааг явуулснаар ойн экосистемийн орчин сайжирна.
- Аймгийн ойн сангаас арчилгааны огтлолтоор 118 га талбай, 2725 м³, эрүүл ахуйн огтлолтоор 2485 га, 24850 м³ мод авч ашигласнаар орон нутгийн иргэдийн мод, модон материал, түлээний хэрэгцээ хангагдана.
- Ойн хомсдол доройтлыг бууруулах арга хэмжээний хүрээнд ойг нөхөн сэргээж ойжуулахад шаардлагатай далд үндэсний системтэй ойн суулгац материалын үйлдвэрлэл нөөц (20.0 сая тарьц) бүрдэнэ гэж төлөвлөснийг Баянхонгор аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгалаа

4.2.1 Ой хамгааллын арга хэмжээ¹

Ойн хомсдол, доройтолд нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь ойн түймэр, ойн хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл, ойн дагалт баялгийн хэт ашиглалт, малын тоо толгойн өсөлт, ойн аж ахуйн арга хэмжээг технологийн дагуу хангалттай явуулахгүй байгаа, уул уурхайн ашиглалт, хүний нөөцийн дутагдалтай байдал зэрэг хүний хүчин зүйлээс шалтгаалсан нөхцөлүүд байна. Мөн түүнчлэн Уур амьсгалын өөрчлөлт, ган гачиг болон байгалийн гамшиг, хуурайшилт зэрэг байгалийн хүчин зүйлс давхар нөлөөлж байна.



Схем-8. Ой хамгааллын арга хэмжээ¹

Ойн хамгаалал гэдэг ойлголтод ойг хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хохирлыг арилгах арга хэмжээ, ойд арчилгаа цэвэрлэгээ хийх, ойн хэвийн өсөлт нөхөн сэргээлтийг хангах, удмын санг хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг хамруулна.

Хүснэгт-56. **Ой хамгаалах төлөвлөгөөний зардал /2022-2026 он/ (ОТМТ, 2022)**

Зорилго	Хугацаа	Төсөв
		/мян.төг/
Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажил	2022 - 2026	1040
Хөнөөлт шавж өвчний судалгаа,	2022 - 2026	8340
Хөнөөлт шавж өвчин, мэрэгчтэй тэмцэх ажил	2022 - 2026	27350
Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх	2022 - 2026	2250
Дүн		38980

Баянхонгор аймгийн ойн сангийн талбайгаас түймэрт өртөх, хөнөөлт шавжид нэрвэгдэх нь харьцангуй бага боловч 2015 оны ой зохион байгуулалтын судалгаагаар Эрдэнэцогт сумын нутагт 327 га ойн талбай түймэрт өртсөн болохыг тогтоосон байна.

Баянхонгор аймгийн ойн санг ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг жилд 5 га талбайгаар бодож 5 жилээр төлөвлөв (Эрдэнэцогт, Галуут).

Ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгаанд Баянхонгор аймгийн ой бүхий газар нутаг жил бүр хамрагдаж байгаа бөгөөд 2009 оноос хойш жилд дундажаар 20-25 мянган га талбайг судалгаанд хамруулж тэмцлийн ажил хийгдсэн байна. Баянхонгор аймгийн ойд Эгэл бийрэн сүүлт, Шинэсний хярга, Өвлийн төөлүүрч зэрэг хортон шавж ихэвчлэн тархдаг байна.

Заган ойд хөнөөлт шавж, өвчнөөс гадна зарим төрлийн мэрэгч амьтад хөнөөл учруулж байдаг. Баянхонгор аймгийн заг бүхий газарт Морин чичүүл гэх мэрэгч амьтны тоо толгой сүүлийн жилүүдэд хурдацтай өсч заган ойд хөнөөл учруулах болсон байна.

Ойг хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээг дотор нь урьдчилан сэргийлэх ба тэмцлийн гэж хоёр хэлбэрээр гүйцэтгэнэ. Ойн хөнөөлт шавжийн хэт олшролт, хөнөөлийн байдал зэргийг цаг алдалгүй тооцоолж мэдэх улмаар цаашдын арга хэмжээг төлөвлөх, тэмцлийн ажлыг зохион байгуулахад судалгааны арга чухал ач холбогдолтой байдаг. Орон нутгийн байгаль орчныг хамгаалах газрын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар хөнөөлт шавж өвчин гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагад шуурхай мэдээлж ойд илэрсэн хөнөөлт шавж өвчнөөс хамгаалах, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоохын тулд хяналт шалгалтыг удирдамж, төлөвлөгөөний дагуу ой бүхий сумдын Засаг даргын Тамгын газраар батлуулан ажиллах шаардлагатай. Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хамтарсан эргүүл шалгалтыг жил бүрийн 3, 4, 5 ба 10,11-р саруудад хийнэ. Хууль бус мод бэлтгэгч нартай тэмцэхийн тулд аймгийн төврүү явах гол зам дээр эргүүл, шалтгалтыг гаргах хэрэгтэй.

4.2.2 Ойн аж ахуйн арга хэмжээ¹

Ойн аж ахуйн арга хэмжээ нь ойг нөхөн сэргээх, ойд арчилгаа, эрүүл ахуйн огтлолт хийж төлөв байдлыг сайжруулах болон зүй зохистой ашиглах зэрэг харилцан уялдаа холбоо бүхий цогц үйл ажиллагаа юм.

Ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээ

Ойн нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд мод, сөөгний үр бэлтгэх, тарьц суулгацыг арчлан ургуулах, ойг зориудаар тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний зорилтыг биелүүлэх ажлуудыг хамруулан гүйцэтгэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 9 дүгээр сарын 22-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах хамгийн үр ашигтай арга бол мод тарих явдал мөн гэдгийг онцолж, 2030 он хүртэл Монгол улс тэрбум мод тарих санаачлага гаргаж “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлсэн.



Зураг-49. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний урьдчилсан төлөвлөгөө

(Эх сурвалж: Ойн салбарын үндэсний чуулган 2021)

“Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөнийг: 2021-2024 он буюу бэлтгэл үе, 2024-2026 он буюу эрчимжүүлэх, 2027-2030 он буюу тогтвортой үргэлжлэх гэсэн гурван үе шаттай өрнүүлэх юм.

Тарьсан модыг ургуулах нь бас чухал учраас урт хугацаанд тогтвортой ургуулан авч явах, түүнээс ашиг хүртэх ногоон бизнесийн орчин бүрдүүлэх менежментийг боловсронгуй болгоход анхаарах, доройтсон болон цөлжилттэй нутгуудад мод тарих ажлыг эрчимжүүлэх, ашигтай бичил биетний био болон органик бордоо туршиж модны төрөл зүйл болон бүс нутгийн онцлогт тохирсон хувилбарыг гаргах, мод тарьсны дараа тарилтын техник, тарьсан модны зүйлийн онцлог, бордооны хувилбарууд нь хөрсний үржил шимийг нэмэгдүүлж буй эсэх, хөрсний органик нэгдлийн хуримтлалд био бордоо болон органик бордоо хэрхэн нөлөөлж байгаа зэргийг судалж ажиллахаар болсон.



Зураг-50. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний урьдчилсан төсөв
(Эх сурвалж: Ойн салбарын үндэсний чуулган 2021)

Нийт нутаг дэвсгэрийн 76,9 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн. Үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт эрчимжсэн газар нутгийн дөрвөн хувийг ойжуулж, нийт газар нутгийн 9 хувь нь ойтой болно. Мөн хүлэмжийн хийн ялгарлыг 600 мянган тонноор бууруулах урьдчилсан тооцоолол хийгээд байна. Энэхүү “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд аймаг, нийслэл нэгдэж, хамтын ажиллагааны гэрээнд байгуулсан ба Баянхонгор аймгийн Засаг дарга “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод ургуулахаар амлалт авсан.

Хүснэгт-57. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх төслийн санал

Төслийн нэр	Зорилго	Төсөв /сая.төг/
“Шинэсний үр бэлтгэх байнгын талбай байгуулах” төсөл	Ойг зориудаар нөхөн сэргээхэд шаардагдах орон нутгийн ойн сангаас бэлтгэсэн чанар болон дасан зохих чадвар сайтай үрээр хангах байнгын үрийн плантаци байгуулахад оршино.	20,0
“Тэрбум жимс” төсөл	Экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн ойг	150,0

	хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд төслийн зорилго оршино. Плантацийг монос, үхрийн нүд, өрөл, гүйлсээр байгуулна. Үүний тулд нөхөн тарилтыг хангаж байх 5 га мод үржүүлгийн газартай болох. МҮГ-т монос, үхрийн нүд, өрөл гүйлсийн суулгац бойжуулахаас гадна салхины хамгаалалт болгож цагаан бургас тарьж ургуулна.	
“Өвөлжөө, хаваржааны нөөлөг” төсөл	Экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн ойн талбайг нэмэгдүүлэх, уур амьсгалыг зөөлрүүлэх, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд зорилгоор хурдан ургадаг навчит мод улиас, бургас болон тухайн нутагт ургадаг хайлаас, харгана, тоорой зэргийг тарихад төслийн зорилго оршино	730,0
“Цагаан бургасны плантаци байгуулах” төсөл	Ойг зориудаар нөхөн сэргээхэд шаардагдах бургасны тарьц, суулгацыг орон нутгийн ойн санд бэлтгэх, ойн санг нэмэгдүүлэхэд шаардагдах тарьц, суулгацийн нөөц бий болгох бургасны плантаци байгуулахад оршино	20,0
“Ойн зурвас- агро аж ахуй” байгуулах төсөл	Төв суурин газар, тариалангийн талбай, булаг шандын эх, ойжуулсан талбайг хүчтэй салхинаас хамгаалах, газрын доройтлыг бууруулах, элсний нүүлт, хөдөлгөөнийг багасгах үндсэн зорилготой	12,0

Үүнээс гадна Шинэжинст суманд “Загийн үр”, Баацагаан суманд Мод үржүүлгийн газар, Бөөнцагаан, Баацагаан сумдад “Доройтсон заган ойг хашиж хамгаалах”, Баян-Өндөр суманд “Баянбүрд” төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Ойг нөхөн сэргээх арга хэмжээ нь түймэрт шатсан ой, мод бэлтгэсэн талбай, хүчтэй салхи бороо цасны улмаас сүйдсэн ой зэрэг гадны нөлөөнд орж хомсдол, доройтолд өртсөн болон ой тэлж ургах боломжтой газруудад ойг зориудаар тарьж ургуулах ажлыг гүйцэтгэнэ. Байгалийн сэргэн ургалт хангалттай байгаа ойд үйл ажиллагаа явуулахдаа өсвөр модыг хамгаалах нь чухал юм. Ойгоос үрлэгдэж сэргэн ургах боломжтой ойн зах болон тармаг модтой газарт үр унаж ургах нөхцөлийг бүрдүүлэн шан татах, ойг хатсан, унасан модноос цэвэрлэж орчныг сайжруулах арга хэмжээ явуулж байгалийн сэргэн ургалтыг дэмжинэ.

Улсын болон орон нутгийн төсвөөс шалтгаалан ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээг жилд бага талбайд хийхээс гадна ойжуулалтын ажил хийсний дараах арчилгаа, тордолт хийхгүй орхисноос ойжуулалтын ажлын чанар хангалтгүй байна. Ойжуулалтанд шилжүүлж байгаа тарьц суулгацыг мод үржүүлгийн газарт арчлан ургуулж байна.

Хүснэгт-58. **Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөний нийт зардал (ОТМТ, 2022) /2022-2026 он/**

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, хөрөнгө оруулалтын нийт хэмжээ:	1 208.5 сая.төг
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсөв – 302.2 сая.төг Орон нутгийн төсөв – 394.0 сая.төг Гадаадын зээл тусламж – 477.0 сая.төг Уул уурхайн хөрөнгө оруулалт – 35.3 сая.төг

Баянхонгор аймгийн ойн зохион байгуулалтын судалгааны дүнгээс үзэхэд ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийх шаардлагатай ойн түймэрт өртсөн, хатаж хуурайшиж хэт сийрэгжиж хээрших хандлагатай болж доройтол, хомсдолд орсон ойн талбай шилмүүст ой бүхий газар нутагт 3614 га, говийн бүсийн заг бүхий талбайд 274401 га тармаг заг, 128 га загжих талбай, 8 га хатсан заг бүхий талбай байна.

Хүснэгт-59. **Шилмүүст, навчит ойн арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжих сумд/га/**

Сум	Шинэсний үр түүх	Арчилгааны огтлолт-Гэрэлжүүлэх	Арчилгааны огтлолт-Сийрэгжүүлэх	Арчилгааны огтлолт-Завсрын	Байгалийн сэргэн ургалтанд туслах	Гэрэлжүүлэх, хатсан, унасан мод цэвэрлэх
Баян-Овоо	98.69					
Галуут	1488.48					
Жаргалант	187.90					
Өлзийт	114.67					
Эрдэнэцогт	5688.87	26.27	167.9	377.39	38.22	301.18
Бүгд	7578.60	26.27	167.9	377.39	38.22	301.18

Судалгаанаас харахад байгалийн заган ойгоос гадны нөлөөнд өртөн сийрэгжиж тармаг ойн талбай руу шилжихээс гадна хомсдолд орж ойн сангийн талбайгаас хасагдах хандлагатай байна. Судлаачдын тодорхойлсноор заган ойн сангийн өөрчлөлтийн тооцоогоор жилд дундажаар 15,8 мян.га талбай “Ой” хэмээх дүр төрхөө алдаж хэт сийрэгжиж байна. (Хауланбек А., 2015).

Баянхонгор аймагт загийг түлшинд хэрэглэх, уул уурхайн ашиглалтад өртөх, малын хашаа хороо барих зэргээр ахуйн хэрэглээ ихтэй, малын бэлчээрлэлтэд болон техникийн олон салаа замд өртөх зэргээр хүний хүчин зүйлийн нөлөө их байна. Мөн хур чийгийн дутагдалтай байдал, хуурайшилт, ган зуд зэрэг байгалийн хүчин зүйл заган ойн хомсдол, доройтолд нөлөөлж байна.

Мод бэлтгэсэн талбайг ойжуулах - Мод бэлтгэсэн талбайг ойжуулахгүй удах бүр хөрс нь хуурайсан өвслөг ургамал шигүү ургах, сийрэгжих эсвэл хус, улиангараар байгалийн сэргэн ургалт явагдах тул ойжуулах ажлын бүтээмж буурдаг. Иймд огтолсон талбайг ойжуулах ажлыг мод бэлтгэсний дараа 2 жилийн дотор багтааж тарьцаар ойжуулах нь илүү үр дүнтэй байдаг.


Ойжуулалтад хэрэглэх тарьц нь мод үржүүлгийн газрын ил хөрсөнд ургуулсан шинэсний 3 настай, хүлэмжинд ургуулсан шинэсний 2 настай, үндэсний хүзүүний бүдүүн нь 2,0 мм-ээс дээш, үндэсний урт нь 15 см, ишний өндөр 18 см-ээс дээш өндөртэй, өсөлт хөгжилт сайтай, ямар нэгэн механик гэмтэлгүй байна.

Тарьцыг ойжуулах талбайд зөөвөрлөх, суулгах ажлын үед үндэсний системийг гэмтээхгүй хатаахгүй байхад онцгой анхаарах хэрэгтэй. Гараар тарих бүрд ажилчин бүр хувин, нийлэг хальсан уутанд тарьцыг 50-100 ширхэгээр багцлан хийж үндэсний системийг шавар зуурмаг, нойтон шороонд далдалсан байх шаардлагатай. Тарихдаа тарьцын үндсийг хөрсөнд нугалахгүй, бөөгнөрүүлэхгүйгээр тараан хийх ба үндэсний хүзүүвчийг газрын гадаргын түвшингээс 1,5-2,0 см дор оруулж хөрсийг зай завсаргүй нягт булсан байвал зохино.

Ойжуулалтад тарих шинэсний тарьцын нягтшил тухайн газар нутгийн байдлаас шалтгаалж харилцан адилгүй байх ба тус нутагт доод тал нь 4300 ширхэг байвал зохино. Мод бэлтгэсэн талбайд ойжуулалт хийхдээ 0,5:0,5 м орчим хэмжээтэй жижиг талбайн хөрсийг 8-10 см зузаантай хүрээр эргүүлэн тарилт хийнэ. Энэ жижиг талбай нь 1 га-д 2500-3000 байхаар тооцоолно.

Хүснэгт-60. **Заган ойн арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжих сумд /га/**

Сум	Хатсан загийг цэвэрлэх	Байгалийн сэргэн ургалтанд туслах	Загийн үр түүх
Баян-Өндөр сум	28636.14	55234.51	15322.17
Богд сум	986.36	36.86	412.60
Жинст сум		84.79	32.94
Шинэжинст сум	6729.66		
Бүгд	36352.17	55356.16	15767.71



Зураг-51. Заган ой бүхий газрын төлөвлөлт

Шатсан талбайг ойжуулах - Түймэрт шатсан ой нь байгалийн аясаар сэргэн ургах нөхцөл бага ба навчит үүлдрийн модоор сэргэн ургахдаа амархан байдаг. Иймээс шатсан талбайг зориудын аргаар, үндсэн төрлийн модоор ойжуулах шаардлагатай байдаг. Шатсан талбайг үрээр ба тарьц суулгацаар нөхөн сэргээх гэсэн 2 арга байна.

Шатсан талбайг үрээр ойжуулах арга - Ойжуулалтад хамгийн сайн чанартай, тухайн орон нутгаас түүсэн үрийг хэрэглэх нь илүү үр дүнтэй. Талбайд үрийг эгнээгээр, зурваслан, мөрлөсөн хонхорт, био бүлэглэл үүсгэж, нэлэнхүйд нь цацах зэрэг аргаар тарина. Эдгээр аргаас тус нутагт шатсан ойг эхний 1-2 жилийн дотор үрийг нэлэнхүйд нь цацаж тарих арга илүү үр дүнтэй. Учир нь түймэрт шатсаны дараа 2 жилийн хугацаанд өвсөн бүрхүүл тэнд тарьсан модны үрийн ургалтанд төдийлөн саад болдоггүй. Үрийг талбайд цацахдаа бороо угтуулан таривал илүү үр дүнтэй байна. Тус нутагт 1 га-д ойролцоогоор 2,0-3,0 кг үр шаардлагатай.

Шатсан ой нь 2 ба түүнээс дээш жил болсон тохиолдолд өвсөн бүрхүүл их хэмжээгээр ургаж ойн орчин нөхцөл нь өөрчлөгддөг учраас заавал хөрсийг эргүүлж, боловсруулсны дараа үрийг эгнээгээр, зурваслан, мөрлөсөн хонхорт тарих зэрэг аргаас хэрэглэнэ.

Шатсан талбайг тарьц, суулгацаар ойжуулах арга - Шатсан талбайн тарьц суулгацаар ойжуулахын өмнө шатсан мод, унангийг зайлуулж цэвэрлэнэ. Цэвэрлээгүй тохиолдолд ойжуулах талбайн хэмжээ багасаж талбайд байрлуулах шаардлагатай тарьцын тоо хэмжээнд хүрэхгүй байх талтай.

Хөрс боловсруулах ажлыг хавар тариалалтын өмнө хийх ба шинэсний тарьц суулгах хугацаа 5-р сарын 10-наас 25-ны хооронд байна. Зурваслан сийрүүлсэн талбайд нэг эгнээгээр тарьц хоорондын зайг 70 см-ээс хэтрүүлэхгүйгээр суулгах бөгөөд гараар бэлтгэсэн нэг жижиг талбайд 3-5 ширхэг тарьц суулгана.

Шан гаргахдаа хэсэгчилсэн жижиг талбай байдлаар 0,7-0,8 м өргөн, 1,0-1,5 мурт хэмжээтэй жижиг талбайн хөрсний 8-10 см гүн үеийг шангийн хоёр хажууд эргүүлэн тавина. Жижиг талбайнуудыг ойжуулах талбайдаа жигд байрлалтайгаар, 1 га-д 1500-2000 ширхэг байхаар тооцоолон бэлтгэнэ.

Заг түүж бэлтгэсэн болон бусад шалтгаанаар заггүй болсон талбайд зориудаар ойжуулахдаа ил талбайд болон бортогонд ургуулсан тарьцаар загийг тарьж ургуулна. Ил үндэстэй тарьцаар ойжуулахад хавар чийгийн хангамж бага тул амьдралтын хувь бага байдаг. Манхан элсний гадаргууг нэлэнхүйд нь ойжуулахад тарьцыг ургамал хооронд 1 метр, эгнээ хооронд 3 метр зайтай эсвэл ургамал хооронд 1,4 метр, эгнээ хооронд 2 метр байхаар байрлуулах нь илүү тохиромжтой. Заган ойн ургах орчны нөхцлөөс шалтгаалан 1 га талбайд суулгах тарьцын тоо өөр өөр байна. Заган ойн хэв шинжээс шалтгаалана. Элсний заг бүхий талбайд 2,0x1,0 схемээр 3300 ш, Шал тойрмын заг бүхий талбайд 2,5 x 1,0 схемээр 4200 ш, Сайр садаргын загтай газарт 2,0 x 1,0 схемээр 5000 ш, Чулуут цөлийн заг бүхий талбайд 1,3x 0,9 схемээр 6000 ш –ийг тарьж ургуулах нь тохиромжтой.

Хүснэгт-61. **Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө /2022-2026/**

Арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэрэгжүүлэх он					Бүгд
		2022	2023	2024	2025	2026	
Ойг нөхөн сэргээх арга хэмжээ	Талбай,га	50	80	100	100	120	450
	төсөв, сая.төг	405000	648000	810000	810000	972000	3645000
Өсвөр мод хамгаалах	га	25	30	30	30	35	150
	мян.төг	18500,0	22200,0	22200,0	22200,0	26640,0	111000,0
Үрээр тарих	га	3	4	4	5	5	21
	мян.төг	1890,0	2520,0	2520,0	3150,0	3150,0	13230,0

Байгалийн сэргэн ургалтанд туслах - Байгалийн сэргэн ургалтад туслах гэдэгт ойгоос үр унаж ургах боломжтой газрыг сонгож хөрсийг боловсруулах, мод бэлтгэсэн, шатсан талбайд байгалийн аясаар сэргэн ургасан өсвөр модыг мал амьтан зэрэг гадны нөлөөнөөс хамгаалах, хаших зэрэг арга ажиллагаа орно. Үндсэн төрлийн шилмүүст моддын их үрийн жилүүдийг угтуулан тооцож хөрс боловсруулалтыг хийнэ.

Ой зохион байгуулалтын материалаас үзэхэд өтгөрөл багатай тармаг ой болон ойн захын талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийх шаардлагатай байна.

Үр боргоцой бэлтгэх - Баянхонгор аймагт зонхилон тархсан шинэс болон загийн үр түүж үрийн сан бүрдүүлнэ. Их үрийн жилд шинэсний болон загийн үр бэлтгэж өөрийн хэрэгцээнд ашиглахаас гадна зах зээлд борлуулж орлого олох боломжтой. Загийн үрийг 10-р сарын 15-наас 11 сарын эхний хагаст багтаан түүнэ.

Тарьц суулгац ургуулах - Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтэд шаардлагатай тарьц суулгацыг мод үржүүлгийн газарт ургуулж тарьц суулгацын байнгын нөөцтэй болох шаардлагатай. Тарьц суулгац ургуулах, хөрс боловсруулах агротехник, арга зүйн мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг үе шаттай зохион байгуулна. Загийн тарьцыг ургуулахад хөнгөн сийрэг бүтэцтэй элсэнцэр хөрс тохиромжтой. Элсэрхэг хөрсийг бэхжүүлэх, элсний нүүлтийг тогтворжуулах, бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, хөрсний элэгдэл, эвдрэлтэй тэмцэх, заган ойн нөөцийг арвижуулах зорилгоор тарьж ургуулах тарьцыг тусгайлан боловсруулсан хөрс бүхий мод үржүүлгийн газарт ургуулдаг. МҮГ-ын ил талбайд загийн үрийг 1,5-1,6 шоо дөрвөлжин см тутамд ургах чадвартай нэг үр байхаар 10 см өргөн 1 метр урт мөрөнд 600-650 ширхэг үр орохоор тооцож тарих нь илүү тохиромжтой. Элсэнцэр хөрсөнд загийн үрийг 0,5-1,0 см гүнд тарина.

Баянбүрд, түүний төлөв байдал:

Говь цөлийн бүсэд хөрсний ус нэвчин булаг, шанд ундарсан, өвс ургамал жигдэрсэн мод, сөөг, өвслөг ургамал хослон ургасан газрыг “Баянбүрд” гэх ба энд ховор, нэн ховор, эмийн ургамал тархан ургасан байдаг.

Баянбүрдийг тодорхойлогч гол модлог ургамал нь тоорой, сухай, жигд, хармаг зэрэг бутлаг ургамал ургана. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас баянбүрдийн тэлж ургах нөхцөл хумигдаж талбай багасаж байна. Мөн хортон шавжид нэрвэгдэж ургах чадвараа алдаж байгаа баян бүрдийн ургамлын гарц 40-60% буурсан зүй тогтол ажиглагдаж байгааг тогтоосон байна.

Тооройн төглийн мод, бут сөөг хатаж хуурайшин ургах чадвараа алдсан байгаагаас гадна ард иргэд тооройг огтолж ахуйн хэрэгцээний сав суулга, нүдүүр, эмээлийн бүүрэг хийх, малын хашаа хороо барихад ашиглаж байгаа нь ховор ургамлыг хомсдолд оруулахад ихээхэн нөлөөлж байна. Энд говь, цөлийн бүсийн ан амьтан орогнодог гол цэг байхаас гадна малчид, нутгийн иргэд баянбүрд, бүрдүүдийг түшиглэн он удаан жил мал аж ахуйгаа эрхэлсээр ирсэн.

Баянбүрд нь эзлэх талбайн хэмжээгээрээ говь цөлийн бүс нутгийн дөнгөж 0,5-1,0 хувийг эзлэх боловч экосистемд үзүүлж байгаа үүрэг ач холбогдол нь маш их юм. Баянбүрдийг дагаж ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн ихсэж, ховор ан амьтны идээшлэн ундаалж орогнодог газар болж байдгаараа онцлогтой экосистемийн өвөрмөц бүрэлдэхүүн хэсэг мөн.

Баянбүрдүүд говь, цөлийн ургамлын бараг 70-аад хувийг агуулдаг нь нэн ховор ургамлын тархац нутаг болж байна. Баянбүрдүүдийг бүрдүүлэгч голлох модлог ургамлын нэг нь Монгол улсын “Улаан ном”-нд бүртгэгдсэн ховор ургамлын жагсаалтанд хамрагдах Тоорой мод юм.

Говьд задгай булаг шанд ховор тул баянбүрдүүд нь голдуу гүний устай шүтэлцэн оршдог байна. Зарим хэсэгт хөрсний ус нэвчин булаг, шанд ундрман манхан элсний хооронд маш бага талбайд нуга, намаг үүсгэн ногоон толбо үүсгэнэ.

Говь, цөлийн баянбүрдүүд байгалийн төрхтэй бөгөөд урт хугацааны хуурайших үйл явцыг тэсвэрлэн үлдэн хоцорсон байна. Баянбүрд нь олон зүйл ургамалтай, төв хэсгээс гадагш цагираг маягаар ургамлын аймаг солигддог. Нэгэнт усны нөөцтэй учир ургамлан нөмрөг нилээд өөр болж ургалт нь түргэсдэг байна.

Баянбүрд амьтны аймгаар баялаг байдаг тул жигүүртэн шувуу, махчин, туруутан, мэргэчид, мөлхөгчдийн баян бүрдэл тогтсон байна. Баянбүрд нь говь цөлийн бүс нутгийн хүмүүсийн амьдрах таатай орчин болохын зэрэгцээ мал аж ахуй эрхэлдэг малчдын малаа адгуулдаг бүс нутаг байсаар ирсэн билээ.

“Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөр”, “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичигт байгалийн баянбүрдийг хамгаалах, сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зэрэг бодлого хэрэгжүүлсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна.

Заган ойн тогтвортой менежментийн дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд баянбүрдүүдэд нарийвчилсан судалгаа мониторинг хийж доройтсон баянбүрдийг нөхөн сэргээх, тэлж ургуулахаар төлөвлөсөн болно.

Ойн эрүүл ахуйн болон арчилгааны огтлолын, арга хэмжээ

Ойн төлөв байдлыг сайжруулах арга хэмжээнд модны өсөлт хөгжилтийг сайжруулж бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийдэг. Ойн аж ахуйн арга хэмжээний нэг чухал хэсэг нь ойн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээ юм. Ойн сайн чанартай модонд өсөлт, хөгжилтийн тохиромжтой нөхцөл бүрдүүлэх зорилгоор моддын титэм нийлэх үеэс эхлэн үндсэн ашиглалтын огтлолт хүртэлх хугацаанд залуу болон дунд насны ойд арчилгааны огтлолтыг явуулдаг.

Баянхонгор аймагт шилмүүст ойд 585 га талбайд арчилгаа явуулах шаардлагатай залуу болон дунд насны ой байна. Жилд дундажаар 50-60 га талбайд арчилгааны огтлолтыг тогтмол хийж байх шаардлагатай байна.

Баянхонгор аймагт одоогийн байдлаар арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг явуулах мэргэжлийн байгууллагын хүрэлцээ, техникийн хүчин чадлын боломжоос шалтгаалан хангалттай хэмжээнд явагдахгүй байна. Ойд арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хангалттай сайн явуулахгүй байх нь ойн ургах орчны нөхцөл доройтох, хатсан унасан модны нөөц ихсэж түймэр, ойн хөнөөлт шавж тархах нөхцөл үүсдэг.

Ойн арчилгаа - сайн чанарын хэрэгцээний мод бүхий цэвэр бүрэлдэхүүнтэй насны зөв бүтэц бүхий ойг бий болгох, моддын өсөлтийг түргэсгэх, ойд ашиглалт явуулах хугацааг наашлуулах, ойн ариун цэвэр эрүүл ахуйн болон хөрс ус хамгаалах ач холбогдлыг дээшлүүлэх, түймэр хортны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойн бүтээмжит чанарыг дээшлүүлэх зорилгоор явуулдаг ойн аж ахуйн хамгийн чухал арга хэмжээ юм. Арчилгааны огтлолт нь ойн онцлог, явуулж байгаа зорилгоосоо хамаараад дөрвөн төрөлд хуваагддаг.

Хүснэгт-62. Арчилгааны огтлолтын хэлбэр, хийх хугацаа

Д.д	Арчилгааны огтлолтын хэлбэр	Огтлолт хийх нас /жилээр /	
		шилмүүст мод	навчит мод
1	Гэрэлжүүлэх	20 хүртэл	10 хүртэл
2	Тохируулах	20-40	11-20
3	Сийрүүлэх	40-50	21-40
4	Завсрын	60-с дээш	41-ээс дээш

Гэрэлжүүлэх огтлолт – Холимог ойд моддын зохистой бүрэлдэхүүнийг тогтоох, дан ширэнгэн ойд гэрлийн хэмжээг нэмэгдүүлж, моддын өсөлтийг түргэсгэх гол зорилготой хийгдэнэ. Гол төрлийн модны өсөлт хөгжилтөнд саад болж байгаа навчит модыг голчлон огтолно.

Тохируулах огтлолт – Гол төрлийн модны байрлалыг тохируулах, өсөлтийн нөхцөлийг сайжруулах үндсэн зорилготой хийгдэх бөгөөд ойн бүрэлдэхүүнд орж байгаа модны төрлийн тоон харьцааг зохицуулна. Тохируулах огтлолтоор гол төрлийн модны өсөлтөнд саад болж байгаа навчит мод төдийгүй өсөлтөөр муу болон шигүү ургасан бүлэг модны доторхи бусаддаа саад болж байгаа гол төрлийн зарим модыг огтолно.

Сийрүүлэх огтлолт – Титэм, ишний хэлбэр сайтай модыг сонгон үлдээж, өсөлт сайн модны титэм, иш зөв хэлбэрших, өсөлт нэмэгдэх тохиромжтой нөхцлийг бүрэлдүүлэх зорилгоор хийгдэнэ. Модны ишний үндсэн хэлбэр дүрс нь өсөлт эрчимтэй явагдаж байгаа үед голчлон бүрэлдэх учраас ойн модны ялгарал, өндрийн өсөлт явагдаж байгаа насанд огтлолтыг явуулна. Энэ огтлолтоор хэлбэр муутай, согогтой модыг голчлон огтолно.

Завсрын огтлолт - Титэм, ишний хэлбэр сайтай модны цаг үеийн өсөлтийг эрчимжүүлж модны техникийн болцын насыг богиносгох зорилгоор хийгдэнэ. Үндсэн ашиглалтын огтлолт хийх наснаас шилмүүст ойд 10 жилийн өмнө, навчит ойд 5 жилийн өмнө завсрын огтлолтыг хийж дууссан байна.

Ойн цэвэрлэгээ - Хөнөөлт шавж, өвчин, түймэрт нэрвэгдсэн, салхи шуурга, усны үер, цасны нөлөөгөөр хугарч гэмтсэн, цаашид ургах чадваргүй болсон модыг огтолж зайлуулах арга хэмжээг ойн цэвэрлэгээ гэнэ.

Цэвэрлэгээний огтлолт нь хатсан хуурай, хөнөөлт шавжид нэрвэгдсэн, хугарсан, унасан модыг огтлон зайлуулж ой модыг эрүүлжүүлэх, өвчин хөнөөлт шавж үүсэх, түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зорилготой.

Цэвэрлэгээний огтлолтыг хийхдээ түүвэрлэх огтлолтын аргаар хийх ба эхний удаа түймэрт хүчтэй шатаж хатсан, салхи, цасанд хугарсан, унасан, мөөгөн өвчин, хөнөөлт шавжид хүчтэй нэрвэгдсэн модыг бэлтгэж ашиглах ойн орчинг эрүүлжүүлнэ.

Ой мод нь хатаж амьдрах чадвараа алдсан ч гэсэн ус зохицуулах, тогтоон барих, хөрс хамгаалах, салхины хүчийг бууруулах, нарны халалтаас хамгаалах зэрэг экологит гүйцэтгэх үүргээ хэвээр хадгалж байдаг учир хатсан модыг нэг дор хавтгайруулан огтлож болохгүй. Түүвэрлэх маягаар давталттайгаар ээлж дараатайгаар огтолно. Хэрэв нилэнхүйд нь огтолбол ойн орчин өөрчлөгдөж тэнд ой дахин ургах боломжгүй болно.

Цэвэрлэгээний огтлолт явуулах 63,0 мянган га талбайд 110,3 мян.м³ хатсан, унасан модны нөөцтэй гэж ой зохион байгуулалтын мэдээнд тусгагдсан тул ойд цэвэрлэгээ хийж хатсан хуурай, унанги модыг ашиглан иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын ахуйн болон түлээний модны хэрэгцээг хангах бүрэн боломжтой тул жилд дундажаар 370 орчим га талбайгаас 12,0-12,8 мян.м³ хатсан, унасан мод бэлтгэхээр тооцоолов.

Хүснэгт-63. Арчилгааны огтлолтын төлөвлөгөө

Огтлолтын хэлбэр	Талбай, га гарах нөөц, м ³	Хэрэгжүүлэх он					Нийт талбай, нөөц
		2022	2023	2024	2025	2026	
Гэрэлжүүлэх	га	1	1	1	1	1	5
	м ³	15	15	15	15	15	75
Тохируулах	га	3	3	3	3	3	15
	м ³	40	40	40	40	40	200
Завсрын	га	18	20	20	20	20	98
	м ³	450	500	500	500	500	2450
	хэрэгцээ	380	400	400	400	400	1980
	түлээ	70	100	100	100	100	470
Аймгийн хэмжээгээр	га	22	24	24	24	24	118
	м ³	505	555	555	555	555	2725

Эрүүл ахуйн огтлолтын төлөвлөгөөг хэрэгжүүлснээр сумын ИТХ-аар энэ ажилд шаардагдах зардлыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусгадаг болно. Эрүүл ахуйн огтлолтыг технологийн дагуу хийдэг болно. Модон материалын тодорхой хэсгийг хангадаг болно. Ойн орчин эрүүлжиж цэвэрлэгдэнэ.

Хүснэгт-64. Ойн эрүүл ахуйн огтлолтын төлөвлөгөө

Талбай, га гарах нөөц, м ³		Хэрэгжүүлэх он					Нийт талбай, нөөц
		2022	2023	2024	2025	2026	
Хатсан модыг цэвэрлэх	га	275	280	280	280	280	1,395
	м ³	9600	9760	9760	9760	9760	48,640
Унанги модыг цэвэрлэх	га	210	220	220	220	220	1090
	м ³	7100	7250	7250	7250	7250	36,100
Аймгийн хэмжээнд	га	485	500	500	500	500	2485
	м ³	16700	17010	17,010	17010	17010	84740

Ойн ашиглалтын арга хэмжээ

Ойн ашиглалтад үндсэн ашиглалтын огтлолтоор болцын насанд хүрсэн модыг түүвэрлэх огтлолтын аргаар авч ашиглах арга хэмжээ багтана. Ойн ашиглалт, мод, модон материалын үйлдвэрлэлээс аймгийн эдийн засагт оруулах хувь нэмэр маш бага байна.

Баянхонгор аймгийн ойн сан нь бүхэлдээ Хамгаалалтын бүсийн ой тул үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэж ашиглах боломжгүй. Харин арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоос гарсан мод, модон материалыг үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээнд ашиглах, айл өрхийн түлшний хэрэгцээг бага хэмжээгээр хангах боломжтой.

Статистик мэдээнээс харахад (статистикийн мэдээний 1212.mn) Баянхонгор аймагт 2000-2001 онд хамгийн их хэмжээгээр 27-89,9 мян.м³, 2007 онд 9,5 мян.м³, 2008 онд 8,0 мян.м³ хүртэл мод бэлтгэж байсан байна.

2004-2006 онуудад жилд 0,32-0,50 мян.м³, 2009-2011 онд мод бэлтгэлийн хэмжээ эрс багасаж 0,1 мян.м³ хүртэл бэлтгэж байсан бол 2012 оноос эхлэн мод бэлтгэлийг бүрэн зогсоосон байна.

Хүснэгт-65. Бэлтгэх модны хэмжээ

Огтлолтын төрөл	Огтлох талбай, нөөц	Хэрэгжүүлэх он					Нийт хэмжээ
		2022	2023	2024	2025	2026	
Арчилгааны огтлолт	га	22	24	24	24	24	118
	м ³	505	555	555	555	555	2725
Эрүүл ахуйн огтлолт	га	485	500	500	500	500	2485
	м ³	4850	5000	5000	5000	5000	24850
Нийт дүн	га	672	689	689	689	689	2603
	м ³	5355	5555	5555	5555	5555	27575

4.2.3 Ойн сангийн газрыг ашиглуулах төлөвлөгөө¹

Ойн сангийн тодорхой хэсгийг ашиглагч нь төлөвлөгөөний дагуу ойг хамгаалах, мод, дагалт баялгийг ашиглах, ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолоор “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам” батлагдсан.

Ойн тухай хуульд заасны дагуу сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээний дагуу эзэмшүүлнэ. Харин ойн сангийн газар нь төрийн мэдэлд байх ард түмний өмч бөгөөд хэн нэгэн хүн, хуулийн этгээд эзэмших, өмчилөх хориотой. Баянхонгор аймгийн ойн сан бүхий газарт гүзээлзгэнэ, хармаг, цагаан гоёо зэрэг байгалийн зэрлэг жимс, жимсгэнэ багахан хэмжээгээр ургахаас гадна чихэр өвс зэрэг нэн ховор эмийн ургамлын гэх мэт нөөцтэй байна. Эрдэмтдийн 2005 онд Баянзаг орчимд хийсэн судалгаанаас үзэхэд гоёоны дундаж нягтаршил 1 га талбай 25 ширхэг байгааг тодорхойлсон ба элсэрхэг газар Улаан гоёо ихэнхдээ 12 ширхэг тоологддог бол Цагаан гоёо зөвхөн 1-3 ширхэг олдоно (Хауланбек ба бусад 2018, Баацагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумын ОТМТ 2021-2024).

Хүснэгт-66. Иргэдийн нөхөрлөлийн ашиглалтанд буй ойн судалгаа

д/д	Нөхөрлөлийн нэр	ИТХ-н шийдвэр он, сар	Эзэмшиж байгаа ойн сангийн талбайн хэмжээ	Гэрчилгээтэй эсэх	Гишүүдийн тоо	Насны ангилал		
					Нийт	16-40	40-45 нас	50-аас дээш
Эрдэнэцогт сум								
1	Баяндаваа	2009.01.01	6000	+	11	8	2	1
2	Гурван өгөөж	2007.11.21	272	+	45	21	15	9
3	Жаргалант	2008.05.06	327	+	38	16	14	8
4	Дэлгэр хангай	2008.05.06	400	+	44	11	22	13
5	Цагаан Овоо	2008.05.06	100	+	46	18	16	8
6	Олон ямаат	2008.05.06	327	+	42	21	16	9
7	Их-Овоо	2008.05.06	327	+	46	23	14	6
8	Дөш хайрхан	2008.05.06	350	+	43	6	8	5
Өлзийт сум								
9	Үзэсгэлэнт хангай	2007.05.12	6000		19	6	8	5
Баянлиг								
10	Зүүн хоолой	2006	2300		8	10		6
11	Говийн ундарга	2006	1020		32	18	28	2
12	Есөн эрдэнэ	2006	850		18	15	2	1
	Дүн		18273		392	173	145	73

Эх сурвалж: Сум дундын ойн ангийн нөхөрлөлийн судалгаа 2021

ТАВ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

5.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт


Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь нэн ховор болон ховордсон ан амьтныг хамгаалах, байгалийн өвөрмөц, унаган тогтцыг хамгаалан, хадгалж хойч үедээ өвлүүлэн үлдээхэд ихээхэн үүрэг гүйцэтгэх төдийгүй томоор харвал дэлхийн нийтийн хэмжээнд байгаль орчны доройтлыг хязгаарлан зогсоож, байгалийн жам ёсны шүтэлцээт харьцааны нөхцөлийг хангах сонгодог нэг хэлбэр болохын хамт хүн төрөлхтний байгаль, түүх соёл, шинжлэх ухааны давтагдашгүй их өвийг үе дамжуулан үлдээх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангаж улмаар улс орнууд байгаль орчиндоо зохицон, тогтвортой хөгжих үзэл санааг баталгаажуулах үндсэн нөхцөл болно.

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 8 газрыг улсын тусгай хамгаалалтанд авсан байна. Эдгээр улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь нийт 2652344 га газар нутгийг эзэлж байна (Хүснэгт 67).

Хүснэгт-67. Улсын тусгай хамгаалалттай газар

№	Тусгай хамгаалалттай газар	Ангилал	Хамгаалалтан -д авсан он	Талбай, га
1	Говийн их /А/	Дархан цаазат газар	1975, 1995	1411776
2	Хангайн нуруу	Байгалийн цогцолборт газар	1996	295082
3	Хангайн нурууны өргөтгөл	Байгалийн цогцолборт газар	2020	35449
4	Их Богд уул	Байгалийн цогцолборт газар	2008	262110
5	Заг Байдрагийн голын эхэн сав	Байгалийн цогцолборт газар	2012	114133
6	Говь гурван сайхан	Байгалийн цогцолборт газар	1993, 2000	520385
7	Хүрэн бэлчир	Дурсгалт газар	2010	11788
8	Хайрхан-Уул	Дурсгалт газар	2020	1621
Бүгд				2652344

Дээрх улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалаар авч үзвэл дархан цаазат газар 1, байгалийн цогцолборт газар 6, дурсгалт газар 2 гэсэн ангилалд тус тус хамрагдаж байна (Зураг-53, Хүснэгт-67).



Зураг-53. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Монгол орны экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдолтой газар нутгийг хамарсан тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн, тэдгээрийн хамгаалалтын менежментийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх үүднээс нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг улсын тусгай хамгаалалтад авах Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон Улсын тусгай хэрэгцээний газрыг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон орон нутгийн саналыг үндэслэн доорх газруудыг улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт-68. Төлөвлөлөөр улсын тусгай хамгаалалтанд авах санал /Полигон/

№	Орон нутгийн тусгай хэрэгцээний газар	Ангилал	Түвшин	Санал	Талбай, га	
1	Номингийн говь-Ногоон цавын хоолой	Дархан цаазат газар	Улс	УГЗБЕТ-нд тусгагдсан	315436	
2	Хангай нурууны өртгөтгөл (Хөл, Сая)	Байгалийн цогцолборт газар	Улс	БЦ-Орог нуур сав газар	45589	
3	Үнхэлцэг уул	Байгалийн нөөц газар	Улс	УГЗБЕТ-нд тусгагдсан	27331	
4	Олгой нуур-Товцог хайрхан	Байгалийн нөөц газар	Улс		53388	
5	Бөөн цагаан нуур	Байгалийн нөөц газар	Улс		140983	
6	Их аргалант уул	Байгалийн нөөц газар	Улс		51328	
7	Шаргалжуут	Байгалийн нөөц газар	Улс		357799	
8	Эдрэнгийн нуруу	Байгалийн нөөц газар	Улс		128422	
9	Их богд өргөтгөл-Орог нуур	Байгалийн нөөц газар	Улс		186774	
10	Зүүн хоолой	Байгалийн нөөц газар	Улс		188019	
11	Баян булгийн тал	Байгалийн нөөц газар	Улс		34176	
12	Улаан чулуут уул	Байгалийн нөөц газар	Улс		18703	
13	Гичгэний нуруу- Бурхан буудай өргөтгөл	Байгалийн нөөц газар	Улс		46158	
14	Гурван эрхэтийн нуруу	Байгалийн нөөц газар	Улс		СЗДТГ	45589
15	Цахир уул	Дурсгалт газар	Улс		УГЗБЕТ-нд тусгагдсан	30571
16	Галуут хавцал	Дурсгалт газар	Улс	404		
17	Уран хайрхан уул	Дурсгалт газар	Улс	СЗДТГ	4589	
18	Цагаан дэл	Дурсгалт газар	Улс		46	
Бүгд					1675305	

Дээрх хүснэгтээс харахад төлөвлөлтийн хугацаанд улсын тусгай хамгаалалтанд 18 газрыг авахаар төлөвлөж өгсөн. Эдгээр улсын тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөсөн газар нутаг нь нийт 1675305 га талбайг эзэлж байна.


Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд улсын тусгай хамгаалалтанд Ямаат нэртэй газрыг аймаг дундын отрын бэлчээр гэсэн ангилалаар авахаар

төлөвлөгдсөн газар нь Хангайн нурууны байгалийн цогцолборт газартай давхацсан учир газар зөрчил, давхацалтай байсан учир улсын тусгай хамгаалалтанд газрын жагсаалтанд тусгагдаагүй болно.

Хээрийн судалгаагаар түүх соёлын болон байгалийн дурсгалт газруудыг улсын тусгай хэрэгцээнд авах саналуудыг өгсөн. Эдгээр газруудыг улсын тусгай хамгаалалтанд авахын тулд түүх соёлын болон байгалийн дурсгалт газруудыг ач холбогдол, зэрэглэл, үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнг харгалзан жагсаалтаар болон хил заагийг нарийвчлан тогтоох тогтоох шаардлагатай (Хүснэгт-69).

Хүснэгт-69. Улсын тусгай хэрэгцээнд шинээр авах газар нутаг (цэгэн)

№	Нэр	Ангилал	Түвшин	Тайлбар
1	Булган хайрхан	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
2	Уран хайрхан уул	Байгалийн дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
3	Гурван мандал	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
4	Бумбатын амны бага хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
5	Цагаан агуй	Байгалийн дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
6	Морины туурайн тамгатай чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
7	Шатар чулуу булш	Байгалийн дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
8	Бичигт хад	Байгалийн дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
9	Алмаст хавцал	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
10	Чихэн агуй	Байгалийн дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
11	Булш 3	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
12	Бор балгас	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
13	Хачин ламын хийд	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
14	Тамчийн их цагаан ам буган чулуун хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
15	Хиргистэйн амны буга хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
16	Ногоон цав	Байгалийн үзэсгэлэнт газар	Улс	УТХ шинээр авах
17	Дуурсахын хөндийн дурсгал	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
18	Латааны суваргын үлдэгдэл	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
19	Замын хашаатын хадны дурсгал	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах
20	Зоог зуухын хөндий	Түүх соёлын дурсгалт газар	Улс	УТХ шинээр авах



Зураг-54. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт

5.2 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар гэдэг нь “Тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад авсан газрыг хэлнэ.” гэж газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай журамд заасан байдаг.

5.2.1 Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт

Тус аймаг нь 2022 оны байдлаар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан ашигт малтмал газрын тосны газрын кадастрын албаны мэдээллийн санд аймгийн тусгай хамгаалалттай 21 газар бүртгэлтэй байна (Хүснэгт-70).

Хүснэгт-70. Аймгийн тусгай хамгаалалттай газар /тогтоолоор/

№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га
1	Баян улаан уул	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	33833.6
2	Давст цагаан нуур	Байгалийн үзэсгэлэнт газар	Аймаг	14971.2
3	Бор овоо нуур	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	9416.0
4	Тайн нурууны гэрэлт хөшөө	Дурсгалт газар	Аймаг	349.8
5	Овоон цагаан	Бичил уурхайд зориулсан талбай	Аймаг	8.4
6	Хөх хайрханы ам	Бичил уурхайд зориулсан талбай	Аймаг	69.6
7		Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	1007.9
8	Байдрагийн голын ай сав	Усны эх газрын нөөц газар	Аймаг	143952.0
9	Түйн голын ай сав	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	97687.5
10	Холбоожийн нуур	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	15473.7
11	Их богд	Дурсгалт газар	Аймаг	8695.6
12	Биндэрьяа хөх нуур	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	79543.8
13	Их бага халбагнат	Галуутын хавцал, Олгой гол орчим	Аймаг	305959.8
14	Галуутын хавцал, Олгой гол орчим	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	214.5
15	Хүрэн бэлчир	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	1071.3
16	Шар усан голын ай сав	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	44123.6
17	Отор дундын бүс	Отор дундын бүс	Аймаг	103238.9

18	Баянхонгор	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	8882393.3
19	Идрэнгийн нуруу	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	302288.1
20	Бөгийн хоолой	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	32883.5
21	Нэмэгтийн хоолой, Тавтын шал	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	162431.8

Дээрх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэний дагуу зураглаж, мэдээллийн санг бүрдүүлэхэд ашигт малтмалын талбайтай давхацсан, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхацсан, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг хоорондоо давхацсан гэх мэт зөрчилтэй газруудын зөрчлийг илрүүлсэн. Зөрчлийн судалгаагаар ашигт малтмал газрын тосны газрын кадастрын албаны мэдээллийн санд бүртгэлтэй аймгийн тусгай хэрэгцээний 21 газраас 15 газар нь ямар нэгэн байдлаар зөрчилтэй байна (Хүснэгт -71).

Хүснэгт-71. Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчилийн судалгаа

№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га	Зөрчил төрөл
1		Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	1007.91	Түйн голын ай сав
2	Байдрагийн голын ай сав	Усны эх газрын нөөц газар	Аймаг	143952.01	Улсын ТХГ Нутагтай давхацсан
3	Түйн голын ай сав	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	97687.53	УТХ авахаар төлөвлөсөн газар болон ОНТ Хэрэгцээний талбайтай давхацсан
4	Холбоожийн нуур	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	15473.68	Түйн голын ай сав
5	Их богд	Дурсгалт газар	Аймаг	8695.60	Улсын ТХГН болон хайгуулын лицензийн талбай
6	Биндэрьяа хөх нуур	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	79543.8139	Улсын ТХГН болон ОНТ Хэрэгцээний талбайтай давхацсан
7	Их бага халбагнат	Галуутын хавцал, Олгой гол орчим	Аймаг	305959.78	Улсын ТХГН болон ОНТ Хэрэгцээний талбайтай давхацсан
8	Галуутын хавцал, Олгой гол орчим	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	214.52	УТХ авахаар төлөвлөсөн газар болон ОНТ Хэрэгцээний талбайтай давхацсан

9	Хүрэн бэлчир	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	1071.35	Улсын ТХГН болон ОНТ Хэрэгцээний талбайтай давхацсан
10	Шар усан голын ай сав	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	44123.59	Улсын ТХГН болон ОНТ Хэрэгцээ, АМ лицензийн талбайтай давхацсан
11	Отор дундын бүс	Отор дундын бүс	Аймаг	103238.90	УТХ авахаар төлөвлөсөн газар болон АМ лицензийн талбайтай давхацсан
12	Баянхонгор	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	8882393.28	Улсын ТХГН болон ОНТ Хэрэгцээний талбайтай давхацсан
13	Идрэнгийн нуруу	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	302288.10	Улсын тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөгдсөн
14	Бөгийн хоолой	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	32883.5435	Улсын ТХГ Нутагтай давхацсан
15	Нэмэгтийн хоолой, Тавтын шал	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	162431.767	Улсын ТХГ Нутагтай давхацсан

Дээрх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчил, маргааныг шийдвэрлэхдээ зөрчилтэй орон нутгийн хамгаалалттай газар нутгийн судалгааг гаргаж орон нутгийн саналыг үндэслэн хил заагт өөрчлөлт оруулах, шаардлагатай талбайнуудад хяналт хийж зөрчлийг арилгасан.

Орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутгийн төлөвлөлтийн ажлын хүрээнд нийт 10 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах, 5 газрын хил заагт өөрчлөлт оруулах санал оруулж байна (Хүснэгт-72).

Хүснэгт-72. Орон нутгийн тусгай хамгаалалтаас хасах, хил заагт өөрчлөлт оруулах /төлөвлөлтөөр/


№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га	Хасах болон хил заагт өөрчлөлт оруулах
Хил заагт өөрчлөлт оруулах					
1		Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	1007.91	Хил заагт өөрчлөлт оруулах
2	Байдрагийн голын ай сав	Усны эх газрын нөөц газар	Аймаг	143952.0	Хил заагт өөрчлөлт оруулах
3	Түйн голын ай сав	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	97687.53	Хил заагт өөрчлөлт оруулах
4	Холбоожийн нуур	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	15473.68	Хил заагт өөрчлөлт оруулах
5	Их богд	Дурсгалт газар	Аймаг	8695.60	Хил заагт өөрчлөлт

					оруулах
Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах					
1	Биндэрьяа хөх нуур	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	79543.8	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
2	Их бага халбагнат	Галуутын хавцал, Олгой гол орчим	Аймаг	305959.7	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
3	Галуутын хавцал, Олгой гол орчим	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	214.52	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
4	Хүрэн бэлчир	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	1071.3	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
5	Шар усан голын ай сав	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	44123.5	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
6	Отор дундын бүс	Отор дундын бүс	Аймаг	103238.9	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
7	Баянхонгор	Ерөнхий тусгай хэрэгцээ	Аймаг	8882393	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
8	Идрэнгийн нуруу	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	302288.1	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
9	Бөгийн хоолой	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	32883.5	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
10	Нэмэгтийн хоолой, Тавтын шал	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	162431.7	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах

Дээрх үндэслэлээр нийт 6 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасаж 8 газрын хил заагт тодорхой хэмжээний өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн. Мөн орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн шинээр 7 газрыг аймгийн тусгай хамгаалалтанд авахаар төлөлөлтөнд тусгаж өгсөн.

Хүснэгт-73. Орон нутгийн тусгай хамгаалалтанд шинээр авах /төлөвлөлтөөр/

№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га	Тайлбар
1	Арц Богд	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	88424.40	ОНТХ шинээр авах
2	Тэгш Буянт, Өндөр Өлзийт	Дурсгалт газар	Аймаг	31761.74	ОНТХ шинээр авах
3	Гурван эрхэт	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	3991.97	ОНТХ шинээр авах
4	Гурван эрхэт	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	43504.01	ОНТХ шинээр авах
5	Нарийн гол, Хөх бүрд	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Аймаг	34073.40	ОНТХ шинээр авах
6	Морин мөрт	Дурсгалт газар	Аймаг	333.12	ОНТХ шинээр авах
7	Хөвших хайрхан	Байгалийн үзэсгэлэнт газар	Аймаг	1794.76	ОНТХ шинээр авах



Зураг-55. Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт

5.2.2 Сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт

Тус аймаг нь 2022 оны байдлаар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан ашигт малтмал газрын тосны газрын кадастрын албаны мэдээллийн санд аймгийн тусгай хэрэгцээний 151 газар бүртгэлтэй байгаагаас 54 нь полигон хэлбэрээр дүрслэгдсэн, 97 газар нь цэгэн хэлбэрээр дүрслэгдсэн мэдээллийн санд орсон байна (Хүснэгт-74).

Хүснэгт-74. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг тогтоолоор (Полигон)

№	Сум	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га
1	Баянцагаан	Баянцагаан нуруу	Байгалийн экологийн тэнцвэр хадгалах	Сум	60347.86
2	Богд	Шар дов	Дурсгалт газар	Сум	293.08
3	Богд	Холбоож нуур		Сум	1225.85
4	Богд	Ар гурван гол		Сум	7741.10
5	Богд	Далан түрүү		Сум	233.76
6	Бөмбөгөр	Буйлсан	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	636.61
7	Бөмбөгөр	Алаг толгой шанаган	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	13140.87
8	Бөмбөгөр	Бөмбөгөр		Сум	3904.16
9	Бөмбөгөр	Бөмбөгөр	Дурсгалт газар	Сум	24353.51
10	Бөмбөгөр	Хөх цав "Мааньт уул"	Түүх соёлын дурсгалт газар	Сум	74605.11
11	Галуут	Янбатын өвөр	Байгалийн нөөц газар	Сум	5839.91
12	Галуут	Бор хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	8013.27
13	Галуут	Өвөр мухар	Дурсгалт газар	Сум	291.45
14	Галуут	Эвдэрхий хийд	Түүх соёлын дурсгалт газар	Сум	16.01
15	Галуут	Хойд үүдийн нуур	Дурсгалт газар	Сум	950.53
16	Галуут	Өвөр хаг	Байгалийн нөөц газар	Сум	816.18
17	Галуут	Их цохиот	Дурсгалт газар	Сум	974.84
18	Галуут	Дүнгэнэдэг дов	Байгалийн нөөц газар	Сум	34.52
19	Галуут	Хойд дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	973.21

20	Галуут	Тээлийн ам	Дурсгалт газар	Сум	1850.40
21	Галуут	Баянхонгор хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	1621.28
22	Галуут	Алтан гадас хайрхан	Түүх соёлын дурсгалт газар	Сум	59.27
23	Галуут	Жаргалантын гол	Дурсгалт газар	Сум	10624.42
24	Галуут	Урт дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	2448.78
25	Галуут	Хөшгийн өвөр	Байгалийн нөөц газар	Сум	5107.84
26	Галуут	Бага цохиот	Дурсгалт газар	Сум	766.65
27	Галуут	Хөшгийн өвөр	Байгалийн нөөц газар	Сум	970.35
28	Галуут	Ногоон сав	Түүх соёлын газар	Сум	3249.32
29	Галуут	Хойд дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	0.06
30	Галуут	Овоон ар		Сум	1696.99
31	Галуут	Гурван цармын нуруу		Сум	11496.83
32	Галуут	Ёлын баруун нуруу		Сум	6115.89
33	Гурванбулаг	Гурван булаг уул		Сум	46.80
34	Жаргалант	Баян мод	Түүх соёлын дурсгалт газар	Сум	0.05
35	Жаргалант	Ногоон толгой	Дурсгалт газар	Сум	12.85
36	Жаргалант	Зарлигийн цохио	Түүх соёлын дурсгалт газар	Сум	0.59
37	Жаргалант	Давсан талын Чойндон яйшил уул	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5.20
38	Жаргалант	Хүрээний буурь	Түүх соёлын дурсгалт газар	Сум	2.44
39	Жаргалант	Сүүжийн булгийн бугат хөшөө чулуунууд	Түүх соёлын дурсгалт газар	Сум	0.02
40	Жаргалант	Байшинт хад	Дурсгалт газар	Сум	0.05
41	Жаргалант	Цохиотын уулзварын буган хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	3.94
42	Жаргалант	Агуу толгой	Байгалийн нөөц газар	Сум	63.07

43	Жаргалант	Цохиотын рашаан		Сум	0.38
44	Жинст	Хоёр улиас мод		Сум	6651.13
45	Заг	Шар усан голын ай сав	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	96906.26
46	Заг	Залаа овоо	Байгалийн экологийн тэнцвэр хадгалах	Сум	7725.52
47	Шинэжинст	Бор хайрхан уул	Түүх соёлын дурсгалт газар	Сум	9361.77
48	Шинэжинст	Бор хайрхан уул	Түүх соёлын дурсгалт газар	Сум	2621.94
49	Шинэжинст	Ногоон сав	Түүх соёлын газар	Сум	85736.90
50	Шинэжинст	Хотгор		Сум	1007.26
51	Шинэжинст	Амарбуянт хийд		Сум	4.12
52	Шинэжинст	Амарбуянт хийдийн Данзанчойжин буудалласан буудал		Сум	6.23
53	Шинэжинст	Шарилын овоо		Сум	13.97
54	Шинэжинст	Тооройтын хөх уул	Байгалийн нөөцөд авсан газар	Сум	63588.66
					524159.05

Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын албаны мэдээллийн санд хил заагийг тогтоож сумын тусгай хэрэгцээнд авсан 54 газар нь 524159.05 га талбайг эзэлж байна. Дээрх газруудаас гадна ашигт малтмал газрын тосны кадастрын албаны мэдээллийн санд бүртгэлтэй цэгэн хэлбэрээр дүрслэгдсэн 97 газар байна (Хүснэгт-75.).

Хүснэгт-75. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг тогтоолоор (цэгэн)

№	Сум	Нэр	Ангилал	Түвшин	Авсан он
1	Шинэжинст	Үзүүр ганга	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	1/7/2005
2	Шинэжинст	Цагаан хаалга	Байгалийн нөөц газар	Сум	1/7/2005
3	Шинэжинст	Зуун мод	Байгалийн нөөц газар	Сум	1/7/2005
4	Гурванбулаг	Морин мөргийн толгой	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	1/8/2005
5	Гурванбулаг	Рашаант толгойн рашаан	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	1/8/2005
6	Гурванбулаг	Өвгөн хүрээний туурь	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/8/2005

7	Гурванбулаг	Мөрөнгийн арын цагаан толгой	Байгалийн нөөц газар	Сум	1/8/2005
8	Гурванбулаг	Билүүтийн хүрээний туурь	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/8/2005
9	Гурванбулаг	Чингийн овоо	Байгалийн дурсгалт газар	Сум	1/8/2005
10	Гурванбулаг	Булагт хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	1/8/2005
11	Гурванбулаг	Гурван ноёны шарилын хамар	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/8/2005
12	Гурванбулаг	Тээлийн гурван нүүрийн сав газар	Байгалийн нөөц газар	Сум	1/8/2005
13	Баацагаан	Жаргалантын давс	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	2/4/2005
14	Өлзийт	Бийрийн буган хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	2/4/2005
15	Баацагаан	Манханы заган ой	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	2/4/2005
16	Баацагаан	Дэвхэргийн шанд	Байгалийн нөөц газар	Сум	2/4/2005
17	Өлзийт	Бага шаргалжуут	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	6/7/2005
18	Өлзийт	Ээжийн цагаан хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	6/17/2005
19	Бөмбөгөр	Гурван бараан буган хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	8/1/2005
20	Жаргалант	Хөшөөгийн булангийн хөшөө чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	4/2/2007
21	Жаргалант	Намсрайн төрсөн газар	Түүх соёлын дурсгалт газар	Сум	4/2/2007
22	Жаргалант	Хар анаг	Байгалийн дурсгалт газар	Сум	4/2/2007
23	Жаргалант	Улаан хурууны хөшөө чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	4/2/2007
24	Жинст	Тээрмийн 2 бул чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	4/14/2007
25	Жинст	Хөнөгийн заган ой	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	7/4/2007
26	Жинст	Уубулангийн Хавцгайтын хөндий	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	7/4/2007
27	Галуут	Олон овооны таг	Байгалийн дурсгалт газар	Сум	8/10/2007
28	Галуут	Баянцагааны нуруу	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	8/10/2007
29	Галуут	Түрэгийн үеийн хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	8/10/2007
30	Галуут	Бурхант хад	Түүх соёлын дурсгалт газар	Сум	8/10/2007

31	Галуут	Чин сүжигт номун хааны хүрээ	Түүх соёлын дурсгалт газар	Сум	8/10/2007
32	Галуут	Алаг хороотын сүг зураг	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	8/10/2007
33	Галуут	Тээлийн амны 2 чулуун хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	8/10/2007
34	Богд	Гэгээнэ овоо	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2008
35	Богд	Загасны дүрстэй чулуу	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2008
36	Богд	Даяндээрхийн овоо	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2008
37	Богд	Ичээтийн рашаан	Байгалийн нөөц газар	Сум	1/1/2008
38	Бууцагаан	Бурхант нуруу	Байгалийн дурсгалт газар	Сум	2/29/2008
39	Жинст	Бодь овоо	Байгалийн дурсгалт газар	Сум	4/14/2008
40	Жинст	Нарийн хярын арын 3 хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	4/14/2008
41	Баянбулаг	Дааган чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2009
42	Богд	1000 цэргийн булш	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/10/2009
43	Богд	Харзтай рашаан	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	11/10/2009
44	Богд	Цагаан суварга	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/10/2009
45	Богд	Луу яст	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/10/2009
46	Богд	Дурсгалын хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/10/2009
47	Баянлиг	Хүн чулуун хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/10/2009
48	Богд	Татуургын гол	Байгалийн нөөц газар	Сум	11/10/2009
49	Богд	Оюу чулуун хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/10/2009
50	Баянговь	Цагаан булгийн хөшөө чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	12/28/2009
51	Баянговь	Бөхболдын чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	12/28/2009
52	Баянговь	Ишигний эвэр хайрхан	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	12/28/2009
53	Баянговь	Хавтгай цагаан	Түүх соёлын дурсгалт газар	Сум	12/28/2009
54	Баянговь	Улаан чулууны цагаан зандан мод	Түүх соёлын дурсгалт газар	Сум	12/28/2009
55	Баянлиг	Цагаан булаг	Ой, амьтан, ургамал,	Сум	12/28/2009

			усны нөөц газар		
56	Баянговь	Сонгинохайрхан уул	Түүх соёлын дурсгалт газар	Сум	12/28/2009
57	Бууцагаан	Номин толгой	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5/21/2010
58	Бууцагаан	Бодь суварга	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5/21/2010
59	Бууцагаан	Хүрэн морины хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5/21/2010
60	Бууцагаан	Чингисийн морины уяа	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5/21/2010
61	Бууцагаан	Дарь эхийн хүрээний туурь	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5/21/2010
62	Бууцагаан	Шар чулууны агуй	Түүх соёлын дурсгалт газар	Сум	5/21/2010
63	Гурванбулаг	Үеийн амны хөшөө	Түүх соёлын дурсгалт газар	Сум	7/7/2010
64	Баян Өндөр	Баянбулгийн тал	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	1/7/2005
65	Жаргалант	Унцгын гэр асга	Байгалийн дурсгалт газар	Сум	2000-01-01
66	Заг	Баянцагааны өрх	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
67	Заг	Цонж	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2000
68	Жинст	Таван элс	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	1/1/2000
69	Заг	Хойд Баянцагааны шавар бунхан	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
70	Эрдэнэцогт	Булш 2	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
71	Богд	Орог нуур хутагт Цэрэндоржийн Латаа	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
72	Баянцагаан	Бумбатын амны эмэгтэй хүн	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2000
73	Баян Овоо	Дуурсахын хөндийн хирэгсүүр	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
74	Заг	Бурхант хясаа	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	1/1/2000
75	Баян Овоо	Үүдийн хөндийн хүн чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
76	Заг	Дулаанхарын 2 хэрэгсүүр	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
77	Баянговь	Хоолойн цахирын агуй	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2000
78	Гурванбулаг	Хөшөөт буган чулуу	Түүх соёлын дурсгалт газар	Сум	1/1/2000
79	Заг	Халиутын рашаан	Байгалийн нөөц газар	Сум	1/1/2000

80	Хүрээмарал	Солир буусан талбар	Байгалийн дурсгалт газар	Сум	1/1/2000
81	Өлзийт	Хийдийн гэээг	Түүх соёлын дурсгалт газар	Сум	11/2/1998
82	Өлзийт	Гялгарын хавцгай	Байгалийн дурсгалт газар	Сум	11/2/1998
83	Баянговь	Байшинт хийдийн туурь	Түүх соёлын дурсгалт газар	Сум	12/28/2009
84	Баянговь	Гурван булгийн рашаан	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Сум	12/28/2009

Дээрх орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутгийг сумыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэний дагуу зураглаж, мэдээллийн санг бүрдүүлэхэд ашигт малтмалын талбайтай давхацсан, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхацсан, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг хоорондоо давхацсан гэх мэт зөрчилтэй газруудын зөрчлийг илрүүлсэн. Зөрчлийн судалгаагаар ашигт малтмал газрын тосны газрын кадастрын албаны мэдээллийн санд бүртгэлтэй сумын тусгай хэрэгцээний 54 газраас 30 газар нь ямар нэгэн байдлаар зөрчилтэй байна (Хүснэгт-76).

Хүснэгт-76. Сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчлийн судалгаа

№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га	Зөрчил төрөл
1	Бор хайрхан уул	Түүх соёлын дурсгалт газар	Сум	0.26	УТХ авахаар төлөвлөсөн газартай давхацсан
2	Ногоон сав	Түүх соёлын газар	Сум	8.57	УТХ авахаар төлөвлөсөн болон АМЛицензийн талбайтай давхацсан
3	Хөшгийн өвөр	Байгалийн нөөц газар	Сум	0.10	УТХ авахаар төлөвлөсөн болон ОНТХ Газартай давхацсан
4	Ногоон сав	Түүх соёлын газар	Сум	0.32	УТХ авахаар төлөвлөсөн болон ОНТХ Газартай давхацсан
5	Хойд дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	0.00001	УТХ авахаар төлөвлөсөн болон ОНТХ Газартай давхацсан
6	Гурван булаг уул		Сум	0.00468	Хил зааг буруу тогтоогдсон
7	Хотгор		Сум	0.10	Ашиглалтын лицензийн талбай
8	Амарбуянт хийд		Сум	0.0004	Хил зааг буруу тогтоогдсон
9	Амарбуянт хийдийн Данзанчойжин буудалласан буудал		Сум	0.001	Хил зааг буруу тогтоогдсон
10	Шарилын овоо		Сум	0.001	Ашиглалтын лицензийн талбай
11	Бөмбөгөр		Сум	0.39	Ашиглалтын лицензийн талбай

12	Холбоож нуур		Сум	0.12	Аймгийн тусгай хэрэгцээнд авсан талбайтай давхацсан
13	Ар гурван гол		Сум	0.77	УТХ авахаар төлөвлөсөн болон Орон нутгийн ТХГ нутагтай давхацсан
14	Далан түрүү		Сум	0.02	УТХ авахаар төлөвлөсөн талбайтай давхацсан
15	Цохиотын рашаан		Сум	0.00	Орон нутгийн ТХГН голын ай савтай давхацсан
16	Овоон ар		Сум	0.17	Улсын ТХГН
17	Гурван цармын нуруу		Сум	1.15	Улсын ТХГН
18	Ёлын баруун нуруу		Сум	0.61	Улсын ТХГН
19	Тооройтын хөх уул	Байгалийн нөөцөд авсан газар	Сум	6.36	УТХ авахаар төлөвлөсөн газартай давхацсан
20	Хоёр улиас мод		Сум	0.67	Орон нутгийн ТХГН
21	Залаа овоо	Байгалийн экологийн тэнцвэр хадгалах	Сум	0.77	Орон нутгийн ТХГН, АМ лицензийн талбайтай давхацсан
22	Сүүжийн булгийн бугат хөшөө чулуунууд	Дурсгалт газар	Сум	0.02	
23	Янбатын өвөр	Дурсгалт газар	Сум	5839.91	Засаг захиргааны хил дамнасан
24	Бор хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	8013.27	УТХ Газартай давхцсан
25	Өвөр хаг	Байгалийн нөөц газар	Сум	816.18	Засаг захиргааны хил дамнасан
26	Хойд дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	973.21	Засаг захиргааны хил дамнасан
27	Жаргалантын гол	Дурсгалт газар	Сум	10624.42	Орон нутгийн ТХГН
28	Урт дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	2448.78	Орон нутгийн ТХГН, засаг захиргааны хил дамнасан
29	Шар усан голын ай сав	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	96906.26	Улс, Орон нутгийн ТХГН
30	Шар усан голын ай сав	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	96906.26	Улс, Орон нутгийн ТХГН

Дээрх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчил, маргааныг шийдвэрлэхдээ зөрчилтэй орон нутгийн хамгаалалттай газар нутгийн судалгааг гаргаж орон нутгийн саналыг үндэслэн хил заагт өөрчлөлт оруулах, шаардлагатай талбайнуудад хяналт хийж зөрчлийг арилгасан.

Орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутгийн төлөвлөлтийн ажлын хүрээнд нийт 21 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах, 9 газрын хил заагт өөрчлөлт оруулах санал оруулж байна (Хүснэгт-77).

Хүснэгт-77. Сумын тусгай хэрэгцээнээс хасах, хил заагт өөрчлөт оруулах /төлөвлөлтөөр/

№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га	Хасах болон хил заагт өөрчлөлт оруулах
Хил заагт өөрчлөлт оруулах					
1	Сүүжийн булгийн бугаг хөшөө чулуунууд	Дурсгалт газар	Сум	0.02	Хил заагт өөрчлөлт оруулах
2	Янбатын өвөр	Дурсгалт газар	Сум	5839.91	Хил заагт өөрчлөлт оруулах
3	Бор хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	8013.27	Хил заагт өөрчлөлт оруулах
4	Өвөр хаг	Байгалийн нөөц газар	Сум	816.18	Хил заагт өөрчлөлт оруулах
5	Хойд дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	973.21	Хил заагт өөрчлөлт оруулах
6	Жаргалантын гол	Дурсгалт газар	Сум	10624.42	Хил заагт өөрчлөлт оруулах
7	Урт дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	2448.78	Хил заагт өөрчлөлт оруулах
8	Шар усан голын ай сав	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	96906.26	Хил заагт өөрчлөлт оруулах
9	Шар усан голын ай сав	Ерөнхий тусгай хэрэгцээ	Сум	96906.26	Хил заагт өөрчлөлт оруулах
Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах					
1	Бор хайрхан уул	Түүх соёлын дурсгалт газар	Сум	0.26	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
2	Ногоон сав	Түүх соёлын газар	Сум	8.57	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
3	Хөшгийн өвөр	Байгалийн нөөц газар	Сум	0.10	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
4	Ногоон сав	Түүх соёлын газар	Сум	0.32	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
5	Хойд дэл хайрхан	Байгалийн нөөц газар	Сум	0.00001	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
6	Гурван булаг уул		Сум	0.00468	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
7	Хотгор		Сум	0.10	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
8	Амарбуянт хийд		Сум	0.0004	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
9	Амарбуянт хийдийн Данзанчойжин буудалласан буудал		Сум	0.001	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах

10	Шарилын овоо		Сум	0.001	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
11	Бөмбөгөр		Сум	0.39	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
12	Холбоож нуур		Сум	0.12	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
13	Ар гурван гол		Сум	0.77	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
14	Далан түрүү		Сум	0.02	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
15	Цохиотын рашаан		Сум	0.00	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
16	Овоон ар		Сум	0.17	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
17	Гурван цармын нуруу		Сум	1.15	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
18	Ёлын баруун нуруу		Сум	0.61	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
19	Тооройтын хөх уул	Байгалийн нөөцөд авсан газар	Сум	6.36	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
20	Хоёр улиас мод		Сум	0.67	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах
21	Залаа овоо	Байгалийн экологийн тэнцвэр хадгалах	Сум	0.77	Орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасах

Дээрх үндэслэлээр нийт 21 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнээс хасаж 9 газрын хил заагт тодорхой хэмжээний өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн. Мөн орон нутгийн удирдлага, мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн шинээр 15 газрыг аймгийн тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөлтөнд тусгаж өгсөн.

Хүснэгт-78. Орон нутгийн тусгай хэрэгцээнд шинээр авах /төлөвлөлтөөр/

№	Нэр	Ангилал	Түвшин	Талбай, га	Тайлбар
1	Халзан хайрхан	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	433.82	ОНТХ шинээр авах
2	Холбоо нуур	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	31.71	ОНТХ шинээр авах
3	Бороо нуур	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	23.27	ОНТХ шинээр авах
4	Буяны суварга /Нарангийн улаан хамар/	Дурсгалт газар	Сум	1.24	ОНТХ шинээр авах
5	Хөшөөт	Дурсгалт газар	Сум	0.10	ОНТХ шинээр авах
6	Чихний агуй	Дурсгалт газар	Сум	0.10	ОНТХ шинээр авах


7	Якутийн агуй	Дурсгалт газар	Сум	0.10	ОНТХ шинээр авах
8	Гялтагнуурын суврага	Дурсгалт газар	Сум	0.05	ОНТХ шинээр авах
9	Бозой зааны чулуу	Дурсгалт газар	Сум	0.10	ОНТХ шинээр авах
10	Шар булгийн хэрэгсүүр	Дурсгалт газар	Сум	0.10	ОНТХ шинээр авах
11	Хийд	Дурсгалт газар	Сум	26.98	ОНТХ шинээр авах
12	Дөрвөлжин хайрхан	Дурсгалт газар	Сум	20.98	ОНТХ шинээр авах
13	Буурал хайрхан	Дурсгалт газар	Сум	380.04	ОНТХ шинээр авах
14	Босго адаг	Дурсгалт газар	Сум	0.35	ОНТХ шинээр авах
15	Хөх цав "Мааньт уул"	Дурсгалт газар	Сум	59.89	ОНТХ шинээр авах

Хээрийн судалгаагаар түүх соёлын болон байгалийн дурсгалт газруудыг улсын тусгай хэрэгцээнд авах саналуудыг өгсөн. Эдгээр газруудыг улсын тусгай хамгаалалтанд авахын тулд түүх соёлын болон байгалийн дурсгалт газруудыг ач холбогдол, зэрэглэл, үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнг харгалзан жагсаалтаар болон хил заагийг нарийвчлан тогтоох тогтоох шаардлагатай (Хүснэгт-79.).

Хүснэгт-79. Сумын тусгай хэрэгцээнд шинээр авах (цэгэн)

№	Нэр	Ангилал	Түвшин	Тайлбар
1	Хаан тоорой	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
2	Толь булаг	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
3	Өлзийтийн булаг	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
4	Эхийн гол	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
5	Дусаалын агуй	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
6	Бурхант	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
7	Бичигт ханан	Түүх, соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
8	Хүж хад	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
9	Ванган овоо	Түүх соёлын дурсгалт	Сум	ОНТХ шинээр авах

		газар		
10	Хүрэн цав	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
11	Бөх ванган булш	Түүх, соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
12	Зараа толгойн дурсгал	Түүх соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
13	Жамбалзундуйн овоо	Түүх соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
14	Арцангийн рашаан	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
15	Хөмсгийн рашаан	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
16	Чингис хааны гүүн зэл гадас	Түүх соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
17	Чингис хааны гүүн зэл гадас	Түүх соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
18	Бүгийн цав	Байгалийн үзэсгэлэнт газар	Сум	ОНТХ шинээр авах
19	Өврийн багшийн буурь	Түүх соёлын дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах
20	Момбон овоо	Байгалийн дурсгалт газар	Сум	ОНТХ шинээр авах



Зураг-56. Сумын тусгай хэрэгцээний газар нутгийн төлөвлөлт

ЗУРГАА. УСНЫ САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

6.1 Усны сангийн газрын нөөц

Усны сан бүхий газарт мөрөн гол, горхи, булаг, шанд, нуур, цөөрөм, тойром гэсэн газар ашиглалтын төрлүүдтэй. Аймгийн хэмжээнд 2021 оны газрын нэгдмэл сангийн тооллогоор усны сан бүхий газарт 51100 га талбайг хамарч байна. Энэхүү үзүүлэлтийг задлан үзвэл аймгийн хэмжээнд усан сан бүхий газрын 93.9 хувь буюу 48000 га газрыг нуур, цөөрөм, тойром, 5.1 хувь буюу 2600 га газрыг гол мөрөн, 1 хувь буюу 500 га газрыг горхи, булаг шанд эзэлж байна.

Хүснэгт-80. 2020 оны Газрын нэгдмэл санд усны сан бүхий газрын эзлэх талбай

Газрын ангилал		Талбайн хэмжээ, га	Эзлэх хувь
Усны сан бүхий газар		51100	100.0%
Үүнээс	Гол мөрний эзлэх газар	2600	5.1%
	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	48000	93.9%
	Горхи, булаг, шандны эзлэх газар	500	1.0%
	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	-	-

Эх сурвалж: 1212.mn





График-13. Усны сан бүхий газрын эзлэх хувь

Баянхонгор аймгийн усны сан бүхий газрын дийлэнх хувийг нуур, цөөрөм, тойрмын газар эзэлж буйгаас үзэхэд томоохон гол, мөрөн харьцангуй олон тоогоор орших ч дийлэнх гадаргын усны нөөцийн хэсгийг бүрдүүлдэггүйг харж болно. Аймгийн хамгийн том голын нэг болох Байдраг гол нь Хангайн нурууны өмнөд хажуугаас эх авч говийн Бөөнцагаан, Адгийн цагаан хоёр нуурт усаа нийлүүлдэг. Нийт урт нь Бөөнцагаан хүртэл 295 км, Адгийн цагаан нуур хүртэл 310 км урсана. Байдраг голын эхэнд баруун гар талаас Загийн гол (80 км), зүүн гар талаас Өлзийтийн гол (135 км) зэрэг 99 гол горхи цутгадаг.

Хүснэгт-81. Баянхонгор аймгийн гадаргын усны тооллого

№	Багийн нэр	Худаг		Булаг, шанд, рашаан		Гол, горхи		Нуур		Цөөрөм		Нийт
		тоологдсон	устай	тоологдсон	устай	тоологдсон	устай	тоологдсон	устай	тоологдсон	устай	
1	Баянхонгор	466	445	5	5	13	13					484
2	Баацагаан	143	140	28	28			1	1			172
3	Баянцагаан	296	252	146	146	15	15	2	2			459
4	Баянговь	218	207	50	43							268
5	Баянлиг	466	430	106	101							572
6	Баян-овоо	128	120	39	38	4	4	3	3	1	1	175
7	Баян-Өндөр	275	273	66	65			8	7			349
8	Богд	237	229	1	1			72	72			310
9	Бөмбөгөр	157	142	50	50	2	2	1	1			210
10	Бууцагаан	226	214	40	39	11	11	6	5			283
11	Галуут	41	41	61	61	42	42	14	14			158
12	Гурван булаг	15	12	24	23	29	29	6	6	3	3	77
13	Жаргалант	45	45	59	59	62	62	10	10	1	1	177
14	Жинст	145	143	43	43	3	3	3	3			194
15	Заг	32	31	137	132	3	3	5	5	1	1	178
16	Өлзийт	132	119	115	111	4	4	1	1	1	1	253
17	Хүрээмарал	139	139	33	33	4	4	16	16			192
18	Шинэжинст	381	356	47	45			3	3			431
19	Эрдэнэцогт	15	15	64	64	71	69	14	14			164
	Нийт	3557	3353	1114	1087	263	261	165	163	7	7	5106

Дээрх хүснэгтээс хархад 2020 онд явагдсан усны тооллогоор 3557 худаг тоологдсоноос 204 худаг эвдэрсэн, ширгэсэн, 1114 Булаг, шанд, рашаан тоологдсоноос 27 ширгэсэн, 263 Гол, горхи тоологдсоноос 2 ширгэсэн, 165 нуур тоологдсоноос 2 ширгэсэн байна.



Зураг-57. Усны сүлжээ

Байдраг гол Хангайн өмнөд уулсын нарийхан хавцал дундуур урсана. Хөндийн хажуу эгц, хад асга ихтэйн дээр хээр, говийн тачир ургамалшилтай юм. Энэ хэсэгт гол нэг гольдролоор урсах бөгөөд гольдролын өргөн 20-40 м, зонхилох гүн 0.3-1.5 м, урсгалын хурд 1-1.5 м/с хүрдэг байна. Мөн том голын нэг нь Түйн гол юм. Түйн гол нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сум буюу Хангайн нуруунаас эх авч, аймгийн хилийн наагуур урссаар Нууруудын хөндий дэх Орог нуурт цутгадаг. Томоохон цутгал гэвэл Шаргалжуут гол билээ. Голын эрэг голдирлын дагуу Баянхонгор аймгийн төв Баянхонгор хот, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд зэрэг сумдын төв байх агаад бас бус багууд байрлана. Уул уурхайн үйл ажиллагаа, дулаарал, говийн уур амьсгал, бага хур тунадас зэргээс шалтгаалан голын ус багассаар байгаа юм.

6.2 Усны менежментэд баримтлах үндсэн зарчим

Хуулийн дагуу усны сан бүхий газарт гадаргуугийн усны эзэлж байгаа газар, мөнх цас, мөсөн гол, түүнчлэн усны нөөц чанарыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай усны эрэг орчмын /усны хөвөө/ зурвас газар багтдаг. Харин олон улсын жишгээр бол нуур, гол горхины эргийн дагуу 50 метр өргөнтэй, усархаг намгархаг газрын эргэн тойрны 100 метр өргөн зурвас газрыг усны эрэг орчмын бүс гэж зарлан түүн дээр усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаанд чанга хяналт тавьдаг. Мөн энэ зурваст газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх, нуур голын усанд ан амьтан чөлөөтэй хүрэх замыг алдагдуулах зэргээс аль болохоор зайлсхийдэг.

Тус аймаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах бөгөөд гадаргын усны нөөц багатай учир ХАА-н хангамжийн усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах зорилтыг нэгдмэлээр шийдэгдэж байж хэвийн оршин тогтнох нөхцөлтэй байдаг. Иймээс Аймгийн хэмжээнд гадаргын болон гүний усны нөөцийн байгалийн тэнцэл, усны чанарыг газар ашиглалтаар дамжуулан хангахын тулд усан сан бүхий газрыг ялангуяа усны эх газар, усны эрэг хөвөө газар, усархаг чийглэг газрыг хамгаалахад чиглэсэн горимын бүсүүд буй болгож ашиглалтын горимыг одоогийнхоос эрс өөрчлөхөөр төлөвлөв. ХАА-н усан хангамжийн хамгаалалтын бүсийн менежмент, төлөвлөлт, ашиглалтын горимыг доор дурьдсан бүсүүд болог хамгаалалтын бүсүүд байгуулах зарчимаар төлөвлөнө.

Усны сан бүхий газрын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг дараах төрөл, хэмжээгээр тогтооно. Үүнд:

- Эрүүл ахуйн бүс;
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс;
- Үерийн хамгаалалтын бүс;

Усны эх, ундарга, нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны аюулаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтооно.

Хамгаалалтын бүсийг дотор нь онцгой хамгаалалтын бүс ба энгийн хамгаалалтын бүс гэж хоёр ангилна (Хүснэгт-82).

Хүснэгт-82. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

№	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Хууль, эрхзүйн үндэслэл
Онцгой хамгаалалтын бүс			
1	Булаг, шанд	50 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
2	Гол, горхи	50 м <	
3	Нуур, урсцын тохируулгатай усан сан	100 м <	
4	Гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт	Усны хагалбарын хилээр	
5	Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усан сан бүхий газар	100 м <	
6	Үерийн хамгаалалтын далангаас	50 м <	
7	Үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас	< 30 м	
Энгийн хамгаалалтын бүс			
8	Булгийн энгийн хамгаалалтын бүс	200 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
9	Голын энгийн хамгаалалтын бүс	200 м <	
10	Нуурын энгийн хамгаалалтын бүс	200 м <	
11	Нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усан сан бүхий газар	< 500 м	

Гол горхи нуур, тойрмын усны эрэг болон гүн хэсгийн хооронд байнгын хөдөлгөөнтэй солилцоо зурвас хэсэг байдаг. Гол горхи, нуур тойрмын эрэг хөвөө дагуу хэсэг зурвас газар нь экологийн хувьд онцгой. Гол горхи нуур, тойрмын усны эрэг болон гүн хэсгийн хооронд байнгын солилцоо зурвас хэсэг байдаг. Гол горхи, нуур тойрмын эрэг хөвөө дагуу хэсэг зурвас газар нь экологийн хувьд онцгой ач холбогдолтой бүс байдаг. Ийм бүсийн зурвас орчмыг усны бүс гэх бөгөөд усны болон хуурай газрын биологийн төрөл зүйлийн хувьд харьцангуй баян хэсэг бөгөөд хамгаалалтын бүсийг доорх байдлаар тогтоов.

6.3 ХАА-н усан хангамжийн төлөвлөлт

6.3.1 ХАА-н усан хангамжийн хамгаалалтын бүсүүд

Дээрх аргачлалын дагуу Баянхонгор аймаг Бөөнцагаан-орог нуурын сав газрын захиргааны газраас авсан материалыг үндэслэн усны сан бүхий газрын менежментэд баримтлах усны хамгаалалтын бүсүүдийг төлөвлөхдөө гол горхи, булаг шанд, нуурын усан хангамжийн эх үүсвэрээс онцгой болон энгийн хамгаалалтын бүсүүдийг тогтоож өгсөн.

Усны тухай хуульд зааснаар усны нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газарт онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүс, рашаанд эрүүл ахуйн болон хориглох бүс тогтоон төлөвлөсөн. (Хүснэгт-83.).

Хүснэгт-83. Усны сан бүхий газрын төлөвлөлтийн бүсүүд

Сумын нэр	Гол, нуур, булаг			Газрын доорх усны орд		Усны урсац бүрэлдэх эх	Рашаан		Нийт
	Онцгой хамгаалалт	Энгийн хамгаалалт	Нуурыг элсний нүүлтээс хамгаалах ойн зурвас	Дотоод тэжээгдэл	Гадаад тэжээгдэл		Эрүүл ахуйн бүс	Хориглолтын бүс	
Баацагаан	4274	9426	1347						15047
Баянцагаан	2697	9061		142	352				12252
Баянговь	862	2885		7163	5421		3	25	16359
Баянлиг	269	1733		57129	65182				124314
Баян-овоо	1316	3517			19	1747			6599
Баян-Өндөр	699	1724		2977	1864				7264
Баян-булаг	3296	9453							12749
Богд	2172	4172	3543						9886
Бөмбөгөр	2293	6486		183	413				9375
Бууцагаан	3273	9944			49		6	31	13303
Галуут	5458	13425		162	235	164453	146	239	184117
Гурван булаг	8106	23135		203	70	4751			36264
Жаргалант	3178	9015				205869	11	58	218130
Жинст	1713	3993	244				3	25	5978
Заг	3673	11091		2160	5860	6490	3	25	29302
Өлзийт	2165	6621		353	467	31735	13	101	41453
Хүрээмарал	1431	3264							4695
Шинэжинст	1914	4972		8462	39080				54429
Эрдэнэцогт	4853	13841			223	159138			178054
ДҮН	53639	147757	5134	78935	119235	574181	185	503	979570

Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсүүдийг төлөвлөхөд гол, нуур, булаг шандны онцгой хамгаалалтын бүс 53639 га, энгийн хамгаалалтын бүс 147757 га талбайг тус тус эзэлж байна.


6.3.2 Рашааны хамгаалалтын бүсийн төлөвлөлт

Рашааны хамгаалалтын бүсийг тогтооходоо эрүүл ахуйн бүсийг 100 метр, хориглолтын бүсийг тогтооходоо 300 метрээр тогтоох шаардлагатай байдаг. Бөөнцагаан-орог нуурын сав газрын захиргаанаас 9 рашааны хамгаалалтын бүсийг тогтоож өгсөн байна. Харин бид хээрийн судалгаагаар орон нутгийн саналыг үндэслэн 6 рашаан хамгаалалтын бүсийг нэмж тогтоож өгсөн (Хүснэгт-84.).


Хүснэгт-84. Рашааны хамгаалалтын бүсийн төлөвлөлт

Сумын нэр	Рашааны нэр	Рашаан		Нийт
		Эрүүл ахуйн бүс, талбай, га	Хориг-лолтын бүс, талбай, га	
Баянговь	Ишгэний эвэр	3	25	28
Бууцагаан	Овоот түрүү	6	31	37
Гурван булаг	Хөх нуур Бумбат	6	31	37
Галуут	Өхэг рашаан	146	239	385
	Өргөөтийн рашаан			
	Тээлийн рашаан			
Жаргалант	Устын рашаан	11	58	69
	Цохиотын рашаан			
Жинст	Хүүхний рашаан	3	25	28
Заг	Нарийний рашаан	6	31	37
	Халиутын рашаан			
Өлзийт	Агуйн рашаан	13	101	114
	Хөх хадны рашаан			
	Бага Шаргалжуут			
	Чонын ус			
ДҮН		194	541	735

Дээрх хүснэгтээс харахад 15 рашааны эрүүл ахуйн бүс 185 га, хориглолтын бүс 503.4 га бүсүүдийг тус тус төлөвлөж өглөө. Жишээ болгож доорх рашааны хамгаалалтын бүс тогтоосоньг харууллаа (Зураг 58.).



Ишгэний рашаан



Овоот рашаан

Зураг-58. Рашааны хамгаалалын бүс тогтоосон байдал

Дээрх хамгаалалтын бүсийг тогтоож өгсөнөөр рашааны ашиглалт, хамгаалалт сайжирна.

6.3.3 Нуурыг элсний нүүлтээс хамгаалах, усны ундаргыг нэмэгдүүлэх

ТӨЛӨВЛӨЛТ

Элсний нүүлтээс хамгаалах, усны ундаргыг нэмэгдүүлэх зорилгоор 3 сумын нутаг дэвсгэрт байрлах томоохон нууруудын эргийн бүсэд ойн зурвас төлөвлөж өгсөн болно (Хүснэгт-85).

Хүснэгт-85. Нуурыг элсний нүүлтээс хамгаалах, усны ундаргыг нэмэгдүүлэх ойн зурвас

Сумын нэр	Нуур	Төлөвлөж ойн зурвас талбай, га	Үүнээс		
			Ойр 2027	Дунд 2032	Урт 2032
Баацагаан	Бөөн цагаан нуур	1347	674	404	269
Богд	Орог	3404	1702	1021	681
	Холбоож	138	83	55	-
Жинст	Холбоож	244	146	98	-
ДҮН		5133	2567	1540	1027

Дээрх хүснэгтээс харахад томоохон нууруудыг элсний нүүлт болон усны ундаргыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 5133 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөж өгсөн болно. Энэхүү ойн зурвасыг төлөвлөлтийн үе шатуудад хувааж ойжуулалтыг хийхээр төлөвлөсөн бөгөөд 2027 он гэхэд 2567 га талбайд, 2032 он гэхэд 154 га талбайд, 2037 он гэхэд 1027 га талбайд ойжуулалт хийхээр төлөвлөж өгсөн болно.

6.3.4 Ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах төлөвлөлт

Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт монгол оронд хүчтэй явагдаж, байгаль экологийн тэнцвэртэй байдал алдагдаж, цөлжилт нэмэгдэж, усны нөөц хомсдож, газар нутаг бүрийн ургамал, хөрсний бүтэц өөрчлөгдөж, салхины хүч ихсэж, ган гачиг үргэлжлэн тохиолдох, гэнэт их хэмжээний үер буух зэргээр гамшигт үзэгдлүүд ихсэх боллоо. Гадаргын усны эх булаггүй уулархаг газар бороо, үерийн усыг хураан малын ус хангажид зориулсан болон урсгал гол горхи, булгийн усыг хуримтлуулан хиймэл нуур цөөрөм байгуулж усалгаатай газар тариаланд ашиглах зорилгоор барьж байгуулдаг.

Хөв, цөөрмийг зориулалтаар нь ус хуримтлуулан усалгаатай газар тариаланд ашиглах, усгүй бэлчээрт цас борооны ус хуримтлуулан малын ус хангамжийг сайжруулах, байгалийн нөхөн сэргээлт, аялал жуулчлал гэх мэтээр ангилдаг. Бид бэлчээр болон газар тариаланд цас болон борооны усыг хуримтлуулан усан хангамжийг сайжруулах зорилгоор ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/205 тоот тушаалын 9-р хавсралтаар батлагдсан арга зүй нь ойлгомжгүй, нөлөөлөх хүчин зүйлүүдийг хэрхэн яаж тооцох шатлал, арга аргачлал нь ойлгомжгүй тодорхой бус байна. Иймээс энэ чиглэлээр олон улсын түвшинд хийгдсэн хэдэн хэдэн ажлуудыг судалж танилцан арга зүйг боловсронгуй болгон хийж гүйцэтгэлээ.

Тохиромжтой байдлын үнэлгээг олон хүчин зүйлийн шинжилгээний аргад тулгуурлан ГЗМС-н технологи дээр суурилдаг (Baban and Wan-Yusof, 2003). Судалгаа нь дараахь хоёр үе шаттай: Мэдээллийг бэлтгэх ба олон хүчин зүйлийн шинжилгээ хийх гэсэн хоёр үе шаттай: Эхний үе шатанд тохиромжтой байдлын хамгийн энгийн шаардлагыг хангах суурь нөхцөлийг тогтооно. Хоёрдугаар шатанд олон хүчин зүйлийн дүн шинжилгээг АНР (АНР Аналитик шатлан эрэмбэлэх математик). программыг хангамжыг ашиглан жигнэсэн дундажаар тогтооно.

Суурь нөхцөлийн үнэлгээ

Constrain буюу суурь нөхцөлийн зураг гаргахад одоо байгаа хот суурин, тариалангийн талбай, авто зам, уул уурхайн талбай, нуур, булаг, худаг, уст цэг, хуурай, сайр, жалга гэх мэт нөхцөлүүдийг харгалзан Constraint буюу суурь нөхцөлийн зургийг гаргасан. Ингэхдээ сонгон авсан үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн зураг үүсгэж, зургуудыг давхцуулж аялал жуулчилалд тохиромжтой газрыг сонгох дүн шинжилгээг Erdas Imagine программ дээр хийсэн (Хүснэгт-86).

Хүснэгт-86. Хөв, цөөрөм байгуулах газрын байршил тогтоох шалгуур

Ашиглалтын төрөл	Балл	Авах арга хэмжээ
Тариалангийн талбай	0	Одоо байгаа тариалангийн талбай дээр байж болохгүй
Одоо байгаа хот суурин	0	Одоо байгаа суурьшлын бүсэд байж болохгүй

газар		
Авто зам	0	Авто замтай давхцаж болохгүй (< 60-100)
Уул уурхайн талбай	0	Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайд байж болохгүй
Нуур	0	Байнгын устай тул шаардлагагүй
Булаг, худаг, уст цэг	0	Булаг, худаг, уст цэгт ойр байх шаардлагагүй (<1000)
Хуурай сайр, жалга	0	Хуурай сайр, гуу жалгатай давхцаж болохгүй (<50)


Эх сурвалж: Хөв, цөөрмийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ. ГХГЗЗГ. 2015.

Суурь нөхцлийн зургийг дээрхи хүчин зүйлийн харгалзан Boolean зургийн аргаар хийдэг. Булеан зураг дээр өгөгдлийн утга нь 0 болон 1 гэсэн хоёр утгын нөхцөлтэй. 0 нөхцөл нь боломжгүй буюу зөвшөөрөхгүй нөхцөл, 1 гэсэн нөхцөлт утга нь зөвшөөрөх буюу боломжит утгыг илэрхийлнэ (Зураг-59).



Зураг-59. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөл

Дээрх зургийг Boolean зургийн нөхцөлт утгын аргыг ашиглан зурагласан бөгөөд 0 утгатай гарч байгаа газруудыг тохиромжгүй гэж үзнэ. Зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн. Дээрх суурь нөхцлийн зургуудыг нэгтгэж нэгдсэн үнэлгээний зургийг гаргасан (Зураг-60).



Зураг-60. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын суурь нөхцөлийн нэгдсэн үнэлгээ

Дээрх зурагт тохиромжгүй буюу 0 утгыг хар өнгөөр, тохиромжтой буюу 1 гэсэн утгыг цагаан өнгөөр үзүүлсэн.


Хүчин зүйлийн үнэлгээ

Тохиромжтой байдлын үнэлгээнд олон хүчин зүйл ашиглаж байгаа (factor) үед энэ аргыг хэрэглэнэ. Олон хүчин зүйлүүдийг хооронд нь харьцуулахад нэг нь нөгөөгөөсөө илүү ач холбогдолтой ба эзлэх жингийн хувьд өндөр жин дарна. Шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэхдээ АНР (analytical hierarchy process) буюу шатлан захирах дүн шинжилгээний аргыг ашигласан (Saaty 1977). Энэ арга нь шалгуур үзүүлэлтийн эрэмбэлэлтийн матрицаар жингийн утгыг тодорхойлдог. Сонгон авсан хүчин зүйлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийг эрэмбэлэлтийн матрицыг ашиглан жингийн утгыг тодорхойлохын тулд судалгаанд ашиглагдаж буй хүчин зүйлийг байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдалд нөлөөлөх ач холбогдлоор эрэмбэлсэн (Хүснэгт-87).

Хүснэгт-87. **Хөв цөөрөм байгуулах хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь**


№	Хүчин зүйл	Эрэмбэ	Харьцангуй жин
1	Тэжээгдэх усны эх үүсвэр	1	0.3506
2	Хур тунадас	2	0.2375
3	Гадаргын налуу	3	0.1589
4	Хуурай сайр, гуу, жалга	4	0.1055
5	Хөрсний ус нэвтрүүлэх чадвар	5	0.0696
6	Хот сууринаас алслах зай	6	0.0461
7	Малчидын улирлын байршил	7	0.0317
CR=0.035			

Дээрх эрэмбэлэлтээс хамгийн ач холбогдолтой нь газрын гадаргын налуу болон хөрсний тогтвортой байдал, хамгийн ач холбогдол багатай нь хөрсний гүний усний түвшин гэж тооцоод хүчин зүйлүүдийг эрэмбэлсэн. Эрэмбэлэлтийн матрицаар тооцон гаргасан жингийн утга хэр зэрэг үнэнд нийцэж байгаа consistency ratio буюу нийцлийн харьцааны индексээр тооцож үзэхэд 0.035 байгаа нь хүчин зүйлийн хоорондын харьцаа зохицол сайтай болох нь батлагдаж байна (Зураг-61).



Зураг-61. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын хүчин зүйлийн үнэлгээ

Дээрхи хүчин зүйлүүдийн нэгдсэн үнэлгээний зургийг радиометрийн заслийн тусламжтайгаар бүх зургийг 0-255 хооронд утга авхуулж засвар хийж зурагласан бөгөөд өндөр утга авах тусам маш тохиромжтой, бага утга авах тусам хөв цөөрөм байгуулахад нэн тохиромжгүй газар нутаг юм. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын суурь нөхцлийн болон хүчин зүйлүүдийн нэгдсэн зургийг гаргасан (Зураг-62).



Зураг-62. Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зургийг тохиромжтой байдлаар нь нэн тохиромжтой, тохиромжтой, дунд зэрэг тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл гэж ангилан авч үзлээ (Хүснэгт-88).

Хүснэгт-88. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

№	Тохиромжтой байдлын ангилал	Талбай, га	Эзлэх хувь
1	Тохиромжтой	1349318	11.68
2	Дунд зэрэг тохиромжтой	2649074	22.93
3	Хязгаарлагдмал тохиромжтой	3186287	27.58
4	Тохиромжгүй	984487	8.52
5	Газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл	3383329	29.29
Нийт		11552495	100

Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний үр дүнгээс газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцлүүдийг хасаж тооцоо хийхэд хорооны нийт нутаг дэвсгэрийн 11.68 хувь буюу 1349318 га нь тохиромжтой, 22.93 хувь буюу 2649074 га нь дунд зэрэг тохиромжтой, 27.58 хувь буюу 3186287 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 8.52 хувь буюу 984487 га нь тохиромжгүй, 29.29 хувь буюу 3383329 га нь газар ашиглалтыг хязгаарлах суурь нөхцөл тус тус гарч байна.

Хөв, цөөрөм байгуулах төлөвлөлт

Монгол орны хувьд хиймэл нуур, хөв цөөрмийг экологи, хөдөө аж ахуй, ус хангамж болон эрчим хүчний зориулалтаар байгуулж байна. Хиймэл нуур, хөв цөөрмийн хэмжээ янз бүр байдаг. Томоохон хиймэл нуурыг усны эрчим хүч ашиглах усан цахилгаан станц (УЦС)-ын зориулалтаар байгуулж байна. Жижиг усан сан болон хөв цөөрмийг гол төлөв малын усалгаанд зарим тохиолдолд усалгаатай тариаланд ашиглаж байна.

Хөв цөөрөм байгуулах нь усны сан бүхий газрын зохистой ашиглалт, хамгаалалтад чухал арга хэмжээ болдог. Усны хөвөө газар нь зэрлэг ан амьтан, мал сүрэг усанд орох сэрүүцэх үедээ түр саатан тогтох нутаг болдог. Түүнчлэн бэлчээрийн мал аж ахуйн нөхцөл дулааны улирлын нутгийн гол цөм нь болдог онцлогтой. Усны хөвөө газрын ашиглалтын хэлбэр, ашиглалтын горим, ялангуяа ургамалжилт нь нуур тойром, гол горхины усны урсгал болон ус сэлэх чадавх усны чанар найрлагад нөлөөлдөг бол усны урсгал, ус сэлгэх хэлбэр маяг нь усны хөвөө газрын биологийн төрөл зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ ялангуяа ургамлын бүрэлдэхүүн, ургамлын нөмрөгийн хэв шинж бүрэлдэхүүн чанар зэрэгт нөлөөлдөг.

Баянхонгор аймаг нь малын болон зэрлэг амьтдын усалгааны эх үүсвэрт гадаргийн усыг өргөн ашиглаж байна. Гадаргын ус сумдын нутаг дэвсгэр бүрд харилцан адилгүй тархах бөгөөд хур бороо бага хуурайшилт ихтэй, ган болсон жилүүдэд зарим усны эх үүсвэрийн нөөц нь усалгаанд хүрэлцэхгүй байх тохиолдол бий. Иймд усан сан, цөөрөм байгууламж, усыг хуримтлуулан ашиглах нь түүний нөөцийг нэмэгдүүлэн усалгааны хэрэгцээг найдвартай хангах үндэс болох юм.

Монгол улсад голуудын урсцын ихэнх нь хур борооны уснаас бүрддэг учраас зуны үерийн ус болон хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглахад голлон анхаарвал зохимжтой. Аймгийн хэмжээнд тохиромжтой байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр 18 байршилд хөв цөөрөм байгуулахаар төлөвлөж байна.


Хүснэгт-89. Хөв цөөрөм байгуулах газрын төлөвлөлт

Сумын нэр	Хөв	Байршил		Тайлбар
		Уртраг	Өргөрөг	
Өлзийт	Хөв цөөрөм	100° 52' 38.27"	46° 9' 21.89"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Жаргалант	Хөв цөөрөм	99° 28' 33.83"	47° 0' 47.95"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Баянлиг	Хөв цөөрөм	100° 45' 9.64"	44° 32' 19.59"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Хөв цөөрөм	99° 0' 3.25"	43° 14' 44.81"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Бууцагаан	Төлөвлөж буй хөв цөөрөм	98° 41' 29.48"	46° 14' 18.66"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв

Бууцагаан	Төлөвлөж буй хөв цөөрөм	98° 33' 17.83"	46° 1' 14.98"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Баянцагаан	Төлөвлөж буй хөв цөөрөм	98° 31' 41.54"	45° 34' 48.04"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Баянцагаан	Төлөвлөж буй хөв цөөрөм	98° 24' 7.40"	45° 6' 45.56"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Баянцагаан	Төлөвлөж буй хөв цөөрөм	98° 54' 5.51"	45° 8' 30.28"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Баянцагаан	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 35' 49.25"	45° 6' 35.38"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Жинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	100° 17' 25.45"	45° 8' 34.18"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Баянговь	Төлөвлөж буй хөв цөөрөм	100° 22' 21.37"	44° 44' 2.74"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 12' 49.05"	44° 22' 37.54"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 22' 28.83"	44° 20' 45.00"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 11' 27.48"	43° 58' 11.80"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 16' 51.780"	43° 52' 10.584"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 19' 37.38"	43° 48' 3.39"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв
Шинэжинст	Төлөвлөж буй хөв цөөрөм	99° 17' 50.68"	43° 10' 51.49"	ТБҮ болон Орон нутгийн саналыг үндэслэв

Монгол улсын голуудын урсцын ихэнх нь хур борооны уснаас бүрддэг учраас зуны үерийн ус болон хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглахад голлон анхаарвал зохино.

- Жижиг гол горхины урсцад тохируулга хийж хэрэглээний усыг хуримтлуулах;
- Хуучин ашиглаж байсан усан сан, цөөрмийг сэргээх;
- Хаврын шар ус, зуны борооны ус хуримтлуулах сан;
- Баян бүрдүүдийг сэргээх;
- Гол горхины хөндийн мод, сөөг, хөрс, ургамлын бүрхэвчийг хамгаалах, нөхөн сэргээх;
- Усалгаанд ашигласан илүүдэл усыг эргүүлэн ашиглах;
- Усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах зэрэг болно.



Зураг-63. Хөв цөөрөм байгуулах төлөвлөлт

6.3.5 Газрын доорх усны ордын нөөц, тэжээгдлийн муж дахь төлөвлөлт

Баянхонгор аймгийн хөгжлийн гол үндэс, шийдвэрлэх хүчин зүйлсийн нэг болох хүн амын унд-ахуйн ба үйлдвэр аж ахуйн нэгжийн техникийн төвлөрсөн ус хангамж хэр хүрэлцээтэй вэ гэсэн асуулт юм. Үүний тулд өнөөгийн эх үүсвэрийн найдвартай байдлыг шинэчлэн тодотгох, одоогийн ус авах хурдгийн нэгдсэн байгууламжийн дэвсгэр талбайн хажуу жигүүрийн залгаа зэргэлдээх бүсэд ойрын ирээдүйн болон алс хэтийн төлвийн хэрэглээнд хүрэлцэхүйц хэмжээний газрын доорх ус ашиглалтын нөөцийн судалгааг хийх шаардлагатай. Энэхүү судалгаанд Монгол улсын хэмжээнд хийгдсэн усны ордын нөөцийн судалгаа, Баянхонгор аймгийн Бөөнцагаан-орог нуурын сав газрын захиргааны газраас авсан газрын доорх усны сав газрын тэжээгдлийн мужийг тогтоосон судалгааны материалуудыг ашигласан болно. Эдгээр судалгаануудыг нэгтгэн авч үзэхэд тус аймгийн 16 сумын нутаг дэвсгэрт 23 усны орд илэрч нөөцийг нь тогтоосон байна. Эдгээр 16 сумаас 10 сумын нутаг дэвгэр дэх усны ордуудын тэжээгдлийн мужийг тогтоож өгсөн байна (Хүснэгт- 90.).

Хүснэгт-90. Газрын доорх усны ордын нөөц, тэжээгдлийн муж

Сумын нэр	Усны ордын нэр	Нөөц м3/ хоног	Газрын доорх усны орд		Нийт талбай, га
			Дотоод тэжээгдэл талбай, га	Гадаад тэжээгдэл талбай, га	
Баянцагаан	Олгойн голын баруун талд	661	142	352	494
Баянговь	Дэлгэрмөрөн	242	7163	5421	12584
Баянлиг	Хөөвөр	1020	57129	65182	122311
	Харзтай, зуух, зүүн хоолой	6912			
Баянхонгор	Баянхонгор	7300.8	159.4	252.1	411.5
Баян-овоо			-	19	19
Өлзийт			353	467	820
Эрдэнэцогт			-	223	223
Баян-Өндөр	Баян-Өндөр	130	2977	1864	4841
	Зараа	1469	-	-	-
Бөмбөгөр	Нарийн хөндий	120	183	413	596
Бууцагаан				49	49
Галуут	Галуут	648	162	235	397
	Өвөрчулуут	3456 1387			
Гурван булаг	Шар усны гол	605	203	70	273
Заг	Нарийн хөндий	120	2160	5860	8020
	Хөшөөт	132			
Шинэжинст	Зараа	106.6	8462	39080	47542

	Залаа, зараа	31.4			
	Эхийн гол	2706			
	Толь булаг	440.6			
Эрдэнэцогт	Шаргалжуут	4406	-	-	
Баацагаан	Хэрсэн	950	-	-	
	Загийн гол	346	-	-	
	Хөшөөтийн хөндий	132	-	-	
	Нарийн хөндий	120	-	-	
ДҮН		33441	79093	119487	198580

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн хэмжээнд 33441 м³/ хоног усны нөөц тогтоогдсон байна. Газрын доорх усны 23 ордуудын 10 гаруйд нь тэжээгдлийн муж тогтоосон байна. Эдгээр усны ордуудын дотоод тэжээгдлийн муж 79093 га талбай, гадаад тэжээгдлийн муж 119487 га талбайг тус тус эзэлж байна. Цаашид усны ордуудын тэжээгдлийн мужуудын ашиглалт, хамгаалалтын горимыг баримтлах шаардлагатай.

6.3.6 Усны урсац бүрэлдэх эх газрын төлөвлөлт

Монгол орны усны нийт нөөц сүүлийн 40 жилд хийсэн судалгааны дүнгээр 608,000 сая шоо метр ба үүнд 34,600 сая шоо метр гол, мөрөн, 500,000 сая шоо метр нуур, 62,900 сая шоо метр мөнх цас, мөсөн гол, 10,800 сая шоо метр газрын доорх усны нөөц тус тус багтана. Усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь оршин байгаа газар нутаг, байгалийн бүс, бүслүүр, агуулж байгаа чулуулгийн тогтоц, найрлагаасаа хамаарч ихээхэн өөр өөр байдаг.

Манай орны нийт ус ашиглалт, усны хэрэглээ жилд 500 сая шоо метр байна. Нийт хүн амын 30.5 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 35.8 хувь нь зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 24.6 хувь нь ус түгээх байр, худагаас, 9.1 хувь нь булаг, шанд, гол горхиноос усаа авч хэрэглэж байна.

Түй, Байдраг, Шар усан голын урсац бүрэлдэх эх газрын ихэнх хэсэг нь улсын тусгай хамгаалалтанд хамруулж авсан байдаг. Дээрх усны урсац бүрэлдэх эх газар нь доорх сумдын нутаг дэвсгэрийг хамарч байна (Хүснэгт-91.).


Хүснэгт-91. Усны урсац бүрэлдэх эх газар

№	Сумын нэр	Талбай, га
1	Баян-овоо	1747
2	Галуут	164453
3	Гурван булаг	4751
4	Жаргалант	205869
5	Заг	6490
6	Өлзийт	31735
7	Эрдэнэцогт	159138
	ДҮН	574181

Дээрх хүснэгтээс харахад усны урсац бүрэлдэх эх газар нь 574181 га талбайг эзэлж байна.

ХАА-н усан хангамжийн хамгаалалтын бүсийн ашиглалт, хамгаалалтын горим Усны хангамжийн онцгой болон энгийн хамаагаалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах
- Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;
- Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
- Түгээмэл тархалттай ашигт малтмал хайх, олборлох;
- Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;
- Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
- Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;



Зураг-64. Усны сан бүхий газрын төлөвлөлт

6.4 Хот, суурины усан хангамжийн төлөвлөлт

6.4.1 Хот, суурины усан хангамжийн хэрэгцээт байдлын үнэлгээ

Баянхонгор аймгийн усан хангамж, хэрэгцээ

Аймгийн хэмжээнд усан хангамжийн хэрэгцээ жил ирэх тусам нэмэгдэх нь харагдаж байна.

Аймгийн нийт хүн амын ундны усны хэрэглээг “Ундны усны хоногт шаардагдах зохистой хэмжээ”-нд үндэслэн одоогийн хэрэглээг тооцож үзэхэд 89332 хүн ам жилд 2217.1 мян.м³ ус хэрэглэх тооцоо гарсан. Ундны усны ирээдүйн хэрэглээг нөлөөллийн эрчим тооцсон хүн амын өсөлтөөр тооцоход 2027 онд 95160 хүн ам жилд 2217.1 мян.м³, 2032 онд 99555 хүн ам жилд 2852.4 мян.м³, 2037 онд 104152 хүн ам жилд 3326.3 мян.м³ усыг ундандаа хэрэглэх тооцоо гарсан. 2037 онд усны хэрэглээ одоогийн хэрэглээнээс 1.5 дахин ихсэх хандлагатай байна (Хүснэгт 93.).

Хүснэгт-92. Баянхонгор аймгийн хэмжээний ундны усны ирээдүйн хэрэглээ

Ус хангамжийн төрөл		Ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ, (хүн/хоног/литр)	Төлөвлөлтийн үе шат								
			2020 он		Ойрын 2027		Дунд 2032		Хэтийн 2037		
			м3.хоног	м3.жил	м3.хоног	м3.жил	м3.хоног	м3.жил	м3.хоног	м3.жил	
Хүн амын тоо			89332	89332	95160	95160	99555	99555	104152	104152	
Хүн амын тоо төвлөрсөн хангамжтай			10719	10719	14274	14274	18915	18915	26038	26038	
Хүн амын тоо төвлөрсөн хангамжгүй			78613	78613	80886	80886	80640	80640	78114	78114	
I.Төвлөрсөн ус хангамж											
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)		200.0	2143.8	782487.0	2854.8	1042002.0	3783.0	1380795.0	5207.6	1900774.0	
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах	30.0	321.6	321.6	428.2	428.2	567.5	567.5	781.1	781.1	
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8.0	85.8	85.8	114.2	114.2	151.3	151.3	208.3	208.3
		Усанд орох (шүршүүрт)	55.0	589.5	589.5	785.1	785.1	1040.3	1040.3	1432.1	1432.1
	Угаалга, цэвэрлэгээ	67.0	718.2	718.2	956.4	956.4	1267.3	1267.3	1744.5	1744.5	
	Ариун цэврийн байгууламж-суулгуур	40.0	428.8	428.8	571.0	571.0	756.6	756.6	1041.5	1041.5	
II. Төвлөрсөн бус ус хангамж											
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)		50.0	3930.7	1434687.3	4044.3	1476176.2	4032.0	1471678.0	3905.7	1425586.9	
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах	14.0	1100.6	401712.4	1132.4	413329.3	1129.0	412069.8	1093.6	399164.3	
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8.0	628.9	229550.0	647.1	236188.2	645.1	235468.5	624.9	228093.9
		Усанд орох (бие угаах)	17.0	1336.4	487793.7	1375.1	501899.9	1370.9	500370.5	1327.9	484699.5
	Угаалга, цэвэрлэгээ	11.0	864.7	315631.2	889.8	324758.8	887.0	323769.2	859.3	313629.1	
Дүн			6074.5	2217174.3	6899.1	2518178.2	7815.0	2852473.0	9113.3	3326361	

Баянхонгор сумын усан хангамж, хэрэгцээ

Хүн амын унд ахуйн усны хэрэглээ, хэрэгцээг тооцоолоход Үндэсний статистикийн хорооноос гаргасан гаргасан хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, төслийн багийн хийсэн хүн амын өсөлтийн тооцоо-хэрэгцээг байдлын үнэлгээ, статистик тооцооллыг ашиглав.

Баянхонгор аймаг нь 1981-1982 онд явуулсан гидрогеологийн нарийвчилсан судалгааны үр дүнд үнэлж тогтоосон газрын доорх усны ашиглалтын нөөцийг тогтоож барьсан 3 худгаас ундны усны эх үүсвэрээр ашигладаг.

Дээрх худгийн ашиглалтыг “Чандмань Баянхонгор” орон нутгийн өмчит ХК хариуцдаг.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас /Одоогийн Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ 2013 онд Баянхонгор хотын ус ашиглалтын хайгуулын судалгааг Арчандамана ХХК хийж гүйцэтгэсэн. Тухайн судалгааны үр дүнд үйлдвэрлэлийн В зэргээр 4449.6м³/хоног хэмжээтэй газрын доорх усны ашиглалтын нөөцийг тогтоосон.

Баянхонгор сум нь 2020 оны статистик тоон мэдээгээр 31948 хүн амтайгаас 9264 хүн амын буюу 40.8 хувь нь төвлөрсөн хангамжтай, 22684 хүн ам нь буюу 59.2 хувь нь төвлөрсөн хангамжгүй эх үүсвэрээс ундны ус хэрэглэж байна (Хүснэгт 95.).

Хотын хүн амын ундны усны одоогийн жилийн хэрэглээг хүн амын ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээнд үндэслэн тооцоход хоногт 1852.8 м³, жилд 676272.0 м³ ундны ус уух тооцоо гарч байна (Хүснэгт-93.).

Хүснэгт-93. Баянхонгор сумын ундны усны нөөцийн эрсдэлийн үнэлгээ

Үзүүлэлт	Нэгж	Төлөвлөлтөөр			
		2020	2027	2032	2037
Төлөвлөлтийн хугацаа	Он	2020	2027	2032	2037
Хүн амын тоо	Хүн	31948	34032	35604	37248
Тооцоот хэрэгцээ	м ³ хоног	2987.0	3488.3	4023.2	4935.3
Боломжит нөөц	м ³ хоног	4449.6	4449.6	4449.6	4449.6
Ашиглалтын хувь	Хувь	67.1%	78.4%	90.4%	110.9%
Үнэлгээ		Бага эрсдэлтэй	Дунд зэргийн эрсдэлтэй	Их эрсдэлтэй	Маш их эрсдэлтэй

Хүснэгт-94. Баянхонгор сумын усан хангамжийн хэрэгцээ

Ус хангамжийн төрөл		Ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ, (хүн/хоног/литр)	Төлөвлөлтийн үе шат								
			2020 он		Ойрын 2027		Дунд 2032		Хэтийн 2037		
			м3.хоног	м3.жил	м3.хоног	м3.жил	м3.хоног	м3.жил	м3.хоног	м3.жил	
Хүн амын тоо			31948	31948	34032	34032	35604	35604	37248	37248	
Хүн амын тоо төвлөрсөн хангамжтай			9264	9264	11911	11911	14953	14953	20486	20486	
Хүн амын тоо төвлөрсөн хангамжгүй			22684	22684	22121	22121	20651	20651	16762	16762	
I.Төвлөрсөн ус хангамж											
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)		200.0	1852.8	676272.0	2382.2	869503.0	2990.6	1091569.0	4097.2	1495478.0	
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах	30.0	277.9	277.9	357.3	357.3	448.6	448.6	614.6	614.6	
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8.0	74.1	74.1	95.3	95.3	119.6	119.6	163.9	163.9
		Усанд орох (шүршүүрт)	55.0	509.5	509.5	655.1	655.1	822.4	822.4	1126.7	1126.7
	Угаалга, цэвэрлэгээ		67.0	620.7	620.7	798.0	798.0	1001.9	1001.9	1372.6	1372.6
	Ариун цэврийн байгууламж- суултуур		40.0	370.6	370.6	476.4	476.4	598.1	598.1	819.4	819.4
II. Төвлөрсөн бус ус хангамж											
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)		50.0	1134.2	413983.0	1106.1	403708.3	1032.6	376881.4	838.1	305910.8	
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах	14.0	317.6	115915.2	309.7	113038.3	289.1	105526.8	234.7	85655.0	
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8.0	181.5	66237.3	177.0	64593.3	165.2	60301.0	134.1	48945.7
		Усанд орох (бие угаах)	17.0	385.6	140754.2	376.1	137260.8	351.1	128139.7	285.0	104009.7
	Угаалга, цэвэрлэгээ		11.0	249.5	91076.3	243.3	88815.8	227.2	82913.9	184.4	67300.4
Дүн			2987.0	1090255.0	3488.3	1273211.3	4023.2	1468450.4	4935.3	1801388.8	


6.4.2 Хот, суурины усан хангамжийн хамгаалалтын бүсийн төлөвлөлт

Усны эх, ундарга, нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны аюулаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтооно. Хамгаалалтын бүсийг дотор нь онцгой хамгаалалтын бүс ба энгийн хамгаалалтын бүс гэж хоёр ангилан төлөвлөв (Хүснэгт-95).

Хүснэгт-95. Хот суурины усан хангамжийн хамгаалалтын бүс

№	Эрүүл ахуйн бүс	Эрүүл ахуйн бүсийн өргөн	Хууль, эрхзүйн үндэслэл
Хориглолтын бүс			
1	Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр	100 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
2	Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр	50 м <	
Хязгаарлалтын бүс			
3	Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашиглавал түүний эргээс	200 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
4	Нийт урт нь 40 км-ээс бага урсгал усны ус хангамжийн эх үүсвэрт	Ус хурах талбайг бүхэлд нь хамааруулна	
5	Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш	5 м	
6	Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр	м <	

Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомстох, бохирдохоос хамгаалах зорилгоор төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтооно. Эрүүл ахуйн бүс нь хориглолтын ба хязгаарлалтын тогтооно. Эдгээр бүсүүдийн ашиглалтын горим хэрхэн зөрчигдөж байгааг авч үзсэн (Зураг-65).



Зураг-65. Усан хангамжийн хамгаалалтын менежментийн бүсүүд

Дээрх зурагт голын эрүүл ахуйн хамгаалалтын хориглолтын бүсийг 100, хязгаарлалтын бүсийг 200, ундны усны зориулалттай худгаас хориглолтын бүсийг 100 метрээр тогтоож зурагласан бөгөөд талбайн хэмжээг тооцож гаргасан (Хүснэгт-96.).

Хүснэгт-96. Хот суурины усан хангамжийн хамгаалалтын бүсийн менежмент, төлөвлөлтийн бүсүүд

Сумын нэр	Голын бүс		Булагийн бүс		Газрын доорх усны орд		Худгийн бүс		Нийт
	Онцгой	Энгийн	Онцгой	Энгийн	Догоод тэжээгдэл	Гадаад тэжээгдэл	Хориглох бүс	Хязгаарлалт - ын бүс	
Баянхонгор	357.8	297.3	2.3	35.3	159.4	252.1	34.3	387.9	1526.5
Баацагаан	-	-	-	-	-	-	2.3	29.8	32.2
Баянговь					5.3	312.5			317.8
Баянлиг						666.6			666.6
Баян-овоо			0.6	6.5			0.8	11.8	19.7
Баян-Өндөр			0.2	5.2			2.3	32.8	40.6
Баян-булаг	30.9	73.4							104.3
Богд	33.0	56.2					1.6	27.7	118.5
Бөмбөгөр							1.6	23.5	25.1
Бууцагаан			5.2	49.6		24.8	2.3	28.5	110.4
Галуут					0.7	5.4	2.3	35.3	43.7
Гурван булаг	2.5	18.7					3.1	43.7	68.1
Жаргалант	63.3	75.1					3.1	35.0	176.5
Жинст							1.6	23.5	25.1
Заг							1.6	22.4	24.0
Өлзийт	1.6	22.0					0.8	11.8	36.1
Хүрээмарал				4.0			1.4	13.8	19.2
Шинэжинст						389.9			389.9
Эрдэнэцогт	40.0	95.8					2.3	35.3	173.4
ДҮН	529.0	638.5	8.4	100.5	165.4	1651.3	61.6	763.0	3917.7

Хот суурины хангамжийн хамгаалалтын бүсүүдийг төлөвлөхдөө Баянбулаг сумын төвөөр урсдаг Бүрд гол, Богд сумын төвөөр урсдаг Түйн гол, Гурван булаг сумын төвийн зүүн хэсгээр урсдаг Шар Усны гол, Жаргалант сумын баруун талаар урсдаг Байдраг гол, Өлзийт сумын баруун хэсгээр урсдаг Шаргалжуутын гол, Эрдэнэцогт сумын төвөөр урсдаг Хойд Мөстрүү зэрэг голуудын онцгой хамгаалалтын бүсэд 529.0 га, энгийн хязгаарлалтын бүсэд 638.5 га талбайд төлөвлөсөн. Булгийн онцгой хамгаалалтын бүсэд 8.4 га, энгийн хязгаарлалтын бүсэд 100.5 га талбайд төлөвлөсөн.

Сумын төвийн ундны усны хэрэглээний худгийн хориглолтын бүс 61.6 га, хязгаарлалтын бүс 763.0 га талбайд тус тус төлөвлөсөн байна.

Усны сан бүхий газрын эрүүл ахуйн бүсийг тогтоож өгөөгүйн улмаас хориглолтын болон хязгаарлалтын бүс түүний дэглэмийг зөрчсөн, тусгай зориулалтын бүсэд газар олголт хийсэн гэх мэт зөрчил дутагдал илэрч байна.

6.4.3 Хот, тосгон бусад суурины усан хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн ашиглалт, хамгаалалтын горим

Ундны усны эх, ундарга, нөөцийг зохистой ашиглах, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зааг, бүсийн дэглэмийг тогтоох шаардлагатай байдаг. Иймээс усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон усны сан бүхий газрын менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Усан хангамжийн хориглолтын болон хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах;
- Хаягдал бохир усыг цэвэршүүлэх байгууламжгүй буюу ариутгах татуургад холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах;
- Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох
- Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
- Түгээмэл тархалттай ашигт малтмал хайх, олборлох;
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах, агуулах;
- Аймгийн төвийн төвлөрсөн хангамжийн хэрэгцээ жил ирэх тусам нэмэгдэх нь харагдаж байна. Одоогийн ундны усны хэрэглээ 8 жилийн дараа буюу 2027 онд ундны усны ашиглалт 53.5 хувьд хүрж 2382.2 м³, 12 жилийн дараа буюу 2032 онд ундны усны ашиглалт 67.2 хувьд хүрж 2990.6 м³, 18 жилийн дараа буюу 2037 онд ундны усны ашиглалт 92.1 хувьд хүрж 4097.2 м³ болох тооцоо гарч байна.
- Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.
- Баянхонгор хотын унд ахуйн болон техникийн төвлөрсөн ус хангамжийн үндсэн эх үүсвэрийн ойрын ирээдүйн ба алс хэтийн төлвийн хэрэглээнд зориулан ашиглахыг зөвлөж байна.

Ашигласан ном, хэвлэл

- Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Баянхонгор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол. Дугаар 2/7, 2020 он
- Аймгийн 2021 хөгжлийн төлөвлөгөө (ногоон хөгжлийн бодлого) батлах тухай, Баянхонгор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол. Дугаар 2/8, 2020 он
- Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр 2021-2024 он
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам. Монгол орны байгаль орчин, IV Боть, Монгол орны бэлчээр, хөрс, ашиглалт ба хамгаалалт. 2017.
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам. Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх технологийн заавар 2020.
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам. Биологийн олон янз байдлын хамгаалал ба ойн нөхөрлөлүүд 2020.
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Ойн судалгаа, хөгжлийн төв. Монгол орны мод сөөг 2014
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Ойн арчилгааны 1, 2-р хэлбэрийн ажлын сургалтын гарын авлага 2020
- Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө, Баянхонгор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны тогтоол 2/8, 2020.
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны тогтоол 2/7, 2020.
- Баянхонгор аймгийн Баацагаан сумын заган ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө 2020.
- Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын заган ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө 2020.
- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын заган ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө 2020.
- Баянхонгор аймгийн Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө Баацагаан сум 2020
- Баянхонгор аймгийн Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө Баян-Өндөр сум
- Баянхонгор аймгийн Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө Шинэжинст сум
- Баянхонгор аймгийн туруутны тооллого 2021
- Ойн салбарын үндэсний чуулган 2020
- Ойн Судалгаа, Хөгжлийн төв, Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ойн аж ахуйн нэгж байгууллаг, нөхөрлөл, ойн ангийн судалгаа 2021
- П. Оюунбат, Г. Элбэгзаяа. Хээр, говийн бүсийн хөрсний тархалт, шилжилтийн онцлог. Монгол орны хөрс судлалын сэтгүүл. 2016. 123-131.

- Мөнхбаяр Х. 1987. Хоёр нутагтан, мөлхөгчид. БНМАУ-ын Улаан ном. III хэсэг. х.63-69.
- Хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутгийн хүрээлэн буй орчны товч тодорхойлолт. Монгол орны өмнийн говийн бүс нутагт “Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь”. БОНХЯ, Дэ Нэйче Консерванси, Монгол дах хөтөлбөрийн газар. Улаанбаатар, 2014, 430х.
- Хуаленбек. Х. 2017. Заган ойг нөхөн сэргээх шийдлүүд, гарын авлага Тэрбиш.Х, Мөнхбаяр.Х, Мөнхбат.Ж, Е.М. Monks, Мөнхбаатар.М, J.E.M.Baillie,
- Батсайхан. Н, Боркин .Л.Я, Самъяа.Р, Семенов .Д.В, (эмхэтгэгчид ба редакторууд) 2006. Монгол орны хоёр нутагтан мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн улаан дансын цуврал. Боть 5. Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Лондон хот. (Англи, монгол хэлээр)
- Шинжлэх Ухааны Академи. Монгол орны өртөгдөн хөнөөгдөж буй ургамлын төрөл, зүйлүүд . 2018. 2-3
- BirdLife International. 2016. *Podoces hendersoni*. The IUCN Red List of Threatened Species 2016. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2016-3.RLTS.T22705883A94039716.en> (In English)
- Clark, E. L., Мөнхбат. Ж, Дуламцэрэн, С., Baillie, J. E. M., Батсайхан, Н., Самъяа, Р., Stubbe, М. (эмхэтгэгчид ба редакторууд). (2006). Монгол орны хөхтөн амьтны улаан данс. Бүс нутгийн улаан дансны цуврал. Бот 1, Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Лондон хот (Англи, монгол хэлээр).
- Dashnyam, B., Delgerzaya, D., Gankhuyag, P. & Amarkhuu, G. 2020. Nesting behavior of the Mongolian ground jay (*Podoces hendersoni*) in the Gobi desert of southern Mongolia. *Mong. J. Biol. Sci.*, 18(1): 41-46. (In English)
- Gombobaatar, S., Monks, E. M., Seidler, R., Sumiya, D., Tsevenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh. & Uugangayar, Ch. 2012. Regional Red List Series. Vol. 7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia, and Mongolian Ornithological Society. (In English)
- IUCN 2019. The IUCN Red List of Threatened Species. Version 2019-2. <https://www.iucnredlist.org>. Accessed on 18 July 2019. (In English)
- Nyambayar .B, Gankhuag .P. Biodiversity and Artisanal and Small-scale Mining in Mongolia. Scoping High Biodiversity Values in soums with active artisanal and small-scale mining (ASM) within ESEC II project sites. 2014. (In English)
- Rogovin, K.A., Semenov, D.V. and Shenbrot, G.I. (2001). Lizards of the northern Mongolian deserts: Densities and community structure. *Asiatic Herpetological Research* 9: 1-

ТӨГСӨВ



ХАВСРАЛТ